

 KONRAD
ADENAUER
STIFTUNG

НЭЭЛТТЭЙ УЛС ТӨР

ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН СЭТГҮҮЛ

№03, 2020/12





KONRAD
ADENAUER
STIFTUNG

Конрад-Аденауэр-Сангаас эрхлэн гаргав.
Энэхүү бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

Бүтээлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

Сэтгүүлийн зөвлөл:

Монгол дахь Конрад-Аденауэр Сан:

Йоханн Фурманн, Суурин төлөөлөгч

Сэнгээгийн Ганзаяа, Хөтөлбөрийн менежер

Хүндэт редактор:

Шинжлэх ухааны доктор Аюурзанын Цанжид



Эрхэм уншигч танаа,

Монгол Улс дахь Конрад-Аденауэр Сангийн суурин төлөөлөгчийн газар нь тус улсад ардчиллыг хөгжүүлэх үйл хэргийг тууштай дэмжин төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ хүрээнд эрх зүйт төр, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн тухай мэдлэгийг олон нийтэд таниулах ажлыг өргөн хүрээтэй зохиож ирлээ. Бид улс төрийн боловсролыг түгээн дэлгэрүүлснээр улс төр, нийгмийн амьдралд идэвхтэй, ухамсартай, хариуцлагатай оролцдог иргэд төлөвшихөд хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа юм. Нээлттэй улс төр сэтгүүлийг эрхлэн гаргаж байгаагийн зорилго үүнд оршиж байна.

Энэ удаагийн дугаар нь КАС-аас судлаачид болон оюутан залуусын дунд өгүүлэл, нийтлэлийн уралдаан зарлаж, оролцогчдоос ирүүлсэн өгүүллгийг эмхэтгэн толилуулж байгаагаараа онцлог юм. Өгүүллийн шалгаруулалтыг эрдэмтэн багш нараас бүрдсэн баг оноолтын системийн дагуу шалгаруулан дүгнэснийг танилцуулъя.

Судлаачдын нийтлэлийн шалгаруулалтын дүн:

- **Нэгдүгээр байр: “Монгол Улсад царай таних камер шаардлагатай юу?”**
Судлаач Л.Галбаатар
- **Хоёрдугаар байр: “Хиймэл оюун ухааны улс төрд үзүүлэх нөлөө”**
Судлаач Г.Золзаяа
- **Гуравдугаар байр: “Улс төрийн намын төлөвшлийн асуудал”**
(намын гишүүний татварын жишээн дээр) Судлаач, доктор Б.Эрдэнэдалай

Оюутнуудын нийтлэлийн шалгаруулалтын дүн:

- **Нэгдүгээр байр: “Иргэдийн оролцоо-Байгаль хамгаалал: Эрх цагаан ишиг”**
Б.Намуун, МУИС-ийн ШУС-ийн сэтгүүл зүйн 3 дугаар түвшин
- **Хоёрдугаар байр: “Иргэдийн оролцоо: Байгаль хамгаалал”**
Б.Уранчимэг, МУИС-ийн ОУХНУС-ийн 4 дүгээр түвшин
- **Гуравдугаар байр: “Иргэдийн оролцоо: Байгаль орчин”**
Т.Батзориг, МУИС-ийн ОУХНУС-ийн 4 дүгээр түвшин

Уралдааны эхний байранд шалгарсан судлаачид, оюутан залуустаа баяр хүргэхийн зэрэгцээ уралдаанд нийтлэлээ ирүүлсэн нийт оролцогчдоо гүн талархал илэрхийлье.

Та бүхэн манай сэтгүүлийг байнга уншиж, ардчиллын үнэт зүйлс, үндсэн зарчим, 21-р зууны ардчиллын онцлогийн тухай мэдлэгээ чамбайруулахын зэрэгцээ өөрийн оронд болон дэлхий дахины ардчиллын үйл явц, саад бэрхшээл, гэтлэн давах арга замын талаар хэлэлцүүлэг ярилцлага өрнүүлэхэд идэвхитэй оролцож сэтгүүлийн дотны нөхөр байна гэдэгт гүнээ итгэж байна.

Йоханн Фурманн
Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч

АГУУЛГА

НЭЭЛТТЭЙ УЛС ТӨР

ИРГЭНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН СЭТГҮҮЛ

ТӨРТ ЁСНЫ УЛАМЖЛАЛ

ТӨРИЙН ДЭЭД ЭРХ БАРИГЧДАД ТАВИГДАХ
ТҮҮХЭЭР БАТЛАГДСАН ШАЛГУУРУУД 8
Д.Сүхболд

ТӨРИЙН ТҮШЭЭДИЙГ ШИЛЖ,
СОНГОХ ТӨРТ ЁСНЫ УЛАМЖЛАЛ 18
А.Болормаа

ХҮНИЙ ЭРХ

ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙГ
ХАМГААЛАХ НЬ: МОНГОЛ УЛСАД ЦАРАЙ ТАНИХ
КАМЕР ШААРДЛАГАТАЙ ЮУ? 26
Л.Галбаатар

“RIGHT TO PRIVACY” БУЮУ ХУВИЙН ОРОН ЗАЙ,
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭРХИЙН
ТУХАЙ ҮЗЭЛ САНАА 34
Л.Амгаланбаатар

СОЁЛЫН ЯЛГАА БА ХҮҮХДИЙН БЭЛГИЙН
ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ 43
Ж.Дөлгөөн

ДИЖИТАЛ ЗАСАГ

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ УЛС ТӨРТ
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ 50
Г.Золзаяа

МОНГОЛ ДАХЬ ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА: СОРИЛТ БА БОЛОМЖ 56
Х.Золжаргал

ИРГЭДИЙН ОРОЛЦОО: БАЙГАЛЬ ОРЧИН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

ИРГЭДИЙН ОРОЛЦОО-БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ: ЭРХ ЦАГААН ИШИГ	70
Б.Намуун	
ИРГЭДИЙН ОРОЛЦОО: БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ	74
Б.Уранчимэг	
ИРГЭДИЙН ОРОЛЦОО: БАЙГАЛЬ ОРЧИН	83
Т.Батзориг	
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ТҮҮНД ИРГЭНИЙ ОРОЛЦОО	90
Х.Бадамлянхуа	

УЛС ТӨРИЙН НАМ, СОНГУУЛЬ

УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛ (НАМЫН ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ЖИШЭЭН ДЭЭР)	108
Б.Эрдэнэдалай	
МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД АРДЧИЛЛЫГ ХЭМЖИХ НЬ	117
А.Бат-Оргил	
ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ЗАРИМ ШААРДЛАГЫГ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗСЭН НЬ	125
С.Номынбаясгалан	
ЗАЛУУ СОНГОГЧДЫН УЛСТӨРИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ТЭДНИЙ СОНСОЖ БУЙ ДУУ НӨЛӨӨЛӨХ НЬ. (18-20 НАСНЫ СОНГОГЧДЫН ЖИШЭЭН ДЭЭР)	135
Б.Уянга	



ТӨРТ ЁСНЫ УЛАМЖЛАЛ



ТӨРИЙН ДЭЭД ЭРХ БАРИГЧДАД ТАВИГДАХ ТҮҮХЭЭР БАТЛАГДСАН ШАЛГУУРУУД

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн эрдэм шинжилгээ, оюутны асуудал эрхэлсэн
проректор, доктор

“Эзэн хааны аз жаргал бол албат нарын аз жаргал байх ёстой”

/ Артхашастра бүтээлээс /

Хураангуй: Улс орныг шалгарсан шилдэг хүмүүс удирдах ёстой юу? шалгарсан шилдэг хүмүүс гэж хэнийг хэлэх вэ? төрийн дээд эрх баригчдад ямар шалгуур тавигдах ёстой юм бэ? тэд бусдаас онцгой авьяас чадвартай байх шаардлагатай юу? биднийг удирдахыг маш их хүсээд буй эрхмүүд төр улсыг засаглан жолоодох арга ухаан, эрдэм мэдлэгт суралцаж чадсан уу? төр улсыг засаглаж жолоодох нь ажил нь хэн бүхний дур зоргоороо хийж чадах ажил мөн үү? эзэн захирагчдад тавих шалгуурын асуудал улс төрийн сэтгэлгээний түүхэнд яагаад хамгийн чухал сэдвүүдийн нэг байв? төрийн дээд эрх мэдлийг хэн барих ёстой вэ? гэсэн асуултуудад улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс хариулт өгөхийг зорив.

Улс орныг шалгарсан шилдэг хүмүүс удирдах ёстой, шалгарсан шилдэг хүмүүс гэж хэнийг хэлэх вэ? Тэд бусдаас юугаараа ялгарах вэ? Тэдэнд ямар шалгуур тавигдах ёстой вэ? Гэсэн асуулт улс төрийн сэтгэлгээний түүхэнд олонтаа тавигдсаар ирсэн. Учир нь улс орны хувь заяаг залуурдан жолоодно гэдэг нь хэн нэг дуртай хүний хийх ажил биш, асар хүнд хэцүү, мөртлөө маш нэр хүндтэй, тал бүрийн мэдлэг, чадварыг шаардсан ажил бөгөөд энэхүү бүхий л хүнд хөдөлмөрийг үүрэхийг зөвшөөрсөн хүн л төрийн өндөр албан тушаалыг хаших ёстой юм.

Үндсэн хуульт төрийн байгуулал үүсэхээс өмнө төр улсыг эзэн хаан, эзэн захирагч нар удирддаг байсан бол өнөө цагт төрийн өндөр албан тушаалтнууд улсыг удирдан засаглаж байна. Төрийн өндөр албан тушаалтан гэдэг нь улсын Ерөнхийлөгч, парламентын дарга, дэд дарга, парламентын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн Газрын гишүүн, Улсын Дээд Шүүхийн дарга, Улсын Ерөнхий Прокурор, хуульд заасны дагуу парламентаас томилогддог бусад албан

тушаалтнууд багтана. Энэхүү төрийн өндөр албан тушаалтнуудад ямар шалгуур тавигдах ёстой вэ. Тэдэнд тавигдах шалгуурыг юуны өмнө Үндсэн хуулиас хайж болох боловч Үндсэн хуульд хэт ерөнхий шалгуур тавигдсан байдаг. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн 3.21 зүйлд “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.”

30.2. Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.

Харин гүйцэтгэх засаглалын тэргүүн, Улсын Дээд Шүүхийн Ерөнхий Шүүгч, Улсын Ерөнхий Прокурорт тавигдах шалгуур Монгол улсын Үндсэн хуульд байхгүй юм.

Угтаа бол төрийн өндөр албан тушаалтнуудад тавигдах шалгуур нь нилээд өндөр байх ёстой ч зөвхөн Үндсэн хуульд бэхжүүлсэн ерөнхий зарчмаар зохицуулахаас өөр арга механизм бидэнд алга. Гэвч бидэнд нэг давуу тал байна. Энэ юу вэ, гэвэл эзэн захирагчдад ямар шалгуур тавигдах ёстой вэ? гэсэн асуулт улс төрийн сэтгэлгээний түүхэнд олонтаа тавигдаж, энэ асуултад аугаа их сэтгэгчид өөр өөрсдийн байр сууринаас хариулсаар ирснийг эртний Грек, Ром, Энэтхэг, Хятадын улс төрийн сэтгэлгээнээс тодорхой харж болох юм. Энэ нь төрийн өндөр албан тушаалтанд тавигдах шалгуурын асуудлыг олон түмний анхааралд оруулж, нийтээр тогтсон үнэлэмж бий болгоход тустай юм. Ингээд энэхүү давуу талдаа дулдуйдан төрийн өндөр албан тушаалтанд тавигдах шалгуурын асуудлыг бага сага дэлгэрүүлэн хөндье. Бүр тодруулбал түүхийн туршид ард түмэн өөрсдийг нь удирдан жолоодох эрх бүхий эзэн захирагчдад ямар шалгуур тавьдаг байсан талаарх баримтыг эртний өрнө, дорнын томоохон төрт улсуудын жишээнээс хайж олсноо та бүхэнд сонирхуулъя. Тухайлбал эртний Грекийн их сэтгэгч Платон нийгмийг:

- Философичид буюу эзэн захирагчид
- Цэрэг дайчид буюу нийгмийг хамгаалагчид
- Гар урчууд худалдаачид, газар тариалан эрхлэгчид

гэсэн гурван давхаргад хуваагаад, эдгээр давхаргуудыг металтай адилтгасан байдаг. Тодруулбал эзэн захирагчдын давхаргыг алттай, цэрэг дайчдын давхаргыг мөнгөтэй, гар урчууд худалдаачдын давхаргыг хүрэл зэстэй адилтгажээ. Түүнийхээр шижир алтны хольцтой хүмүүс болох философичид буюу эзэн захирагчид л төр нийгмийг удирдах ёстой бөгөөд дээрхи гурван давхаргынхан хоорондоо холилдолгүйгээр тус тусын оноогдсон ажил үйлээ сайн хийх нь нийгмийн шударга ёс болно гэдгийг сануулаад ялангуяа эзэн захирагчид буюу философичид алдаа гаргах эрхгүйгээр улсыг удирдах ёстой. Учир нь талхчин хүн алдаа гаргаж талхаа түүхий хийлээ гэхэд талхыг идсэн цөөн хүмүүс хохирно. Нийгмийг хамгаалагчид болох цэрэг дайчид алдаа

гаргавал улс оронд нэлээдгүй хэмжээний хохирол учирна. Харин философичид буюу эзэн захирагчид төр улсыг удирдах ажилдаа алдаа гаргавал бүхэл бүтэн улс орон мөхөж сүйрэх аюулд орох тул тэд ямар ч алдаатай шийдвэр гаргах эрхгүй гэсэнээрээ удирдагч хүмүүсийн үүрэг ач холбогдлыг тодотгож өгчээ. Цаашлаад “Бүгд найрамдах улс” зохиолдоо эзэн захирагчдын улсыг засаглан жолоодох чадвар бол хэн бүхний дур зоргоороо хийж чадах ажил биш гэдгийг тайлбарлахдаа хөлөг онгоцны тухай сонирхолтой аналогийг ашиглажээ. Үүнд: **“Усан онгоцон дээр байна гэж санацгаая.** Хөлгийн ахмад нь бага зэрэг дүлий, хараа муутай хүн байсан боловч насаараа хөлөг онгоц жолоодох арга ухаанд суралцсан хүн байлаа. Харин хөлөг онгоцны зорчигчид хөлгийг удаан явж байна хэмээн шүүмжилж, **хөлгийг** хэрхэн жолоодох талаар хоорондоо маргалдаж, өөр өөрийгөө удирдах ёстой хэмээн бодоцгооно. Тэд хэзээ ч усан онгоц жолоодох урлагт суралцаж, түүнд цаг заваа зориулж байгаагүй атлаа тэгж хэлсэн хүнийг алахад ч бэлэн байлаа. Тэд ахмадынхаа дэргэд хий дэмий үймэцгээн цагаа барах бөгөөд удирдлагыг авахын тулд чадах бүхнээ хийцгээнэ. Хэн нэг нь илүү амжилттай байх юм бол өрсөлдөгчид нь түүнийг алах юм уу онгоцны хашлага давуулж шидэхэд ч бэлэн байлаа. Удалгүй тэд шударга ахмадаа согтоон мансууруулах ч юм уу өөр ямар нэгэн аргаар зайлуулаад усан онгоцыг хяналтандаа авч, өөрсдийн чадах зүйл болох зугаа цэнгэлтэй аяллыг цаашид үргэлжлүүлэв. Харамсалтай нь тэдэнд жинхэнэ далайчинд байх ёстой зүйл болох онгоцоо удирдан залахад шаардлагатай ур чадвар, жилийн улирал, тэнгэр, од гариг, салхины байдал болон бусад зүйлийн талаар ямар нэг ойлголт байгаагүй. Тэд далай тэнгисээр аялах урлагийн тухайд юу ч мэдэхгүй”¹ Эцэст нь хөлөг онгоц мэргэжлийн удирдлагагүйн улмаас далайд живсэн түүхтэй. Живсэн хөлөг онгоцны эмгэнэлт түүхийг давтахгүйн тулд биднийг удирдах хүмүүс улс төр, эдийн засаг, психологи, хүний сэдлийн талаар нарийн мэдлэгтэй байхаас гадна ажиллах чадвар өндөр, юмыг сайтар задлан шинжилдэг, зоригтой, ухаалаг сэргэлэн, аливаа шийдвэрийг олон талаас нь нухацтайгаар авч үзэж байж гаргадаг, өгөөмөр ариун сэтгэлтэй, шударга зарчимч, ой тогтоолт сайтай, ажлын туршлагатай гэх мэт шаардлагыг зайлшгүй хангасан байх шаардлагатай. Үүнээс гадна Платоны үзсэнээр эзэн захирагч нарт зайлшгүй байх нэг шинж нь бие бялдрын өв тэгш зөв хүмүүжил юм. Үүнтэй холбоотойгоор эзэн захирагч нарыг хэрхэн бэлтгэх талаар авч үзсэн бөгөөд түүнийхээр чөлөөт иргэдийн үр хүүхдийг бага балчраас нь тусгай хүмүүжлийн байгууллагаар дамжуулан өсгөх ёстой. Энэ сургалтын үйл ажиллагаанд нас хүйс, гарал угсааг үл харгалзан сургана. Хүүхэд залуучуудыг 35 нас хүртэл нь тусгай сургалт хүмүүжлийн төлөвлөгөөний дагуу сургаад, 35 наснаас хойшхи 15 жилд иргэний болон цэргийн боловсролыг олгоно. Энэ хугацаанд шалгарч гарч ирсэн хүмүүсийг өөрийнх нь онцлогийн дагуу төрөлжүүлэн мэргэшүүлсний эцэст 50-70 насандаа төрийн өндөр дээд албанд зүтгэх эрхтэй болно. Хорин жилд төрд зүтгэсний дараа хүүхэд залуучуудыг сурган хүмүүжүүлэхэд оролцоно.

1 Ж.Вольф “Улс төрийн философийн удиртгал” 92 дахь тал. УБ., 2002

Платон Аристотель нарын гаргасан төрийн хэлбэрүүд дотор Аристократ гэсэн төрийн хэлбэр байдаг ба энэ нь шилдгүүдийн засаглал гэсэн утгатай юм. Платоны шавь Аристотель политика буюу шилмэл төрийн онолдоо аристократ засаглалын давуу талыг дурдаад зогсохгүй төрийг удирдан жолоодох өндөр дээд албан тушаалтан гэдгийг анх тодорхойлсон. Үүнд: “Засаглалыг хуваарилах болон засаглалын тодорхой эрх мэдлийг өөртөө төвлөрүүлж, түүнд нөлөөлөх шийдвэрийг үзүүлж чадах, хуулийг хэлэлцэхэд оролцдог тодорхой эрх бүхий хүнийг төрийн дээд албан тушаалтан гэнэ”² гэжээ.

Эртний Монголчууд түшмэл ёс гэдгийг эрдэм мэдлэг, хуримтлуулсан турилагаараа бусдаас тодорсон албан тушаалтан буюу төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны хувьд удирдах, гүйцэтгэх өвөрмөц эрх мэдлийг хэрэгжүүлдэг хүмүүс хэмээн ойлгож байснаас гадна төрийн албанд ажиллах хүмүүсийг өндөр шалгуураар шалгаж авдаг тогтолооог Их Монгол улсын үед бий болгосон байдаг.

Эртний дорно дахины улс түмэн ч мөн адил төрийг удирдан жолоодох удирдагч хүн ямар байх ёстой талаар өөр өөрсдийн шалгууруудыг гаргаж, энэ талаар зохиол бүтээлүүд ч туурвигдсан байна. Тухайлбал эртний Энэтхэгт МЭӨ 3-р зууны үед зохиогдсон болов уу хэмээн тооцогддог ³ Артхашастра гэдэг бүтээл өөрийн эрхгүй анхаарал ихэд татдаг бөгөөд судлаачид уг бүтээлийг цэвэр улс төрийн шинжлэх ухааны бүтээл гэж үздэг. Артхашастра гэдэг нь ашиг тусын тухай гэсэн утгатай бөгөөд мөн төрийг удирдах арга барилын тухай шастир гэсэн утгаар өргөн хэрэглэдэг. Уг бүтээл 500 гаруй хуудастай, зохиогчийг нь Энэтхэгийн Макиэвелли хэмээн зарим тохиолдолд алдаршуулан нэрлэдэг. Энэхүү бүтээлд төрийн дээд эрхийг барина гэдэг бол асар хүнд хэцүү, мөртлөө маш нэр хүндтэй, тал бүрийн мэдлэгийг шаардсан ажил бөгөөд энэхүү бүхий л хүнд хөдөлмөрийг үүрэхийг зөвшөөрсөн хүн л тэрхүү өндөр албан тушаалыг хаших ёстой гэжээ. Хэрвээ эзэн хаан үүнийг хүсэж байвал дараах зүйлийг онцгойлон анхаарах ёстой. Үүнд: Эзэн хааны аз жаргал бол албат нарын аз жаргал, ард түмэнд таалагдсан зүйл нь эзэн хаанд ч мөн таалагдах ёстой хэмээн хаан хүний үүрэг хариуцлагыг заан өгчээ. Цаашлаад төгс төрийн захирагч нар ямар шинж чанаруудыг агуулсан байх талаар ч өгүүлжээ. Үүнд:

1. Язгуур гарал өндөр
2. Настай хүний үгийг сонсдог
3. Шударга зарчимч
4. Бусдыг хэрэгтэй үед хошуучлан дагуулдаг
5. Мэдлэг боловсролын чадавхийг эд баялагийн чадавхиас хэд дахин илүүд үнэлдэг

² Аристотель “Политика” 1983 онд хэвлэгдсэн түүвэр зохиолын 4-р ботийн 519 дэхь тал

³ Энэ ч учраас Оросод энэхүү бүтээлийг хамгийн сүүлд дахин хэвлэхдээ “Артхашастра или наука политика” гэсэн нэртэйгээр гаргажээ.

6. Уран цэцэн үгтэй
7. Төрийн өндөр албан тушаалд хамгийн боловсролтой, хамгийн нэр хүндтэй, хамгийн туршлагатай, хүнийг томилдог
8. Төр барих үйл ажиллагаандаа аль болох хамгийн найдвартай аргыг өргөнөөр ашиглах чадвартай байх ёстой гэжээ.

Эртний хятадын их сэтгэгч Күнз /МЭӨ 551-479/ эзэн хааны засаглал бурхан тэнгэрээс эхтэйг хүлээн зөвшөөрч байсан боловч тэрхүү тэнгэрийн зарлигийг биелүүлэгч төрийн дээд эрх баригч нь дотоод хүчин чадал, авьяас мэргэн ухаантай байхын чухлыг өгүүлснээс гадна хаан эзэнд туслагч түшмэдүүд өндөр мэдлэг чадвар, ёс суртахуунтай, ард иргэдийн эрэлт хэрэгцээ, ахуй амьдралын сайн мэддэг байх ёстой⁴ хэмээжээ. Күнз хүмүүсийг гурван хэсэгт хуваасан байдаг. Үүнд:

- Эрхэм дээд хүн
- Өчүүхэн хүн
- Завсарын хүн

Түүнийхээр эрхэм дээд хүмүүс бол хамгийн шилдэг, сайн хүмүүс бөгөөд төрийн дээд эрхийг баригчид эрхэм дээд хүмүүн байх учиртай, тэдний хамгийн чухал шинж нь хүнлэг чанар, хүмүүжил боловсрол гэжээ. Тэрээр хүнлэг чанарыг хүмүүжил, боловсролоос дээгүүрт тавьсан.

Төрт ёсны олон зууны түүхтэй эртний Монголчуудын хувьд хэдийгээр хаант засгийн хэлбэрээр удирдуулж байсан боловч хаанд зөвлөн туслах үүрэгтэй шаталсан зэрэг дэв бүхий “түшмэл”ёсыг бий болгожээ. Эртний Монголчууд түшмэл ёс гэдгийг эрдэм мэдлэг, хуримтлуулсан туршлагаараа бусдаас тодорсон албан тушаалтан буюу төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны хувьд удирдах, гүйцэтгэх өвөрмөц эрх мэдлийг хэрэгжүүлдэг хүмүүс хэмээн ойлгож байснаас гадна төрийн албанд ажиллах хүмүүсийг өндөр шалгуураар шалгаж авдаг тогтолцоог Их Монгол Улсын үед бий болгосон байдаг. Тухайлбал Өгөдэй хаан “бичгийн мэргэд шалгаруулж төрийн албанд авах тухай” зарлигийг 1235 гаргажээ. Төрийн албыг эрдэмтэй, авьяаслаг хүмүүсээр нөхөн сэлбэх шаардлагын үүднээс сонгодог зохиол, алба гувчуур, улс орны цаг үеийн асуудал, монгол хэл гэсэн дөрвөн сэдвээр бичгийн шалгалтыг 1237 онд авч, бичгийн эрдэм мэдэх янз бүрийн үндэстний 4030 хүн шалгаруулалтанд оролцжээ.⁵ Төрийн албанд хүмүүсийг шалгаруулж авахдаа яс үндэс, угсаа гарвал, нас, хүйс үл хамааран зөвхөн мэдлэг чадварыг нь гол шалгуур болгодог байсан нь орчин үеийн “мерит”⁶ зарчим бүхий төрийн албанд нэлээд дөхсөн чадварлаг аппарат бүрдүүлэх үндэс болж байв.⁷

4 МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” 37 дахь тал. УБ., 2001

5 Д.Наран “Монголын төр ёсны боловсролын түүх” УБ 2001. 99-р тал

6 Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.3. Чадахуйн зарчим /мерит/” гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг хэлнэ. “<https://www.legalinfo.mn/law/details/13025>

7 МУИС Политологи сэтгүүл №14. 57 дахь тал. Ц.Батболд “Их Монгол гүрний төрийн байгуулалт: Анхны

Их Юан гүрнийг үндэслэн байгуулагч Хубилай хаан төр барих ахуйдаа хаан хүний эрдэм боловсрол, ёс журам, сахилга, бат, төр улсаа хэрхэн засах арга ухаан болоод сүр хүчийг хаан хүний гурван их үйл, дөрвөн их төр, зургаан их үлгэр, есөн их бэлгэ хэмээх ойлголтуудаар тодорхойлсныг “Арван буянт номын цагаан түүх” шастирт тэмдэглэн үлдээжээ. Үүнд:

- **Гурван их үйл:** 1.Улсыг номын ёсоор засаж амгалан болгох 2.Төрийн ёсоор засаж жаргал эдлүүлэх 3. Цэргийн явдлыг хичээж улсыг батлан хамгаалах
- **Дөрвөн их төр:** 1.Хамаг амьтны тусын тулд нигүүлсэхүй сэтгэл гаргаж, өвчин тахалд мэргэн эмч болж, төөрсөн амьтанд замыг заагч, харанхуй шөнийн гэрэлт зул болох 2.Үгээгүй ядууд эрдэнийн сангаас олгуулж, бодисатва нарын адил тэгшээр хамаг амьтанд туслах 3.Хаан хүн төр барихдаа энх амгаланг эрхэмлэх 4.Сайд түшмэдээрээ төрийг сайтар засуулах явдлыг өөрийн үндсэн зарчим болгох
- **Зургаан их үлгэр:** 1.Монголын хаадын төрийг зассан өмнөх түүхийн үлгэр дууриалал 2.Төр засах журмын тухай бурхан багшийн сургааль зарлигийн үлгэр дууриалал 3.Төр ёсыг явуулах ёслол дүрмийн үлгэр дууриалал 4.Дур зоргоороо явж үл болохын үлгэр дууриалал 5.Цэрэг байгуулж төрөө хамгаалахын үлгэр дууриалал 6.Арвилан хэмнэж, өсгөн нэмэгдүүлэхийн үлгэр дууриалал
- **Есөн их бэлгэ:** Харьяа ихт хар туг, хашгираа ихт улаан бүрээ, хүч ихт алтан сум, цог ихт шар шүхэр, зангараг ихт алмас илд, чийрэг сайн алтан эмээл, эгэл ихт хүнд бүс, өндөр далбаат исэр, түшээ сайт өрлөгүүд. Эд бол эзэн хааны хотлыг захирсан сүр хүч, эрх мэдлийн бэлгэ тэмдэг болно.

Төрийн дээд эрхийг барих ёстой шалгарсан шилдэг хүмүүсийн үзэл санаа системчлэгдэн боловсрогдож, эхэлсэн үе бол улс төрийн сэтгэлгээний түүхэнд рациональ хандлагын үе хэмээн нэрлэгдсэн XV-XVIII зуун юм. Тодруулбал улс орныг хэн захирах вэ? төрийн дээд эрх баригч ямар байх ёстой вэ? гэсэн асуултад Италийн нэрт сэтгэгч Никколо Макиэвелли /1469-1527/ “Государь” буюу эзэн захирагч⁸ “Тита Ливийн эхний арав хоногийн тухай эргэцүүлэл”⁹ зэрэг бүтээлүүдээрээ улс төрийн шинжлэх ухааны үндэстэй¹⁰ хариултыг өгсөн юм. Тэрээр улс төрийн шийдвэрийг гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд хошуучлагчийн /лидерийн/ өмнөө тавьсан зорилго, тухайн үеийн нөхцөл байдал чухал нөлөөтэй, өөрөөр хэлбэл аливаа улс төрийн шийдвэрийн үр ашиг хошуучлагчаас ихээхэн хамаардаг гэжээ. Төрийн дээд эрх баригчийн улс орны төлөө гэсэн аугаа том зорилгыг ямар ч нөхцөл байдал өөрчлөх ёсгүй, зорилгодоо хүрэхийн тулд ямарч

холбооны улсын загвар”

8 1513 онд бичсэн

9 1520 онд бичсэн

10 Тэрээр өмнөх сэтгэгчдийн мөрөөдлөөр бичсэн төр ямар байх ёстой вэ? Гэсэн асуудлыг түүх, сэтгэлзүй, антропологи, социологийн зэрэг судалгааны аргуудаар дамжуулан судалсан. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” 47 дэхь тал УБ., 2001

арга хэрэгслийг ашиглаж болох тухай өгүүлсэн нь өдгөө “Макиэвеллизм”¹¹ хэмээх парадоксийг бий болгожээ. Европын улс төрийн сэтгэлгээнд Н.Макиэвеллийг хошуучлагчийн ажлын үр ашигтай загвар бүтээхийг чармайж байсан судлаач хэмээн дүгнэдэг.

Төр улсыг шалгарсан шилдгүүд удирдах ёстой гэсэн улс төрийн төсөөлөл нь эртний Грек, Ром, Энэтхэг, Хятадын улс төрийн сэтгэлгээнээс эх авч хөгжсөөр XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеэс “Элитийн онол” болтлоо боловсрогджээ. Элит гэсэн нэр томъёо нь Франц хэлний “Elite” шилдэг, сонгогдсон, түүгдсэн гэсэн утгатай үгнээс гаралтай¹² бөгөөд чухам энэ үеэс шинжлэх ухаанд хэрэглэгдэх болжээ.

Элитийн онолыг боловсруулахад Н.Макиэвелли, Т.Карлейль, О.Шопенгауэр, Ф.Ницше нар үнэтэй хувь нэмэр оруулсан боловч Италийн В.Парето, Г.Моска, Германы Р.Михельс нарын зохиол бүтээлүүдэд элитизм нь шинжлэх ухааны чиглэл болтлоо хөгжжээ.

Италийн социологич В.Парето /1848-1923/ хүмүүс угаасаа тэгш бус гэсэн санааг гаргаад, аль ч салбарт хамгийн өндөр амжилтанд хүрч байгаа хүмүүсийг нийтэд нь “элит” гэж нэрлэсэн. Өргөн утгаараа элит гэж оюун ухаан, зан араншин, авхаалж самбаа зэрэг олон янзын чадварыг хамгийн өндөр хэмжээнд эзэмшсэн хүмүүсийг хэлжээ. Хүн төрөлхтний түүх бол засгийн эрхийн төлөөх шилмэл хүмүүсийн өөр хоорондоо хийх тэмцлийн түүх, засаглал нэг хэсэг шилмэл хүмүүсийн гараас нөгөө хэсэг шилмэл хүмүүсийн гарт шилжиж ирсэн түүх болно.¹³ Тэрээр үзэхдээ дарангуйлагч нийгэмд ч ардчилсан нийгэмд ч хөшигний цаана засаглалыг хэрэгжүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг хүмүүс ямагт байдаг. Чухам ийм хүмүүс элитийн үндсийг бүрдүүлж, түүхийн үйл явц, чиглэлийг тодорхойлж, гүйцэлдүүлж байдаг гэжээ. Парето элитийг захирах аргаар нь

- Арслан маягийн элит
- Үнэг маягийн элит

гэж хоёр хуваасан. Арслан дүрт удирдагчид өөртөө итгэлтэй, шийдэмгий, хүчирхийллийн аргаар удирдах чадвартай аливааг төвлөрүүлэн нэгтгэх бодлогыг тууштай хэрэгжүүлж чаддаг. Ийм удирдагчид гол төлөв улс үндэстний хөгжил задрал бутрал орж эхэлсэн, хүчирхэг гар, удирдлага шаардагдсан, тийм үед тодрон гарч ирдэг, тэгээд ч задрал бутрал, эмх замбараагүй байдлаас улс орноо аварна, төвлөрсөн сахилга дэг журмыг тогтооно, нэг хүний засаглал хүчирхэгжинэ. Гэвч ийм байдал урт удаан хугацаагаар эцэс төгсгөлгүй үргэлжилвэл дарангуйлал тогтож, нийгмийн хөгжил зогсонги байдалд орох талтай. Яг ийм үед ардчиллын үзэл газар авснаар арслан дүрт удирдагчдын

11 “Зорилго нь аргаа зөвтгөнө” гэсэн улс төрийн үзэл санаа Д/С

12 МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” 134 дэхь тал. УБ., 2001

13 Н.Хавх “Нийгмийн гүн ухаан” 61 дахь тал. УБ., 1996

халааг “үнэг” дүртэнгүүд авна. Үнэг шинжийн уирдагчид дээрхийн эсрэг аль болохоор хавь ойрын хүмүүсийн сэтгэл санааны аясыг харсан, олон түмнийг итгүүлэн үнэмшүүлэх аргаар улс төрийн бодлого явуулна. Тэд өөртөө тийм итгэлтэй бус, аль болохоор бусдын гараар юмаа хийлгүүлэх, хожим сүүлдээ өөрөө мултарч, хоцорч үлдэхээ бодно. Үүнээс болж эмх замбараагүй, хариуцлагагүй, хяналтгүй байдал газар авч буцаад арслан дүртнүүд засгийн эрхийг авна.

Парето арслан хэв шинжийн удирдлагад тираны үеийн Грекийн политийн төр, Спарт, Август болон Тиберийн үеийн Римийн төр, абсолютизмын үеийн европын олон төрийн эрх баригчид хамааруулсан бол үнэг хэлбэрийн элитийн жишээнд Афины демагог¹⁴, Римийн аристократууд, бүх бүгд найрамдах улсуудын төрийг оруулжээ. Цаашлаад элит нь байнгын өөрчлөгдөж шинэчлэгдэж байх ёстой, хэрэв ингэхгүй бол нийгмийн хөгжил удаашралд орох бөгөөд энэ үйл явцыг тэрээр “Элитийн циркуляци¹⁵” онолоор тайлбарлажээ. Энэ нь угтаа элитийн “цус сэлбэлт” гэсэн санаа юм. Элитийн цус сэлбэлтийн удаашрал нь ялангуяа арслан дүрт удирдагчид төр барьж буй үед илүү ажиглагдана. Хэрвээ элитийн циркуляци явагдахгүй удвал хувьсгалд хүргэх нэг шалтгаан болно.

Элитийн онолыг шинэ шатанд гаргагчдын нэг Г.Моска /1853-1941/ бүх соёл иргэншилт нийгэмд удирдагч болон удирдуулагч гэсэн хоёрхон анги байна. Удирдагч анги нь үргэлж цөөн тоотой, цөөн учраас зохион байгуулагдах чадвартай, улс төрийн бүх үүрэг хариуцлагыг хүлээж, засгийн эрхийг барьдаг, удирдуулагч анги нь олон тоотой, олон учраас эмх замбараагүй, зохион байгуулалтгүй, тэд үргэлж цөөнхийн хяналтанд байдаг гэжээ. Г.Моска элитэд орох шинжүүдэд цэргийн гялалзсан амжилт, эд баялаг, гарал үүсэл, оюун ухаан, эрдэм боловсрол, авьяас билгийг оруулсан. Нийгэмд засаглалаа хэрэгжүүлэх явдал нь эрх баригч ангийн нөхөгдөх чадвараас хамаарна. Моска энэ чадварыг гурав ангилсан. Үүнд:

- Өв уламжлагдах
- Сонгогдох
- Кооптаци /нэмэгдэн орох/

Элитийн онолд Германы судлаач Р.Михельс үнэтэй хувь нэмэр оруулсан. Нийгмийн харилцааг судлах явцдаа тэрээр олон түмний шууд ноёрхол, шууд ардчилал бол бодит амьдрал дээр хэрэгжих боломжгүй, учир нь олон түмэн заавал ямар нэгэн цөөнхөөр дамжуулж /Үйлдвэрчний эвлэл, улс төрийн нам/ засгийн эрх барьдаг бөгөөд энэ нь хөдлөшгүй мөнхийн гэснээрээ тэрээр “олигархийн төмөр хууль”-ийг боловсруулжээ. Өөрөөр хэлбэл түүхийн бүх үед, ардчилсан төрийн үед ч гэсэн засгийн эрхийг цөөнх барих нь хөдлөшгүй төмөр хууль лугаа адил гэсэн санаа юм.

¹⁴ Зорилгодоо хүрэхийн тулд ямар нэгэн худлаа мэдээллийг ашиглах гэсэн утгатай Грек үг.

¹⁵ Эргэлт, эргэлдэх хөдөлгөөн гэсэн латин үг.

Шалгарсан шигшмэл хүмүүсийн бусдаас онцгой авъяас чадвартай байдгийн цаад шалтгааныг байгаль дэлхий, газарзүйн нөлөөлөлтэй холбож тайлбарладаг онолууд хүртэл байдаг бөгөөд энэ нь улс орны нийгмийн хөгжил хөдөлгөөнд хүртэл нөлөөлдөг гэсэн үзэл баримтлалын гол ухагдахуун болтлоо хөгжсөн байдаг. Тухайлбал Оросын эрдэмтэн Л.Н.Гумилевийн /1912-1992/ “Эрчим хүчний онол” хэмээх нийгмийн үзэгдэл, үйл явцыг байгаль дэлхийгээс авах биохимийн эрчим хүч, байгаль цаг агаартай холбон үздэг, тэрчлэн нийгмийн шинжтэй хүчин зүйлүүдийг харьцуулан тайлбарладаг үзэл баримтлалыг дурдаж болно. Түүний үзлээр бол аливаа улс үндэстний хөгжил нь:

- Эрчимт хүмүүс
- Тэгш хүмүүс
- Аминч хүмүүс

хоорондын зөрчил, тэмцлийн түүх бөгөөд эрчимт хүмүүс гэдэг нь байгаль дэлхийгээс орж ирсэн эрчим хүч нь байвал зохих хэмжээнээсээ хэтэрч давсан гарамгай суут маягийн хүмүүс юм. Харин аминч хүмүүс гэж амьдрах хүч нь тэрхүү хэмжээнд хүрэхээ больж багассан хүмүүс байдаг бол тэгш хүмүүс гэж эрчим нь хэвийн хэмжээнд хүртэл буурч чадсан, эсвэл тийм хэмжээнд байна шахам байдаг хүмүүс болно.

Эрчимт хүмүүс улс орон ард олныхоо төлөө өөрийн амь амьдралыг эс хайрлан, улс үндэстнийхээ бие даасан байдал, тусгаар тогтнол, хөгжил дэвшилд саад бологч бүхэнтэй хайр найргүй тэмцэл хийнэ. Энэ нь тэдний байгаль дэлхийгээс авах эрчим хүч нь ихэдсэнийх агаад тэдгээр хүмүүс уг эрчимт хүч хэвийн байдалд орон ортол тэмцэл тулалдаанаа үргэлжлүүлнэ. Аминч хүмүүс нь байгаа амьдрах хүч нь байвал зохих хэмжээнээсээ доошилож багассан, зөвхөн хувиа бодож, амиа аргацаах төдийхөн хүсэл тэмүүлэлтэй, энэ чиглэлийн зорилгоо биелүүлэхийн төлөө юугаа ч өгөхөөс буцахгүй, улс орон, үндэстнийхээ бие даасан байдал, ард олныхоо эрх ашгыг ч золиослон улайрсан тэмцэл хийдэг хүмүүс юм. Үүний зэрэгцээ эрчим хүч нь хэвийн хэмжээнд хүртэл буурч чадсан, эсвэл тийм хэмжээнд байнга шахуу байдаг хүмүүсийг тэгш хүмүүс гэнэ. Улс үндэстэн цэцэглэн мандаж буй оргил үед үед хүн амын ихэнхийг нь эрчимт хүмүүс бүрдүүлсэн байдаг бол гудайлтын үед тэгш хүмүүс, харин уруудан доройтож буй үед аминч хүмүүс хүн амын ихэнхийг эзэлдэг¹⁶ хэмээн эрчим хүчний онолд дурджээ. Эрчимт хүмүүс улс үндэстэн задран бутарч, мөхөх сүйрэхийн ирмэгт тулж ирсэн, одоогийнхоор нийгэм эдийн засаг хямарсан үед энгийн бие хүний оюуны хүч чадал, сэтгэлийн тэнхээ хүрч эс чадах агуу зорилгыг ухааран ойлгож, улмаар түүнийг шийдвэрлэж чадсанаар улс түмнээ сүйрлээс авардаг хүмүүс юм. Эрчимт хүмүүс ийм л нөхцөлд гарч ирэн амь насаараа дэнчин тавин байж, тэмцэлдсээр ялан дийлж өөд гарах авч ихэнх нь үүргээ гүйцэтгэмэгц ямар нэгэн шалтгаанаар амь эрсдэнэ, эсвэл нийгмийн идэвхтэй амьдралын хүрээнээс зайлуулагдана, эсвэл эсвэл үүргээ гүйцэтгэж тэмцэл хийж байхдаа

16 Н.Хавч “Нийгмийн гүн ухаан” 103 дахь тал. УБ., 1996

амь үрэгдэнэ. Гегелийн хэлснээр “Тэд жаргал цэнгэлийн төлөө төрсөн улс биш, тэдний бүхий л амьдрал нөсөр хөдөлмөрөөр дүүрэн, энэ бүхний цаана тэдний хүслэн, тэмүүлэл бий. Зорьсон хүссэндээ хүрмэгц тэд бүхэн үрнээс түүний хальс салж унах лугаа адил үгүй болно. Тэд Александр шиг эрт өөд болцгооно, тэднийг Цезарь шиг эрт амийг нь хорооно, эсвэл тэднийг Наполеоныг ариун Елены аралд цөлсөн шиг цөлнө.”¹⁷

Төрийн дээд эрх мэдлийг зөвхөн шалгарсан шилдгүүд барих ёстой, тэд бусдаас онцгой гэсэн үзэл санаа нь орчин үед засгийн бүх эрхийг ард түмэнд гэсэн ардчилсан үзэлтэй зөрчилдөх боловч улс орны хувь заяаг залуурдан жолоодно гэдэг нь хэн нэг дуртай хүний хийх ажил биш, асар хүнд хэцүү, мөртлөө маш нэр хүндтэй, тал бүрийн мэдлэг, чадварыг шаардсан ажил бөгөөд энэхүү бүхий л хүнд хөдөлмөрийг үүрэхийг зөвшөөрсөн хүн л тэрхүү өндөр албан тушаалыг хаших ёстой гэдгийг сануулах нь энэхүү өгүүллэгийн зорилго байв.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Ж.Вольф “Улс төрийн философийн удиртгал” УБ 2002
2. Аристотель “Политика” 1983 онд хэвлэгдсэн түүвэр зохиолын 4-р боть
3. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2001
4. Д.Наран “Монголын төр ёсны боловсролын түүх” УБ 2001
5. МУИС Политологи сэтгүүл №14 Ц.Батболд “Их Монгол гүрний төрийн байгуулалт: Анхны холбооны улсын загвар” 57 дахь тал
6. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2001
7. Н.Хавх “Нийгмийн гүн ухаан” УБ 1996
8. Г.В.Ф. Гегель. Философия историй. СПб. 1993
9. Арван буянт номын цагаан түүх” Монголын түүхэн сурвалж бичиг 2-р боть УБ 2006
10. Ч.Жүгдэр “Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ” /Эртнээс XIV зуун хүртэл/ УБ 1984

¹⁷ Г.В.Ф. Гегель. Философия историй. 83 дахь тал. СПб. 1993 Дам шиллэл

ТӨРИЙН ТҮШЭЭДИЙГ ШИЛЖ, СОНГОХ ТӨРТ ЁСНЫ УЛАМЖЛАЛ

А.Болормаа

ШУТИС. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн
Нийгмийн ухааны салбарын ахлах багш, доктор (Ph.D)

Монголчууд эрт дээр үеэс хүчирхэг төртэй, “Далай их Монгол” улсыг байгуулан уудам нутаг дэвсгэртэй улс орон байсны хувьд менежментийн асар их өвтэй орон гэж бусад орны менежмент судлаачид үздэг билээ.¹ Монголын менежментийн энэ их өв, түүхэн туршлага нь төрт ёсны үүсэлтэй салшгүй холбоотой. Монголын төрт ёсны түүхэн уламжлал нь нүүдэлчдийн анхны төрт улс болох Хүннүгээс үүссэн гэдгийг олон судлаачид өөрсдийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, А.Цанжид “...Өдгөө монголын тулгар төр Хүннү гүрнээс эхлэлтэй гэж албан ёсоор үзэх болжээ”² гэжээ.

Хүннүгийн үеэс төрт ёсны нэг бүрэлдэхүүн болох төрийн түшмэдийн тогтолцоог бий болгосон гэж үздэг. Монголын төрт ёсны түүхэн уламжлалд төрийн хүний шинж төрх, эрдэм мэдлэг, гавьяа зүтгэл гаргах чадварыг чухалчлан үзсэн түшмэл ёсны тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлж иржээ.³ “Хүннүгийн үеэс түшмэдийн ёсон үүссэн”⁴ гэж Т.Дорж, Г.Батхүрэл, Х.Пүрэвдагва нарын эрдэмтэд хамтын бүтээлдээ дурдсан байна. Тухайн үеийн хаадаас Модун Шаньюй, Аттила хаан хийсэн үйл хэрэг, байгуулсан гавьяа, төрт ёсны түүхэнд оруулсан хувь нэмрээрээ ихэд алдаршсан байна. Тухайлбал, Аттила хаан төрийн удирдах албанд хүнийг томилогдоход тавигдах шалгуурт ихээхэн ач холбогдол өгдөг байсан бөгөөд энэ нь Хүннү гүрэн оршин тогтнохын чухал үндэс гэж үздэг байсан нь “Хүннүчүүд бид үүрэг хариуцлагаа чандлан биелүүлж чадах эрдэм чадал, хүч боломжтой, чин зүтгэлтэй удирдагчдыг удирдлагын түвшин бүрд тохоон томилох нь бидний Хүннү гүрэнд амин чухал болой” хэмээн сургамжилж байснаас харагдаж байна.⁵

Монголын төрт ёсонд түшмэл бол төрийн дам нуруу хэмээн үзэж, онцгойлон түшмэл болсон хүн бол нэгэнт өөрийгөө төрд хүчин үнэлэхээр худалдагдсан бие хэмээн ойлгож нэгэн үзүүрт сэтгэлээр төрийн хэрэгт зүтгэх ёстой гэж үздэг

1 Менежмент. Сурах бичиг. ШУТИС. УБ., 2019. 75 дахь тал

2 Цанжид А., Монголын төрт ёс. УБ., 2019. 42 дахь тал

3 Байгал Д., Төрийн захиргааны албан тушаалд шаардлагатай мэдлэг, чадварын судалгаа. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2013. 54 дэх тал

4 Монгол улсын шинжлэх ухаан: Менежментийн ухаан. 35 дахь боть. УБ., 2010. 36 дахь тал

5 Байгал Д., Төрийн захиргааны албан тушаалд шаардлагатай мэдлэг, чадварын судалгаа. Удирдахуйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2013. 56 дахь тал

нь төрд түшмэлийн эзэлдэг байр суурь, ач холбогдлыг тодорхойлж байна.⁶

Монгол төрт ёсны уламжлалын нэг чухал зүйл нь хүнийг эрдэм чадал, үнэнч шударга, ажилч хичээнгүй чанараар нь шилэн сонгож төрийн албанд томилдог ёс юм. Төрийн зүтгэлтэн, төрийн бодлоготон, төрийн түшмэдийг бага залуугаас нь эхэлж бэлтгэж, зааж сургаж, тодорхой шалгуур хангасан, бэлтгэгдсэн хүмүүсийг сонгон төрд алба хаших боломж олгодог байв. Тийм ч учраас төрд алба хаших хүн ямар байх ёстойг ухамсарласан, итгэл үнэмшилтэй, бэлтгэгдсэн, боловсролтой хүмүүс гардаг байжээ.

“XX зууны эхэн үеийн монголын улс төрийн нэрт сэтгэгч” Дандаа буюу Дэмчигдорж “Монгол төрийн түшээ хүний шинжийг шударга, үнэнч байх явдал гэж тодорхойлсон. Тэрээр төрийн албан хаагч “шударга, гэгээн, цээр хэмээх гурван үгсийг сахиж чадваас” ажил үйлс нь өөдрөг бүтэлтэй байх тухай өгүүлсэн байна. Дандаа буюу Дэмчигдорж “төрийн албыг хаших баг бүрдүүлэхдээ нутаг ус, жалга довын үзэл зэргийг цээрлэн, шударга ёс, гавьяа зүтгэлийг баримтлах ёстой бөгөөд шударга ёс, хуулийг баримтлан ажиллавал улс орон хөгжинө”⁷ гэжээ.

Монголын төрт ёсны түүхэн хөгжилд Чингис хааны төр барьж байсан үе онцгой байр суурь эзэлдэг. Америкийн “Leader value” хэмээх зөвлөгөө өгдөг компанийн ерөнхий зөвлөх Мик Эйч Чингис хааны манлайлан удирдах аргыг “4E” хэмээх томъёололд оруулан тайлбарласан байна. Түүний үзэж байгаагаар Чингис хаан ер бусын алсын хараа, холч бодлоготой (envision), түүнийгээ хэрэгжүүлэх асар өндөр чадвартай (enable), эрч хүчтэй (energize), эрх мэдлийг доод шатны удирдлагад итгэн хүлээлгэдэг (empower) удирдагч байжээ.⁸

Германы эрдэмтэн Удо Б.Баркманн “ямар хөдөлгөгч хүч чухамдаа нүүдэлчдийн жижигхэн нийгмийг дэлхийн эзэнт гүрэн байгуулахад хүргэсэн бэ?” гэсэн асуултыг “Чингис хааны судлал Өрнөдөд” өгүүлэлдээ (2009) хөндөн тавьсан байна. Тэрээр энэ асуултынхаа хариулт болгон “Чингис хаан болон тэр үеийн Монголын элитүүдийн суу билиг, юм сурах онцгой чадвар, авхаалж сэргэлэн ухаан нь Барууны эрдэмтдийн анхаарлыг байнга татаж байдаг ер бусын үзэгдэл болно”. Энэ асуултын хариулттай дүйцэхүйц санааг бүр XIII зууны сүүлч XIV зууны эхээр Персийн түүхч Рашид-Ад-дин “Судрын чуулгандаа “Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэхээр Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно”⁹ гэсэн байна.

6 Цанжид А., Монголын төрт ёс. УБ., 2019. 257 дахь тал

7 Энхбат А., Их эрдэмтэн Дандаа хэмээх Дэмчигдорж. УБ., 2005. 38-42 дахь тал

8 Шуурав Я. Нарын. Менежментийн шинэ парадигм: төлөвшил, хөгжлийн үндсэн хандлагууд. УБ., 2014. 240 дэх тал

9 Нарангэрэл С., Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шашидир. УБ., 2014. 8 дахь тал

Солонгосын эрдэмтэн Ким Жон Рэ Чингис хааныг жолоодогч хувь хүнийх нь хувьд судлан түүний дүр төрхийг үндэс угсаагаа дээдлэн мөнхжүүлэгч, зовлон бэрхшээлийг ялан дийлэгч, ачтан, цэргийн аугаа их жанжин, аугаа их улс төрч, бүтээн байгуулагч хэмээн тодорхойлжээ. Эдгээр жишээнээс дүгнэхэд монголын төдийгүй гадаадын олон эрдэмтэн судлаачид Чингис хааны менежментийн талаар судалж байсан байна.

Чингис хаан төрийн албыг бүрэлдүүлж төлөвшүүлэхэд эрдэм ухаан, авьяас чадвар, билиг арга сайтай, сэтгэл оюун уужим, бодож сэтгэх нь саруул, туршлага хатуужилтай хүмүүсийн хүч чадлыг дээдэлж ашиглах бодлого баримталсан нь төр улсыг бэхжүүлэх нэгэн чухал хүчин зүйл болсон ажээ.¹⁰ Монгол үндэсний хүчирхэг улс байгуулах нэг чухал шаардлага нь төрийг мэдлэг, ур ухаан, өндөр сахилгатай, хатуужсан, төлөвшсөн, үнэнч шударга түшээгээр хангах явдал бөгөөд энэхүү нөхцөл шаардлагыг хангах төрийн хүч хэрэгсэл нь Их засаг хууль байна хэмээн үзэж түүнийг чандлан мөрдсөн нь Чингисийн эзэнт улсын төрийн жолоог барих гол түлхүүр нь болсон байна. Их засаг хууль нь тухайн үедээ төгс боловсрогдсон, хууль цаазат төрийн үндэс болсон хууль төдийгүй түүнийг хэзээ ч өөрчлөхгүй байхыг Чингис хаан үр удамдаа зарлиг болгосон нь түүний ач холбогдлыг илтгэж байсан. Аливаа хэргийг мэдэгч нь хэдийгээр эрх мэдэлтэй байвч, үйл ажиллагаандаа эзэн хааны зарлиг, хуулийг ёсчлон дагаж байх учиртай байлаа. Удирдлагын үйл ажиллагаа хуулийн хүрээнээс хэзээ ч хальж үл болохыг Чингис хаан чандлан сахиж байсан юм.¹¹

Чингис хааны удирдлагын харилцааны амжилтын нэг чухал үндэс нь төрийн албанд тавигдах шаардлагад “авьяас чадвар, эзэндээ үнэнч чанар” зэрэг хандлага, ур чадварт хамаарах шалгуурыг чухалчилж, мэдлэг чадвартай хүнийг язгуур угсаа, дайсны тал гэж ялгалгүй төрийн доод түвшний албан тушаалаас дээд түвшний албан тушаал хүртэл томилдог, хэрэв чадахгүй бол албан тушаалыг хураадаг байсан явдал юм. Тэрээр тухайн хүний гүйцэтгэх ур чадвар, ёс суртахууны байдлыг эн тэргүүнд тавьдаг байжээ. Зөв хүнийг зөв албан тушаалд зөв цагт нь язгуур угсаа, хүний өөрийн гэж ялгалгүй шударгаар томилж, төрд үнэнчээр зүтгэх нөхцөлийг бүрдүүлдэг байсанд Чингис хааны давтагдашгүй амжилтын нэг чухал хүчин зүйл нь оршиж байсан.¹²

Энэхүү зарчим нь монголчуудын үе үеийн төрд дамжин уламжлагдаж ирсэн бөгөөд өнөөгийн төрийн эрхэм нандин өв, уламжлал төдийгүй мэргэшсэн, чадварлаг албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэх “чадахуйн” буюу мерит зарчмын үндсэн суурь гэж үзэж болно.

10 Дашиям Н., Монгол улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. УБ., 2005. 300 дахь тал


11 Пүрэвдагва Х., Чингис хааны менежментийн товчоон. 2 дахь хэвлэл. УБ., 2020. 53 дахь тал

12 Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн явц, үр дүн, хандлага. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2014. 17 дахь тал

Чингис хаан түшмэл хүний есөн эрдмийн дотор түвшин сэтгэлийг эрхэмд үзэж, тал засдаг бялдууч зан, овжин зальхай, сувьдаг шунахай араншныг зэвүүцэн жигшиж, “эрхэм өршөөлт эзэн улсын эрдэнэ, эрх ухаант сайн түшмэл төрийн эрдэнэ” гэж хүндэтгэн дээдэлж иржээ. Тиймээс “төрийн босго өндөр байх нь Чингис хаан “биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэж сургасантай холбоотой юм. Биеэ зөв засаж, оюунлаг өмч бий болгосон хүнд гэрээ засах асуудал хүнд биш. Гэрээ засна гэдэг нь хэнээс ч үл хамаарах эрх мэдэл, өмчтэй байхыг хэлнэ. Гэрээ засах урлагт суралцаагүй, тэгш эрхтэй байрын баталгаа болсон оюунлаг өмчөө бүрэлдүүлж эзэмшээгүй хүн төрд мугуйдлан зүтгэх нь төрийн албаны ёс, гүн хүндэтгэлийг доройтуулж, төрд бишрэх олны сэтгэлийг сэвтүүлж хямруулдаг.¹³ Энэ уламжлалыг батагтан зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт түшмэлийг сонгон шалгаруулах, дэвшүүлэн томилох, албан тушаал, цол хэргэмийг бууруулах, халах журмыг хуульчлан тогтоож байсан байна.

Чингис хааны үйл ажиллагаа, удирдлагын ур чадварын талаар бичсэн хүн бүр түүний хүнийг олж, төрд хэрэглэх чадварыг нь юуны өмнө дурдаж, өндөр үнэлсэн байдаг билээ.¹⁴ Хүнийг зөв таньж сонгоход нь ихэнх сод хүмүүст байдагтай нэгэн адил хүний сэтгэлийн дотоод ертөнцийг таних, зан чанарыг нь таних, мэдрэх авьяас нь нөлөөлж байжээ. Үнэнч сэтгэл, шударга зан, тэсвэр хатуужлыг тэрээр буянт үйл, ач тус гэж үздэг байсан байна. Харин урвалт, итгэл эвдэлт, хулчгар занг гэмт явдал хэмээн үзэн яддаг байжээ. Чингис хаан эдгээр шинжүүдээр хүмүүсийг 2 ангилалд хуваажээ.¹⁵

Зураг 1. Хүмүүсийг сэтгэл зүйн хэв шинжээр ангилсан нь



Эх үүсвэр: (Пүрэвдагва Х., 2015)

¹³ Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн явц, ур дүн, хандлага. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2014. 26 дахь тал

¹⁴ Цанжид А., Монголын төрт ёс. УБ., 2019. 153 дахь тал

¹⁵ Пүрэвдагва Х., Менежмент: бүтээлийн эмхэтгэл. УБ., 2015. 245 дахь тал

Сэтгэл зүйн хоёрдох хэв шинжийн хүмүүсийн сэтгэл зүрхэнд ёс зүйн хэм хэмжээ байсан буюу дэг журамд захирагдах гүн бишрэлтэй байжээ. Их эзэнт гүрний хэмжээнд сэтгэл зүйн ийм хэв шинж бүхий хүмүүсээр бүрдсэн удирдлагын шатлалыг бүрэн тогтоож байв. Чингис хааны хүч чадлын амин сүнснийг бүр XIII зууны үед тухайлбал, Персийн түүхч Жувейни түүний "сүр хүч", "төрөлхийн соргог чанар" гэсэн бол Марко Поло "шулуун шударга зан, энэрэнгүй ивээл"-д байна гэж үзжээ. Харин Рашид-ад-дин "ёс суртахуун"-д байна гэсэн байна. Эдгээр нь бүгд ёс суртахуунтай холбоотой ба Чингис хаан ийнхүү ухаан цэцэн, ард олон, улс эх орноо гэсэн чин сэтгэлтэй, шударга үнэнч, ёс зүйтэй хүмүүсийг төрд сонгон авдаг байжээ.¹⁶

Удирдагч хүн эрдэм чадалтай хүнийг сонгон олж төрийн хэрэгт ашиглая гэсэн эрмэлзэлтэй л байвал тийм хүн хэзээд олох ба тийм эрмэлзэлгүй бол мянган сайн хүн байгаад ч тусгүй гэж үздэг. Чингис хаан хийлгэх гэж буй ажилд нь тэнцэх, түүнийг хэрхэн хийхийг мэддэг, шударга хүмүүсийг томилж байсан нь олон тодорхой баримт байдаг ажээ. Жишээ нь балгасны төр ёсыг мэддэг хүн хэмээн Махмуд Ялавач эцэг хүүгээр хотын дарга тавьж байжээ. Аль нэг өөр хүнийг байгуулсан гавьяаных нь төлөө ч юм уу, ойр дотно, төрөл гэх мэт шалгуураар хотын дарга тавьсан бол ажил хэрэг хохирох магадлалтай. Сайн хүнийг олж, түүнд итгэл хүлээлгэн, эрх өгч чухал ажлыг гүйцэлдүүлэх нь одоо ч удирдлагын үр нөлөөтэй арга юм.

Чингис хааны давуу тал нь өөрөө мэдэхгүй юмыг нь мэддэг хүмүүсийг олж төрийн хэрэгт зүтгүүлэхийг эрхэмлэдэг зарчимтай байсан байна. Хэчнээн агуу хүн байлаа ч нэг хүн бүгдийг мэддэг, чаддаг гэж үгүй тул шударга үнэнч, хүнийг олж тавихын тулд түүнийг янз бүрийн нөхцөлд шинжиж, ажигладаг байжээ.¹⁷ Хүнийг ажил хэргийн үр дүнгээр шалгаруулж байх тухай түүний сургаалыг ном сударт олонтгоо тэмдэглэсэн байна.

Монголын менежмент, төрт ёсны хөгжилд Чингис хааны үе залгамжилсан Алтан ургийн хаадууд тодорхой хувь нэмэр оруулсан. Хубилай, Батмөнх даян хаан, Лигдэн хаан зэрэг эрдэм мэдлэгтэй хаадууд эрдэм номын сургууль байгуулж, залуу үедээ мэдлэг боловсрол олгох, ном шасдир хэвлүүлж түүх соёлоо тэмдэглэн үлдээх, үйлдвэр, хот барьж байгуулах зэрэг үйлдвэрлэл, нийгмийн асуудлаа хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байжээ.¹⁸ Өгөдэй хаан олон түмний нийгмийн хамгааллын асуудалд ихээхэн анхаарч, Чингис хааны үед өнчдийг ивээх сан байгуулсныг өргөтгөн, ядуучуудад тусалж байхаар тогтоосон байна. Тэрээр сүм хийд, цэрэг иргэн, зах зээлийн газраар байнга явж хүмүүстэй уулзаж ярилцдаг байжээ. Өгөдэй хаан хүмүүсийг урамшуулан дэмжих, идэвхжүүлэх их мастер, бусдын төлөө санаа тавьдаг, эрдэм ухаанд төгс, өөрийн алдаа дутагдалд шүүмжлэлтэй ханддаг, зохион байгуулалт

16 Нарангэрэл С., Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шашидр. УБ., 2014. 21 дэх тал

17 Цанжид А., Төр барихуй монгол ухаан. УБ., 2011. 82 дахь тал

18 Менежмент. Сурах бичиг. ШУТИС. УБ., 2019. 78 дахь тал

сайтай удирдагч байсан байна. Тулуй хаан ухаалаг, хүмүүнлэг, үнэнч улс төрийн бодлоготон байжээ. Монголын хаант төрийг түвшин байлгах гэсэн чин эрмэлзэлтэй ажилладаг, аливаа асуудалд зөвшилцлийг эрхэмлэдэг, зорилгынхоо төлөө тууштай, шийдвэрийг нөхцөл байдалд тохируулан зөв гаргаж чаддаг, бусдыг дэмжин ажилладаг хаан байв. Гүюг хаан төрд үүссэн завхайрлыг засаж, төрийн хүчийг сэргээх бодитой ажил хийж, хууль цааз, татварын бодлого, албанд томилох зарлиг шийдвэр зэргийг журамлаж, хуралдайн бэлтгэл, зохион байгуулалт бий болгожээ. Мөнх хаан багаасаа удирдах арга барилыг ажиглан суралцсан, асуудлын мөн чанарыг олохын төлөө зүтгэдэг, юманд ул суурьтай ханддаг, баг бүрдүүлэхдээ хянамгай, нягт ханддаг, эрдэмтэй хүмүүсээр хүрээлүүлж, тэднийг улс орны ажилд дайчилж чаддаг байсан байна.

Их Юань улс (1260-1368)-ын үед төрийн удирдлага, эдийн засаг, аж ахуйн удирдлагын баялаг туршлага хуримтлагдсан бөгөөд төрийн хаан, сайд, түшмэдийн аж ахуй, удирдлагын чиг үүрэг тодорхой, төрийн хэргийг удирдан зохион байгуулах гүйцэтгэх засаглалын чиг үүргийн байгууллагуудыг байгуулжээ. Энэ үед монголын төрд гүйцэтгэх эрх мэдлийн бүтэц, зохион байгуулалт хэлбэржин тогтож эхэлсэн. “Хэдийгээр Монгол нутагт тогтож байсан эртний улсууд болон Их Монгол, Монголын Юань улсын хаадын гарт гүйцэтгэх эрх мэдэл төвлөрч байсан боловч гүйцэтгэх эрх мэдлээ хэн нэгэн итгэмжит шадар зүтгэлтэнд шилжүүлэн ончтой эдлүүлэх, уг эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ эрдэмтэн мэргэдийн зөвлөгөө, сургамжийг анхааран үзэж байсан өвөрмөц онцлогтой юм”.¹⁹

Юань улсын үед хаан ширээнд 34 жил хаан суусан Хубилай хаан цэргийн их жанжид, эрдэм мэдлэгтэй төрийн түшмэлүүд, эрдэмтэн мэргэдийг харийн хүн гэлгүйгээр хуран цуглуулж зөвлөгөө авахаас гадна идэр ахуй цагаасаа боловсрол мэдлэг эзэмшүүлсэн мэргэдээ хүндэтгэн, ач гавьяаг нь үнэлж байсан тул тэдгээр мэргэд ч хааны насан туршийн зөвлөгч, туслагч байжээ. Алсын хараатай жолоодогч хүний улс орноо хамгаалах ухааны нэгэн аргыг Хубилай сэцэн хаан хэрэглэж чадсанаар улс төрийн их холч бодлоготон гэдгээ харуулсан. Манлайлагч хүн өөрийн баг, өөрийн хүрээлэлтэй байхын үлгэрийг үзүүлсэн агаад баг буюу төрийн зүтгэлтнүүдийг хүчээр албадан байгуулах бус, харин тэднээр хүндлүүлж, тэдний ажиллах эрхийг хангаснаар бүрдүүлж болохыг Хубилай харуулсан.²⁰

XVII зуунд манжийн эрхшээлд орсон үед удирдлагын сэтгэлгээний хөгжилд эерэг, сөргөөр бичигдэх олон түүхэн өөрчлөлтүүд гарчээ. Манжийн дарангуйллын үеийн монголын төрийн алба нь дангаар ноёрхогчдод үйлчлэх алба байсан. 1696 онд гарсан Монголыг дарангуйлан захирах Манжийн хааны

19 Лундээжанцан Д., *Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт*. УБ., 2014. 267 дахь тал

20 Батхүрэл Г., *Монголын эдийн засгийн удирдлагын сэтгэлгээний хөгжлийн судалгаа: онол, үзэл баримтлал, чиг хандлага. Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл*. УБ., 2011. 106 дахь тал

зарлигийн анхдугаар эмхэтгэлд албан хэргийг манж хэлээр хөтлөх, орон нутгийн дээд удирдлагыг манжаас томилдог, огцруулдаг, баталдаг байх, язгууртнууд ямар эзэмшил нутагтай, ямар цол хэргэм, ямба ёслолтой байх зэргийг нэг бүрчлэн зааж өгсөн байна. Чухам энэ үед монголын эзэнт гүрний үеэс эрхэмлэж ирсэн төрийн албаны үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ алдагдаж, хүнд сурталд автах, алдар нэр, албан тушаал хөөцөлдөх, хувийн жаргал цэнгэлийг эрхэмлэх зэрэг төрт ёсны уламжлалд цээрлэж ирсэн муу зуршил газар авч архагшсан байна.²¹

Монголчууд олон жилийн тэмцлийн дүнд 1911 онд үндэсний тусгаар тогтнолоо сэргээн VIII Богд Жибзундамбыг хаанаар өргөмжилсөн. Богд хаан гүйцэтгэн захирамжлах хэргийг чангатгахын тулд Бүгд Ерөнхийлөн шийтгэх яамыг байгуулсан нь нэг ёсны Сайд нарын зөвлөл байв. Тус яамны сайдаар Сайн ноён хан Намнансүрэнг томилсон нь үндсэндээ Ерөнхий сайдын албан тушаал бий болгожээ. Ийнхүү төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо, Засгийн газрын тэргүүнийг томилох ажиллуулах эхлэл тавигдсан байна.²² Богд хаант монгол улсын үед батлагдсан "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг"-ийн "Түшмэлийн засаг" гэсэн хэсэгт төрийн алба ямар байх ёстой, түшмэл хүнийг хэрхэн сонгон шалгаруулж, төрийн албанд авах талаар тодорхой заасан байна. Төрийн албанд түшмэлийг сонгон шалгаруулж дэвшүүлэхдээ эрдэм, сахилга, хэрэг, нас гэсэн дөрвөн зүйлийг иш үндэс болгож байхыг хуульчлан баталгаажуулсан байна.²³

Монголын төрт ёсны уламжлалаас судлан дүгнэхэд төрийн бүтэц, зохион байгуулалт нь илүү дутуу нүсэр шат дамжлагагүй, цомхон бөгөөд төр засах цөөн тооны тулгуур хуультай байж тэр нь тэгш үйлчилж ял, гавьяаг адил үзэж шударга оноодог, төрд эрдэм чадалтай, үнэнч шударга зүтгэл, чин санааг эрхэмлэдэг, түшээдийг нарийн шалгуураар сонгон авч тэдгээр хүмүүсийн хүчийг төр, ард түмнийхээ төлөө хэрэглэдэг, төрийн үйл ажиллагааны бүх шатанд итгэлийг голч бодлого болгож, тал тохой татах, далд муу заль хэрэглэдэггүй, ил тод, шулуун шударга үйл ажиллагааг эрхэмлэж ирсэн явдал юм. Энэхүү зарчим нь монголчуудын үе үеийн төрд дамжин уламжлагдаж ирсэн бөгөөд өнөөгийн төрийн эрхэм нандин өв, уламжлал төдийгүй мэргэшсэн, чадварлаг албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэх "чадахуйн" буюу мерит зарчмын үндсэн суурь гэж үзэж болно.

Монголчуудын төрт ёсны уламжлалд орчин үеийн удирдахуйн ухааны болон төрийн удирдлагын ухааны үндсэн зарчмууд багтаж байгааг олон судлаачид нотолж байна. Энэ бүхэн нь монголчууд дэлхийн удирдахуйн ухааны өв санд оруулсан хувь нэмэр юм.

21 Төрийн албаны үнэт зүйлс: Тулгамдаж буй асуудлууд. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2018. 14 дэх тал

22 Батхуяг Д., Богд хаант Монгол улсын төрийн байгуулал. Төрийн захиргаа сэтгүүл. 2011. Тусгай дугаар. 19 дэх тал

23 Төрийн албаны үнэт зүйлс: Тулгамдаж буй асуудлууд. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2018. 14 дэх тал

ХҮНИЙ ЭРХ



ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ: МОНГОЛ УЛСАД ЦАРАЙ ТАНИХ КАМЕР ШААРДЛАГАТАЙ ЮУ?

Л.Галбаатар

Хуульч, судлаач

Ирэх таван жилд Монгол Улсын иргэдийг бүгдийг нь хууль сахиулах байгууллагаас царай таних камераар хянахаар болсон. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2020.08.28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 7.4.1-т “дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна” гэж заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 115-д “Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх” ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцаж 2025 он хүртэл хэрэгжүүлэх, ингэхдээ 106,3 тэрбум төгрөгийг зарцуулах ба санхүүжилтийн эх үүсвэр нь гадаадын зээл, тусламж /хөнгөлөлттэй зээл/ байна гэжээ.

Энэ нь Монгол Улс дахь бүх хүнийг гэмт хэрэгтэн байж магадгүй гэж сэжиглэж, камераар хянах нөхцөл болж байна. Иргэдийн хувьд хэрэг хийгээгүй мөртлөө хэрэгтэн мэт хэзээ, хаагуур явж байгаа, хэнтэй уулзаж байгаагаа байнга мөрдүүлэх нөхцөл байдалтай болохоор байна.

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга О.Чинзориг ярилцлагадаа “Холбогдох байгууллагууд шаардлагатай үед болон сэжигтэй тохиолдолд хүнийг царайгаар эсхүл хөдөлгөөн, үйлдэл, өндөр, нам, явдал гэх мэт шинж чанараар нь таних, хайх боломжтой технологийг нэвтрүүлнэ” гэж хэлсэн. Тэгэхээр энэ хяналтын камер нь зөвхөн царай биш, хүний хөдөлгөөн, үйлдлийг нь бас хянах нь ээ. Гэмгүй хүн хирнээ хэрэгтэн мэт царайтай, эвгүй хөдөлгөөнтэй хүнийг энэ камераар сэжиглэж, шалгах эрсдэлтэй болж байна. Энэ хяналтын

камерын үйл ажиллагаа нь хүнийг мөрдөн мөшгиж байгаа хэрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т зааснаар хүн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч мөрдөн мөшгихийг хориглоно. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах зохицуулалт бий. Тус зүйлийн 21.5-д “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй” гэж, 21.6-д “Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй” гэж тус тус заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн

***Монгол Улс дахь
бүх хүнийг гэмт
хэрэгтэн байж
магадгүй гэж
сэжиглэж, камераар
хянах нөхцөл болж
байна. Иргэдийн
хувьд хэрэг
хийгээгүй мөртлөө
хэрэгтэн мэт хэзээ,
хаагуур явж байгаа,
хэнтэй уулзаж
байгаагаа байнга
мөрдүүлэх нөхцөл
байдалтай болохоор
байна.***



1-т энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч мөрдөн мөшгихийг хориглоно гэж заасан. Мөн тус хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3-т зааснаар мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр явуулна. Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Мөн эрх бүхий албан тушаалтан хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгисэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эндээс үзэхэд, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалахын тулд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хуульд дараах шаардлага тавьсан байна.

-Хүнийг мөрдөн мөшгиж болохгүй.

-Хүний дүрс буюу царайг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр дүрс бичлэгт буулгаж болохгүй.

-Прокурорын зөвшөөрөлгүйгээр хүнийг техник хэрэгсэл /царай таних камер/ ашиглан мөрдөн мөшгиж болохгүй.

Энэ нь зөвхөн дотоодын хууль тогтоомжоор тогтоосон шаардлага бус, олон улсын эрх зүйн хэм хэмжээ юм. Тодруулбал, Монгол Улс "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ад 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд хүний халдашгүй байх эрхийг "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй" гэж зохицуулсан. Энэ заалтыг 1988 онд НҮБ-ын Хүний эрхийн хорооны 32 дугаар чуулганаар баталсан Ерөнхий зөвлөмжид тайлбарлажээ. Энэхүү тайлбарт дурдсанаар,

-“Хорооны үзэж буйгаар энэхүү халдашгүй чөлөөтэй байх эрх нь төрийн эрх бүхий байгууллага, хувь хүн, хуулийн этгээд зэрэг хэн бүхнээс дур зоргоор, хууль бусаар халдахаас хамгаалсан баталгаа юм. Энэхүү баталгааг бүрдүүлэхийн тулд төрөөс хууль тогтоомж батлах, бусад үр дүнтэй арга хэмжээ авах үүрэгтэй. ...

-‘Хууль бус’ гэдэг нь хуульд зааснаас бусад тохиолдолд хөндлөнгөөс

оролцох боломжгүй гэсэн үг юм. Улс орнуудын зөвшөөрөгдсөн хөндлөнгийн оролцоо нь зөвхөн Пактын заалт, зорилго, зорилтод нийцсэн хуулийн үндсэн дээр л явагдаж болно...

-Хорооны үзэж байгаагаар 'хөндлөнгөөс дур мэдэн оролцох' ойлголт нь хуульд заасан хөндлөнгийн оролцоонд мөн хамаарна. Хуульд заасан үндэслэлтэй байх нь халдашгүй байх эрхэд халдах бүх халдлагыг зөвтгөхгүй бөгөөд тийнхүү халдах тохиолдол бүрийг зайлшгүй байсан эсэхэд үндэслэж дур зоргоороо авирласан эсэхийг тогтооно. ...

-Хууль ёсны хөндлөнгийн оролцоо нь Пактад нийцсэн байсан ч холбогдох хууль тогтоомжид тэрхүү хөндлөнгөөс оролцох боломжтой нөхцөл байдлыг нарийвчлан зааж өгөх ёстой. Ийм эрх бүхий хөндлөнгийн оролцоог зөвхөн хуульд заасан эрх бүхий байгууллага хэрэг тус бүрийн хүрээнд шийдвэрлэнэ. ... Эрх бүхий төрийн байгууллага хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг зөвхөн Пактад заасны дагуу нийтийн ашиг сонирхолд зайлшгүй шаардлагатай болох нь тодорхой нөхцөлд гаргуулж авч болно. ...

-Утас, телефон, бусад хэрэгслээр дамжих харилцан яриаг хөндлөнгөөс сонсох, бичлэг хийх зэргээр цахим болон бусад хэлбэрээр тагнахыг хориглоно. ...

-Төрийн байгууллага, хувь хүн, байгууллага хэн байхаас үл хамааран компьютер, өгөгдлийн төхөөрөмж болон бусад төхөөрөмж дээр хувийн мэдээллийг цуглуулах, хадгалахыг хуулиар зохицуулах ёстой. ...

-Хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг хүлээн авах, боловсруулах, ашиглах, хуулиар зөвшөөрөөгүй хүмүүсийн гарт хүргэхгүй байхын тулд улс орнууд үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд эдгээр нь хэзээ ч Пакттай үл нийцэх зорилгоор ашиглагдах ёсгүй. Хувь хүн бүр түүний файлыг төрийн захиргааны байгууллага, хувь хүн, байгууллага хянаж буй эсэх, эсвэл хянах боломжтой эсэхийг тогтоолгох боломжтой байх ёстой. Хэрэв эдгээр файл нь хувийн алдаатай мэдээллийг агуулсан, хуульд заасныг зөрчиж цуглуулсан, боловсруулсан бол хүн бүр түүнийг засуулах, устгуулах хүсэлт гаргах эрхтэй."

Хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг хүлээн авах, боловсруулах, ашиглах, хуулиар зөвшөөрөөгүй хүмүүсийн гарт хүргэхгүй байхын тулд улс орнууд үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд эдгээр нь хэзээ ч Пакттай үл нийцэх зорилгоор ашиглагдах ёсгүй.

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос холбогдох гомдлыг хянан хэлэлцэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн 1981-2019 оны 100 орчим шийдвэр бий. Голландын иргэн Н.К-гийн зүгээс түүний халдашгүй байх эрхийг Нидерланд улс зөрчсөн гэж үзэж Хороонд 2013.12.10-ны өдөр гаргасан гомдлыг Хорооноос холбогдох журмын дагуу хянан хэлэлцэж, 2017.07.18-ны өдөр шийдвэр гаргажээ. Хорооны зүгээс, хүний

ДНХ-ийн материалыг хэрэг мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгох зорилгоор ирээдүйд ашиглагдах мэдээллийн сангийн зориулалтаар цуглуулах, хадгалах нь Пактын 17 дугаар зүйлд заасан гомдол гаргагчийн халдашгүй байх эрхэд “хөндлөнгөөс оролцох” зөрчилд хамаарна гэж үзжээ. Хорооны зүгээс дээрх үйлдэл буюу хөндлөнгийн оролцоо нь дотоодын хууль тогтоомжоор хууль ёсны байж болох ч, Эрүүгийн хуульд заасан хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэргийг мөрдөн шалгах хууль ёсны зорилгод зохих хэмжээнд дүйцэхгүй байна гэж дүгнэжээ.

Хүний царай нь ДНХ-тэй адил хүний давтагдашгүй буюу онцгой өгөгдөл юм. Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий зохицуулалт”-ын 4 дүгээр зүйлийн 14-т зааснаар хувийн давтагдашгүй өгөгдөл гэдэгт хүний ДНХ, хурууны хээ, бичгийн хэв, царай төрх, алхаа, дуу хоолойн мэдээлэл багтана.

Эндээс дүгнэж үзэхэд, хүний царайг камераар таньж, хянахын тулд тэрхүү ажиллагаа нь хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, тохиромжтой байх гэсэн гурван шаардлагыг нэгэн зэрэг хангаж байх ёстой. Үүнтэй холбоотойгоор хүнийг царай, хөдөлгөөнөөр нь хянах камер хэр зөв, алдаагүй ажилладаг вэ, хүнийг хэлмэгдүүлэх эрсдэл бий юу, заавал царай таних камер ашиглах шаардлагатай юу гэх асуудал гарч ирж байна.

-АНУ-ын Үндэсний стандарт, технологийн институтээс тус улсад ашиглаж байгаа царай таних технологийн үйл ажиллагаанд иж бүрэн судалгаа хийхэд, Ази, Африкийн хүмүүс болон уугуул америкчуудын царайг буруу таньдаг, улмаар ийм хүмүүсийг хэлмэгдүүлэх эрсдэлтэй гэдэг нь нотлогдсон.

***Европын холбооны
“Өгөгдөл хамгаалах
ерөнхий зохицуулалт”-
ын 4 дүгээр зүйлийн
14-т зааснаар хувийн
давтагдашгүй өгөгдөл
гэдэгт хүний ДНХ, хурууны
хээ, бичгийн хэв, царай
төрх, алхаа, дуу хоолойн
мэдээлэл багтана.***

-Их Британийн independent.co.uk сайтад энэ оны 3 дугаар сард гарсан мэдээллээр, Лондонд 1 хүнийг баривчлахын тулд 13,200 хүний царайг сканардсан байна. Энэ нь царай таних технологийн алдаа гаргах магадлалыг илэрхийлсэн нэг үзүүлэлт юм.

-Мөн Их Британид энэ оны 8 дугаар сард Давж заалдах шатны шүүхээс “хууль сахиулах байгууллагын зүгээс царай таних камер суурилуулж ашиглах нь хүнийг мөрдөн мөшгиж буй хэрэг бөгөөд хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчиж байна” гэж шийдвэрлэжээ. Австрийн Үндсэн хуулийн шүүхээс мөн 2019.12.11-нд төстэй хэргийг адил үндэслэлээр “Үндсэн хууль зөрчсөн” гэж шийдвэрлэсэн байна.

-Энэ оны 9 дүгээр сард АНУ-ын Портланд хотын зөвлөлөөс царай таних камерыг төрийн байгууллагууд төдийгүй хувийн хэвшил ашиглахыг хориглолоо. Өмнө нь АНУ-ын Бостон, Сан-Франциско, Окланд хотуудад зөвхөн төрийн байгууллагад царай таних камер ашиглахыг хориглоод байв.

-Түүнчлэн Амазон, Майкрософт, АйБиЭм зэрэг технологийн томоохон компаниуд царай таних технологийг хууль сахиулах байгууллагуудад худалдахаа больж, түдгэлзээд байна.

-Энэ оны 9 дүгээр сарын эхээр Өвөрмонголд “Эх хэлээ аваръя” тэмцэлд оролцож буй өвөр монголчуудын нүүр царайг камераар таньж, тэдний зургийг, нэр усын хамт өнгөтөөр хэвлэн тарааж, мэдээллийг нь хуваалцсан хүмүүст өндөр шагнальтай гэсэн заруудыг тарааж, улмаар жагсагчдыг баривчилж эхэлжээ.

Энэ мэтээр царай таних камер ашиглах нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчих үр дагавартай тул түүнийг улс орнууд, байгууллагууд ашиглахаас татгалзсаар байхад Монгол Улсад яагаад царай таних камер ашиглах гэж зүтгээд байна вэ?

Нийслэлийн засаг даргын тамгын газрын мэдээллээс үзэхэд, царай таних камер суурилуулснаар Улаанбаатарт гэмт хэргийн гаралт 40-50 хувь буурах боломжтой гэж үзжээ. Гэвч нийслэлд хулгайн гэмт хэргийн 5 хувийг теле камераар илрүүлж, нотлох баримтаар ашиглаж байна. Энэ нь гэмт хэрэг ихэвчлэн ил үйлдэгдэггүй, нууц, далд

Энэ оны 9 дүгээр сард АНУ-ын Портланд хотын зөвлөлөөс царай таних камерыг төрийн байгууллагууд төдийгүй хувийн хэвшил ашиглахыг хориглолоо.

аргаар үйлдэгддэг бөгөөд гэмт хэргийн гаралт багасахад царай таних камер шууд хамааралгүй болохыг харуулж байна.

Энэ оны 1 дүгээр сард TheDiplomat.com сайтад гарсан нийтлэлд БНХАУ-ын Нийгмийн үнэлгээний систем буюу тухайн улсын иргэдийн аж амьдрал, үйл хэргийг үнэлж, тэрхүү үнэлгээгээр нийгмийн статусыг нь тодорхойлдог тогтолцоог Төв Азийн орнуудад /Казахстан, Киргизстан, Монгол/ нэвтрүүлж байна уу гэх асуудлыг хөндсөн. Энэ нийтлэлд ОХУ-ын эрдэмтэн доктор Владимир Овчинскийгийн ярилцлагыг дурджээ.

Оросын эрдэмтэн ярилцлагадаа баталснаар 2020 онд Монгол Улсын иргэдийн болон албаны мэдээллийг БНХАУ-ын албаны хүмүүс хүлээн авч, боловсруулах эрсдэлтэй болсон. Энэ үйл явц 2018 оны 10 дугаар сараас эхэлсэн бололтой. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр 2020 онд “Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл”-д 28.5 сая ам.долларыг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан зарцуулахаар болсон байна.

Эдийн засагчдын хувьд гадаадын, ялангуяа БНХАУ-ын “Бүс ба Зам” санаачлагын хүрээнд зээл, тусламж авахдаа болгоомжтой хандах, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, түүний санхүүжилт, хэрэгжилтийн ил тод байдлыг хангах, иргэний нийгмийг оролцуулах нь чухал болохыг онцолсон байна.

Эндээс, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсад суурилуулж ашиглах царай таних камерыг БНХАУ-аас авах уу?, тэдгээр хүний нүүр царай, хөдөлгөөн, үйлдлийг хянах чадалтай хяналтын камерын мэдээллийн санг өөр зорилгоор ашиглахгүй байх баталгаа бий эсэх? тэрхүү мэдээллийн санг гаднын халдлагаас бүрэн хамгаалах боломжтой эсэх? зэрэг асуулт гарч ирж байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан

Оросын эрдэмтэн ярилцлагадаа баталснаар 2020 онд Монгол Улсын иргэдийн болон албаны мэдээллийг БНХАУ-ын албаны хүмүүс хүлээн авч, боловсруулах эрсдэлтэй болсон. Энэ үйл явц 2018 оны 10 дугаар сараас эхэлсэн бололтой. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр 2020 онд “Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл”-д 28.5 сая ам.долларыг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан зарцуулахаар болсон байна.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.1.8-д “Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ” гэж заасан.

Гэвч, Засгийн газраас “дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх”-дээ буюу царай таних камер сонгохдоо эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх талаар тодорхой мэдээлэл өгөөгүй байна.

Царай таних камержуулалтын нэгдсэн систем нь одоогоор төлөвлөгөөний шинжтэй бөгөөд холбогдох хууль батлагдаагүй байна. Тодруулбал, Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай хууль батлагдаагүй нөхцөлд царай таних камерыг ашиглаж болохгүй. Гэвч, Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын чуулганаар хэлэлцэх асуудалд дээр дурдсан хуулийн төслүүд тусгагдаагүй байна.

Тэгэхээр Монгол Улсын хувьд энэ царай таних технологи бүхий хяналтын камерын үйл ажиллагааг хэт хавтгайруулахгүй байх, зөвхөн шүүх, прокурорын болон олон нийтийн онцгой хяналтын дор тодорхой нэг хэргийн хүрээнд маш хатуу чанд нөхцөлтэйгөөр ашиглаж болохыг зөвшөөрсөн тусгайлсан зохицуулалттай болоогүй нөхцөлд “дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн систем”-ийг дэмжих боломжгүй байна. Монгол Улсын Засгийн газраас царай таних камер суурилуулахтай холбоотой бүхий л үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах, иргэний нийгмийн оролцоог хангах зайлшгүй шаардлагатай байна.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.1.8-д “Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана. Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг өндөр түвшинд бэлтгэгдэж, итгэмжлэгдсэн үндэсний мэргэжилтнээр гүйцэтгүүлнэ” гэж заасан.

“RIGHT TO PRIVACY” БУЮУ ХУВИЙН ОРОН ЗАЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ҮЗЭЛ САНАА

Л.Амгаланбаатар

Судлаач (LL.M)

1. ОРШИЛ

Нийгэмд мэдээлэл хурдацтай түгэн тархаж, хүн бүр мэдээллийн дунд аж төрж, амьдрах болсон өнөөгийн цаг үед нэг талаас мэдээллийн нээлттэй урсгалыг дэмжиж хөгжүүлэхийн сацуу нөгөө талаас хүний хувийн орон зай, хувийн мэдээлэл, халдашгүй байдлыг ухамсарлаж хүндэтгэх зайлшгүй шаардлага бий болж байна. Иргэд өдөр тутмын амьдралдаа “хувийн орон зай” гэдэг үгийг хэрэглэж хэвшсэн хэдий ч, энэ үгийн цаана ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол оршиж байдаг, мөн ямар үнэ цэнэтэй зүйл болохыг төдийлөн ухамсарлаагүйгээс төрөөс иргэдийн хувийн орон зай, хувийн мэдээлэл, халдашгүй байдалд дур зоргоороо халдах, энэ нь цаашлаад иргэд өөр хоорондын хувийн амьдрал, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцох, нэгнийхээ хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олж авах, ашиглах, олон нийтэд дамжуулах зэрэг нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, иргэдэд хүний эрхийн суурь ойлголтыг сурталчлан таниулах зорилгоор иргэдийн хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн үзэл санааны талаар судалж таниулах нийгмийн бодит хэрэгцээ шаардлага үүсч байна.

2. ХУВИЙН ОРОН ЗАЙ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ОНОЛ, СУУРЬ ОЙЛГОЛТ

“Right to privacy” буюу хувийн орон зай, халдашгүй байдлын эрх нь хувь хүний амины шинжтэй салшгүй эрхүүдийн нэг билээ.

Хувийн орон зай, халдашгүй байдлын эрх нь бусдын хувийн амьдрал, хэрэгт оролцохгүй байх, бусдын хувийн мэдээллийг олон нийтэд ил болгохоос зайлсхийх гэсэн хувь хүний дотоод ашиг сонирхолд чиглэсэн шинжтэй ч, хувь хүн тодорхой төрлийн харилцаанд нийгэмд чиглэсэн чухал шийдвэрийг бие

даан гаргах шаардлагатай болдог тул нийгмийн шинжийг ч агуулна гэж үзэх болсон¹.

“Хувийн орон зай, халдашгүй байдал” гэдэгт зөвхөн тухайн хувь хүнд хамааралтай, амины шинжтэй бүхий л зүйлийг ойлгох хэдий ч, энэ нь хэт өргөн ойлголт тул хууль буюу шүүхээр хамгаалагдвал зохих хувийн халдашгүй байдлын хүрээ, хязгаарыг тодорхой болгох шаардлагатай гэж зарим нэг судлаачид тэмдэглэжээ. Энэ талаар Харвардын их сургуулийн профессор, Үндсэн хуулийн эрх зүйн судлаач Laurence H. Tribe нь төрөөс а. хувь хүний оюун санаанд нөлөөлөх замаар түүний халдашгүй байдалд халдах, б. хувь хүний бие махбодид шууд хэв нөлөөлж, удирдах замаар халдах, в. хувь хүний амьдралын маяг, төлөвлөгөөгөө сонгох боломжид халдах, г. хувь хүнийг бусдаас ялгах онцлог шинж байдлыг тодорхойлж болохуйц мэдээллийг олж авах, хадгалах, дамжуулах зэргийг бусдын хувийн орон зай, халдашгүй байдалд халдах үйлдэл гэж томъёолсон байна. Эндээс хувийн орон зай, халдашгүй байдал нь дан ганц хувь хүний мэдээлэл, нууцын халдашгүй байдлаар хязгаарлагдахааргүй өргөн ойлголт гэдгийг харж болно. Жишгийн эрх зүйн тогтолцоо бүхий улс орны гэм хорын эрх зүйд энэ эрхийг хувь хүний хувийн амьдралтай холбоотой мэдээллийг нийтэд ил болгох, бусдаас өөрийн хувийн орон зайд халдахаас хамгаалуулах эрх чөлөө гэдэг утгаар тайлбарлаж ирсэн. Ийнхүү гэм хорын эрх зүйд 1. Хүний нэр болон дүрсийг зөвшөөрөлгүйгээр ашиглах, 2. Хүний хувийн амьдралд зүй бусаар халдах, 3. Хүний хувийн хэргийг нийтэд дэлгэх, 4. Хувь хүнийг нийтэд буруугаар хүлээн зөвшөөрүүлэхүйц байдлаар ойлгуулах гэсэн дөрвөн хэлбэрээр ойлгодог байсан хэдий ч, нийтийн эрх зүйн хүрээнд буюу Үндсэн хуулиар хамгаалагдвал зохих үндсэн эрхийн түвшинд авч үзэх болсон.

Хувийн орон зай, халдашгүй байдлын эрх нь бусдын хувийн амьдрал, хэрэгт оролцохгүй байх, бусдын хувийн мэдээллийг олон нийтэд ил болгохоос зайлсхийх гэсэн хувь хүний дотоод ашиг сонирхолд чиглэсэн шинжтэй ч, хувь хүн тодорхой төрлийн харилцаанд нийгэмд чиглэсэн чухал шийдвэрийг бие даан гаргах шаардлагатай болдог тул нийгмийн шинжийг ч агуулна гэж үзэх болсон.

Хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн агуулга, хэрэгжих хүрээ хязгаарыг тодорхой болгох үүднээс Япон Улс болон АНУ-ын туршлага, практикийг харьцуулан авч үзье.

3. ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА

Япон Улсын хувьд хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийг үндсэн эрх гэж хүлээн зөвшөөрч, түүнийг агуулгыг “right to be let alone” буюу ганцаараа чөлөөтэй байх эрх гэхээс илүүтэйгээр, “right to control personal information” хувь

¹ Япон Улсын парламентийн дээд танхимийн Үндсэн хуулийн судалгааны хэлтэс “Мэдэх эрх, мэдээлэл авах эрх, хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн талаарх үндсэн баримт бичиг” Дугаар 28, 2003 он, 9-10 дах тал

хүн өөрт хамааралтай мэдээллийг удирдан захирах эрх гэж авч үзэх хандлага давамгайлж байна.²

Орчин үеийн нийгэмд мэдээллийн салбар хурдтай хөгжихтэй зэрэгцэн хувийн орон зай, халдашгүй байдлын эрх нь хувь хүн өөрийн амин шинжтэй бүхий л хувийн хэргийг бие даан шийдвэрлэх гэсэн ойлголтыг илэрхийлэх болсон. Өөрөөр хэлбэл хувийн мэдээллийн эрх буюу хувь хүн өөрт хамааралтай мэдээллийг удирдан захирах эрх, эрх чөлөө гэсэн утгаар ойлгох болсон. Үүний үндэслэл нь төрөөс хувь хүний хувийн мэдээллийг тодорхой хязгааргүйгээр олж авч, цуглуулж, хадгалж, ашиглаж, нийтэл ил болгож болохуйц нийгэмд иргэд улс төрд оролцох эрхээ чөлөөтэйгээр эдлэх боломж бололцоо бага байдаг тул хувь хүн өөрт хамааралтай мэдээллийг өөрөө мэдэн удирдан шийдвэрлэж, төрөөс өөрийн мэдээллийн талаар засвар оруулах, арилгах, мөн хянаж шалгахыг зогсоохыг шаардах эрхтэй гэж тайлбарлах болсонтой холбоотой байна.³

Энэ талаар Үндсэн хуулийн эрх зүйн судлаач Кожи Сато “Хувь хүн нь ёс суртахуунтай оршихуй болохынхоо хувьд аливаа зүйлийн талаар өөрийнхөө хувьд зөв гэсэн шийдвэр гаргаж бусадтай харилцдаг. Иймд өөрт хамааралтай мэдээллийн нийтэд ил болгож болох хүрээ, хязгаарыг өөрөө бие даан шийдвэрлэх, сонгох эрхтэй. Хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн хэрэгжилтийг хангахын тулд төрөөс хувь хүний мэдээллийг олж авах, цуглуулах, хадгалах, хэрэглэх, дамжуулахтай холбоотой зохицуулалт шаардлагатайгаас гадна хувь хүний ямар мэдээллийг олж авах, хадгалж болох талаар нийтэд ил болгохыг үүрэг болгож, иргэд өөрт хамааралтай тухайн мэдээллийг чөлөөтэй олж авах, шалгах, засварлах, арилгахыг шаардах эрхтэй байхаар зохицуулах ёстой” гэж тэмдэглэжээ.⁴ Захидал харилцааны нууцын хүрээнд төрөөс хувь хүний захидал харилцааг хөндлөнгөөс чагнахыг хориглох, хувь хүний орон байр, бичиг баримтад нэгжлэх хийх, мөн түүнтэй холбоотой хувь хүний мэдээллийг олж авах, хураан авах ажиллагааг зөвхөн шүүгчийн захирамжаар явуулах зэрэг нь хувь хүний орон зай, халдашгүй байдлын эрхийг хамгаалж байгаагийн хэлбэр болно. Иймд хувийн орон зай, халдашгүй байдлын эрх нь Үндсэн хуулиар хамгаалбал зохих үндсэн эрхэд хамаарах бөгөөд энэ эрхийг “right to pursuit of happiness” буюу “аз жаргалыг эрэлхийлэх эрх”-ийн хүрээнд тайлбарладаг.⁵

“Хувийн мэдээлэл” гэдэгт хувь хүний оюун санааны процесс болон биеийн хэв шинж, нөхцөл байдалтай холбоотой, дээд зэргийн нууцлал бүхий мэдээллийг ойлгоно. Үүнд, хувь хүний улс төр, шашин, итгэл үнэмшил, сэтгэл зүй болон бие махбодь, гэмт хэргийн түүх зэрэгтэй холбоотой мэдээллийг хамааруулна. Харин нууцлал багатай мэдээллийн хувьд төрөөс тодорхой зүй ёсны зорилгыг хангах үүднээс зөв аргаар олж авах, хадгалах, дамжуулахад хувь хүний орон зай,

2 芦部信喜『憲法学 II 人権総論』374-378 頁

3 芦部信喜『憲法 第三版』117 頁

4 佐藤幸治『憲法(第三版)』青林書院(1995年)453-456 頁。

5 松井茂記『日本国憲法』有斐閣(2007年)496-499 頁。

халдашгүй байдлын эрхийн зөрчил болохгүй. Энд “хувийн мэдээллийг удирдан захирах” гэдгийг хүн өөрт хамааралтай мэдээллийг хэзээ, яаж, ямар хүрээнд, хэнд дамжуулахаа өөрөө шийдвэрлэх буюу тухайн хүний хүсэл зоригоос шууд хамаарна гэсэн утгаар тайлбарлана.⁶

Анх Япон Улс шүүхийн жишгээр 「宴のあと」 буюу “After the Banquet” гэх хэрэг, маргаанд хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийг хуулиар хамгаалбал зохих эрх гэж хүлээн зөвшөөрсөн. Уг хэрэгт зохиолч Юүкио Мишимагийн “After the Banquet” гэх зохиолын гол дүрийн баатраар Япон Улсын экс Гадаад хэргийн сайд байсан хүнийг түүний Токио хотын даргын сонгуульд ялагдсан үйл явдлаар сэдэвлэж, орлуулан бичсэн нь тухайн хүний хувийн орон зай, халдашгүй байдалд халдсан үйлдэл гэж үзсэн тухай маргаан юм. Тус маргаанд Дээд шүүхээс “Үндсэн хуулиар баталгаажуулсан human dignity буюу хувь хүнийг хүндэтгэх зарчмын үүднээс хувь хүн нь өөрийн хувийн эрхийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд ил болохоос хамгаалагдах баталгааг эдэлнэ. Энэ нь хуулиар хамгаалагдвал зохих амины шинжтэй хууль ёсны ашиг сонирхолд хамаарах бөгөөд үүнийг эрх гэж авч үзэхэд хориглох зүйл байхгүй” гэж тайлбарласан байна.⁷

Дээд шүүхийн дээрх тайлбар нь анх удаа аливаа хүн өөрийн хувийн хэргийг түүний зөвшөөрөлгүйгээр олон нийтэд ил болохоос хамгаалуулах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ нь хувь хүнийг хүндлэх зарчимд суурилна гэж үзсэн. Энэхүү шийдвэр гарснаас хойш Дээд шүүхээс цагдаагийн албан тушаалтнаас жагсаал цуглаан хийж байгаа жагсагчид дундаас зөрчил илрүүлэх зорилгоор хүмүүсийн зургийг авах⁸, автомашины хурд хэмжих хяналтын төхөөрөмжөөр хүний царай төрхний зургийг авах,⁹ мөн гадаад иргэдийн бүртгэлтэй холбоотойгоор гадаад иргэдийн хурууний хээг тэдний зөвшөөрөлгүйгээр заавал авахыг үүрэг болгох¹⁰ зэрэг үйлдлүүдийг бусдын хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн зөрчил гэж тайлбарлаж шийджээ.

Япон Улсад хувьд хэдийгээр бусдын хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийг хувь хүн өөрт хамааралтай мэдээллийг удирдан захирах эрх гэж тайлбарлаж байгаа ч, энэ нь хүний хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн хэргийг нийтэд ил болохоос хамгаалагдах эрх чөлөө гэсэн суурь үзэл санаанд тулгуурласан хэвээр байгаа гэж зарим судлаач тэмдэглэснийг¹¹ дурьдах нь зүйтэй.

6 芦部信喜『憲法学 II 人権総論』有斐閣(1994年) 378-383頁。

7 東京地判昭和39・9・28下民集15巻9号2317頁。

8 最判昭和44・12・24刑集23巻12号1625頁。

9 最判昭和61・2・14刑集40巻1号48頁。4

10 東京高判昭和61・8・25判時1208号66頁。

11 Япон улсын парламентийн дээд танхимийн Үндсэн хуулийн судалгааны хэлтэс “Мэдэх эрх, мэдээлэл авах эрх, хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн талаарх үндсэн баримт бичиг” Дугаар 28, 2003 он, 18 дах тал

4. АНУ-ЫН ТУРШЛАГА

АНУ-ын хувьд 1928 оны “Olmstead v. United States” хэрэгт шүүгчдийн цөөнхийн саналаар right to be let alone “ганцаараа чөлөөтэй байх” эрх-ийг үндсэн эрх гэж хүлээн зөвшөөрч, “энэ эрх нь үндсэн эрх дотор хамгийн өргөн хүрээтэй бөгөөд иргэншсэн хүмүүсийн хувьд хамгийн үнэ цэнэтэй эрх” гэж тодорхойлсон байна¹². Үүний дараа 1950-1960-аад оны үед Холбооны Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлтээр оруулсан үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхийн агуулгыг хувь хүн дурын ямар ч бүлэгт чөлөөтэйгээр элсэж орж болно гэдэг байдлаар тайлбарлаж, хүлээн зөвшөөрсөн. Мөн 1965 оны “Grisworld v. Connecticut” хэрэгт жирэмслэлтээс хамгаалах эрхийг хувийн орон зай, халдашгүй байдлын эрхээр хамгаалагдах үндсэн эрх гэж хүлээн зөвшөөрсөн байна¹³.

Мөн 1970 оны “Roe v. Wade” хэргийн хүрээнд үр хөндөлтийг хувийн орон зай, халдашгүй байдлын эрх гэж хүлээн зөвшөөрч, эмэгтэйчүүд нь ураг амьдрах чадварт шилжих хүртэлх үе шатанд хүрэхээс өмнө жирэмслэлтийг зогсоож болно гэж тайлбарласан¹⁴. Хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн агуулгын талаар 1977 оны “Whalen v. Roe” хэрэгт Дээд шүүхийн шүүгч Стэйвенс “үг эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан харилцан адилгүй хоёр хууль ёсны ашиг сонирхлыг багтаасан ойлголт бөгөөд эхнийх нь хүний хувийн хэргийг нийтэд ил болгохоос зайлсхийж буй ашиг сонирхол бол нөгөөх нь тодорхой шийдвэрийг төрийн ямар нэг нөлөөгүйгээр бие даан шийдвэрлэж буй ашиг сонирхол” гэж дурьджээ¹⁵.

Дээрх Япон Улс болон АНУ-ын жишээ, практикаас үзвэл хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн хүрээ, хязгаар нь хувь хүн өөрийн хувийн амьдрал, хувийн хэргийг (үр хөндөлт, жирэмслэлтээс хамгаалах г.м) чөлөөтэйгээр бие даан шийдвэрлэж болохуйц байдлаар авч үзэх болон хувь хүн зөвхөн өөрт хамааралтай мэдээллийг удирдан захирах байдлаар авч үзэх гэсэн үндсэн хоёр хандлага ажиглагдаж байна. АНУ-ын хувьд эхний хандлага нь давамгайлж байгаа бол Япон Улсын хувьд сүүлийн хандлагыг илүүтэйгээр дэмжсэн байр суурьтай байна.

5. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ТАЙЛБАРЛАХ БОЛОМЖ

Манай улсын хувьд хувь хүний орон зай, халдашгүй байдлын эрхийн талаар шууд тодорхой заасан эрх зүйн зохицуулалт байхгүй ч хүний нэр, нэр төр, алдар хүн, ажил хэргийн нэр хүнд, хувийн нууц, дүрсийн талаар тус тус зохицуулсан зарим эрх зүйн зохицуулалт бий.

12 *Olmstead v. United states*, 277 U.S. 438 (1928)

13 *Griswold v. Connecticut*, 381 U.S. 479 (1965)

14 *Roe v. Wade*, 410 U.S. 113 (1973)

15 *Whalen v. Roe*, 429 U.S. 589 (1977), 5

Монгол Улсын Үндсэн хуульд Монголын ард түмэн улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон билээ. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд Монгол улсын төр, Монголын бүхий л ард түмэн хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх учиртай. Энэ нь Үндсэн хуульд заасан үндсэн эрхээр хязгаарлагдахгүй, хүн хүмүүн болж төрснийхөө хувьд заавал эдлэх ёстой, хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн талаарх суурь ойлголт, зарчим юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасны дагуу Монгол Улсын иргэн бүр “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” үндсэн үүргийг хүлээнэ. Энэ нь хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх тухай ойлголтыг илэрхийлэхээс гадна бусдын халдашгүй байдал, чөлөөтэй байх эрх, эрх чөлөөг хүндэтгэх гэсэн утгыг давхар илэрхийлнэ. Мөн 16 дугаар зүйлийн 13 дах хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан байна. Энэ талаар 1961 оны

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциор хүний эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцохгүй байх, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууц болон нэр төр, алдар хүндийн эрхийг тус тус хүлээн зөвшөөрсөн байна.

10 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд хүний халдашгүй дархан байх эрхийн талаар “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 12 дугаар зүйлд хүний нэр төр, алдар хүндийн талаар “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциор хүний эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцохгүй байх, орон байрны

халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндийн эрхийг тус тус хүлээн зөвшөөрсөн байна.

1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан “Хувь хүний нууцын тухай” хуульд «хувь хүний нууц» гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ гэж тодорхойлсон. Энэ хуулиар хувь хүний зургаан нууцыг захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн болон хуулиар тогтоосон бусад нууц гэж тус тус ангилжээ. Дээрх хуулийн агуулгаас үзвэл, нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэж тодорхойлсон байна.

Энэ нь нэгдүгээрт тухайн хүний нууц нь “Хувь хүний нууцын тухай” хууль эсхүл бусад хуулиар тогтоосон нууцад хамаарч байх, хоёрдугаарт нууцыг задруулснаар тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учирч болзошгүй байх гэсэн шаардлагыг хангах ёстой байна. Энэ хуулиар хувь хүний нууцын талаар зохицуулсан хэдий ч, хувь хүний орон зай, халдашгүй байдлын талаар зохицуулаагүй байна. Харин хувь хүний нэр, нэр төр, алдар хүн, ажил хэргийн нэр хүнд болон дүрсийн талаарх зохицуулалтыг Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлээс харж болно.

Уг хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр, нэр төр, алдар хүн, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээдийн хариуцлага, бусдын хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас ч учирсан гэм хорын хариуцлага, иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс учирсан гэм хорын хариуцлагын талаар тус тус зохицуулсан.

Монгол Улсын Иргэний хууль нь хувийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулна. Уг хууль нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрхүүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ. Үүнээс хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төр аль нь ч байсан өөрсдийн хүсэл зоригийн дагуу эрхээ эдэлж, хэрэгжүүлнэ гэсэн агуулгатай.

Энэ зарчим нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын бие даасан байдлыг хангах зарчимтай салшгүй холбоотой бөгөөд хувийн ашиг сонирхлыг хүндэтгэн нийгмийн ашиг сонирхолтой зөв хослуулах үндэс болно. Энэ утгаараа нийгмийн ашиг сонирхлыг дээгүүр тавьж, хувийн ашиг сонирхлыг боогдуулж болохгүй, харин хувийн ашиг сонирхол, хувийн хэрэг нь нийгэм болон нийтэд хор хохиролгүй байх ёстой¹⁶.

Дээрхээс үзвэл, манай улсын хувьд хувь хүний орон зай, халдашгүй байдлын эрхийн агуулгад багтдаг хувь хүний нэр, хувийн нууц, дүрсийн талаар холбогдох зохицуулалт байгаа ч, энэ нь хангалтгүй байна. Учир нь “Хувь хүний нууцын тухай” хуулиар хувь хүний нууцад юу хамаарахыг тоочиж заасан хэдий ч, хуульд тодорхой заагаагүй байгаа хувь хүний нууцыг хэрхэх талаар зохицуулалт оруулаагүй байна. Үүний үр дүнд хүн өөрт хамааралтай хувийн аль нэг мэдээллийг нууц гэж үзсэн ч, энэ нь хуульд заасан захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн нууцад хамаарахгүй бол тухайн хүн хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулж чадахгүй байх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл төрөөс хүний хувийн орон зай, халдашгүй байдалд ямар нэг байдлаар халдсан бол тухайн хүн уг хуулийн хүрээнд хамгаалагдаж чадахгүй байна. Мөн хувийн орон зай, халдашгүй байдлыг хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээс ялгаж авч үзэх шаардлагатай. Хүний нэр төр, алдар хүнд нь тухайн хүний талаарх нийгмийн үнэлэмжийг хэлэх бол хувийн орон зай, халдашгүй байдал нь нийгмийн үнэлэмжтэй хамааралгүй, тухайн хүний өөрийн дотоод хувийн орон зайг хэлнэ.

6. ДҮГНЭЛТ

Манай улсын хувьд хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийг хүн өөрийн хувийн амьдрал, хувийн хэргийг төрийн оролцоогүйгээр өөрөө бие даан шийдвэрлэх эрхтэй гэж тайлбарлах хандлагыг хараахан хүлээн зөвшөөрөөгүй байна. Хүний хувийн орон зай, халдашгүй байдал дотроос хувийн нууцын талаар тусгайлсан хуулиар зохицуулсан байгаа нь сайшаалтай ч, тус хууль нь цаг хугацааны хувьд хоцрогдсон, зохицуулалтын агуулга-хэлбэр талаасаа хангалтгүй байгаа тул өнөөгийн мэдээллийн дэвшилтэт нийгэмд хувь хүний нууцыг хамгаалах зорилгыг бүрэн хангаж чадахгүй байна. Иймд төрөөс иргэдийн хувийн орон зай, халдашгүй байдалд халдахаас урьдчилан сэргийлэх, иргэд өөр хоорондын хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцож, хууль ёсны ашиг сонирхлыг нь зөрчихгүй байх үүднээс “right to privacy” буюу хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн мөн чанар, үнэ цэнийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар ойлгуулах, сурталчлан таниулах шаардлага үүсч байна.

16. *Ё.Каюот нар “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар/шинжлэх ухааны тайлбар” Хоёр дахь хэвлэл, УБ.,2015 он, 8 дахь тал 7*

Юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дах хэсгийн Монгол Улсын иргэдийн “халдашгүй, чөлөөтэй байх эрх”-ийн агуулгыг өргөжүүлэн тайлбарлах замаар орчин үеийн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хувийн орон зай, халдашгүй байдлын эрхийн ойлголтыг өөрийн дотоодын хууль тогтоомжийн хүрээнд авч үзэх боломжтой байна.

“Хувь хүний нууцын тухай” хууль нь 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр буюу одоогоос 25 жилийн өмнө батлагдсан. Хууль батлагдсан тухайн үеэс хойш нийгэмд мэдээллийн салбар уламхурдацтай хөгжиж, хувь хүний нууцад хандах хандлага өөрчлөгдсөөр байгаа тул хувь хүний нууцын бүрэн бүтэн байдлыг илүү хамгаалах, нийгмийн бодит шаардлага үүсээд байгаа юм.

СОЁЛЫН ЯЛГАА БА ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

Ж.Дөлгөөн

Номин Холдинг ХХК, гадаад гэрээний хуульч

Монгол Улсад эрт дээр үеэс эрэгтэй хүүхдийн боожгойн арьсыг шамлаж, тамхилах ёс тогтсон. Яг хэдийн үеэс уг ёс тогтсон эсэх талаар тодорхой судалгаа байдаггүй ч манай урд хөрш болох Хятад Улсад бас ийм соёл байдаг ажээ. Тамхилах ёс нь угтаа бага насны эрэгтэй хүүхдийг өхөөрдөж буй хэлбэрээс гадна хүүхдийн боожгойн хөвчний арьсыг тамхилах замаар шамлаж сунгаснаар тээрхийн нарийсал буюу “Фимоз” эмгэгээс урьдчилан сэргийлэх ардын уламжлалт анагаах арга гэж яригддаг. “Фимоз” нь шээхдээ дүлэх юмуу шээх нь ямар нэгэн байдлаар хүндрэлтэй байх, мөн шээсний дараа хүүхдийн тээрхийн арьс болон шодойн толгойн хооронд шээс үлдэж байгаа зэрэг шинж тэмдгээр илэрдэг бэлэг эрхтний эмгэг юм. Монголчууд болон Азийн ихэнх орнуудад хөвч таслах ёс хийгддэггүй тул боожгойг тамхилах замаар “Фимоз” эмгэгээс урьдчилан сэргийлсээр иржээ.



§ 176 Sexueller Mißbrauch von Kindern

- (1) Wer sexuelle Handlungen an einer Person unter vierzehn Jahren (Kind) vornimmt oder an sich von dem Kind vornehmen läßt, wird mit Freiheitsstrafe von sechs Monaten bis zu zehn Jahren bestraft.
- (2) Ebenso wird bestraft, wer ein Kind dazu bestimmt, daß es sexuelle Handlungen an einem Dritten vornimmt oder von einem Dritten an sich vornehmen läßt.
- (3) In besonders schweren Fällen ist auf Freiheitsstrafe nicht unter einem Jahr zu erkennen.
- (4) Mit Freiheitsstrafe von drei Monaten bis zu fünf Jahren wird bestraft, wer
1. sexuelle Handlungen vor einem Kind vornimmt,
 2. ein Kind dazu bestimmt, daß es sexuelle Handlungen vornimmt, soweit die Tat nicht nach Absatz 1 oder Absatz 2 mit Strafe bedroht ist,
 3. auf ein Kind mittels Schriften (§ 11 Absatz 3) oder mittels Informations- oder Kommunikationstechnologie einwirkt, um
 - a) das Kind zu sexuellen Handlungen zu bringen, die es an oder vor dem Täter oder einer dritten Person vornimmt oder von dem Täter oder einer dritten Person an sich vornehmen lassen soll, oder
 - b) eine Tat nach § 184b Absatz 1 Nummer 3 oder nach § 184b Absatz 3 zu begehen, oder
 4. auf ein Kind durch Vorzeigen pornographischer Abbildungen oder Darstellungen, durch Abspiehlen von Tonträgern pornographischen Inhalts, durch Zugänglichmachen pornographischer Inhalte mittels Informations- und Kommunikationstechnologie oder durch entsprechende Feiten einwirkt.
- (5) Mit Freiheitsstrafe von drei Monaten bis zu fünf Jahren wird bestraft, wer ein Kind für eine Tat nach den Absätzen 1 bis 4 anbietet oder nachzuweisen verspricht oder wer sich mit einem anderen zu einer solchen Tat verabredet.
- (6) Der Versuch ist strafbar; dies gilt nicht für Taten nach Absatz 4 Nummer 4 und Absatz 5. Bei Taten nach Absatz 4 Nummer 3 ist der Versuch nur in den Fällen strafbar, in denen eine Vollendung der Tat allein daran scheitert, daß der Täter eingesehen hat, sein Einwirken beziehe sich auf ein Kind.
- Nichtamtliches Inhaltsverzeichnis*

§ 176a Schwerer sexueller Mißbrauch von Kindern

- (1) Der sexuelle Mißbrauch von Kindern wird in den Fällen des § 176 Abs. 1 und 2 mit Freiheitsstrafe nicht unter einem Jahr bestraft, wenn der Täter innerhalb der letzten fünf Jahre wegen einer solchen Straftat rechtskräftig verurteilt worden ist.
- (2) Der sexuelle Mißbrauch von Kindern wird in den Fällen des § 176 Abs. 1 und 2 mit Freiheitsstrafe nicht unter zwei Jahren bestraft, wenn
1. eine Person über achtzehn Jahren mit dem Kind den Beschluß vollzieht oder ähnliche sexuelle Handlungen an ihm vornimmt oder an sich von ihm vornehmen läßt, die mit einem Eindringen in den Körper verbunden sind,
 2. die Tat von mehreren gemeinschaftlich begangen wird oder
 3. der Täter das Kind durch die Tat in die Gefahr einer schweren Gesundheitschädigung oder einer erheblichen Schädigung der körperlichen oder seelischen Entwicklung bringt.
- (3) Mit Freiheitsstrafe nicht unter zwei Jahren wird bestraft, wer in den Fällen des § 176 Abs. 1 bis 3, 4 Nr. 1 oder Nr. 2, jeweils auch in Verbindung mit § 176 Absatz 6 Satz 1, als Täter oder anderer Beteiligter in der Absicht handelt, die Tat zum Gegenstand einer pornographischen Schrift (§ 11 Abs. 3) zu machen, die nach § 184b Absatz 1 oder 2 verbreitet werden soll.
- (4) In minder schweren Fällen des Absatzes 1 ist auf Freiheitsstrafe von drei Monaten bis zu fünf Jahren, in minder schweren Fällen des Absatzes 2 auf Freiheitsstrafe von einem Jahr bis zu zehn Jahren zu erkennen.
- (5) Mit Freiheitsstrafe nicht unter fünf Jahren wird bestraft, wer das Kind in den Fällen des § 176 Abs. 1 bis 3 der Tat körperlich schwer misshandelt oder durch die Tat in die Gefahr des Todes bringt.
- (6) In die in Absatz 1 bezeichnete Frist wird die Zeit nicht eingerechnet, in welcher der Täter auf behördliche Anordnung in einer Anstalt verwahrt worden ist. Eine Tat, die im Ausland abgeurteilt worden ist, steht in den Fällen des Absatzes 1 einer im Inland abgeurteilten Tat gleich, wenn sie nach deutschem Strafrecht eine solche nach § 176 Abs. 1 oder 2 wäre.
- Nichtamtliches Inhaltsverzeichnis*

Манайд энэ үйлдэл нь эрт дээр үеэс тогтсон ёс заншил, хүүхдийг өхөөрдөх арга хэлбэр бол өөр бусад гадны улсад ийм ёс заншил байдаггүй ба энэ нь бэлгийн гаж зан үйл, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах үйлдэлд тооцогддог байна. Саяхан буюу 2020 оны 08 дугаар сарын 01-нээс 09-ний өдрүүдэд ХБНГУ-д зорчиж явсан өндөр настай, Монгол Улсын иргэн Б гэгч¹ хөрш айлын хоёр гадаад хүүхдийн боожгойг тамхилан өхөөрдсөнөөр цагдаад баривчлагдаж, Эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдсан билээ. Уг хэргийн талаар нарийвчлан дурдвал:

Иргэн Б нь хүүхдүүд дээрээ зочлох зорилгоор ХБНГУ-д 2 сард зорчсон ба Ковид-19 цар тахлын улмаас хил хаагдаж, эх нутагтаа ирж чадахгүй хөл хорионд байсаар 6 сарыг үдсэн. Олон сарын хугацаанд хөл хорионд гацсан өндөр настай өвөө сэтгэл санаагаар ихэд унаж, гэрээсээ гадагш гарч чадахгүй байсаар Германд "Ковид-19"-ийн хөл хорио тавигдахад гэрийнхээ ойролцоо байрлах усан санд гэр бүлийн хамт цагийг өнгөрөөсөн. Усан санд байх явцдаа хөрш айлын 2 болон 3 настай хоёр эрэгтэй хүүхдийг өхөөрдөн, боожгойг нь тамхилснаас хүүхдийн эцэг эх цагдаа дуудан баривчлуулсан байдаг. 24 цаг баривчлагдсаны эцэст ХБНГУ-д байрлах Монгол Улсын Элчин Сайдын Яамны хүсэлтээр баривчлах шийтгэлийг тэнсэн болгож өөрчлүүлсэн. Ийнхүү эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж, улмаар нэгдүгээрт, бага насны хүүхдийн эсрэг хоёрдугаарт, 2 ба түүнээс олон хүний эсрэг зэрэг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр "Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах" гэмт хэргээр зүйлчлэгдэж, 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлэх, 20'000 еврогоор торгууль оногдуулах ял төлөвлөгдсөн байна.²

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь субъектив талаас гэм буруугийн санаатай, бэлгийн дур хүслээ хангах зорилготой байх ёстой. Гэтэл иргэн Б-гийн уг үйлдэл нь бэлгийн дур хүсэл, бэлгийн гаж донтой огт холбоогүй, Монгол Улсад урт удаан хугацааны (хэдэн зуун жилийн) турш

¹ Жич: Уг хэрэгт холбогдогч болон түүний ар гэрийн хүсэлтээр иргэний нэр, насыг нууцлав.

² ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйл. (1872.01.01) Эх сурвалж: <https://www.gesetze-im-internet.de/stgb/BfNR001270871.html#BfJNR001270871.BfJNG005002307>

тогтсон зан заншил байх ба бэлгийн дур хүслийн илэрхийлэл бус, бага насны эрэгтэй хүүхдийг боожгойг тамхилах үйлдэл нь хүүхдийг өхөөрдсөн, хүүхдээр бахархсан, анхаарал халамжийн илэрхийлэл болсон үйлдэл юм.

Нөгөө талаас ХБНГУ болон бусад Христийн шашинтай улс оронд эрэгтэй хүүхдийн хөвчийг таслах ёслол хийгддэг бол Монголд ийм ёслол хийгддэггүй. Эрэгтэй хүүхдийн боожгойн тээрхийн арьс шамардаггүй, улмаар эмгэг болдог тул тамхилах заншлаар тээрхийн арьсыг султган сунгаж, нэг төрлийн массаж болдог. Иймд эрт дээр үеэс Монголчууд эрэгтэй хүүхдийн боожгойг тамхилж, эрүүл мэндэд нь анхаарах уламжлал нь удаан хугацааны турш заншил болон тогтсон үзэгдэл юм. Иймд уг үйлдлийг *culture difference*³ / *misunderstood crime*⁴ утгаар тайлбарладаг.

Хүүхдийн боожгойг тамхилах ёс нь Нэгдсэн Үндэсний Байгууллагад соёлын өв, ёс заншлаар бүртгэгдээгүй байх ба олон улсад төдийлөн танил болоогүй заншил байх тул шүүх хуралдаанд уг үйлдлийг Монголын ёс заншил гэдгийг нотлох шаардлага үүссэн. Иймд дараах хүсэлтүүдийг шүүхэд гаргасан. Үүнд:

- ХБНГУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-аас эрэгтэй хүүхдийн боожгойг тамхилах ёсны тухай тайлбар, дүгнэлт гаргуулах
- Шүүхэд Монгол судлаач (*cultural expert*) томилуулах, дүгнэлт гаргуулах
- Өөр төрлийн бусад төстэй кейсийг иш татах (тухайлбал, Шинэ Зеланд улсад гарсан 79 настай Хятад өвөө 3 настай хүүгийн боожгойд хүрсэн үйлдэлд 1000\$-ын торгууль оногдуулсан зэрэг кейс)⁵
- Тань руу нүүж явна киноны холбогдох хэсгийг нотлох баримтаар оруулах зэрэг хүсэлтийг ХБНГУ-ын шүүхэд тавьснаар Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн ба хохирогчийн ар гэрт нөхөн төлбөр олгож хэрэг хаагдсан.

Дээр дурдсан жишээтэй төсөөтэй хэргүүд ХБНГУ-д өмнө нь 2 удаа бүртгэгдсэн (1996, 2003 он) байх ба энэ удаа ч манай зүгээс Германчуудыг сүржигнэсэн, хатуу хандсан зэргээр хэрэгт холбогдогчийг өмөөрөөд өнгөрсөн.

Гэтэл хүүхдийн бие махбод, тэр тусмаа бэлэг эрхтэнд хэн дуртай нь тамхилах нэрийдлээр хүрэх нь хэвийн үзэгдэл үү?

Тамхилах үйлдэл нь хүүхдийн бие болоод сэтгэцийн эрүүл мэндэд дараах байдлаар нөлөөлдөг байна. Тухайлбал,

Сэтгэл зүйч *Н.Ариун-Эрдэнэ* “Бага насны хүүхдээ хамгаалахын тулд бид хэвшмэл ойлголт, хандлага, хэв маягаа дахин эргэн харах цаг нь болжээ. Мөн

3 Sannomiya, M. (1987). *Misunderstanding in human relations: A preliminary survey of verbal misunderstanding*, Naruto University of Education, 31-46.

4 Lawrence S. Wrightsman (Ph.D) (1959) *Rape: The Misunderstood Crime*, University of Minnesota, 178-235.

5 Шинэ Зеланд Улсад гарсан төсөөтэй кейс. Эх сурвалж: <https://www.bbc.com/news/blogs-china-blog-49093697>

охиндоо, хүүдээ өөрийгөө хэрхэн хамгаалах талаар зааж өгөх, хэн биед нь хүрч болох, танихгүй хүн хүрвэл хэрхэх талаар хүүхдийн нас, бие бялдар, сэтгэл зүйн онцлогт нь тохируулан зааж өгөх юм. Австрийн сэтгэл судлаач А.Адлерийн "Бие хүний хөгжил"-ийн онолоор бол хүний амьдралын хэв маяг хүүхдийн 4-5 настайд бий болдог ба насанд хүрэхэд нэг их өөрчлөлт гардаггүй гэж үзсэн. Хүүхдийн сэтгэцийн процессууд буюу сэрэл хүртэхүй сэтгэхүй нь бидний амьдралын хэв маягаас хамаарч байдаг гэжээ. Мөн зан үйлд гарч байгаа өөрчлөлт нь хандлагыг өөрчилдөг. Тэгэхээр байнга л бэлэг эрхтнээ оролдуулаад байдаг хүүхдийн сэтгэхүй бол бусдад зөвшөөрөлгүй хүрэх нь хэвийн зүйл гэж ойлгож болох нь. Мөн өөр сэдлийг ч бий болгох магадлалтай."⁶

Сэтгэл зүйч *Г.Төмөрзаяа* хүүхдэдээ бага наснаас нь "Бэлгэ эрхтэн нь зөвхөн чиний нандин зүйл гэдгийг маш сайн ухааруулах хэрэгтэй". "Гэтэл энэ нандин зүйлдээ дурын хүн хүрэхийг зөвшөөрдөг болчихно, эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай" гэсэн бол сэтгэл зүйч *Д.Лхамсүрэн* "Тамхилах" гэдгийг огт ойлгодоггүй. Эрэгтэй хүүхэд гэдгээр нь бахархаад байгаа юм уу? Байж болох зүйл огт биш. Гол нь тамжилж байгаа хүн энэ нь хүүхдэд гэм хортой зүйл гэж боддоггүйд учир бий"⁷ гэжээ.

Нөгөө талаас бохир гар, бохир амаар хүүхдийн бэлэг эрхтэнд хүрэх, үнсэх, үнэрлэх нь төрөл бүрийн өвчин халдах эх үүсвэр болно. Цинт эмнэлгийн судалгаагаар дөнгөж төрсөн 100 нярай эрэгтэй хүүхдийн 95-96 нь бэлэг эрхтэн буюу шодой шамлагддаггүй, ердөө 4-5-ынх нь л шамлагддаг байна. 1- 3 нас хүрэхэд 30%-д, 5 насанд 60%-д шодойн толгойг хучиж буй тээрхийн арьс өөрөө хагас эсвэл бүрэн шамлагддаг болно. Энэ насанд шамлахад шээсний сүв харагдахгүй бол фимоз гэнэ. Тэгэхээр Фимоз гэдэг оношийг 5 наснаас өмнө тавих ёсгүй бөгөөд 5 наснаас өмнө шодойг хүчээр шамлах /язарна, өвдөнө, сорвижино/, байнга шамлах "дасгал" хийх /шодойгоороо оролддог буруу зуршилтай болно/, тээрхийн арьсыг тайрах /циркумцеци/, сэтлэх зэрэг мэс ажилбар /10-аад төрлийн хүндрэл гарах магадлалтай, гоо сайхан нь алдагдана/ хийж болохгүй гэдгийг эцэг эхчүүд төдийгүй эмч нар анхаарах хэрэгтэй. 5 наснаас хойш ч мөн адил эдгээр зүйлийг хийж, хийлгэж болохгүй.⁸

Иймд тамхилах ёс нь хүүхдийн бие махбод, сэтгэлзүй, хөгжлийн хувьд сайнаар нөлөөлдөггүй, хүүхдийн сэтгэцэд сөргөөр нөлөөлж, хувь хүний хөгжил, өөрийгөө илэрхийлэх, хамгаалж сурах үйл явцад сөргөөр нөлөөлдөг байна. Мөн хүүхдийн тээрхийн арьс нь хэн нэгэн, гадны нөлөөгүй байгалийн жамаар өөрөө шамлагддаг, харин гаднаас нь шамлах гэж оролдох нь төрөл бүрийн эмгэг, өвдөлтийг бий болгох үр дагавартай байна.

6 Сэтгэл зүйч *Н.Ариун-Эрдэнэ* 2020 оны 06 сарын 05-ны өдөр өгсөн "Соёлын довтолгоо" ярилцлага. Эх сурвалж: <https://gogo.mn/r/y647e>

7 Сэтгэл зүйч *Д.Лхамсүрэн* 2020 оны 06 сарын 05-ны өдөр өгсөн "Соёлын довтолгоо" ярилцлага. Эх сурвалж: <https://gogo.mn/r/y647e>

8 Цинт Эмнэлэг "хүүхдийн бэлгийн бойжилт" судалгаа. (2017.04.28) Эх сурвалж: <http://en.zint.mn/clinic/b/49-eregtey-hh-dyn-beleg-erhten-hezee-shamlagdah-ve.html>

Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хуульчилсан ба 14 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт заасны дагуу хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй дархан байх эрхтэй.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 3 дугаар зүйлд хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй. Халдашгүй дархан байх гэдэг нь бие махбод, сэтгэлзүй, хувийн болон гэр бүлийн зэрэг бүх талаар бусад этгээд, гадны нөлөөлөл, дарамтаас ангид байхыг ойлгоно.

Бид насанд хүрсэн хүний бие махбод, тэр дундаа бэлэг эрхтэнд хамаагүй хүрдэггүй, тэгж хүрэх нь бэлгийн дарамт, ёс бус үйлдэл гэдгийг бүгд мэднэ. Гэтэл насанд хүрээгүй, бага насны, юмны учир мэдэхгүй, өөрийгөө хамгаалж, илэрхийлж чадахгүй бага насны хүүхдийн хамгийн эмзэг, хувийн эрхтэнд өхөөрдөж байгаа нэрээр дураараа хүрч, энэ үйлдлийг нь нийгэм хэвийн зүйл мэт хүлээж авсаар байх нь хүүхдийн эрх, халдашгүй байдлыг зөрчиж буйн хамгийн том илрэл юм.

Тамхилах ёс нь бэлгийн санаа зорилгогүй боловч объектив талын үйлдлээрээ хүүхдийн хүсэл зоригоос гадуур түүний бэлэг эрхтэнд хүрч, хүүхдийн сэтгэл зүйд өөрчлөлт оруулж буй үйлдэл юм. Хүн бүр халдашгүй байх эрхийнхээ хүрээнд өөрөө хүсээгүй бол хэнийг ч өөрийн бие махбоддоо, ямар ч шалтгаанаар хүргүүлэхгүй байх эрхтэй. Хайр, халамжийн энхрийлэл байна уу? Ямар ч шалтгаан, зорилготой бай гэсэн хүний биед, тэр тусмаа эмзэг эрхтэнд хүрэх, олон нийтийн газар өмдийг нь шувтлах, уг үйлдэлдээ инээх, хүүхдийг шоолох нь хүүхдийн өөрөө өөрийнхөө эзэн байх наад захын эрхэд халдаж буй үйлдэл юм.


Жишээ нь, өсвөр насны эрэгтэй хүүхдэд тамхилах үйлдэл хийх гэж оролдвол эсэргүүцэж, уурлаж, ичнэ. Гэтэл бага, балчир насны хүүхэд нь өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадваргүй (зарим нь хэлд ч ороогүй), өөрийгөө хамгаалах, эсэргүүцэх чадваргүй, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, эрх, эрх чөлөөний талаар ямар ч ойлголтгүй байдаг. Өөрийгөө хамгаалж чадахгүй байдлыг нь далимдуулан бага насны хүүхдийн бие, эрх, эрх чөлөөнд дураараа халдах энэ хуучирсан ёс заншлыг яаралтай халах шаардлага, цаг үе ирээд байна.

1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улс Хүүхдийн Эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан ба үүнээс хойш даруй 30 жил өнгөрсөн боловч бид хүүхдийн эрхийг зөрчиж буй наад захын халдлага, хүчирхийлэл, дарамтыг халаагүй л явна. Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 6 дугаар зүйлд “оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангах”, 19 дүгээр зүйлд “Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л

хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна” гэж заасны дагуу төрөөс хүүхдийн энэ хүчирхийлэл, халдлагыг халах, хориглох хууль эрх зүйн зохицуулалт батлаж, дагаж мөрдүүлэх шаардлагатай.

Эцэг эх бид энхрий балчир үрсээ өөрсдөө ч мэдэлгүй энэ халдлагын бай болгохоос сэргийлж, хуучирч, бугшсан муу ёс заншлыг халж, хүүхдэд ээлтэй шинэ сайхан ирээдүйг бүтээх нь зүйтэй.

Нэг ч хүүхдийн эрх бүү зөрчигдөөсэй!



ДИЖИТАЛ ЗАСАГ

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ УЛС ТӨРД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Г.Золзаяа

Отгонтэнгэр Их Сургуулийн багш, (МА)

Түлхүүр үгс: Хиймэл оюун ухаан, Ардчилал, Улс төрийн шийдвэр, Хөгжил

Key words: Artificial intelligence, Democracy, Political decision-making, Development

ОРШИЛ

2018 оны ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр “Алис” (Alice) хэмээх нэр дэвшигч өрсөлдөв. Тэрээр кампанит ажилдаа “Таныг хамгийн сайн мэдэх ерөнхийлөгч” гэсэн уриатайгаар хэдэн мянган хүний саналыг авсан. Гэтэл Алис нь “Yandex” компаний хөгжүүлсэн хиймэл оюун ухаан (AI) байв.

2017 онд Японы нийслэл Токио хотын нэгэн дүүрэг болох Тама хотод болсон Хотын даргын сонгуулийн үеэр Михихито Мацуда (Michihito Matsuda) нэртэй хиймэл оюун ухаан нийт нэр дэвшигчдээс авсан саналын тоогоор III эрэмбэлэгдсэн. Мөн Шинэ Зеланд Улсад Сэм (Sam) нэртэй машиныг 2020 оны бүх нийтийн сонгуульд оролцуулахаар бүтээсэн нь дэлхийн хамгийн анхны виртуал улс төрч гэж нэрлэжээ.

Дижитал сурталчилгаанаас эхлээд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хүртэл интернет улс төрийг өөрчилсөн. Гэхдээ хиймэл оюун ухааны өсөлт нь ардчилсан үйл явцад улам гүнзгий сорилтуудыг авчирч байна. Хиймэл оюун ухааны эринд ардчилал оршин тогтнох боломжтой юу? Эсвэл бүх нийтээр хүссэн хүсээгүй “Tech-Totalitarianism”-руу шилжих үү? хэмээх асуулт бидний өмнө тулгарч байна. Иймд дээрх өгүүлэлд хиймэл оюун ухааныг улс төрд ашигласнаар ямар үр нөлөөтэй болох талаар тодорхойлохыг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хиймэл оюун ухаан нь эмнэлгийн оношлогоо, эмчилгээнээс эхлээд замын хөдөлгөөний хяналтын систем, хүрээлэн буй орчныг хамгаалах хүртэл ихээхэн ашиг тустай байдаг. Гэхдээ хиймэл оюун ухааны хүч нь бидний үндсэн эрх, ардчилсан нийгмийн үйл явц, дадал, институцид ноцтой сорилт, заналхийлэл учруулдаг бодит жишээнүүд олон байдаг. Жишээ нь: 2020 он гэхэд Хятадын (Social credit system) нь иргэн бүрийн үйл хөдлөлийг хянах бөгөөд төрийг шүүмжилсэн бичлэг, санал, шүүмжлэлд хариуцлага тооцох юм. Иргэн бүрийг

оноогоор дүгнэж, оноо өндөр иргэд сайн орон сууцтай болох, өндөр хурдны интернетэд холбогдох, хүүхдүүдээ нэр хүндтэй сургуульд сургах, ашиг олох боломжтой ажилд орох гэх мэт урамшуулал хүртдэг.

Хиймэл оюун ухааны шийдвэр гаргах хандлага нь хүмүүсийн хэлэлцүүлэг, хариуцлагыг орлож байгаа бөгөөд "Cambridge Analytica"-ийн нэгэн адил ардчиллын үйл явцад хөндлөнгөөс оролцох, хүн амыг хянах, ажиглалт хийхэд сөргөөр ашиглаж болно.

Нэг талаас бид олон нийтийн мэтгэлцээнийг хөнгөвчлөх, хүмүүсийг холбох, мэдээллийн урсгалыг хөнгөвчлөх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан харилцааны платформуудаас ашиг хүртдэг. Эдгээр шинж чанарууд нь бүгд ардчилсан яриа, хэлэлцүүлгийн үндсэн элемент юм. Гэсэн хэдий ч хиймэл оюун ухааны хэрэглээг ардчилсан улс төрийн үйл ажиллагааг алдагдуулахад ашиглаж болзошгүйг дээр дурдсан.

Европчуудын технологид хандах хандлагын талаархи шинэ судалгаанаас харахад улс төрчдийн оронд бодлогын шийдвэрийг хиймэл оюун ухаанаар хийвэл хүмүүсийн дөрөвний нэг нь үүнийг илүүд үзэх болсон байна.

Испанийн IE их сургуулийн дэргэдэх Өөрчлөлтийн засаглалын төвөөс 1-р сард Их Британи, Испани, Герман, Франц, Ирланд, Итали, Нидерландын 2500 насанд хүрэгчдийн дунд санал асуулга явуулжээ. Судалгааны үр дүнгээс харахад технологийн дэвшлийн үр дүнд гарч буй өөрчлөлтөд сэтгэл түгшсэн байдал ажиглагдаж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь ажлын байрыг роботоор солих болно гэж санаа зовж, 70% нь хяналтгүй технологийн шинэчлэл нь нийгэмд ашиг тусаас илүү их хор хөнөөл учруулж болзошгүй гэж үзэж байна. Судалгаанд оролцогчид илүү олон хүмүүс онлайнгаар цагийг өнгөрөөдөг тул хүмүүсийн харилцааг орлох дижитал харилцаа хэрхэн нөлөөлж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлсэн байна.

Гэсэн ч ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хиймэл оюун ухаан Алисд 24 цагийн хугацаанд Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчээр 2500 гаруй хүн саналаа өөрийн цахим хуудасаар дамжуулан өгчээ. Учир нь энэхүү кампанит ажлын үеэр Алис бусад (Хүн) нэр дэвшигчдээс:

- Логик сэтгэлгээ
- Сэтгэл хөдлөл, гадаад үзэмжид автдаггүй
- Хувийн эрх ашгийг эрэлхийлдэггүй
- Өнгөц, хувийн үзэмжээр дүгнэлт өгдөггүй
- Мөн 24/7 ажиллах боломжтой бөгөөд хөгширдөггүй,
- Хүний тархинаас 7 дахин хурдан ажилладаг оюун ухаантай
- Олон сая санал бодлыг харгалзан үзэх чадвартай хэмээн тодорхойлсон.

Алиса: "Зөвхөн тодорхой алгоритмын үндсэн дээр батлагдсан оновчтой шийдвэрт үндэслэн оновчтой шийдвэр гаргана"

Ардчилсан засаглалд хиймэл оюун ухаанаас үүдэн гарах эрсдлүүд:

- Хүмүүсийн нүүрний дүр төрх, дуу хоолой, эсвэл тэдний ярианы агуулга, хэлбэрийг хиймэл оюун ухаанаар бий болгох арга хэмжээ авах нь Cambridge Analytica-тай холбоотой өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга техникээс гадна ардчилсан сонгуульд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг олгодог. Жишээ нь: АНУ-ын Төлөөлөгчдийн танхим дахь Ардчилсан намын удирдагч Нэнси Пелозигийн хэлсэн үг өөрчлөгдөж, буруу сонсогдож, Пелозиг согтсон гэсэн буруу ойлголтыг бий болгосноор дээрх эрсдэл бодитоор иргэдэд нөлөөлсөн. Ийм өөрчлөлт нь хууран мэхлэлт бөгөөд энэ нь ардчилсан замаар сонгогдсон улс төрчид эсвэл төрийн албан тушаалд томилогдохоор бэлтгэж буй хүмүүсийн итгэлийг бууруулж болзошгүй юм.
- Хиймэл оюун ухаан нь хүний хувьд сэргээн босгоход хэцүү, боломжгүй байдаг хар хайрцгаар, машинаар шийдвэр гаргах боломжийг олгодог. Ажилд авах, дадлага, багшийн үнэлгээ зэрэг олон салбарт улам бүр ашиглагдаж байгаа нь хүнээс илүү машинаар шийдвэр гаргах түвшинд шилжих нь хариуцлага, хариуцлагын зарчмуудыг алдагдуулж, маш их асуудал үүсгэх эрсдэлтэй.
- Авторитар дэглэмтэй орнуудад хиймэл оюун ухааны систем нь дотоодын хяналт, тандалтыг шууд ашиглаж, дотоодын аюулгүй байдлын хүчнүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, мессеж, имэйл, утасны дуудлага зэрэг олон тооны мэдээллийг боловсруулахад илүү хурдан бөгөөд үр дүнтэй тусалдаг. Цагдаагийн байгууллага эдгээр системүүдийн олж мэдсэн мэдээлэлд үндэслэн нийгмийн чиг хандлага, дэглэмд заналхийлж болзошгүй тодорхой хүмүүсийг тодорхойлж чадна.

Жишээлбэл, Хятадын засгийн газар Хятад дахь үндэстний цөөнх амьдардаг бүс нутгуудад өргөн хүрээтэй хэлмэгдүүлэлт хийхэд хиймэл оюун ухааныг ашигласан.

Шинжаан, Түвд дэх тандалтын системийг “Орвеллиан” гэж тодорхойлсон байдаг. Эдгээр хүчин чармайлтын хүрээнд ДНХ-ийн заавал дээж авах, Wi-Fi сүлжээний хяналт, нүүрний таних өргөн камер зэргийг багтаасан болно. Эдгээр системийн тусламжтайгаар Хятадын эрх баригчид АНУ-ын Төрийн департаментын мэдээлснээр 1-2 сая хүнийг «дүр мэдэн саатуулсан» байна.

Хятадын засгийн газар Хятад дахь үндэстний цөөнх амьдардаг бүс нутгуудад өргөн хүрээтэй хэлмэгдүүлэлт хийхэд хиймэл оюун ухааныг ашигласан.

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ АРДЧИЛСАН ТОГТОЛЦООНД ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ НӨЛӨӨ

Хиймэл оюун ухаан нь улс төр, эдийн засгийн чиглэлээр илүү оновчтой шийдвэр гаргахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм. Машин сурах (machine learning), мэдээллийн шинжлэх ухаан, урьдчилан таамаглах чадварыг засаглалд ашиглах нь бодлого боловсруулагчид нотолгоонд суурилсан бодлого хэрэгжүүлэх боломжийг олгож болох юм. Улс оронд юу хэрэгтэй, асуудлыг хэрхэн шийдэж болох талаар нарийн дүр төрхийг харуулах боломжтой. Жишээлбэл, Урьдчилан таамагласан анализ хийх замаар эдийн засгийн хямралд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлж, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өгөх боломжтой. Мөн эдийн засагт бизнесийн мөчлөгийн сөрөг үр дагаврыг үнэн зөв урьдчилан тооцоолох, багасгах боломжтой байж болох юм.



Хиймэл оюун ухаан нь улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг «улс төрийн», намчирхал багатай, нотолгоонд суурилсан болгох, харилцан буулт хийхийн тулд илүү нарийвчлан судлах шаардлагатай асуудлууд дээр зөвшилцөлд хүрч, туйлшралыг бууруулах боломжтой юм.

Өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах нь засгийн газар иргэдтэй харилцах, төрийн үйлчилгээг аль болох үр дүнтэй аргаар үзүүлэх боломжийг олгох замаар ардчилсан тогтолцоог илүү сайжруулах юм.

Даниэл Эсти, Рийз Рашинг нарын бичсэнчлэн “Мэдээллийн шинэ технологиуд нь хэд хэдэн жилийн өмнө боломжгүй байсан олон тооны мониторинг хийх, өгөгдөл солилцох, дүн шинжилгээ хийх, бодлогын үнэлгээ, гүйцэтгэлийн харьцуулалтыг хийж байна. Энэ нь яг одоо шөнийн дунд өтгөн манан дундуур давхиж байгаатай адил юм. Мэдээллийн зөрүү их байгаа нь асуудлыг тодорхой харж, цаашдын чиглэлийг тодорхойлоход хэцүү болгодог.” Иймд хиймэл оюун ухааныг улс төрийн үйл ажиллагаанд оновчтойгоор ашигласнаар үр дүнтэй, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргахад саад болж байсан өгөгдлийн зөрүүг арилгах боломжтой.

Ардчилсан засаглалын дотоод шинж чанар бол алдаанаас суралцах, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар юм. Үүнд нээлттэй нийгэм нь програм хангамж хүрээлэн буй орчноосоо тасралтгүй суралцаж өөрийгөө сайжруулахын тулд машин сурах парадигмтай ижил төстэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Арматурын дэвшилтэт алгоритмуудыг улс төрд ашиглах нь засгийн газрын үр ашгийг ихээхэн нэмэгдүүлэх болно. Эцсийн эцэст, олон өгөгдөл авах тусам одоо байгаа алгоритмууд илүү сайн ажиллаж, өгөгдөлд суурилсан бодлого боловсруулагчид илүү үр дүнтэй засаглалыг хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Нээлттэй нийгэм нь хаалттай нийгэмтэй харьцуулахад илүү их амжилтанд хүрч ирсэн нь мэдээлэл боловсруулахтай холбоотой. Дарангуйллын засаглалтай улс орнууд мэдээллийн төвлөрсөн боловсруулалтыг ашигладаг бол нээлттэй нийгэм нь олон тооны мэдээлэл боловсруулах нэгжүүдээр тархдаг. Тархсан боловсруулалт нь илүү үр дүнтэй загвар болох нь батлагдсан бөгөөд хэрэв олон тооны боловсруулагчдын нэг нь (засгийн газар, ТББ, бизнес, иргэний нийгэм) бүтэлгүйтсэн бол бусад нь алдааг олж илрүүлж, засч залруулахыг эрмэлздэг.

“Дарангуйллын дэглэмд ганц шийдвэр гаргагч байдаг. Хэрэв энэ шийдвэр гаргагч нь авъяаслаг, ухаалаг удирдагч бол (Маогийн дараах Хятадад гэх мэт) тухайн улс амжилтанд хүрч магадгүй ч бага зэргийн алдаа нь сүйрлийн үр дагаварт хүргэж болзошгүй тул засч залруулах систем байдаггүй.”

Хиймэл оюун ухааны тусамжтай сонгогчид нэр дэвшигч бүрийг өнгөрсөн ажлын туршлага, үйлдэл, манлайлах ур чадвараар нь шинжилж, аль нэр дэвшигчид санал өгөх талаар тодорхой мэдээллийг авах боломжтой.

Хиймэл оюун ухааны хэрэглээнд үндэсний, үндэсний болон олон улсын түвшинд улс төрийн болон эрх зүйн хяналт тавих ажил хөгжингүй орнуудад эхлүүлсэн. Их Британийн хүрээнд парламентын сонгон шалгаруулах хэд хэдэн хороод мэдлэг, мэдээлэл дээшлүүлэх, шинэ хууль, удирдамжийг мэдээлэх ажлыг эрэлхийлсэн. Хиймэл оюун ухааныг идэвхжүүлсэн технологи, тэдгээрийн оролцдог бодлогын чиглэлтэй холбоотой одоо байгаа хяналтын журамд Мэдээллийн комиссар, хяналтын камерын комиссар, биометрийн комиссар зэрэг олон нийтийн байгууллагууд хамрагддаг.

Дэлхийн хэмжээнд хиймэл оюун ухаан хөгжиж, тархаж байгаа нөхцөлд үндэсний зохицуулалтыг бий болгох хүчин чармайлт нь үр дүнгүй болж магадгүй тул олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай юм. Жишээлбэл, Европын холбооноос Хиймэл оюун ухааны түр хороо байгуулж, хиймэл оюун ухааны хүний эрх, ардчилал, хууль дээдлэх байдалд үзүүлэх нөлөөллийг судалдаг.

Европын Холбоо хиймэл оюун ухааныг ашиглах талаархи ёс зүйн удирдамжийг боловсруулж, Мэдээлэл Хамгаалах Ерөнхий журмаараа мэдээлэл хамгаалах чиглэлээр хиймэл оюун ухааныг зохицуулах үндсэн тогтолцоог нэвтрүүлсэн.

Европын Холбоо хиймэл оюун ухааныг ашиглах талаархи ёс зүйн удирдамжийг боловсруулж, Мэдээлэл Хамгаалах Ерөнхий журмаараа мэдээлэл хамгаалах чиглэлээр хиймэл оюун ухааныг зохицуулах үндсэн тогтолцоог нэвтрүүлсэн.

ДҮГНЭЛТ

Ойрын хэдэн арван жилд хиймэл оюун ухаан дэлхийн хэмжээнд эрс өөрчлөлт хийх төлөвтэй байгаа тул ирээдүйд хүмүүс машин механизмтай хамт засаглах эсэх асуудал хурцаар тавигдаж байна. Иргэд улс төрчдөд бухимдах тусам тэдний ялах магадлал өссөөр байна.

Хиймэл оюун ухааныг ардчилсан улс төрд зүй бусаар оролцуулахын эсрэг арга бол хиймэл оюун ухааныг ардчилсан засаглалд тохируулан ашиглахуйц болгох, хяналт, зохицуулалтыг зөв тавих бөгөөд ингэснээр хүний хөгжил, нийгмийн хэрэгцээ, нийгмийн нөлөө, иргэдийн хамгаалал, ялангуяа эмзэг, гадуурхагдсан хүмүүс, олон нийтийн хамгаалалтыг баталгаажуулах боломжтой юм.

НОМ ЗҮЙ:

1. Lanisha Butterfield, University of Oxford, How AI is shaping the future of politics, 2018
2. Sukhayl Niyazov, "A.I. Will Mark A Turning Point in the History of Politics: How technology can make the world more democratic", 2020.02.11 (Web)
3. Tulio Chiarini and Steve Evans "Empowering political participation through artificial intelligence" Science and Public Policy, 46(3), 2019
4. <https://www.themoscowtimes.com/2017/12/07/artificial-intelligence-robot-alisa-nominated-for-russian-president-a59845>

МОНГОЛ ДАХЬ ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА: СОРИЛТ БА БОЛОМЖ

Х.Золжаргал

Улс төр судлалын магистр

ЦАХИМ ЗАСАГЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ? ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Дэлхийн улс орнууд аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжсэн эринд шилжих үйл явц улам эрчимжиж, нийгмийн баялаг, үнэт зүйлсийг бүтээх эх сурвалж нь мэдлэг, мэдээлэл гэдгийг хүлээн зөвшөөрч улс төр, эдийн засаг, төрийн үйлчилгээ, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг өргөнөөр нэвтрүүлэн ашиглаж байна.

НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн судалгааны дүгнэлтэд төр төвтэй нийгмийг иргэн төвтэй нийгэм болгон өөрчилж, төрийн үйлчилгээг тухайн улсын өнцөг булан бүрт амьдарч буй иргэдэд хүргэх боломжийг мэргэшсэн, үр өгөөжтэй, хүртээмжтэй, ил тод байдлыг хангасан цахим засаглал олгох боломжтойг онцолсон байна.

Засгийн газрын зүгээс төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр буюу интернетийн сүлжээ, цахим төхөөрөмжийг ашиглан иргэд, бизнесийн байгууллага болон хөдөлмөр эрхлэгчдэд хүргэж буй цогц үйл явцыг цахим засаглал гэж тодорхойлж болно. Олон улсын хэмжээнд цахим засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг хэлбэрийн хувьд:


1. "Government to citizens"- Төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээ
2. "Citizen to Government"- Иргэдээс төрд чиглэсэн харилцаа
3. "Government to Government"- Төрийн байгууллагуудын хоорондох харилцаа
4. "Government to Employees"- Төрийн байгууллагаас хөдөлмөр эрхлэгчид рүү чиглэсэн үйлчилгээ
5. "Government to Business"- Төрийн байгууллагаас бизнесийн байгууллагууд руу чиглэсэн үйлчилгээ гэж ангилдаг байна.

Цахим засаглалыг улс орондоо амжилттай нэвтрүүлсэн хөгжиж буй болон хөгжингүй улс орнууд мэдээлэл холбооны төвлөрсөн бус, нээлттэй дэд бүтцийг байгуулж, төрийн төрөл бүрийн үйлчилгээ, мэдээллийн сангуудыг хооронд нь холбосон иж бүрэн цогцолбор сүлжээг бий болгожээ.

Уг дэд бүтэц нь шинэ салбар, шинэ бүтээгдэхүүнээр нэмэгдэж тухайн улсын цахим засаглалын сүлжээ өргөжин тэлж иргэд, бизнесийн байгууллагуудын шинэ хэрэгцээ, шаардлагыг хангах боломжийг бүрдүүлсэн байна. Цахим засаглалыг амжилттай нэвтрүүлсэн Эстони улсад нийтийн засаглалын ил тод, нээлттэй байдлыг хангаж иргэд, төрийн байгууллагууд болон бизнесийн байгууллагууд мэдээллээ аюулгүй өндөр хамгаалалттай цахим орчинд солилцох боломжтой болсон.



ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС



UNITED NATIONS
Map No. 4607.1 June 2020

(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020)

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс (UN DESA) -аас дэлхийн улс орнуудын цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийг 2001 оноос хоёр жил тутамд харьцуулан судалж эхэлсэн байна. Харин 2020 онд НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн хэлтсээс дэлхийн 193 орныг хамруулсан судалгааг боловсруулахдаа дараах 5 үндсэн үзүүлэлтийн хүрээнд судалжээ.

1. "The Online Service Questionnaire"- Цахим буюу алсын зайны үйлчилгээний санал асуулга
2. "The Telecommunication Infrastructure Index"- Харилцаа холбооны дэд бүтцийн индекс
3. "The Human Capital Index"- Хүний нөөцийн индекс
4. "The EGD Results"- Цахим засаглалын хөгжлийн индексийн үр дүн
5. "The Pilot Assessment of Local E-Government Development"- Орон нутгийн цахим засаглалын хөгжлийн туршилтын үнэлгээ

Энэхүү таван үндсэн бүлэг үзүүлэлтэд тулгуурлан тоон аргачлалыг ашиглаж дэлхийн 193 орны цахим засаглалын хөгжлийн индексийг тооцоолон гаргасан байна.

Цахим засаглалыг иргэдэд илүү ил тод, мэргэшсэн, хүртээмжтэй байдлаар хүргэснээр иргэд гэрээсээ гарахгүйгээр сонгуульд саналаа өгөх, бүх төрлийн тайлан, мэдээ бэлтгэн, холбогдох маягт, гэрээ хэлцэл дээр өөрийн гар утсаа ашиглан гарын үсгээ зурах, компани буюу хуулийн этгээдийг хэдхэн минутын дотор бүртгүүлж төрийн үйлчилгээг цахим төхөөрөмжөө ашиглан түргэн шуурхай авах боломж бүрдэх юм.

ПОСТКОММУНИСТ УЛС ОРНУУДЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТҮВШИН

Монгол улсын цахим засаглалын хөгжлийн түвшинг тодорхойлохын өмнө бид өөрсдийнхөө бүс нутагтаа болон посткоммунист улсууд дотроо үнэлэгдэх үнэлэмжийг танин мэдэх шаардлагатай тулгарч байна. Иймд ардчиллын гурав дахь давалгаанд өртөн бидэнтэй адил ардчилсан шилжилт хийсэн посткоммунист улсуудын цахим засаглалын хөгжлийн түвшинг харьцуулан судлах нь илүү бодитой юм.

Хөгжиж буй посткоммунист улс орнуудын интернетийн эрх чөлөө болон цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлтэд харьцуулсан судалгаа хийхэд Эстони улс дэлхийн 193 орноос 0.94 оноогоор 3 дугаар байранд эрэмбэлэгджээ. Харин интернетийн эрх чөлөөний үзүүлэлтээр тус улс посткоммунист 20 улсаас хамгийн өндөр буюу 94 оноогоор тэргүүлсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1: Посткоммунист улс орнуудын Цахим засаглалын хөгжлийн түвшин

№	Улсын нэр	Эрх чөлөөний индекс	Цахим засаглалын хөгжлийн индекс		Интернетийн сүлжээний эрх чөлөөний байдал		Засаглалын хэлбэр
			Оноо	Эрэмбэ	Оноо	Эрх чөлөөний байдал	
1	Азербайжан	Эрх чөлөөгүй	0,71	70	39	Эрх чөлөөгүй	Хагас ерөнхийлөгч
2	Армени	Хагас эрх чөлөөтэй	0,71	68	76	Эрх чөлөөтэй	Парламент
3	Беларусь	Эрх чөлөөгүй	0,80	40	35	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгч
4	Болгар	Эрх чөлөөтэй	0,79	44	70	Эрх чөлөөтэй	Парламент
5	Казахстан	Эрх чөлөөгүй	0,83	29	32	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгч
6	Киргизстан	Хагас эрх чөлөөтэй	0,67	83	61	Хагас эрх чөлөөтэй	Парламент
7	Латви	Эрх чөлөөтэй	0,77	49	71	Эрх чөлөөтэй	Парламент
8	Литва	Эрх чөлөөтэй	0,86	20	73	Эрх чөлөөтэй	Хагас ерөнхийлөгч
9	Молдав	Хагас эрх чөлөөтэй	0,68	79	60	Хагас эрх чөлөөтэй	Парламент
10	Монгол	Эрх чөлөөтэй	0,64	92	75	Эрх чөлөөтэй	Парламент
11	Оросын Холбооны Улс	Эрх чөлөөгүй	0,82	36	60	Хагас эрх чөлөөтэй	Хагас ерөнхийлөгч
12	Польш	Эрх чөлөөтэй	0,85	24	76	Эрх чөлөөтэй	Хагас ерөнхийлөгч
13	Румын	Эрх чөлөөтэй	0,76	55	74	Эрх чөлөөтэй	Хагас ерөнхийлөгч
14	Словак	Эрх чөлөөтэй	0,78	48	77	Эрх чөлөөтэй	Парламент
15	Словени	Эрх чөлөөтэй	0,85	23	75	Эрх чөлөөтэй	Парламент
16	Узбекистан	Эрх чөлөөгүй	0,66	87	26	Эрх чөлөөгүй	Ерөнхийлөгч
17	Украйн	Хагас эрх чөлөөтэй	0,71	69	56	Хагас эрх чөлөөтэй	Хагас ерөнхийлөгч
18	Унгар	Хагас эрх чөлөөтэй	0,77	52	72	Эрх чөлөөтэй	Парламент
19	Чех	Эрх чөлөөтэй	0,81	39	78	Эрх чөлөөтэй	Парламент
20	Эстони	Эрх чөлөөтэй	0,94	3	94	Эрх чөлөөтэй	Парламент

(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020, Global Freedom Status 2020)

Манай улсын хувьд 2018 онд Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн үзүүлэлтээр дэлхийн 193 улсаас 0,58 оноогоор 92 дугаар байранд эрэмбэлэгдэж байсан бол 2020 оны Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлтээр 0,64 оноогоор дэлхийн 193 улсаас мөн адил 92 дугаар байранд эрэмбэлэгджээ. Монгол улсын хувьд цахим засаглалын индексийн үзүүлэлтээр 0,64 оноог авч өмнөх судалгааны үр дүнгээс 0,6 оноогоор дээшилсэн боловч эрэмбийн хувьд өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Цахим оролцооны индекс (E-Participation Index)-ийн үзүүлэлтээр 2018 онд дэлхийн 193 улсаас 65 дугаар байранд эрэмбэлэгдэж байсан бол 2020 оны судалгааны үр дүнгээр 87 дугаар байрыг эзэлсэн үр дүнг үзүүлсэн байна.

Манай улсын хувьд цахим засаглалыг улс орондоо амжилттай нэвтрүүлэхийн тулд мэдээлэл холбооны төвлөрсөн бус, нээлттэй дэд бүтцийг шинэчлэн байгуулж, төрийн үйлчилгээ, мэдээллийн сангуудыг хооронд нь холбосон иж бүрэн цогцолбор сүлжээг хөгжүүлэх шаардлага үүссэнийг Цахим оролцооны индексийн судалгааны үр дүн илтгэж байна.

Европ тивийн улсуудын төлөөлөл болгон тус бүс нутгийн хөгжингүй 21 улсын цахим засаглалын индексийн үзүүлэлтэд харьцуулсан судалгаа хийв. НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс 2020 (EGDI) -ийн үзүүлэлтээр Хойд Европын бүс нутагт байрлах Дани, Эстони, Финлянд, Швед, Их Британи, Нидерланд, Исланд, Норвеги, Австри болон Швейцарь улсууд эхний 10 байрт эрэмбэлэгдэж тэргүүлсэн байна.

Хүснэгт 2: Европ тивийн улсуудын Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлт

№	Улсын нэр	ЦЗХИ эрэмбэ	Бүс нутаг	Европын Холбооны гишгүүн эсэх	ЦЗХИ EGDI (2018)	ЦЗХИ EGDI (2020)
1	Дани	1	Хойд Европ	Тийм	0,91	0,97
2	Эстони	3	Хойд Европ	Тийм	0,84	0,94
3	Финлянд	4	Хойд Европ	Тийм	0,88	0,94
4	Швед	6	Хойд Европ	Тийм	0,88	0,93
5	Англи	7	Хойд Европ	Үгүй	0,89	0,93
6	Нидерланд	10	Баруун Европ	Тийм	0,87	0,92
7	Исланд	12	Хойд Европ	Үгүй	0,83	0,91
8	Норвеги	13	Хойд Европ	Үгүй	0,85	0,90

9	Австри	15	Баруун Европ	Тийм	0,83	0,89
10	Швейцарь	16	Баруун Европ	Үгүй	0,85	0,89
11	Испани	17	Өмнөд Европ	Тийм	0,84	0,88
12	Франц	19	Баруун Европ	Тийм	0,87	0,87
13	Мальт	22	Өмнөд Европ	Тийм	0,80	0,85
14	Герман	25	Баруун Европ	Тийм	0,87	0,85
15	Ирланд	27	Хойд Европ	Тийм	0,82	0,84
16	Лихтенштейн	31	Баруун Европ	Үгүй	0,82	0,83
17	Люксембург	33	Баруун Европ	Тийм	0,83	0,82
18	Португал	35	Өмнөд Европ	Тийм	0,80	0,82
19	Итали	37	Өмнөд Европ	Тийм	0,82	0,82
20	Грек	42	Өмнөд Европ	Тийм	0,78	0,80
21	Хорват	51	Өмнөд Европ	Тийм	0,70	0,77

(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020)


Дани Улсын Засгийн газар мэдээлэл, холбооны дэд бүтцээ байгуулахдаа төрийн байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд болон хотын захиргаадыг холбосон иж бүрэн сүлжээг шинээр байгуулж иргэдэд ил тод, хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэх эхний алхмаа хийсэн байна. Мөн тус улсын засгийн газрын зүгээс иргэд болон бизнесийн байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломжтой тусгай цахим хаягуудыг бий болгосон байна. Түүнчлэн Данийн Засгийн газар “Хиймэл оюун ухааны үндэсний стратеги” хөтөлбөрийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэнд, нийгмийн болон бусад салбаруудын мэдээлэл, холбооны дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийж цахим засаглалын дэд бүтцийн сүлжээгээ өргөжүүлсэн байна.

Эстони улсын цахим засаглалын үндэсний сүлжээ нь дижитал шилжилтийг хэрэгжүүлж буй дэлхийн улс орнуудыг тэргүүлдэг.


Өнөөгийн байдлаар Эстони улсын иргэд гэр бүлээ батлуулах, цуцлах болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, шилжүүлэх үйл явцаас бусад төрлийн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүлээн авдаг байна.

Эстони Улсын цахим засаглалын үндэсний сүлжээ нь дижитал шилжилтийг хэрэгжүүлж буй дэлхийн улс орнуудыг тэргүүлдэг. Тус улсын иргэд бүх төрлийн төрийн үйлчилгээг цахим технологийн сүлжээг ашиглан хүлээн авдаг. Эстони улсын засгийн газар “Иргэний нийгмийн хөгжлийн стратеги”-ийг баталсан байна. Уг хөтөлбөрийн хүрээнд төрийн бодлого боловсруулах болон хуулийн төслүүдийг боловсруулахын өмнө иргэдийн санал, санаачилгыг цахим хэлбэрээр түргэн шуурхай хүлээн авдаг юм. Өнөөгийн байдлаар Эстони улсын иргэд гэр бүлээ батлуулах, цуцлах болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, шилжүүлэх үйл явцаас бусад төрлийн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүлээн авдаг байна.

Бус нутгийн улсуудын Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI 2016, 2018, 2020)



(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020)



НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн 2020 оны судалгааны үр дүнгээр бүс нутгуудын ерөнхий үзүүлэлт дээшилсэн боловч Европ тивийн бүс нутгийн улсуудын цахим засаглалын хөгжлийн индекс хамгийн өндөр үзүүлэлтээр тэргүүлж дэлхийн нийт бүс нутгийн 58 хувийг эзэлсэн байна. Харин Ази тивийн бүс нутаг 26 хувь, Америк тивийн бүс нутаг 12 хувь, Ази Номхон далайн бүс нутаг 4 хувийг эзэлж байна.

АЗИ ТИВИЙН УЛСУУДЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТҮВШИН БА АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС

Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) –ийн үзүүлэлтээр Ази тивийн улсуудаас БНСУ, Сингапур болон Япон Улс тэргүүлсэн байна. БНСУ Ази тивд Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлтээрээ 0,90 оноогоор 2 дугаар байранд эрэмбэлэгджээ. Тус улс 5 жил тутамд “Цахим засаглалын стратеги” хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж баталдаг. БНСУ-ын Засгийн газар “Цахим Засгийн газрын мастер төлөвлөгөө”-ний хүрээнд иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэдэг. Тус улсын Цахим Засгийн газрын хууль, эрх зүйн тогтолцоо нь иргэдийн хувийн мэдээллийн нууцлал болон дижитал аюулгүй байдлыг хамгаалах зохицуулалттай байдаг.

Харин Сингапур Улсын хувьд Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлтээрээ (EGDI) 0,88 оноогоор 11 дүгээр байранд эрэмбэлэгджээ. Сингапур Улсын Засгийн газрын Технологийн Агентлаг нь төрийн байгууллагуудын хоорондох харилцаа, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хэрэгжүүлж хөгжүүлдэг. 2014 онд тус улс “Ухаалаг үндэстэн” санаачлагын хүрээнд “Дижитал

Засгийн газар"-ын үйл ажиллагааг шинээр эхлүүлжээ. Сингапур улсад иргэдэд төрийн үйлчилгээг нэг цонхоор дамжуулан хүргэх боломжтой Засгийн газрын (www.gov.sg) портал ажилладаг. Мөн Засгийн газрын зүгээс иргэд нийгмийн даатгалын хуримтлал болон тайлангаа төлөвлөх боломжтой дижитал платформыг бий болгожээ. Цахим засаглалыг хөгжүүлэхтэй холбоотойгоор хууль, эрх зүйн тогтолцооны хувьд тус улс 2012 онд "Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль" болон "Кибер аюулгүй байдлын тухай хууль" -ийг баталсан.

Япон Улсад "Засгийн газрын Дижитал шилжилтийн төлөвлөгөө" нь шинэ технологиудыг нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, цахим засаглалыг бэхжүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд чиглэгддэг. Тус улсын Шинжлэх ухаан, технологи, инновацийн зөвлөл цахим засаглалын шинэ санаачилгуудыг хөгжүүлэх, мэдээлэл солилцох, түгээх, бизнесийн хөгжлийг дэмжих чиг үүрэгтэй ажилладаг. Япон улсад дижитал засгийн газрын төвлөрсөн портал (e-gov.go.jp), цахим оролцооны (e-Testimony), нээлттэй өгөгдлийн (data.go.jp) болон олон нийтийн цахим худалдан авалтын (gers.go.jp) платформууд иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлдэг.

Хүснэгт 3: Ази тивийн улсуудын цахим засаглалын хөгжлийн индекс

№	Улсын нэр	ЦЗХИ Эрэмбэ	Бүс нутаг	Хүний нөөцийн индекс	Харилцаа холбооны дэд бүтцийн индекс	ЦЗХИ (EGDI) 2020	Авлигын төсөөллийн индекс (2019)	
							Эрэмбэ	Оноо
1	БНСУ	2	Зүүн Ази	0,89	0,96	0,90	39	59/100
2	Сингапур	11	Зүүн Өмнөд Ази	0,89	0,88	0,88	4	85/100
3	Япон	14	Зүүн Ази	0,86	0,92	0,87	20	73/100
4	Кипр	18	Баруун Ази	0,84	0,87	0,77	41	58/100
5	Арабын Нэгдсэн Эмират Улс	21	Баруун Ази	0,73	0,85	0,82	21	71/100
6	Казахстан	29	Төв Ази	0,88	0,83	0,75	113	34/100
7	Израиль	30	Баруун Ази	0,89	0,83	0,79	35	60/100
8	Бахрейн	38	Баруун Ази	0,84	0,82	0,81	77	42/100
9	Саудын Араб	43	Баруун Ази	0,86	0,79	0,71	51	53/100
10	Хятад	45	Зүүн Ази	0,73	0,79	0,68	41	80/100
11	Кувейт	46	Баруун Ази	0,74	0,79	0,73	85	40/100
12	Малайз	47	Зүүн Өмнөд Ази	0,75	0,78	0,71	53	51/100
13	Оман	50	Баруун Ази	0,77	0,77	0,68	52	56/100
14	Турк	53	Баруун Ази	0,82	0,77	0,71	91	39/100
15	Тайланд	57	Зүүн Өмнөд Ази	0,77	0,75	0,65	101	36/100


(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020, Corruption Perceptions Index 2019)

ЦАР ТАХАЛ БА ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Ковид-19 цар тахлын хямралын үед улс орнуудын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж засгийн газрын зүгээс иргэдэд нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол үзүүлэхэд мэдээлэл, харилцаа, холбооны технологийн салбарын дэд бүтцийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ.

Дэлхийн улс орнуудын Засгийн газрууд цар тахлын эрчимтэй дэгдэлтийн үед үндэсний цахим сүлжээ болон нийгмийн сүлжээг ашиглан цаг үеийн мэдээллийг өөр хоорондоо түргэн шуурхай хуваалцаж байна. Түүнчлэн Засгийн газрууд үндэсний цахим сүлжээний дэд бүтцээ шинэчлэн сайжруулахдаа хувийн хэвшлийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран шинэ техник технологийг нэвтрүүлж цар тахлын дэгдэлтийн эсрэг идэвхитэй тэмцэж эхэллээ. Цар тахлын дэгдэлтийн үед бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийн хоорондох харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дижитал Засгийн газар чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Цар тахлын үед Засгийн газруудын цахим сүлжээндээ байршуулсан мэдээлэл, зөвлөмжийн өсөлтийн хувь ба халдварын батлагдсан тохиодлууд



(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гутерреш Ковид-19 цар тахлын дараа дэлхийн улс орнуудад дижитал шилжилт илүү өргөн хүрээтэйгээр өрнөх тухай мэдэгдсэн байна. Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) судалгааны дүгнэлтэд дурдсанаар НҮБ-ын гишүүн 193 улсын үндэсний цахим сүлжээнд 2020 оны 3 дугаар сарын байдлаар мониторинг, харьцуулсан судалгаа хийхэд 110 улс буюу 57 хувь нь үндэсний цахим сүлжээндээ цар тахлаас хэрхэн сэргийлэх тухай мэдээлэл, зөвлөмжийг байршуулж байсан бол 2020 оны 5 дугаар сарын байдлаар 188 улс буюу 97,5 хувь нь Ковид-19 цар тахлын тухай мэдээлэл, зөвлөмжийг үндэсний цахим сүлжээндээ байршуулсан тухай онцолсон байна. Цар тахлын хямралын үед улс орнуудын засгийн газрууд иргэдийг үнэн бодитой, шуурхай мэдээлэл, зөвлөмжөөр хүртээмжтэй байдлаар хангахын тулд технологийн компаниуд, төрийн бус байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж байна. Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед Дижитал Засгийн газрын хэрэгжүүлэх хариу үйлдэл, арга хэмжээнүүдийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүйгээр тодорхойлов.

Хүснэгт 4: Ковид-19 цар тахлын эсрэг Дижитал Засгийн газрын хариу үйлдэл

Цаг хугацаа	Бодлогын арга хэмжээ	Дижитал Засгийн газрын хариу үйлдэл
Богино хугацаанд	Хариу үйлдэл үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - Дижитал платформууд (онлайн порталууд, нийгмийн сүлжээ)-ыг ашиглаж, цаг тухай бүрт мэдээллээ солилцох - Иргэдтэй 2 талт хамтын ажиллагааг эхлүүлэх, цахим оролцоог дэмжих (хакатон, оюун санаанд нөлөөлөх арга хэмжээнүүд) - Мэдээллийн нууцлалыг хангаж хүний эрхийг хамгаалах, технологийн төлөвлөгдөөгүй үр дагаврыг харгалзан үзэх
Дунд хугацаанд	Асуудлыг шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Олон талт үр дүнтэй түншлэлийг (хувийн хэвшлийн байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд)-тай бүс нутгийн, орон нутгийн болон үндэсний түвшинд хөгжүүлэх - Төрийн албан хаагчид, хүүхэд, эмэгтэйчүүд рүү тусгайлан чиглэгдсэн дижитал бичиг үсэгт тайлагдалтын боловсролыг олгох - Дижитал хэрэгсэл, шинэ технологийг нэвтрүүлэхэд орон нутгийн захиргаанд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх - Цар тахлын хямралаас үүдэлтэй сургамж, бодлогын санал, дүгнэлтийг ашиглах
Урт хугацаанд	Цахим сүлжээний дэд бүтцийг дахин шинэчлэн байгуулах	<ul style="list-style-type: none"> - Шинэ технологиудад (хиймэл оюун ухаан, блокчейн, робот, дрон гэх мэт) хөрөнгө оруулалт хийж иргэдэд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг цахим сүлжээний дэд бүтцийг шинэчлэн байгуулах - Нийгмийн эмзэг бүлэг (цагаачид, дүрвэгсэд, үндэстний цөөнх) рүү чиглэсэн дижитал дэд бүтцийг хөгжүүлэх - Мэдээлэл хамгаалах, нууцлалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2020)

МОНГОЛ УЛСАД ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Хүснэгт 5: Монгол улсын Цахим засаглалын индексийн үзүүлэлтүүд

Засгийн газрын цахим портал	Үндэсний портал, www.zasag.mn
Бүс нутаг	Зүүн Ази
Цахим засаглалын хөгжлийн индекс	0,64 оноо, 92/193, (92 дугаар байр)
Цахим оролцооны индекс	0,60 оноо, 87/193, (87 дугаар байр)
Авлигын төсөөллийн индекс	35 оноо, 106/180, (106 дугаар байр)

(Эх сурвалж: UN E-Government Knowledgebase 2020)

Цахим засаглалын нөөц, боломжийг бүрэн ашиглаж чадвал манай улсын төрийн үйлчилгээнд хөгжлийн түүхэн боломжийг олгож байна.



Цахим засаглалын нөөц, боломжийг бүрэн ашиглаж чадвал манай улсын төрийн үйлчилгээнд хөгжлийн түүхэн боломжийг олгож байна. Сүүлийн 10 жилийн статистик үзүүлэлтүүдийг харьцуулан судлахад Цахим засаглалыг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсад ахиц дэвшил гарсан байна. 2003 оны байдлаар Монгол улс Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн үзүүлэлтээр 0,34 оноогоор дэлхийн 193 улсаас 103 дугаар байранд эрэмбэлэгдэж байсан бол 2020 оны байдлаар 0,64 оноогоор 193 улсаас 92 дугаар эрэмбэлэгджээ. Манай улсын хувьд 2005-2012 онд “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”, “Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг 2008-2012 онд, “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийг 2012-2016 онд хэрэгжүүлж иржээ. Түүнчлэн Монгол улсын Засгийн газрын зүгээс цахим засаглал бодлогын хүрээнд E-Mongolia төслийг хэрэгжүүлж төрийн бүх үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж иргэдэд нэг цонхоор төрийн үйлчилгээг хүргэхээр зорьж 2019 онд “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Монгол улсын цахим засаглалын цаашдын хөгжилд тулгамдаж буй асуудал бол цахим сүлжээний дэд бүтэц, хувь хүний нууцлал, мэдээллийн аюулгүй байдал болон дижитал аюулгүй байдлыг хамгаалах явдал юм.

Монгол Улсын цахим засаглалын цаашдын хөгжилд тулгамдаж буй асуудал бол цахим сүлжээний дэд бүтэц, хувь хүний нууцлал, мэдээллийн аюулгүй байдал болон дижитал аюулгүй байдлыг хамгаалах явдал юм.

Мөн Засгийн газрын зүгээс цахим сүлжээний дэд бүтцийн бэлэн байдал, төрийн нэгдсэн цахим сүлжээг байгуулах, иргэдийн мэдээллийн технологийн бичиг үсгийн тайлагдалт, боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг үнэлэх чадварыг

олгох шаардлагатай байна. Түүнчлэн иргэдийн хувийн мэдээллийн нууцлалын баталгаа, мэдээллийг хамгаалахтай холбоотой хувь хүний нууцыг хамгаалах, цахим засаглалыг ашиглахад итгэлийг нэмэгдүүлэх зүй ёсны шаардлага үүсч байна. Эстони улсын мэдээллийн технологийн мэргэжилтэн Сийм Сиккут жижиг улсууд цахим засаглалыг нэвтрүүлэхдээ интернетийн сүлжээний холболт, цахим сүлжээний нэгдсэн дэд бүтэц болон Засгийн газрын яам, агентлагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх гэсэн 3 үндсэн хүчин зүйлийг харгалзан үзэх тухай онцолжээ.

Засгийн газрын агентлагуудын тоо хэт олон байх тусам цахим засаглалын хөгжилд саад тотгор учруулдаг байна. Дижитал шилжилт хийх үйл явцад Засгийн газрын урт хугацааны бодлого, тогтвортой байдал, цахим технологийн дэд бүтцийн нэгдсэн сүлжээ шаардлагатай. Түүнчлэн Засгийн газар иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчид болон иргэдийн оролцоотойгоор цахим засаглалын нэгдсэн сүлжээг бий болгох боломжтой. Цахим засаглалын хөгжлийн индексийн үзүүлэлтээр дэлхийн улсуудыг тэргүүлдэг Дани, Эстони, Швед, Финлянд улсын хувьд цахим засаглалыг хөгжүүлэх эхний алхам болох цахим дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээ шинэчлэн байгуулж төрийн үйлчилгээний нэгдсэн платформ бий болгосон явдал юм.


ДҮГНЭЛТ

2020 онд дэлхийн улс орнуудыг цочроосон коронавирус цар тахлын дэгдэлт нь бүс нутгийн улс орнуудын цахим засаглалыг хөгжлийг хурдасгах зүй ёсны шаардлагыг бий болгожээ. Засгийн газрууд дижитал Засгийн газрын стратегийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн цахим сүлжээндээ хиймэл оюун ухаан (AI) болон блокчейн технологи гэх мэт шинэ технологиудыг нэвтрүүлж эхэлсэн. Засгийн газраас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний нөөц боломж хүчин чадлаасаа давсан үед хиймэл оюун ухаанд суурилсан технологи илүү үр дүнтэй болох нь батлагдаж байна. Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэхэд цахим засаглалын цаашдын хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ. Ковид-19 цар тахлын дэгдэлт нь техник технологийн ач холбогдлыг илүүтэйгээр чухалчилж буй бөгөөд илүү үр дүнтэй, хүртээмжтэй, хариуцлагатай Цахим Засгийн газар байгуулагдах боломжийг олгож байна.

СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

1. <https://www.un.org/development/desa/publications/publication/2020-united-nations-e-government-survey>, НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс судалгааны тайлан
2. <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia>, НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс судалгааны тайлан, Монгол улс
3. <https://e-estonia.com/solutions/e-governance/>, Эстони улсын цахим засаглалын хөгжил

**ИРГЭДИЙН
ОРОЛЦОО:
БАЙГАЛЬ
ОРЧИН, БАЙГАЛЬ
ХАМГААЛАЛ**



ИРГЭДИЙН ОРОЛЦОО-БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ: ЭРХ ЦАГААН ИШИГ

Б.Намуун

МУИС-ийн ШУС-ийн сэтгүүл зүйн 3 дугаар түвшин

“Охин минь дээ охин минь. Эмээгийн эрх цагаан ишиг. Ингэж газар сэндийлж болдоггүй юм шүү дээ...” гэж эмээ минь эрхлүүлж, зэмлэхийн завсар хэлдэг байж билээ.

2020 оны дөрөвдүгээр сард “Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын тусгай хамгаалалттай газраас хууль бусаар нойтон мод огтлон 400 ширхэг хананы цуулбар унь, хана бэлтгэж тээвэрлэсэн байна”, 2020 оны наймдугаар сард “Ташуунсухайт дахь гаалийн газрын нүүрсний терминалын гарах чиглэлээр авто машины чиргүүлийн урд хэсэгт, нүүрсэн дунд 43 шуудай нийт 680 кг дэрвэгэр жиргэрүү ургамлын үндсийг тээвэрлэж, улсын хилээр хууль бусаар гаргах гэж байжээ”. Энэ мэтээр байгаль орчны эсрэг гэмт хэргийг өдөр болгон мэдээлдэг. Гэхдээ бид байдаг л зүйл, байх ёстой асуудал мэтээр хүлээж аваад хэдийн дасчихсан нь харамсалтай. Тэгвэл ингэж өөрчилбөл ямар сонсогдож байна. “10-15 насны 25 охиныг хууран мэхэлж, албадлагаар хөдөлмөр эрхлүүлж, биеийг нь үнэлүүлэх зорилгоор улсын хилээр авч гарах гэж байжээ”. Хэн ч айж, цочирдохоор байна шүү дээ. Эрдэнэт хүний амийг ургамалтай зүйрлэлээ гэж бүү өгдүүцээрэй. Хар муур урдуур өнгөрвөл муу ёр гэдэгт итгэдэг ард түмэнд ингэж ойлгуулахгүй бол хэн ч анхаарахгүй нь, өршөөгөөрэй.

Дээр өгүүлсэнчлэн би эмээгийнхээ эрх цагаан ишиг нь байсан юм. Хүн бол байгалийн амьтан гэдэг. Магадгүй тийм учраас эмээ минь намайг өхөөрдөм жаахан ишигтэй зүйрлэдэг байсан биз. Эргээд санахад эмээ намайг бага байхын л амьтантай зүйрлэж, байгалиа хамгаалах олон уламжлалт арга, цээрлэх ёсыг зааж сургадаг байжээ. “Хүний нутгийн чулуу өшиглөвөл өөрийн гэрийн голомт доргидог юм” гэж сургаж байсан эмээгийнхээ үгийг тэрхэн үедээ эс ухамсарладаг байж. Гэвч сайн мууг ялгахтайгаа болсон энэ цаг үедээ нэхэн санаж буйдаа талархах юм. Эмээгийнхээ сургаалыг сонсож өссөн болохоор газар шороо, байгалиа хайрладаг нэгэн болж хүмүүжсэн ч эргээд нэг харахад олон зүйлийг анзааралгүй өнгөрөөжээ. “Эрх цагаан ишиг минь” гэж байгаад сургадаг байсан эмээгийнхээ сургаалыг ганцаар дагаж мөрдсөнөөс биш бусдад хэлж ирсэнгүй. Эсвэл бусдад хэлж дамжуулах дайтай том болохыг минь хүлээлгүй томчууд аль хэдийн газраа ухаад, усаа бараад, эрчим хүчээ дуусгаад, амьтдаараа шуба хийж өмсөөд байгалийн нөөцөө шавхчихсан бололтой.

Гэнэт л бүгд тогтвортой хөгжлийн 17 зорилго гэж ярьдаг болчихсон. Яг л цоо шинэ зүйл ярьж буй мэт. Гэвч энэ зүйл бидний оршин буй энэ цаг үед гэнэт гарч ирээд бид огт мэдэхгүй нэр томъёог чухалчлан үзэж буй хэрэг огт биш. “Эмээгийн эрх цагаан ишиг” үүнийг мэддэг байсан. Эмээ минь ч мөн мэддэг байсан. Магадгүй оюун ухаант хүн үүссэн тэр мөчөөс хойш үе үеийн хүүхэд багачууд, залуучууд, ахмад настан, азай буурлууд минь тогтвортой хөгжлийн боловсролыг нэгэндээ хэлж зааж сурган дамжуулсаар ирсэн биз.

***Монголын
уламжлалт
байгаль
хамгаалах зан
үйл, цээрлэх ёс
нь тогтвортой
хөгжлийн үндэс
юм.***

Өөрөөр хэлбэл Монголын уламжлалт байгаль хамгаалах зан үйл, цээрлэх ёс нь тогтвортой хөгжлийн үндэс юм. Хүний адгууслаг тал болох булчин шөрмөсний давамгайлал үеэ өнгөрөөж, хүний бурханлаг тал болох оюун ухаан дээрэлхэх болсон энэ цаг үед бид булчингийн хүчнээс эрчим хүч рүү шилжсэн билээ. Яг л палеоцений үед үлэг гүрвэлийн үе дуусгавар болж плиоцений үед мөстлөгийн үе эхэлж байсан шиг. Технологи хурдацтай хөгжиж эхэлсэн. Үүнийг дагаад бид шинжлэх ухаан, материализмд хэт анхаарч байгальд хандах хандлагад ч хүнлэг энэрэнгүй үзэл огт илрэхээ больсон билээ. Бид газрыг өөрийн дураар өөрчилж, үйлдвэрийн хог хаягдлыг байгальд шууд гарган, зам харилцааг бий болгохдоо зөвхөн өөрсдийн зорилгын үүднээс ханддаг болсон. Ургамал ногоо, ундны ус, далай тэнгис, цэвэр агаараар баян байсан тэр үедээ хүн төрөлхтөн хөгжиж дэвшихийн тулд байгалиа сүйтгэсэн. Улмаар өөрсдийгөө ч сүйтгэсэн. Бид ядуурсан, бид өлссөн, бид өвчилсөн, бид тэгш эрхийг хүссэн. Хүн төрөлхтөн хүй нэгдлийн үе, газар тариалангийн үе, үйлдвэржсэн нийгэм, үйлдвэржилтийн дараагийн нийгмийг туулж өнгөрүүлж ахиц дэвшил гаргаж олон он жилийг өнгөрөөхдөө байхгүй зүйлийг байлгахын тулд хөдөлмөрлөсөн. Гэвч хэн ч байгаа зүйлээ байхгүй болгож буйгаа ухаараагүй. Хүн болоод нийгэм нь байгальтай харилцан шүтэлцээтэй байхаас өөр аргагүй гэдгийг таталцлын хүч, шувуудын нүүдэл, голын урсгал батлаад байхад ч бид ойлгоогүй. Яг үнэндээ өнөөгийн байгаль орчны асуудал бүрхэг, биднээс хол хөндий мэт боловч өдөр тутмын хэрэглээ амьдралын хэв маягтай шууд холбоотой байдаг. Бид байгаль дэлхийгээ хайрлахыг нэг их томоор ойлгож ярьсаар байгаад өөрийнхөө сэтгэлд дарамт үүсгэж хий хоосон хөөрцгөөсөөр өнөөг хүрсэн. Гэвч автомашинаар явах уу, дугуйгаар явах уу гэдгээс л тогтвортой хөгжлийн боловсрол эхэлдэг юм.

Их засаг хуульд хөрс шороог алдаж, өвс бэлчээрийг хохироулахыг хориглоно гэж цээрлэсэн нь нүүдлийн мал аж ахуйт оронд газар, нутаг өвс бэлчээр нэн чухлыг тодотгон авч зүй бусаар ашиглахыг хориглож байжээ. Мөн хавар, зун хоёр улиралд өдрөөр усанд орох, гол мөрөнд гараа угаах, алт мөнгөн саваар ус татах, хээр талд хувцас угааж, хатаахыг хориглоно. Усанд ба үнсэнд шээж, газарт сүү болон бусад идээ цагааны зүйл асгаж болохгүй. Энэ бүгдийг зөрчвөл даруй цаазлах ялтай байв.

Марко Поло тэмдэглэлдээ “Монголчууд өртөө замын хоёр хажуугаар мод тарьсан нь нар шарахгүй сүүдэртэй, өвөл цас унахад зам алдаж төөрөхгүй сайн талтай. Энэ модод алсаас их сүрлэг харагдана. ...Говь цөлийн зам дагуу ч мөн тийм мод суулгасан нь худалдаачид хийгээд элч нарт туйлын таатай. Тэрчлэн бүх хаант улс, муж улсын замын дагуу тийм мод буй ажээ” гэж бичжээ. Хубилай хааны их замын дагуу хоёр, хоёр алхмын зайтай газар мод тарихыг заасан нь ургамал, бэлчээр хамгаалал төрийн бодлогын дор байсныг гэрчилнэ. Гэвч өнөөдөр бидэнд байгаль хамгаалах хууль цааз битгий хэл ухамсар ч нэн тааруу байна.

Бага байхад эмээ бид хоёр байшингийн дээвэр дээрх шувууны сангас цуглуулдаг байж билээ. Дээвэр дамжин сангас цуглуулж, ишиг шиг харайж явдаг болохоор эмээ намайг эрх цагаан ишиг гэж нэрлэсэн байх. Муухай үнэртэй эл ажлыг хийж дууссаны дараа нэг хэсэгтээ шувуу харахаар үмхий үнэртэй шиг санагдаж, төвөгшөөдөг байв. Устай модон торхонд цуглуулсан сангасаа хийж, 7 хоног торхныхоо амыг даавуугаар таглаж исгэсний дараа үнэр нь бүр ч долоон дор юм болдог байж билээ. Иссэнийх нь дараа торхонд анх байсан устай ижил хэмжээний ус нэмснээр шингэн бордоо бэлэн болно. Муухай үнэртэй сангасыг таримлын ургацыг 25-30 хувь нэмэгдүүлэх бордоо болгох ажил дөрөвдүгээр сард сангас цуглуулах ажлаар эхэлж, зуны 3 сар бордоо болгон бэлдсэнээр өндөрлөдөг байлаа. Шингэн бордоогоор ургамлаа усалсан жил хогийн ургамал, хортон шавжаар сүйтгэгдэх нь бага байдаг гэж эмээ ярьдаг байв. Одоо бодоход энэ арга ургацыг нэмэгдүүлж, ус ашиглалтыг бууруулах зэрэг олон давуу талтай байжээ. Төр юу ч хийхгүй байна гэж гомдоллохгүйгээр байгалиа хамгаалах аргад эмээгийнхээ ачаар суралцаж, өнөөдөр хүмүүс төдийлөн мэддэггүй олон ажлыг хамтдаа хийдэг байв.

Монгол орны бэлчээр нутгийн 70 орчим хувь нь доройтсон байдаг. Бэлчээрийн доройтлын гол шалтгаан нь бэлчээрийн даацыг хэтрүүлж ашиглах юм. Доройтсон бэлчээрт ишгэн шарилж, өмхий өвс, үхэр шүлхий зэрэг ихээр ургасан байдаг. Бэлчээрт тархсан шарилжийг 30-50 орчим хувийн бүрхэцтэй байхад нь хадвал үндсэн ургамлыг сэргээдэг гэдгийг ч эмээгээсээ сурч билээ. Гадаа гарч эр, гэрт орж эм болдог эмээ маань малчны морин машинаар шарилж хаддаг байсан нь трактор хадуур байхгүй гэж гараа хумьж суугаагүй ажээ. Шарилж хадсанаар бэлчээрийн үндсэн ургамал сэргэж, дарш тэжээл бэлтгэн, малын тэжээлийн нөөц нэмэгдүүлэх давуу талтай. Түүнчлэн орчны нөхцөл сайжирч, шарилжны тоосонцрын тархалт багасдаг байна.

Бидний өнөөдрийн үйл ажиллагаа бидний маргаашийн ирээдүйд эерэгээр, эсвэл эсрэгээр нөлөөлж байдаг учир цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиуд, боловсролын байгууллагууд нь хүүхэд залуучуудыг хариуцлагатай, дэлхийн иргэн болгон төлөвшүүлэх, хамтран аж төрөх, хамтран ажиллах, суралцахад сургах, уур амьсгалын өөрчлөлт зэрэг глобал асуудлуудыг хамтдаа шийдэхэд сургахад чиглэн ажиллах хэрэгтэй

болж байгаа юм. Тогтвортой хөгжлийн боловсрол нь боловсролыг тогтвортой хөгжлийн үндэс гэж үздэг тул боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн биз. Иймээс тогтвортой хөгжил гэдэг үгний араас боловсрол гэх үгийг нэмсэн болов уу.

Хөрсөө хөндөхгүй гэсэндээ монгол гутлын хоншоор ээтэн байдаг. Гэтэл өнөөдөр бид юу болчихоо вэ? Тогтвортой хөгжлийн боловсрол гэж ярих хэрнээ амьдралдаа зөв сонголт хийж чадахаа байж. Монголчуудын байгалиа хамгаалах ёс жаяг, ахмад настан, эцэг эх, эмэгтэй хүн, эр хүнийг хүндлэх ёс тэр чигтээ Тогтвортой хөгжлийн боловсролын үндэс суурь билээ. Монголчууд бид ийм л анхдагч ийм л ухаалаг ард түмэн. Гэвч сүүлийн үед...

***Модоо огтлоод
огтолсон модоороо
цаас хийгээд цаасан
дээрээ “Модоо
хайрлая!” гэж бичээд,
бичсэн цаасаа хог
болгож хаях биш,
жинхэнэ утгаараа
байгалиа хамгаалах
хэрэгтэй.***

Эрдэнэт биеийг олуулж энэ зэрэгт хүргэсэн эцэг эхээ хөдөө хөсөр хаячхаад “Ээждээ очих хамгийн сайхан” гэж найран дээр бархирах болж

Байгаль дэлхийгээ хайрлъя гэж олны өмнө үлгэр шиг сайхныг ярьчхаад идсэн чихрийн цаасаа газар хаядаг болж...

Тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшинэ гэдэг нь бид өөрсдөө эхлээд тогтвортой хөгжсөн боловсон иргэд болохыг хэлнэ. Модоо огтлоод огтолсон модоороо цаас хийгээд цаасан дээрээ “Модоо хайрлая!” гэж бичээд, бичсэн цаасаа хог болгож хаях биш, жинхэнэ утгаараа байгалиа хамгаалах хэрэгтэй.

Бүтээх ажил дундрахгүй их байхад, бидний хүсэл зориг унтрахгүй оргилох болно.

“Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангахыг хэлнэ”. (Бидний хамтын ирээдүй, Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн даян дэлхийн комиссын тайлан, 1987 он)

ИРГЭДИЙН ОРОЛЦОО: БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Б.Уранчимэг

МУИС-ийн ОУХНУС-ийн 4 дүгээр түвшин

Иргэний оролцоо буюу бидний оролцоо бол төр, төрийн байгууллага, иргэний аль алинд нь чухал үр нөлөө бүхий үйл явц бөгөөд төр болон иргэн харилцан хариуцлагажиж, харилцан эрх мэдэлжинэ. Төрийн зүгээс иргэдийн амьдралд тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлын харилцан хамаарал, эрэмбийг тогтоох, иргэдийн хэрэгцээг үр дүнтэй, үр ашигтай байдлаар хангах арга замыг тодорхойлох, иргэдтэй харилцах харилцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцох, хууль тогтоомжуудын хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах, нөөц эх үүсвэрийг оновчтой хуваарилах зэрэг олон эерэг үр нөлөө бүхий боломж бүрддэг. Харин иргэн бидний хувьд төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдэж авах, төрд шууд хандан үгээ хэлэх боломж бүрдэх, төрийн бодлого, шийдвэр гаргалтад өөрийн хувь нэмрийг оруулах, төрийг хариуцлагатай, эргэн тайлагнадаг буюу “иргэний хяналтад байлгах” боломжтой болж эрх мэдэлжинэ¹. Өөрөөр хэлбэл иргэдийн оролцоо гэдэг нь төр ба иргэн хоорондын хамтын ажиллагаа, зөвлөлдөх, түншлэх замаар иргэд шийдвэр гаргах бүх үйл явц ба үр дүнд нь оролцох тухай ойлголт юм. Энэ бол хүний суурь эрх. Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 482 хуулийн 109 нь иргэдийн оролцоог хангасанд тооцогддог байх ба тэдгээрийн 308 нь зохицуулалт байна². Харин бид эрхээ эдэлж чадаж байна уу? Өдрөөс өдөрт техник технологи, уул уурхайн салбар хөгжиж буй энэ 21-р зуунд дэлхий даяар байгаль орчин, хамгааллын асуудалд ард иргэдийн оролцоо үгүйлэгдэж байна.


Уругвай улсын Ерөнхийлөгч Хосе Мухика “Бидний өмнө тулгараад буй том асуудал бол байгаль орчны аюул бус улс төрийн асуудал” хэмээн 2012 онд Бразилийн Рио Де Жанейро хотод болсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” хурал дээр хэлсэн юм. Тэрбээр Германы нэг өрхийн машинтай тэнцүү тооны машиныг Энэтхэгийн өрх бүр эзэмшвэл, энэ гариг юу болох бол? Амьсгалахад шаардлагатай хүчилтөрөгч цаана нь хэдий хэр үлдэх бол? хэмээн асууж байлаа. Мөн “Хэт хэрэглээ дэлхийг сүйтгэсээр атал, хүмүүс өндөр үнэтэй барааны төлөө амьдралаа үрсээр байна” хэмээн хэлсэн юм. Угтаа байгаль орчны асуудлын

1 (Иргэдийн оролцоог захируулсан зарим хууль тогтоомжийг таниулах нь, 2019, хууд. 6)

2 (Монгол Улсын хуулиуд дахь иргэний оролцооны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, 2018, р. 12)

үндэс нь эдийн засгаа өсгөх зорилгоор хүлэмжийн хий ихээр ялгаруулж байгаа улс орнууд хийгээд нөгөө талд хэт их хэрэглээ, хэрээс хэтэрсэн тансаглал дунд амьдарч буй бидний амьдралын хэв маягаас хамаарч байна гэлтэй. Гэхдээ энэ асуудлыг шийдэх түлхүүр нь ард иргэдийн гарт байна. Энэ асуудалд бидний дуу хоолой, бидний оролцоо үгүүлэгдэж байгааг дэлхийн дулаарал, байгаль орчны бохирдол, тоо толгой нь өдрөөс өдөрт цөөрсөөр буй ан амьтад, цөлжилт, зуун жилийн дараа хэрхэн амьдрахаа мэдэхгүй байгаа үр хойч маань бидэнд сануулсаар байна.

Зураг 1. 1880-2000 он хүртэлх дэлхийн гадаргуун температур




Эх сурвалж. NOAA climate.gov

Сүүлийн 5 жил бол цаг уурын ажиглалт явуулж эхэлснээс хойших түүхэн дэх хамгийн халуун жилүүд болсон юм. Аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад сүүлийн 120 жилд агаарын дундаж хэм 1,1-ээр өссөн байна. Хойд мөсөн далайн мөсөн бүрхүүлийн талбай сүүлийн 40 жилийн хугацаанд 10 жил тутамд 12 хувиар багасч байна. Үүний улмаас 1997-2006 онд далайн усны түвшин жил бүр 3 мм-ээр нэмэгдэж байсан бол сүүлийн 10 жилийн хугацаанд жил бүр 4 мм-ээр дээшилжээ. Түүнчлэн далайн усны хүчиллэг шинж чанар аж үйлдвэржилтийн эхэн үетэй харьцуулахад 26 хувиар нэмэгдсэн байна³.

**“Хэт хэрэглээ
дэлхийг
сүйтгэсээр атал,
хүмүүс өндөр
үнэтэй барааны
төлөө амьдралаа
үрсээр байна”**

Доорх зураг нь Аляскийн Кенай нурууны Аиалик буланд орших Педерсен мөсөн гол ба 1917 болон 2015 онд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хэрхэн өөрчлөгдөж буйг үзүүлсэн юм. Мөн Дэлхийн мөсөн голын хяналт шинжилгээний алба (Worldwide Glacier Monitoring Service) –наас мөсөн голуудын 90 орчим хувь нь ширгэж байгаа бөгөөд 1970-аад оноос хойш энэ үйл явц хурдацтай явагдаж байгааг мэдээлсэн. Дэлхийн дулаарал гэдэг нэгэнт долоон тэрбум хүний өмнө нүүр тулаад ирчихсэн энэ цагт байгаль хамгааллын асуудал нэн тэргүүнд тавигдах ёстой.

Зураг 2. Педерсен мөсөн гол 1917, 2015 он



Эх сурвалж: NOAA Climate.gov

Профессор Жоонэс Коок (Jonas Salk) “Хэрвээ дэлхийгээс бүх шавжийг түүгээд устгачихвал..., 50 жилийн дараа гэхэд бүх амьд байгаль мөхөх биз. Харин дэлхийгээс бүх хүмүүсийг олоод устгачихвал..., 50 жилийн дараа амьд байгаль улам цэцэглэн хөгжсөн байхаас зайлахгүй” хэмээн хэлсэн байдаг. Шавж хүн хоёрын ялгаа гэвэл “байгалийнхаа өгөгдлөөр” амьдарч байна уу үгүй юу гэдэгт л байгаа юм. Харин бид өөрсдийн бий болгосон системийн дагуу амьдарч, байгалийн хуулийг зөрчиж байна.

Төрийн тэргүүнээс өгсүүлээд арван жилийн сурагч хүртэл дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар ярилцана. Нүдэн дээр байгаль дэлхий хэрхэн өөрчлөгдөж байгааг мэдэрнэ. Улс орнууд бие биедээ уриална. “Тогтвортой хөгжил - 2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан ба хамгийн чухал нөлөөтэй хэмээн эдийн засгийн

өсөлт, нийгмийн оролцоо, байгаль хамгаалал гэх гурван тулгуур хүчин зүйлийг тодорхойлсон байдаг. Эдгээр хүчин зүйлс нь өөр хоорондоо шууд холбогддог оос гадна нийгэм, хувь хүний сайн сайхан байдлыг хангахад чухал нөлөөтэй. Байгаль хамгааллын салбарт сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, далай тэнгисийн нөөц, хуурай газрын экосистемийг хамгаалах, хариуцлагатай хэрэглээг дэмжих, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зэрэг арга хэмжээг авна хэмээн зорилт дэвшүүлсэн. Мөн уг зорилгын хэрэгжилтийг хангахад улс орнуудын засгийн газар, яамд, төрийн бусад байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний болон орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, холбогдох бусад газар болон иргэд оролцоно гэж заасан байна. Манай улсын хувьд 2016 оны 2-сард УИХ-ын 19-р тогтоолоор “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг баталсан ба байгаль хамгааллын салбарт 6 зорилтыг хэрэгжүүлэхээ тодорхойлж, Ерөнхий сайдаар ахлуулсан “ТХЗ-ын үндэсний хороо”-г байгуулсан юм⁴.

Одоогоос арван жилийн дараа буюу 2030 онд улс орнуудын төрийн тэргүүнүүд гэрийн даалгавраа хэрхэн хийсэн, амлалтандаа хүрсэн эсэх талаар тайлагнана. Үүнд иргэн бидний идэвх маш чухал ба өөрсдийн оролцоотой байснаар эрхээ эдэлж, төрийг иргэний хяналтад байлгах боломж бүрдэх бол, нөгөө талаас амьдарч буй эх дэлхий, байгаль ээжээ хамгаалж, үр хойчдоо өвлүүлэн үлдээх нь бидний үүрэг, хариуцлага юм. Бид юу хийх боломжтой вэ?


1. ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ БИЙ БОЛГОЁ

Хүн төрөлхтөн өдгөө жил бүр 2.12 тэрбум тонн хог хаягдал бий болгож буй. Тэдгээрийг ачааны машинд овоолон цуваа үүсгэх юм бол дэлхийг 24 удаа ороож хүрэхүйц их хэмжээтэй ба тэр их хог хаягдлын 80 хувийг байгальд хаяж, дөнгөж 20 хувийг нь дахин боловсруулж байна. Цаашлаад дэлхийн хүн ам 2050 он гэхэд 9,8 тэрбум давж, хүнсний хэрэгцээ 70 хувиар нэмэгдсэнээр хог хаягдлын хэмжээ 3.4 тэрбум тоннд хүрэх тооцоо бий⁵. Харин эх дэлхий маань ийм их хог хаягдлыг тээгээд цаашдаа оршин тогтнож чадах болов уу, мөн хүн төрөлхтөнд энэ хэмжээний хэрэглээг өгч чадах болов уу. Асуултанд магад хэн ч тийм гэж хариулж чадахгүй байх.

4 (Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, 2016)

5 (2030: Та жил бүр 1,5 тонн хог үйлдвэрлэсээр байх уу?, 2020)

Зураг 3. Дэлхийн хог хаягдлын бүрэлдэхүүн



Эх сурвалж: NOAA climate.gov

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс 2014-2015 онд хийсэн судалгаагаар Монгол Улс өдгөө ДНБ-ий нэг ам долларыг үйлдвэрлэхдээ байгалийн болон бусад нөөцийн 14 доллартой тэнцэх хэмжээний зардал гаргаж байна⁶ хэмээн мэдээлсэн. Энэ хүрээнд манай улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөх 10 орны тоонд багтаад байгаа юм. Бид "Reduce, Reuse, Recycle" буюу "Багасга, дахин ашигла, дахин боловсруул" гэх үгийг сонсоод өнгөрөх бус өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх, дадал болгох цаг нэгэнт иржээ. Философич Сенека "Ядуу хүн гэж өчүүхэн эзэмшилтэй хүнийг бус хязгааргүй хүсэлтэй, хэзээ ч ханадаггүй хүнийг хэлнэ" хэмээн бичсэн байдаг. Бид хэрэглээний нийгэмдээ захирагдаж, нэг эд зүйлээс нөгөөг нь авахын тулд хөдөлмөрлөх гэж бус амар тайван, аз жаргалтай амьдрах гэж энэ хорвоо дэлхийд төрсөн билээ.

Бидэнд чөмөдэн дүүрэн хувцас хэрэггүй. Өөрт тохирсон, биед эвтэйхэн хувцас хэрэгтэй. Бидэнд гэр дүүрэн эд хогшил хэрэггүй. Оюун ухаан дүүрэн мэдлэг, чадвар хэрэгтэй. Бидэнд нэг нэгэндээ үзүүлэх гэж авдаг үнэтэй цаг,

⁶ (Mongolian second Assessment Report on Climate change, 2014, p. 33)

утас, компьютер гэх ухаалаг багаж төхөөрөмжүүд хэрэггүй. Бидэнд бодит байдалтай нүүр тулж, асуудал нь юу вэ? гэдгийг олж хардаг ухаан хэрэгтэй. Бидэнд үнэтэй хоол, хөргөгч дүүрэн мах, чихэр хэрэггүй. Бидэнд шим тэжээл сайн 2000 калоритой дүйцэх хүнс л хэрэгтэй. Мөн хамтаар шийдэл хайдаг, нэг нэгнээ ойлгож хүндэлдэг ёс суртахуун хэрэгтэй. Иймд бид хэрэглээд хаядаг, өндөр үнэтэй амьдралын хэв маягийг өөрчилж, тогтвортой хэрэглээг бий болгох шаардлагатай байна.

2. НОГООН ОРЧИНГ БҮРДҮҮЛЬ


НҮБ-аас мэдээлснээр өдгөө дэлхийн хүн амын тэн хагас нь хот суурин газар амьдарч байгаа бөгөөд хүн амын төвлөрөл ихсэхийн хэрээр түлш, эрчим хүч, хоол хүнсний хэрэглээ, дэд бүтцийн ажлууд алхам тутамд нэмэгдэж байгаль орчинд үзүүлэх асар олон хор хөнөөлийг дагуулсаар байна. Хүн амын хэт төвлөрлийн улмаас дэлхий дээр нэг сар бүр Нью-Йорк хоттой тэнцэхүйц хэмжээний хот суурин баригдаж байна. 100 жилийн өмнө 10 хүн тутмын хоёр нь хотод амьдардаг байсан бол өнөөдөр дэлхийн 7 тэрбум хүний гурав нь хот суурин газарт суурьшжээ. 2030 он гэхэд дэлхийн арван хүн тутмын зургаа нь хот суурин газарт амьдрах тооцоо бий. НҮБ-аас 2014 онд хийсэн судалгаагаар дэлхий дахинд хот суурин газарт амьдарч буй хүмүүсийн 80 хувь нь ДЭМБ-аас гаргасан агаарын чанарын стандартаас дор хаяж 2.5 дахин их бохирдол ихтэй нөхцөлд амьдарч байна. Хүн амын тоо энэ хэвээр өссөөр байвал 2050 он гэхэд хүн төрөлхтний 70 хувь нь хот суурин газарт амьдрах ажээ. Дэлхийн хотууд нийт газар нутгийн ердөө гуравхан хувийг эзэлдэг хэдий ч нийт эрчим хүчний хэрэглээний 60-80 хувийг зарцуулж, нийт хүлэмжийн хийн 75 хувийг бий болгож байна⁷. Тиймээс НҮБ-аас дэлхийн улс орнуудыг хүн амын хэрэглээний тогтвортой хангамжийг бий болгох, агаар, орчны бохирдлыг бууруулах, ногоон, эрүүл хотыг бий болгохыг уриалсаар байна.

Монгол Улсын үндэсний их сургуулийн судлаачдын багийн хийж гүйцэтгэсэн "Монгол улс: "Хүн амын дотоодын шилжих хөдөлгөөний судалгаа"- ны дагуу 1989 онд хүн амын дөрөвний нэг хувь нь (26.8%) оршин сууж байсан нийслэлд, өдгөө нийт улсын хүн амын бараг тал (47%) хувь нь оршин сууж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр, 2010-2016 онуудад 126,143 хүн Улаанбаатарт албан ёсоор шилжин суурьшсанаар, 2018 онд нийслэлийн хүн ам 1,463,000 хүржээ⁸.

7 (2030: Хязгаараас давсан хотжилтын хэрэглээг хойч үедээ үлдээх гэж үү?, 2019)

8 (Монгол улс: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа, 2018)

Зураг 4. Монгол Улсын шилжих хөдөлгөөний цэвэр урсгал, 2000 оноос хойш, бүс нутгаар



Эх сурвалж: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгааны тайлан, 2018

Хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь ажилгүйдэл, замын түгжрэл, агаарын бохирдол зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон асуудлыг ар араасаа дагуулж байна. Эдгээрасуудалнь ардиргэдийн бухимдал, ууруцаар, төр засагтаа итгэх итгэлийг үгүй хийнэ. Харин төр нь иргэдээ үнэн мэдээллээр хангаж, иргэд нь оролцоотой байснаар шийдэл олдоно. Хот гэдэг хүмүүсийн нэгдэл учир хүн төвтэй, хүмүүсийн амьдралын хэрэгцээ, шаардлагуудыг цогцоор нь харж түүнийг байгальд ээлтэйгээр зохицуулан төлөвлөх нь хамгийн чухал юм. Тэнд л гарц бий. Иргэн бид өөрсдөө ногоон орчинг бүрдүүлэх хэрэгтэй. Үүнд гэртээ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглан, нүүрснээс үүдэлтэй эрчим хүчний хэрэглээгээ бууруулах, автомашинаас татгалзаж, зуны улиралд унадаг дугуй унах, амьдарч буй орчиндоо ногоон байгууламж бий болгож, мод, цэцэг тарих, хотын ногоон хөгжилд зориулсан төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, хувь нэмрээ оруулах гэх зэрэг алхмуудыг хэрэгжүүлсэнээр бид ойр хавьдаа ногоон орчин, цаашлаад хамтын ажиллагаатай байж, бие биендээ нөлөөлсөнөөр хотдоо ногоон орчинг бүрдүүлж чадна⁹. Мянган бээрийн аялал нэг алхмаас эхэлнэ.

3. БУСДЫН ЭРХ ХАНГАГДСАНААР МИНИЙ ЭРХ ХАНГАГДАНА

Өнөөдөр таны уур бухимдал, дургүйцлийг хүргэхгүй байгаа өөр хэн нэгэнд тулгарч буй асуудал бол таны ч асуудал гэдгийг ухамсарлаасай гэж би хүсч байна. Улаанбаатар хотод амьдардаг нэгэн гэр бүлд тулгарч буй агаар, хөрсний

9 (2030: Хязгаараас давсан хотжилтын хэрэгтээ хойч үедээ үлдэх гэж үү?, 2019)

бохирдол магад хөдөө амьдардаг малчинд хамаагүй байж болно. Зүүн дөрвөн замаас, баруун дөрвөн зам хүртэлх замын хөдөлгөөнд оролцогчдын бухимдал, уур уцаар сумын төвд нэг захаас нөгөө захруу алхаад явчихдаг багш нарт хамаагүй байж болно. Уул уурхайн хэт их олборлолтоос болж ундны усгүй болсон малчны амьдрал төвийн бид нарт хамаагүй байж болно. Дэлгүүр ороод юу дуртайгаа ууж, хүссэнээ авч иддэг хэн нэгэнд Африкт амьдарч буй нэгэн хүүгийн өдрийнх нь амьдрал, аж байдал хамаагүй байж болно. Газар хөдлөлт, цунами гэх байгалийн давагдашгүй үзэгдэл олноор тохиолддог Япон, Филиппин гэх улсад амьдарч буй иргэд өнөөдөр Монголын гурван сая иргэнд хамаагүй байж болно. Миннесота мужийн Миннеаполис хотод Жорж Флойдын амийг хөнөөсөн хэрэг магад өнөөдөр хичээлээ хийгээд сууж байгаа надад хамаагүй байх... Гэхдээ зөвхөн өнөөдөр л. Маргааш хэнийх нь эрх зөрчигдөх бол?

Зураг 5. АНУ-ын Миннесота мужийн Миннеаполис хотын иргэн Жорж Флойд




Эх сурвалж: Алжазера

Хөдөө амьдардаг малчны хүү хотод оюутан болохоор аавтайгаа ирнэ. Сумын төвийн багш хотод сургалтаар ирчихээд, нэг газраас нөгөө газарлуу явах нь хол гэдгийг мэдэн пиг дүүрэн хүнтэй автобусанд суугаад, замын голд түгжирнэ. Хотын хүмүүс амралт зугаалгаар хөдөө явна. Юу дуртайгаа иддэг хүү нэг л өдөр халаас нь хоосон болж, хоолгүй хонох өдөр ирнэ. Байгаль орчны асуудал гэдэг нэг орны бус, дэлхийн улс орнуудын нийтийн асуудал болж Монгол Улсын иргэд хэрэглээгээ хянаж, байгаль дэлхийгээ хайрлах цаг ирнэ. Хэдэн жилийн дараа Америкад суралцахаар явсан надад Жорж Флойд шиг

эрхээ зөрчүүлэх цаг ирэх л болно. Эдгээр хүн бүрт бас надад харуусал, гуниг төрөх болно. Арга хэмжээ авч, өөрийн дуу хоолойгоо тухайн цагт төр засагтаа хүргээгүй өөрсдийгөө бид буруушаана. Би дахиад хэлье. Өнөөдөр таны уур бухимдал, дургүйцлийг хүргэхгүй байгаа өөр хэн нэгэнд тулгарч буй асуудал бол таны ч асуудал гэдгийг ухамсарлаасай гэж би хүсч байна. Бусдын эрх хангагдсанаар миний эрх хангагдана гэдгийг хүн бүр мэдээсэй гэж би хүсч байна. Иймээс иргэн бид өнөөдрөөс эхлээд байгаль орчноо хамгаалж, хогоо хогийн саванд хийж, мод тарин, хэрэглээгээ хянаж, ухаалаг багажуудад өөрийгөө даатгадаг бус, өөрийгөө ухаалгаар авч явах цаг иржээ.

Зураг 6. Дэлхийн температур /Эх дэлхий өдрөөс өдөрт халж байна/



Эх сурвалж: NOAA climate.gov

Бидэнд уул уурхай дээр түшиглэсэн эдийн засаг бус, мэдлэг дээр тулгуурсан эдийн засаг хэрэгтэй. Хожим бүгдээр харамсахаас өмнө, үр хойч минь биднийг буруутгаж, яллахаас өмнө онгон дагшин байгаль эхээ хамгаалцгаая. Асуудал гэдгийг хаалга тогшоод, орж ирэхээс нь өмнө, өөр дээрээ асуудлыг үүрч хүнд бэрхийг туулахаас өмнө, алсын хараатай байж аюулгүй амар амгалан дэлхийг бүтээцгээе. Үүнд л иргэн бидний оролцоо чухал. Энэ бол бидний эрх бас хариуцлага.

ИРГЭНИЙ ОРОЛЦОО: БАЙГАЛЬ ОРЧИН

Т.Батзориг

МУИС-ийн ОУХНУС-ийн 4 дүгээр түвшин

1. ЭРТ БА ЭДҮГЭЭ

Газарт зоосон гадасаа авахдаа хүртэл хорвоо дэлхийг хайрлан өрөвдөж, эдгэнэ хэмээн итгэж идээ будааны дээжээр, ээдээгүй цагаан сэтгэлээрээ нөхөн засаж гүйцээдэг үнэт өв, өвөг дээдсийн ухаан. Алтан нар уулс түшин өндийж, улбар туяа нь өвсний үзүүрт тогтсон шүүдэрт солонго болон эрхэлж, буурал салхи өвгөдийн захиас тээж, олон зууны түүх, он жилүүдийн урсгал даган ниснэ. Хүний хайранд байгалийн өнгө ийн хөтлөгдөж, байгалийн хайранд хүмүүний амьдрал ингэж л хөвөрдөг санжээ.

Хорвоо ертөнц эргэдэн, сансар огторгуйн уудамд биднийг тээн, цаг хугацааг элээхийн зэрэгцээ, өөрөө өөртөө нас нэмж буйгаа үл анзааран урагшилсаар. Хүн төрөлхтөн, улс үндэстэнд хил хязгаар үгүй болох тэр ирээдүй биднийг урин дуудсаар, урдаа тавих зорилго, уриа лоозон маань нэгэн хэвэнд цутгагдсаар. Байгалийн үр шимийг амсаж, дөрвөн цагийн эргэлтэд нүүдэллэн амьдардаг малчдын амьдралын хэв маяг даяаршил хэмээх энэ эргэлтэд өөрчлөгдөн хувирч тэнгэр баганадаж нар гялбуулсан барилга байгууламж, тээврийн хэрэгслийн дуу чимээ, хөл хөдөлгөөн, эдийн засаг нийгмийн хөл алдам хөгжлөөр эгэл амьдрал төсөөлөгдөх болжээ.

Шинжлэх ухааны агуу их нээлтүүд, шинэ амьдралын хэв маяг үйдвэрлэл хотжилтыг үгүйсгэх гээгүй. Хүссэн хүсээгүй бид хүн төрөлхтний хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах нь жам. Он цагийн урсгалд бид цаг үеийн шаардлагаар олон ч зүйлийг гээж бас олж авсан. Гэхдээ бидний эрхэмлэдэг үнэт зүйл, өндөр хөгжил бүхий нийгмийг бүтээх мөрөөдөл, ашиглагдаж буй арга хэрэгсэл маань байгаль экологийн тогтвортой байдалтай зөрчилддөг ажээ. Тухайлбал Монгол Улсад 2019 оны байдлаар уул уурхайн салбар нь ДНБ-ны 25%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 72%, экспортын 90%-ыг тус тус бүрдүүлж байгаа тухай Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас мэдээллээ. Гэвч эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч болж буй уул уурхайн салбарт түгээмэл тулгардаг асуудал бол байгалийн зохистой хэрэглээ, нөхөн сэргээлт, орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй амьдрал, бэлчээр, усны асуудал.

Хөгжил байгаль хоёрын энэхүү зөрчилдөөн манай улсын хил хязгаараас даван гарч дэлхий нийтийн анхаарал татсан асуудлуудын нэг болон хувираад байна.

Судлаачдын үзэж буйгаар европын хойд хэсэг буюу харьцангуй өндөр хөгжил бүхий баян улс орнууд байгаль экологийн асуудалд ихээхэн ач холбогдол өгч байгаа бол умардын ядуу буурай улс орнуудын дунд ийм төрлийн үйл ажиллагаа, үзэл суртал эрх мэдэлтнүүдийн дунд ч, энгийн иргэдийнх нь дотор ч харьцангуй цөөн байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Мөн иргэд, ялангуяа залуучуудын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг компани т ажлыг томоохон үйлдвэрийн эзэд, бизнесмэнүүд үгүйсгэхдээ залуу үеийнхэн эдийн засгийн томоохон хямрал, хүнд хэцүү нийгмийг төдийлэн мэдэрч байгаагүйгээс эдгээр салбарын хөгжлийг байгаль орчны асуудлаас доогуур тавьж байна хэмээн үзэж байна.

2. АРДЧИЛАЛ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол Улсад ардчилсан хувьсгал ялснаас хойш эдүгээ хагас жаран өнгөрчээ. Ургах наран мэт ардчиллын туяа улс орны өнцөг булан бүрт гийж, засаглалын эрх хэн нэг эрх мэдэлтэн, хэсэг бүлэг этгээдийн гарт бус энгийн малчин ард, эгэл ажилчин ангийн гарт шилжив. Өмч хөрөнгө, өнгө зүс ялгалгүй хуулийн өмнө тэгш эрх, тэнцүү ачаа үүрэх нийгмийг ард олны санал санаачлагаар цогцлоон бий болгов. Ийм хөгжлийн замд гарсан шинэ Монгол Улсын цулбуур жолоо ард түмний гарт байх бөгөөд өөрийн эрхийг, өрөөл нэгний эрхээр хязгаарлан, нийтээр баримтлах байр суурь хэм, хэмжээг хууль хэмээн нэрийдэж, хэрэгжүүлэлт зохицуулалт, шударга үнэнийг дэнслэхдээ өөрийн оролцоо, үзэл бодолоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой ийм нийгэм, тийм тогтолцоо бүрдсэн ажээ.

Нэг үгээр, хамгийн энгийнээр төсөөлдөг төр, төмөр хашаатай цагаан ордон чинь бид, бидний оролцоо юм байна.

Гэвч бид ардчиллыг бодит байдал дээр хэрхэн ойлгодог вэ? Миний эрх гэж нийтийн эрхийг үгүйсгэх үү? Ашиггүй бол хамаагүй гэсэн ахархан бодлоор, надаас бусад нь өрсөлдөгч гэсэн үзэл суртлаар амьдрах уу? Дийлэнхи олонхи маань өнөө маргаашийн хангалуун амьдралаа харж, өндөр барилга, өргөн замуудаар ирээдүйг харах алсын хараагаа хаалгуулсаар байтал хийж байгаа ихэнхи үйлдэл маань байгаль орчны эсрэг, өөрсдийнхөө эсрэг, ирээдүйнхээ эсрэг болчих вий дээ. Гэхдээ өнөө маргаашийг харсан гээд буруутгах арга ч алга л даа. Тэгээд бас өөрсдөө оролцоогүй байж байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин нэхэх үндэслэл ч бүдэгхэн. (Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2018) Ургийн эндэгдэл, уушги, зүрх судасны өвчлөл, хорт хавдар, хоол хүнсний чанар үүнтэй л холбоотой. Хангалттай оролцоо, хараа хяналт сул байгаа нь эргээд бидний амьдралд сөрөг үр дагаварыг бий болгож, эргүүлж засахын тулд ихээхэн хэмжээний эдийн засгийн нөөц бололцоог шаардаж байна. Байгаль орчныг өөр гаригынх юм шиг, өөрт хамааралгүй мэт аягласаар, алдсаар л байх уу?

3. ТӨР БА БАЙГАЛЬ ОРЧИН

Их хотын чимээ шуугиан, үйлдвэрийн яндангаас гарах нүүрсний хорт утаа, загас биш хог хаягдал урсах гол горхи, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байгальд үзүүлж буй бүхий л сөрөг нөлөөллийг бууруулахын тулд засгийн газар, харьяа холбогдох яамдаас бодлого, зохицуулалт, хууль эрхзүйн таатай нөхцөл байдлыг хангах үүрэгтэй. Тухайлбал Монгол Улсын хөгжлийн бодлого, алсын хараа-2050 баримт бичгийн үндсэн 9 зорилгын 6-рт (Монгол Улсын засгийн газар, 2020) Мөн түүнчлэн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас Утааг бууруулах үндэсний хөтөлбөр, Бүх нийтийн экологийн боловсрол зэрэг төрөл бүрийн үндэсний хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч байгаль орчны доройтол тулгамдсан асуудлуудын нэг хэвээр байсаар байна.

Тэгэхээр дан ганц хууль боловсруулж, төсөл санаачилдаг эрх мэдэлтнүүдийн шийдвэрлэдэг асуудал, шийдвэрлэсэн тохиолдолд хүсэн хүлээсэн үр дүнд хүрдэг хялбархан шийдэлтэй, амархан зүйл биш байх нь. Дээр дурдсанчилан ардчилсан нийгэмд төр гэдэг төмөр хашаатай, цагаан ордон биш эрхээ эдэлж, үүргээ биелүүлдэг эгэл жирийн ард иргэдээс эхэлдэг учраас та бидний оролцоо, тал бүрийн санал санаачлага байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд голлох нөлөөтэй байх нь ээ.

Үгүй ядахдаа хамгийн энгийн дээ, хүрээлэн буй орчиндоо, таатай эрүүл байхыг хүсдэг атлаа татсан тамхины ишээ тааралдсан хогийн савандаа хийдэггүй, шүлсээ хаяж мөс болгоод унаж бүдчиж явдаггүй байвал эрүүл орчин тэндээс эхэлж байгаа юм л даа. Уг нь байгаль өөрөө бохирдоогүй, бид л бохирдуулж байгаа гэдгээ санууштай. Агаарын бохирдлоос үүдсэн амьсгалын замын өвчлөл урагт нөлөөлж, ундны усны аюулгүй байдал алдагдаж, урсах гол горхи ширгэн үгүйрч, литр усыг 100 төгрөгөөр аваад, түм түмээр уралдаж өсгөсөн малынх нь идэх ургамал ховордоод ирэхээр бид хэнээс хариуцлага нэхдэг вэ? Төр засгаас уу? Бид хэнээс тусламж эрдэг вэ? Төлөгч мэргэд, бөө лам нараас уу?

4. ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА БАЙГАЛЬ ОРЧИН

Иргэдийн оролцоо гэж чухам юу вэ? гэдэг талаар одоо хамтдаа эргэцүүлцгээе. Сонгууль өгөх, сонгогчидтэй хийх уулзалтад дуртай дургүй очих, сошиал ертөнцөөр, цэнхэр дэлгэцний араас цэцэрхэж, талцах. Оролцоо мөн үү? Ардчилсан улсад амьд яваа маань ч гэсэн оролцоо юм болов уу?

Харин судлаачид иргэдийн оролцоог өөр өөрийн өнцөг, мэдлэг туршлагаас тайлбарлажээ. Тэдгээрийг нэгтгэн нэг ойлголт болговол "Төр ба иргэн хоорондын хамтын ажиллагаа, зөвлөлдөх, түншлэх замаар иргэд шийдвэр гаргах бүх үйл явц ба үр дүнд нь оролцох тухай ойлголт." Д. Сүнжид

Харин ямар тохиолдол иргэдийн оролцоо хэмээн ярих вэ? гэсэн асуултад (Ганзориг, 2019) Үнэн зөв мэдээллийн үр дүнд сэтгүүлчид иргэдийн мэдээлэлд

үндэслэн, нийтлэл, сурвалжлага бэлдэж, төр болон иргэдийн анхаарлыг тухайлсан асуудалд чиглүүлснээр өөрэг үр дүнд хүрсэн тохиолдолд олон байдаг. Тэгэхээр иргэдийн оролцоо гэдгийг энгийнээр төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд өөрийн эрхээ хамгаалуулахаар оролцдог ардчилсан нийгмийн арга хэрэгсэл хэмээн тодорхойлж болох байна.

Үнэн зөв мэдээлэлтэй иргэд, өөрсдөд тулгамдаж буй асуудлууд, нийтлэг ашиг сонирхлоороо нэгдэн иргэний нийгмийн байгууллагыг үүсгэнэ. Байгуулагдсан шалтгаан, шийдвэрлэх асуудал нь хүүхэд хамгаалал, хүрээлэн буй орчин гээд төрөл бүрийн байх боломжтой. 2018 онд л гэхэд Монгол Улсад бүртгэлтэй иргэний нийгмийн байгууллагын тоо 17634 байсан байна.

Тэгвэл иргэн оролцож, иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулж байгаль орчны асуудалд хэрхэн нөлөөлдөг, оролцоо ямар түвшинд байгаа талаар судалъя. Байгаль орчны бохирдол гэдэг өргөн хүрээтэй ойлголтыг багцлан хураангуйлж, араасаа түмэн асуудал дагуулдаг уул уурхайн салбарын талаар цаашид арай гүнзгийрүүлэн авч үзье.

5. УУЛ УУРХАЙ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Дээр дурдсанчилан, уул уурхайн салбар нь Монгол улсын хувьд тун чиг ээдрээтэй салбарын нэг. Монгол улсыг хүнтэй жишвэл, суралцаж, хөгжих замдаа олон саад бэрхшээлүүдтэй тулгарч яваа оюутан гэж хошин өнгө аяс оруулаад ч болтугай төсөөлье л дөө. Дэлхийн улс орнуудын нүд эрээлжилж, толгой эргэм хурдацтай хөгжил дунд нэг хөлөндөө “мал аж ахуй” гэсэн өнө эртнээс өвлөгдөж ирсэн гутал, нөгөө хөлөндөө уул уурхай гэсэн тодхон чимэгтэй ч томдож холгоод асуудал тарьдаг гуталтай. Солиод өмсөж гэсэн ч материал чанар сайтай гутал маргааш, нөгөөдөртөө олдохгүй. Холгосоор эдгээж боломгүй шарх үүсгэхээс нь өмнө, сэлбэж засаад, хөлдөө тааруулаад, сэлгэж болох өөр гутал олтлоо ашиглах шаардлага тулгарч байна л даа. Монгол улсад мал аж ахуй нүүдлийн хэлбэрээр голдуу явагддаг тул хуурай газар нутагт усны хүртээмж, чанар нь хөдөө орон нутгийн иргэдийн тогтвортой амжиргаанд маш чухал ач холбогдолтой (Sternberg, 2008). Уул уурхайн үйл ажиллагаа олширч усны хэрэгцээ нэмэгдэхэд хуурай газар нутгийн усны хэмжээ, чанарт сөргөөр нөлөөлнө. Ийнхүү уул уурхайн явуулж буй үйл ажиллагаа, холбогдох дэд бүтэц нь малчдын амьдрал, бэлчээрт төрөл бүрийн сөрөг нөлөө авчирснаар талуудын хооронд зөрчил, сөргөлдөөн үүсдэг. Тийм ч учраас иргэдийн дунд уул уурхайн салбарын үнэлэмж, итгэлцэлийн түвшин доогуур байдаг гэж дүгнэж болно.

Уул уурхайн төслийн явц нь хайгуул, уурхайг барьж байгуулах, олборлолт, уурхайн хаалт зэрэг үндсэн 4 үе шатаас бүрддэг. Эдгээр үе шатуудын байгальд үзүүлэх сөрөг нөлөө харилцан адилгүй. Тухайлбал хайгуулын үе шатанд байгальд нөлөөлөх нөлөө бусад үе шатуудтай харьцуулахад бага байдаг хэдий ч газрын эвдрэл, тунадасжилт үүсэх, мал амьтан дайжих, газар талхлах, химийн

бодистой холбоотойгоор хөрс, ус бохирдох зэрэг аюул учирдаг. Харин олборлолт явагдаж дуусаад уурхайн хаалт хийгдсэн үед байгаль орчинд үүсэх хохирол нь уул уурхайн ашиглалттай холбоотой олон төрлийн химийн бодис, тэдгээрийн хаягдал, газрын гүний болон гадаргын усны бохирдол, хөрс, ургамлын нөхөн сэргэлт явагдахгүй байх, байгаль унаган хэв шинжээ алдах зэрэг байна. Ялангуяа саяхныг хүртэл ашигт малтмалын нөөц шавхагдахад олборлолтыг зогсоож, уурхайг тэр чигээр нь орхидог байсан. Үүнийг уурхайн хаалт хэмээн сэтгэж, хэвийн үзэгдэл мэт ойлгодог байв. 2012 оны байдлаар Монгол Улсад 600 гаруй орхигдсон уурхай байна гэсэн тооцоолол байдаг. Энэ мэтчилэн орхигдсон, буруу эсвэл дутуу нөхөн сэргээлт хийгдсэн уурхайнууд химийн хорт бодисыг ихээр ялгаруулж хүн, мал амьтны эрүүл мэнд, урагт нөлөөлөх, цаашлаад цөлжилт, газрын гүний бол ил бохирдол зэрэг олон сөрөг үр дагаваруудыг бий болгодог. Энэ мэт бүхий л үе шатуудад үүсэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх менежментийн чухал арга барилуудын нэг нь орон нутгийн иргэдийн оролцоо юм.

Иргэд энэхүү асуудалд дараах байдлаар оролцож, иргэний үүргээ биелүүлж, байгалиа хамгаалах боломжтой:

1. Хайгуул, олборлолт явуулж буй этгээд тусгай зөвшөөрөлтэй эсэхийг олж мэдэх
2. Явуулж буй үйл ажиллагаа нь байгаль хамгааллын ажлыг зүй зохистойгоор хэрэгжүүлж буй эсэхийг нягтлах
3. Ашигт малтмал, түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжуудад заасан байгаль орчны хамгааллын талаар хүлээх үүргээ биелүүлж буй эсэхийг нягтлах,
4. Олборлолтын явцад иргэдийн амьдарч буй орчны гадаргын ус уурхайруу орж бохирдохгүй байхад хяналт, шаардлага тавих
5. Ашиг сонирхол нэгтэй иргэд эвлэлдэн нэгдэн иргэний нийгмийн байгууллага байгуулан, уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаатай зөвлөлдөх
6. Багийн уулзалт, олон талт ажлын хэсэг, зөвлөгөөний бүлгүүдийн хэлэлцүүлгийн явцад оролцож, хэрхэн хувь нэмэр оруулах талаар ойлголт, үнэн зөв мэдээллийг авах
7. Орон нутгийн холбогдох удирдлагуудад үнэн зөв мэдээлэл хүргэх, санал хүсэлт гаргах, зөрчил илэрсэн, сөрөг нөлөө учирсан тохиолдолд хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн бусад хяналт тавих байгууллагуудад хандах

Энэ мэт олон төрлөөр байгаль орчны засаглал буюу уул уурхайн салбар дахь байгаль орчны менежментийн стандарт журмуудыг тодорхойлж, бүх түвшинд

мердүүлдэг тогтолцоог бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудаас гадна иргэний оролцоо чухал үүрэг гүйцэтгэнэ. Жишээлбэл (НҮБ Хөгжлийн сан, 2017)Энэ нь иргэдийн байгаль орчин, нийгмийн эрүүл аюулгүй байдлын төлөө гаргасан идэвх санаачлага, түүний үр дүнгийн тод илрэл болдог. Мөн орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох нь үр дүнд хүргэдэг болохыг Австралийн Квинсланд мужийн Моранба хотод болсон явдал харуулсан байна. (Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2018) Бидний нэрлэдэг Хариуцлагатай уул уурхай, Ногоон хөгжлийн хэрэгжилт, үр дагавар нь энгийн хэрнээ өргөн цар хүрээтэй иргэдийн оролцоотой шууд хамааралтай.

6. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА БА БАЙГАЛЬ ОРЧИН

Иргэний нийгмийн байгууллага гэдэг нь судалгааны байгууллага, олон нийтийн бүлэг, холбоод, улс төрийн хөдөлгөөн болон сонирхлын бүлгүүд гэх мэт байгууллагуудыг хэлдэг. Өөрөөр хэлбэл нийтлэг ашиг сонирголоор нэгдэж, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх зорилго бүхий хүмүүсийн зохион байгуулалттай нэгдэл хэмээн ойлгож болно. Яг л бидний сонсож, уншиж өссөн Алунгоо эхийн сургааль шиг багцалж нэгтгэсэн, зохион байгуулалт бүхий нэгдэл. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн томоохон байгууллага бол Монголын байгаль орчны иргэний зөвлөл. (Азийн хөгжлийн банк, 2018) Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэсэн зарчмаар ИНБ-ууд салбарынхаа тулгамдсан асуудлыг тодорхойлох, Засгийн газар болон холбогдох Яам, Тамгын газруудад шинэ стратеги, шинэлэг санаачилгыг нэвтрүүлэх замаар шийдвэргаргах, хэрэгжүүлэх үйл явцад идэвхитэй оролцдог иргэдийн нэг хэлбэр юм. Сүүлийн жилүүдэд төр, засгийн зүгээс иргэний нийгмийн байгууллагын ач холбогдолд анхааран, тэдний дуу хоолойг сонсох, үйл ажиллагаандаа татан оролцуулах хандлага нэмэгдэж байна. Энэ нь ардчилалын суурь зарчим буюу иргэд чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх эрхээ зөв эдэлж, хэрэгжсэн хойно нь хэлэлцэж буруу зөвийг нь шүүхээс илүүтэй төлөвлөлт, зохион байгуулалтын үйл явцад оролцох боломж бүрдэж байна гэсэн үг юм.

Тухайлбал ИНБ-ууд байгаль орчны бохирдлын эсрэг тэр дундаа агаарын бохирдлын асуудал, шийдлийг холбогдох байгууллагуудад өргөн барьсан бөгөөд МБОИЗ нь Монгол орны байгаль доройтлыг зогсоох, хойч үедээ эрүүл аюулгүй амьдрах байгаль орчинг үлдээхэд хувь нэмрээ оруулах, төр, иргэний нийгмийн түншлэлийн хүрээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ, иргэдийг мэдээллээр хангах, үйл ажиллагааг нь дэмжих, чадавхижуулах, тогтвортой хөгжлийг хангахад иргэний нийгмийн идэвхитэй оролцоо, олон талт эрх тэгш түншлэл, хүчтэй хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг хэмээн үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ тодорхойлжээ.

7. БАЙГАЛЬ ОРЧИН БА БИ

Буугаад мордоход нь буян ерөөж үддэг, өлзий дэмбэрэлтэй үсгээр өглөөг угтаж, үдэш жаргаадаг сайхан Монгол заншил. Эрүүл саруул, энх тунхыг бэлгэдэж, эд баялаг биш итгэл сэтгэлээр дүүрэн бас цагаахан байхыг хичээдэг эрхэм өв. Өвлөгдөж ирээд, өөрчлөгдөж шинэчлэгдэв.

Гэхдээ бид ардчилсан нийгмийн өнгө аяс, амиа бодож, хувиа хичээх тухай биш, нийтээрээ хяналт тавьж, нэгдэж нийлэх тухай болохыг цаг урагшилж, юмс өөрчлөгдөх бүрт мэдэрч эхлэв. Ардчилал, хүний эрхийг дээдлэх улс орнуудын тоо нэмэгдэхийн хэрээр иргэдийн оролцоо хэмээх ойлголт улам бүр газар авсаар байна. Байгаль орчны асуудлаар дэлхийн өнцөг булан бүрт анхаарлаа хандуулж, улс орны хил хязгаар хамааралгүйгээр, уул усны харъяалал ялгаагүйгээр, нэг дэлхий, нэг байгаль ертөнц гэсэн үзэл хүчтэй дэлгэрч эхлэв. Үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө ялгаагүйгээр өнцөг булан бүрт залуучууд байгаль орчны асуудлыг нэн чухалд тооцож, засгийн газар, холбогдох эрх мэдэлтнүүдэд шинжлэх ухааны үндэслэлтэй санал шийдлийг хүргүүлж, анхааралдаа авч, ажил хэрэг болгохыг шаардсаар байна.

Болоод өнгөрсөн бүхний араас хариуцлага нэхэж, харамсаж суудаггүй, бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд нь хувь нэмэрээ оруулдаг. Татсан тамхины ишээ хогийн саванд хийгээд, тарьсан зүлэг модыг хайрлаж хамгаалдаг энгийн хэрнээ эерэг өөрчлөлтүүд ногоон хөгжлийн үндсийг тавина.

Гаргасан шийдвэрийн буруу зөв нь бидний амьдралаар шүүгддэг, гарах үр дүн, хэрэгжилт нь иргэд бид өөрсдөө болохоор хэн нэгэн шидтэн гарч ирээд мэргэн зам бас хялбархан шийдэл зааж өгнө гэж хүлээлгүй оролцож эхэлвэл хүсдэг хөгжлийн үндэс тэр болов уу. Хариуцлага нэхдэг байя. Хэнээс гэж үү? Өөрсдөөсөө. Өөрсдөөсөө хариуцлага нэхэх, хариуцлагатай амьдрах хариуцлагаа нэхдэг байя.

Зөв хандлага халдварладаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Азийн хөгжлийн банк. (2018). Иргэний нийгмийн танилцуулга. Улаанбаатар: Азийн хөгжлийн банк.
- Байгаль орчин аялал жуулчлалын яам. (2018). Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018. Улаанбаатар: БОАЖЯ.
- Ганзориг. (2019, 10 16). Иргэний оролцоо. (Сүнжидмаа, Interviewer)
- Монгол улсын засгийн газар. (2020). Алсын хараа 2050. Улаанбаатар: МУЗГ.
- НҮБ Хөгжлийн сан. (2017). Хариуцлагатай уул уурхай. Улаанбаатар: НҮБ хөгжлийн сан.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ТҮҮНД ИРГЭНИЙ ОРОЛЦОО

Х.Бадамлянхуа

М-Си-Эс Проперти ХХК, гэрээний ажилтан

АЯЛАГЧИД БА ХОГ ХАЯГДАЛ

Өдрөөс өдөрт хүн ам нь нэмэгдэж, түм түжигнэж, бум бужигнах болсон их хотын завгүй амьдралаас түр ч болов хөндийрч, агаарт гаран, байгальд амрахаар хүн болгон шахуу зуны цагт хөдөөг зорьдог билээ. Намрын цагт орон нутгаас хотыг зорих шилжилт хөдөлгөөн ихэсдэгийн адилаар урин цагт хотоос хөдөөг зорих аялагчдын цуваа тасрахгүй. Өвөл, хаваржин нам гүм, амар амгалан оршсон байгаль дэлхийг дуу чимээгээрээ цочоон сэрээж, хог хаягдлаа тараан бохирдуулж, ан амьтдыг үргээн сүйтгэж, өвс ургамлыг нь гишгэлэн талхлах “хөнөөлт” аялагчид энэ цуваанд нэн олон.

Бидний гэр бүл ч энэ зуны амралтаараа Архангай аймгийн Тэрхийн цагаан нуурыг зорин очиж, тухлан амраад ирсэн билээ. Хэдэн арван километр үргэлжлэх нуурын эрэг дагуу шөнөдөө ойр ойрхон зайд буудаллан, майхнаа барин хөгжим дуу хангинуулан бужигнах аялагчид олон аж. Биднээс зүүн тийш 300 орчим метр зайнд буудалласан залуус шөнөжин дуулж хуурдан, хашгиралдсаар хоносон юм. Үзэсгэлэнт сайхан нуурын эрэг дээр үдэш оройн цагаар дуулан хөгжилдөж, задгай тэнгэрийн дор байгалийн цэвэр агаарт амарч хонох туйлын жаргал. Гэвч шөнөжин дуулалдан, найрлаж хоносон аялагчдыг ачаалаад хөдөлсний дараа очиж үзэхэд эргэн тойрон тамхины иш, архины шил, ус ундааны хуванцар сав,ажилсан бохь гэх мэтээр энд тэндгүй хогоо үлдээгээд явсан байх юм. Ухаант хүн төрөлхтөн атлаа араатан амьтнаас дор байгаль орчноо хайрлан энэрэх сэтгэл үгүй байхыг нь гайхаад барахгүй. Шинжлэх ухаан, техник технологи улам л боловсронгуй болж сайжран, хүний сэтгэхүй ч түүнээ даган хөгжил, даяаршил руу тэмүүлэн буй сан. Эд материал нь ухаалаг систем рүү хувиран буй энэ цаг үед эдэлж хэрэглэдэг ухаант хүн нь улам ухамсар дорой болж буй нь гачлантай. Монголчууд бид байгаль орчноо хамгаалан, хайрлах өнө эртний уламжлал, сайхан ёс заншилтай ард түмэн. Тиймдээ ч эцэг дээдсээсээ өвлөсөн ёст сэтгэхүй, билигт сургаалийн үрээр ганцхан би л цэвэр байвал, миний хаясан хог биш гэх аминч, өчүүхэн сэтгэл өвөрлөлгүй энэ сайхан нуур, байгалийн үзэмж тансагаараа байг хэмээгээд гэрийнхэнтэйгээ хамт тэр хавийн хог хаягдлыг түүн уутлаад, аймгийн төвийн нэгдсэн хогийн цэгт аваачиж хаясан билээ. Ирээдүйд ийм ухамсар, сэтгэхүйгээс хол байгаасай

гэсэндээ хүүхдүүдээ уриалан дуудаж, хамтдаа байгаль орчноо цэвэрлээд буцсан маань энэ. Ийм жишээ зуны цагт энд тэндгүй байгаа. Зуны дэлгэр цагт дотоодын аялагчдаас өдөрт 2000 тонн хог хардаг гэсэн тойм судалгаа байдаг. Үүнээс үзэхэд бидэнд хог хаягдлын менежментийн тухай нэгдсэн бодлого, зохицуулалт зайлшгүй хэрэгтэй байгаа нь харагдана.

Хөгжин буй цаг үе, технологийн дэвшлийг дагаад өдгөө хог болох зүйлийн нэр төрөл ч асар их болжээ. Хэрэглээнээс ялгаран үлдсэн хогийг нэг уутанд хийгээд хогийн саванд хаядаг байсан тэр цаг хуучирч, юу хаяж байгаагаас хамааран энгийн ба дахивар гэж ялган хаях шаардлага үүссэн байна. Энэ дэлхийд оршин буй зүйлс бүхэн эргээд эх дэлхий, газар шороондоо шингэн уусч үгүй болдог. Хүн ч тэр, хог ч тэр. Гэхдээ хог хэмээн хаядаг бүхэн харилцан адилгүй хугацааг элээн, байгальд бүрэн уусч шингэдэг аж. Хэдхэн долоо хоногийн дараа үгүй болдог хог байхад хэдэн сая жил өнгөрч, хэдэн төрлийг олж хүмүүн мэндэлсэн ч байж л байдаг хортой хог хаягдал ч байна. Тиймээс задарч, байгальд шингэх нь асар их хугацаа зарцуулдаг зай, хуванцар сав, шил, хөнгөн цагаан лааз, төмөр, гялгар уут зэргийг шууд хаялгүй дахин боловсруулалтанд оруулж, байгаль дэлхийгээ аврахын зэрэгцээ, хүний хэрэгцээг тасралтгүйгээр байнга хангах боломжтой юм.

Хүмүүсийн хамгийн ихээр энд тэндгүй, цонхоороо хаядаг тамхины иш л гэхэд байгальд 1-2 жил, бохь 5 жилийн дараа бүрэн шингэдэг аж. Ганцхан ширхэг хуруу зай 1мкв хөрсийг, ойролцоох 8000 литр усыг бохирдуулж асар их хор уршиг үзүүлсээр байдаг байна. Энэ мэтчилэн хог бүр харилцан адилгүй.


Задарч, байгальд шингэх нь асар их хугацаа зарцуулдаг зай, хуванцар сав, шил, хөнгөн цагаан лааз, төмөр, гялгар уут зэргийг шууд хаялгүй дахин боловсруулалтанд оруулж, байгаль дэлхийгээ аврахын зэрэгцээ, хүний хэрэгцээг тасралтгүйгээр байнга хангах боломжтой юм.



Дээрх судалгаанаас харахад Монгол Улсын нийт хог хаягдлын 50% нь дахин боловсруулах боломжтой хог хаягдал байдаг буюу иргэн бидэнд байгаль дэлхийгээ хамгаалах боломж байна гэж харагдаж байна. Хоггүй эко амьдаръя, аялья гэж хүн бүхэн ямар нэг байдлаар мэдээ мэдээлэл авч, тодорхой түвшний мэдлэгтэй болсон байдаг. Гэвч хэрхэн, яаж үүнийг биелүүлэх вэ гэдэг арга учраа мэддэггүй, эсвэл үүнийг дэлхийн, улс орны хэмжээний том, хөндлөнгийн асуудал мэтээр хүлээн авдагт учир байна гэж би боддог. Хүн бүр өөрийнхөө ухамсар, амьдралын хэмнэл, өдөр тутмын үйлдэл, үйлдэхүйдээ анхааран, зөв цэгцтэй ёс горимд суралцчихвал хог хаягдлын талаар таагүй мэдээ олон сонсохгүй гэдэгт эргэлзэхгүй байна. Тиймээс бид нэн түрүүнд хогоо ангилан ялгаж сурах хэрэгтэй. Энэ талын мэдлэг мэдээллийг дунд сургуулийн сургалтын системд нь тусган, бага балчраасаа эхлэн хог хаягдлын тухай ойлголт, түүний байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл, дахин боловсруулалтын ач холбогдол зэргийг таниулах нь зүйтэй юм. Ерөөс иргэн бүр бага балчраасаа эхлэн байгаль орчноо хайрлах, хамгаалах экологийн зөв сэтгэхүй хүмүүжилтэй болчихвол сайн сан. Элдэв тоо томъёо, дүрэм журмаас илүүтэй ээж аав, эх нутаг, амьд бүхнийг энэрэх “Хайрлахын ухаан”-д л түлхүү сургамаар санагддаг даа.

Орон сууц, гэр хорооллоос авсан бүх дээжний хог хаягдлын бүтэц

(Жингийн эзлэх хувь)



Эх сурвалж: www.ubn.mn

Энэхүү судалгаанаас харахад хог хаягдлын дийлэнх хэсгийг хүнсний хаягдал эзэлж байна. Тиймээс бид хүнсний бүтээгдэхүүн авахдаа ч нэг удаагийн болон тетрапак савлагаанаас татгалзаж, аль болох эко буюу дахин ашиглаж болох савлагааг сонгох нь зүйтэй юм. Аялал зугаалгад ч бид маш их ус, ундаа, нэг удаагийн хэрэгслүүд авч явдаг. Үүнийгээ байгаль орчинд ээлтэй талаас бодолцож, хэрэглээний дараа үүсэх хог хаягдлын тухай авч үзэх хэрэгтэй байгаа юм. Үүний тулд олон жижиг савтай уснаас илүүтэй том савнаас өөрсдийн усны савандаа хийгээд уугаад явах, мөн нэг удаагийн бүтээгдэхүүнээс зайлсхийж өөрсдийн аяга, тавгаа авч явж хоолловол хүний эрүүл мэнд талаасаа ч тэр, ялгарч үлдэх хог хаягдал гарахгүй талаасаа ч тэр хамгийн зөв сонголт болж байгаа юм.

Хогны нэр төрлөөс хамааран тэдгээрийг ангилан ялгах нь айл өрх, иргэн бүрийн үүрэг, хариуцлагын асуудал боловч айл бүр, тэр битгий хэл орон сууцны орц, гэр хорооллын гудамж, хотхоны нэгдсэн цэгт ийнхүү ялган ангилах зориулалтын хогийн сав тэр бүр байдаг билүү?

Үүнээс л хогны менежментийн асуудлын эхлэл тавигдана. Ялган ангилдаг хогийн савгүй учраас иргэд ахуйн хог хаягдлаа нэг уутанд хамтад нь хийгээд хаядаг. Тиймээс дахин боловсруулах үйлдвэр, хог хаягдлын менежмент зэрэг том асуудлаас илүүтэй эдгээр бэлтгэн нийлүүлж, гарц нээх хамгийн энгийн бөгөөд чухал хэсэг бол айл өрх, гудамж орц бүрийг зориулалтын хогийн саваар хангах нь нэн чухал хэмээн иргэн би үзэж байна. Ядаж орцонд маань ийм ангилан ялгадаг хогийн сав байдаг бол хүүхдүүддээ зааж тайлбарлан, хогийг ялган ангилж сурахын ач холбогдлыг таниулан, ирээдүйд байгаль дэлхийгээ хогоор бохирдуулахгүй хайрлан хамгаалах үзэлд багаас нь төлөвшүүлэхийг эрмэлзэхсэн.

Байгалиа хамгаалахад иргэн хүний хамгийн энгийн оролцоо бол үүрэг хариуцлагаа ухамсарлан хог хаягдал аль болох гаргахгүйгээр, гаргасан тохиолдолд түүнийгээ зориулалтын уутанд ангилан ялгаж ачаад, нэгдсэн хогийн цэгт аваачин хаяж, анх очиход байсан байгалийн тэр л үзэмжийг хэн ч ирээгүй мэт хэвээр нь үлдээж чадах соёлч энэрэнгүй хандлага юм. Тиймээс хүн бүр эх дэлхийгээ хамгаалан хайрлах үйлсэд оролцож, байгаль хамгаалагч байж чадах билээ.

Хогны нэр төрлөөс хамааран тэдгээрийг ангилан ялгах нь айл өрх, иргэн бүрийн үүрэг, хариуцлагын асуудал боловч айл бүр, тэр битгий хэл орон сууцны орц, гэр хорооллын гудамж, хотхоны нэгдсэн цэгт ийнхүү ялган ангилах зориулалтын хогийн сав тэр бүр байдаг билүү? Үүнээс л хогны менежментийн асуудлын эхлэл тавигдана. Ялган ангилдаг хогийн савгүй учраас иргэд ахуйн хог хаягдлаа нэг уутанд хамтад нь хийгээд хаядаг. Тиймээс дахин боловсруулах үйлдвэр, хог хаягдлын менежмент зэрэг том асуудлаас илүүтэй эдгээр бэлтгэн нийлүүлж, гарц нээх хамгийн энгийн бөгөөд чухал хэсэг бол айл өрх, гудамж орц бүрийг зориулалтын хогийн саваар хангах нь нэн чухал хэмээн иргэн би үзэж байна.

БОХИР ЖОРЛОН БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

Аялалаар явах зуурт төрсөн бас нэгэн хүндхэн бодол бол замд тааралдах жорлонгийн асуудал. Уух усаа зөөгөөд, хаях хогоо ачаад явж болох ч бие засах газрыг ачиж, зөөгөөд явдаггүй нь хамгийн бэрх асуудал мэт санагдсан ч байж болох юм. Юутай ч байгалийн үзэсгэлэнг бишрэнгээ аялах зам зуурт зориулалтын дагуу тохижуулан бэлтгэсэн ариун цэврийн газар тун ховор байсан. Тун ховор гэдэг нь зарим нэг хоолны газар, үйлчилгээний төвтэй суурин газарт л байна уу гэхээс хээр хөдөөд бол ийм жорлон байхгүй. Жилдээ хэдэн мянган гадаад, дотоодын аялагч, жуулчид зорин очиж амран саатдаг газрууддаа зам зуурт болон тухайн газарт нь тохижилт, ариун цэврийн шаардлага хангасан боловсон жорлонг бий болгохгүйгээр аялал жуулчлалын салбар хөгжихгүй мэт санагдсан. Хүний наад захын биологийн хэрэгцээг бүрэн гүйцэд хангаж чадахгүйгээс болж арчаагүй айлын эл хульхан хашаа мэт цаас ялгадсаар өнгө алагласан хөдөө байгалийг та хаанаас ч олж харахад амархан. Майхан, хөнжлөө баглаад өөрсдөө хээр хөдөөд аялж яваа аялагчид бол байгаль-жорлон хэрэглэхээс өөр аргагүй. Тэрхийн цагаан нуурын үзэсгэлэнг тольдон эрэг дагуу нь амран хоноход ч тэрхэн хэсэгт нь байрлах жуулчны баазаас өөр газар зориулалтын модон жорлон ч байхгүй. Тийм болохоор эрэг дагуу бие даан аялагчид бол дур дураараа, тааралдсан газраа бие засна, цаасаа хаяна. Энэ бол монголын аялал, жуулчлалын бүсэд хаа ч тааралдах дүр зураг. Аялал жуулчлал бол үйлчилгээний салбар. Хүнд шаардагдах хэрэгцээ бүхнийг хангаж, найрсаг хүлээн авч үйлчлэх нь энэ салбарын онцлог. Гэтэл манайд ирээрэй, зорин очиж саатан морилоорой гэдэг, улсын нүүр царай болсон салбар нь өөрөө үзэсгэлэнт байгалиа өмнөө барьж эзний нэрээр урихаас бус эзэгтэйн сэтгэлээр үнэлэгдэн буцаадаггүй. Байгаль эхийн бүтээн бий болгосон гайхамшигт бүтээл бүрийг хайрлан хамгаалж, гадаад дотоодын аялагч бүрийн зорин очихдоо сэтгэл хангалуун байх бүхий л дэд бүтцийн асуудлыг шийдэж гэмээнэ, энэ



салбар ч хөгжиж байгаль дэлхий ч бохирдохгүй гоо үзэсгэлэнгээрээ харсан бүхний мэлмийг баясган байх бус уу. Хэрвээ би аялал жуулчлалын салбарын сайд, эрх бүхий тушаалтан байсан бол зорин очиж амран таашаах хэн бүхний цуваа тасардаггүй байгалийн сор болсон газруудаа зам, орчин, дэд бүтцийн талаас бүхий л тохижилтыг хийж, түүнээс олсон орлогоороо буцаад байгаль дэлхийгээ нөхөн төлжүүлж, сэргээн сайжруулж, эргээд ирэхэд нь үзэн сонирхох зүйлсийг нь нэмэгдүүлж улс орноо ч бусдын өмнө сэтгэл бардам байлгахсан. Энгийн иргэн миний бодлоор энэ бол биелүүлэхэд хамгийн амар бөгөөд шийдэл нь тодорхой дүр зурагтай асуудал юмсан. Гэтэл үе үеийн шийдвэр гаргах эрх мэдэлтэнгүүдээс энэ чиглэлээр хийсэн дорвитой бүтээн байгуулалт, хөгжүүлэлт харагдсангүй. Аялал жуулчлал бол байгаль орчинтой салшгүй холбоотой салбар. Тиймдээ ч энэ чиглэлийн яам нь нэг байдаг. Гэвч энэ яам байгаль орчин-аялал жуулчлалын чиглэлээр дорвитой юуг хийдэг юм бэ? Хариуцсан яам нь ажлаа сайн хийдэг бол байгаль нь аялалыг бий болгож, аялал нь байгалийн сайхнаа хадгалан, халамжилж сэргээн төлжүүлж байх ёстой юм. Гэвч бүхнийг төр захиргаа, хууль журманд даатгалгүй иргэн бүрийн өөрсдийн зүгээс хийж чадах зүйл бол сэргээн засдаггүй юмаа гэхэд байгаа зүйлийг нь сүйтгэдэггүй, балладаггүй баймаар. Хад чулуу байвал нэр тоо сийчнэ, харгуй зам байхад дураараа давхин өвс ургамал сүйтгэнэ..... ер өвтгөм олон дүр зургийг байгаль эхээ хайрлах сэтгэлийн үүднээс харвал ойрхон зуур аялахдаа ч олж харсаар байх юм даа.

УУЛ УУРХАЙ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ

Монгол улсад үүсэн бий болоод өдгөө 95 дахь жилтэйгээ золгож буй, эдийн засгийн томоохон хөшүүрэг бол уул уурхайн салбар юм. 2016 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувь, экспортын 86 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71 хувь, Улсын нэгдсэн төсвийн орлогын дөрөвний нэг хувийг тус тус бүрдүүлж буй уул уурхайн салбарт эдүгээ 40 мянга гаруй хүн ажиллаж байна гэсэн мэдээ бий. Энэ том салбарын хөгжилтэй хамт зайлшгүй яригдах сэдэв бол байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал юм. Уул уурхай, байгаль орчны эко систем хоёр уялдаа холбоотой байх ёстой. Гэтэл алтыг нь аваад, авдрыг нь хаях-ын адилаар газрын хөрсийг ухаж малтаж авчихаад, буцааж нөхөн сэргээлт хийлгүй хаядаг аж ахуйн нэгж, хувь хүмүүс маш олон.

Байгаль орчныг хамгаалах салбар нь байгалийн нөөц баялгийг түүний даацад нь тохируулан иж бүрэн, зүй зохистой ашиглах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Уул уурхайн ашиглалт нь байгальд хамгийн их хохирол учруулж болзошгүй байдаг. Иймд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, нөхөн сэргээх ажлын чанарыг сайжруулах нь маш чухал. Энэ ажилд нутгийн иргэдийн оролцоог хангахад түлхүү анхаарах шаардлагатай байна. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрч, нөхөн сэргээлгүй орхисон газрын тооллого хийх ажлыг БОАЖЯ-наас санаачлан 2017-2018 онд зохион байгуулахад эвдэрсэн 27 405.46 га байгаа




нь тогтоогдсон. Тодорхой хэлбэл, нийт 1100 газар буюу 8871.18 га талбайг нөхөн сэргээх шаардлагатайг тогтоогоод байна гэсэн мэдээллийг БОАЖЯ-наас өгсөн байна. Энэ тоо магадгүй жилээс жилд өсч байдаг нь эргэлзээгүй. Гэхдээ монголын уул уурхайн томоохон компаниуд бол энэ чиглэлийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж, тусгай санд нөхөн сэргээлтийн зардал гэж жил бүр тогтмол байршуулан хураалгадаг аж. Гэвч тэр сангийн мөнгө яг байгалиа нөхөн сэргээж байна уу гэдэг эргэлзээтэй. Харин жижиг компаниуд болон хувиараа алт, баяжмал олборлогч буюу нинжа хэмээн нэршсэн хэсэг бүлэг хүмүүс уулаа нүхлэн, ургамал модоо сүйтгэн байж эд мөнгөнд шунан баяживч эргээд нөхөн сэргээх ажил огт хийдэггүй нь илхэн харагдана. Газрын хэвлий дэхь үнэт баялаг бүхнийг гадаад, дотоод гэлтгүй ухаж сэндийлэн авдаг ч эргээд байгаль дэлхийдээ талархан мөргөөд нөхөн сэргээлт хийж, эмнэн эдгээдэг бол зөв бөгөөд сайхан сан. Энд тэндгүй ухсан газар, нүхэлсэн уул, бужигнасан шороо..... үүнийгээ дагаад усны бохирдол, бэлчээрийн хомсдол доройтол, замын эвдрэл гэмтэл гээд олон сөрөг үр дагавар дагуулаастай. Ядаж ухан авч байгаа баялгийнхаа ард уул усаа аргадан сүсэглэж, зам харгүй, ургамал модыг нь сэргээн бүтээж, чухам уул уурхай дагасан нутаг орон бүр хөгжин цэцэглэж байдаг бол миний эх орон эдүгээ хөгжлийн түүчээ болсон байх учиртай юм.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогын олон төрлийн хуультай улс юмсан уг нь. 2009 онд батлагдсан урт нэртэй хууль буюу “Тол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн ашиг тус гэж өнөө хэр гарсангүй. Манай орны нийт 29 гол мөрөн уул уурхайн үйл ажиллагааны

улмаас бохирдсон гэсэн мэдээ байдаг. Төрийн бүх шатандаа авилгалд идэгдсэн манай улсын хувьд хууль дүрэм байлаа ч түүнийг даган мөрдөх мөнгө, эрх мэдэлтэй хүн үгүй болохоор нутгийн удирдлага гэгдэх ухаангүй авилгачдын балгаар ийнхүү нутаг аймаг бүрт уул уурхай дагасан байгалийн зохиомол гамшиг үргэлжилсээр байгаа билээ. Уул уурхайн олборлолт явагдаж байгаа нутаг бүрт гол ус ширгэж, мал амьтан харангадан үрэгдэж, уулыг нь нүхэлж ургамлыг нь сүйтгэснээс агаарын хуурайшилт, цөлжилт улам хаяа тэлсээр байна. Өргөн ай саваа даган мяралзаж урсдаг байсан маш олон гол мөрөн ширгэн нарийсч, байгалийн борооны усаар хааяахан хүчээ авахаас мөрөн голын ус жижиг горхи болтлоо ширгэсэн байхыг хөдөө хээрээр аялан байх замд олныг харж сэтгэл шимшрэн явсан билээ. Авсныхаа хэрээр өгч сураагүй хүмүүсийн ийм өөдгүй хүмүүсийн эсрэг нутгийн ард иргэд тууштай тэмцэн эсэргүүцэж, байгалийн баялгаа хадгалан үлдэх хэрэгтэй. Даанч Монголчууд бид нэгдэн тэмцэж чаддаггүй ард түмэн аж. Нүдэн дээр байсан бүхэн нь үгүй болж, газар нутаг нь цөлжин эзгүйрч, малчид нь нутаг сэлгэн нүүж амь тэмцэхийг харсан ч хараагүй мэт хөнжилдөө л улам шурган хөлөө дотор нь жийлцэхээс, шударга ёс, эрүүл ирээдүйн төлөө хүчээ нэгтгэн тэмцэх нь үгүй. Тиймдээ ч ард иргэд бидний шогшрон гасалж, ам булаалдан муугаар хэлэх асуудал, бэрхшээлийн тоо л өсөхөөс бус шийдэгдэж, цэгсэрсэн нь ховор. Тэмцдэггүй ард түмэн мөхдөг гэж юутай үнэн. Дэлхийн бусад улс оронд шударга бус байдал, хүний эрхийн төлөө ямар ч асуудал дээр эвлэлдэн нэгдэж, жагсаал цуглаан хийн тэмцсээр зорилгодоо хүрч буй жишээ олон. Бидний одоо хамгийн их дуу хоолойгоо өргөн тэмцэх асуудал бол энэхүү байгаль орчны бохирдол, замбараагүй уул уурхайн асуудал юм. Энэ бол зөвхөн өнөө цагийн асуудал биш. Өвгөдийн сургаал, уламжлалт ёсноос эхэлсэн өнгөрсөн цаг, өнөөдрийн бидний уух ус, амьдрах орчин, ирээдүй үр хойчдоо эрүүл байгалиа хадгалан үлдээх гээд гурван цагийг дамнасан аугаа сэдэв мөнөөсөө мөн билээ.

ХОТЖИЛТ БА ХЭТИЙДСЭН ХЭРЭГЛЭЭ

Өнөө цагт энэ дэлхий улам л хотжин, хөл хөдөлгөөн ихтэй том хотуудын тоо ихэссээр байна. Манай улсын хувьд ч нийслэл Улаанбаатар хот үүний адилаар улам тэлсээр, дөрвөн уулын дундах уудам хөндийдөө ч багтахгүй болж байгаа. Хүн амын төвлөрөл нягтаршил хамгийн өндөртэй энэ хот руу чиглэх нүүдэлчдийн цуваа өнөө хэр ч тасрахгүй л байгаа. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Монгол Улсын хүн ам 3.296.866, өрхийн тоо 897.427 болжээ. Түүнчлэн хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 46 хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1-2 хүн ноогдох өргөн уудам нутагтай манай улсын хүн ам өсч байгаа нь таатай хэрэг. Гэтэл суурьшил, нягтаршлаас нь харахад төв суурин газартаа хэт бөөгнөрөл үүсгэн, үүнээс хамаарсан олон сөрөг үр дагавруудыг дагуулж байна. Хотжилт, нягтаршил үүсэхийн хэрээр өнөөдөр Улаанбаатар хотын агаар, хөрс, ус бүгд бохирдон, ачаалал даацын хэмжээ хэдийнээ хэтэрчихээд байгаа



билээ. Агаарын бохирдол гэдэг асуудал Улаанбаатарчуудын шүдний өвчин болоод байгаа юм. Өвөлдөө цэвэр агаар гэдгийг хотоос даруй 50-60 км холдож байж амьсгалахтай үгүйтэй. Дээгүүр нь утаан хөшиг татсан их хотын амьдрал хүүхэд багачуудын өвчин, эмнэлгийн орны хүрэлцээ, сургуулийн амралт гээд л бүх салбарыг хамран бухимдал стрессээр дүүрэн нэгэн улирлыг өнгөрүүлдэг болоод байна. Өнгөрсөн өвлөөс түүхий нүүрсийг халж, сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн нь энэ асуудлын шийдэлд томоохон нөлөө үзүүлсэн хэдий ч үүнийг дагасан угаарталт, хорт утааны хэмжээ ихсэлт зэрэг таагүй үр дагаврууд ч олон гарсан билээ. Агаар мандалд нь хорт хий, химийн бодисууд тунаран байхад амьд хүн, амьтан эрүүл байх аргагүй юм. Тиймээс ч байгаль орчны салбарын тулгамдсан томоохон асуудлын нэг нь яахын аргагүй агаарын бохирдол байгаа юм. Агаарыг бохирдуулагч дараагийн том хүчин зүйл нь автомашины яндангаас гарах хорт утаа юм. Манай улсын хувьд нийтийн тээвэр болон хувийн автомашинуудын дийлэнх хувь нь насжилт өндөртэй буюу хуучин тээврийн хэрэгслүүд байдаг. Тухайн улсдаа хэрэглэгдэхээ больж хуучирсан автомашиныг засч янзлаад монгол руу оруулж ирэн унадаг нийтлэг тогтолцоо бий болсон нь энэхүү агаар бохирдуулах эх сурвалж болоод байгаа юм. Тиймээс иргэн бидний оролцож шийдвэрлэж чадах арга бол ядаж хуучин, утаа их хаядаг автомашин аль болох хэрэглэхгүй, хотын их утааг багасгаж чадахгүй юм аа гэхэд, нэмэрлэхгүй байвал сайн сан. Түүнчлэн хорт утаа гаргах түлшнээс аль болох зайлсхийж, гэр хорооллын айл өрх бүр сайжруулсан түлшээ түлж, яндандаа хорт хий шүүгч зэргийг судлан суурилуулчихвал бүр ч хэрэгтэй

байгаа юм. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр жил бүр улсаас өчнөөн тэрбум төгрөгийн төсөв гаргадаг ч тэр бүр оновчтой шийдэл болж чадахгүй байгаа нь харамсалтай. Эрдэмтэн мэргэдээ түшиглэн маш нарийн судалгаа, туршилт хийн янданд нь хорт хий шүүгчийг суурилуулах, ийм шүүгчийг айл бүрт тараах нэгдсэн чиглэмж гаргах нь миний хувьд хамгийн үр дүнтэй арга мэт санагдана. Утаагүй түлш, утаагүй зуух гэж хаана ч байхгүй. Харин яндангүй айл, автомашин гэж байдаггүйн адил гаргаж буй утаагаа орчинд тархахаас нь өмнө шүүчихвэл зөв шийдэл болох буй за.

Дараагийн том асуудал хөрс болон усны бохирдол. Үндэсний хэмжээнд авч үзвэл нийт өрхийн 69.9 хувь нь гэр хороололд амьдардаг бол 27.5 хувь нь төвлөрсөн системтэй орон сууцанд амьдарч байна. Харин нийт өрхийн 43.6 хувь буюу 391.7 мянган өрх амьдардаг Улаанбаатар хотын гэр хороололд 200 мянга орчим өрх амьдарч байгаа гэсэн тоо баримт байна. Гэр хорооллын эдгээр айлын 96 хувь нүхэн жорлонтой байгаа нь хөрсийг ихээр бохирдуулж, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа тухай засгийн газрын мэдээлэл байна. Улаанбаатар хотын хөрснөөс дээж аван судлахад 88 хувьд нь нянгийн бохирдол илэрч, хөрс их хэмжээгээр бохирдсон нь тогтоогдсон төдийгүй хамгийн их бохирдол илрэх дундаж гүн 2.8 метр байгаа нь нүхэн жорлонгийн дундаж гүнтэй ойролцоо байгаа тухай нийслэлийн Байгаль орчны газраас мэдээлэл хийсэн байдаг. Түүнчлэн нүхэн жорлон нь хөрсний бохирдол үүсгээд зогсохгүй гүний усыг эмгэг төрөгч бичил биетээр бохирдуулж байгаа нь нотлогдсон байна. Азийн хөгжлийн банк, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо зэрэг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр жил бүр тодорхой тооны нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар сольдог аж. Сүүлийн үед жорлонгоо өөрчилж гэсэн уриатай эко био жорлонгийн төсөл хэрэгжиж байгаа нь байгаль орчинд хамгийн ээлтэй, ариун цэврийн хувьд ч тэр, байгаль орчны талаас ч тэр маш хэрэгтэй шийдэл болж байна. Тиймээс эрүүл ахуй, гоо зүйн талаас ч тэр, орчин тойрон амьдран буй хот улсаа бодсон ч тэр байгальд ээлтэй энэхүү жорлонг хэрэглэж иргэний үүрэг оролцоогоо бий болгоосой гэж би хүснэм.

Хөрсний бохирдлыг дагаад ундны усны бохирдол үүсэх нь тодорхой. Тодруулбал, гадаргад ойрхон буюу 1.5 метр гүн худгийн усанд шинжилгээ хийхэд нянгийн бохирдол их байгаа бол 47 метр гүн худгийн усыг шинжлэхэд нян бага зэрэг илэрчээ. Хүн, амьтны ялгадсанд агуулагдах 500 гаруй төрлийн бактери, вирус, шимэгч хорхой усаар дамжиж халварлагддаг байна. Нян вирус үржсэн усыг ундандаа хэрэглэх монголчуудын ходоод, бүдүүн нарийн гэдэсний халдварт болон хавдар өвчин өндөр хувьтай байдаг нь үүнтэй холбоотой. Улаанбаатар хотын ундны усны 99 хувийг Туул голын хөндий дэх газар доорх ус бүрдүүлдэг. Гэтэл Улаанбаатар хотын хувьд гэхэд нийт улсын хэмжээний 50 гаруй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн 46 нь энд байрладаг ба 30 орчим нэр төрлийн хортой, хорт хавдар үүсгэгч химийн бодисыг үйлдвэрлэлд хэрэглэж, улмаар хэрэглэсэн бохир усаа Туул голд шууд нийлүүлдэг гэсэн мэдээлэл ч байна.

Улаанбаатар хотын дундуур мяралзан шуугиж урсдаг байсан өргөн Туул гол өнөөдөр ямархан дүр зурагтай, гол гэхэд хэцүү өрөвдмөөр цөөрөм болсон байгааг хотын иргэд бүгд харж байгаа. Гадаргад ойрхон ус бохирдон, ховордох тусам гүний усны хэрэглээ түүнээ даган нэмэгдэнэ. Гэтэл ус гэдэг бодис өөрөө нөөцийн хэмжээтэй тул усны хомсдол хэмээх том гачлан дэлхийн улс орнуудад хэдийнээ нүүрлээд байна. 2050 он гэхэд буюу хорь гучхан жилийн дараа гэхэд манай улс

гүний цэнгэг усны нөөцгүй болно гэсэн мэдээ байна. Гүний цэнгэг ус 1450 жилд ганцхан удаа нөхөгддөг гэдэг. Усны хомсдол гэдэг том гамшиг манай улсад нүүрлэвэл Африкийн орнуудын араас орж, алт эрдэнэс гартаа атгаад ч аяга ус ч олж ууж чадахгүй туйлдаж мэдэхээр нөхцөл өнөө цагт бий болоод байгааг хүн бүхэн ойлгоосой. Хүнийг амьд байлгах нэн тэргүүний хүчин зүйл бол агаар, ус билээ. Ус агаар мэт чухал гэдэг үг ч үүнээс улбаатай. Хүн агаар амьсгалахгүйгээр 5 секунд, усгүй бол 5 хоног, хоолгүйгээр 50 хоног тэсвэрлэж чадна гэж эрдэмтэд тооцсон байдаг. Хэрвээ хүний биеийн усны хэмжээ 1-2 хувиар буурвал цангах, 5 хувь болоход ухаан балартах, 10 хувь бол хүнд хэлбэрийн усгүйжилт үхлийн ирмэгт тулж, 20-25 хувь хүрэхэд шууд үхэлд хүргэх аюултай. Тиймээс ус агаар бол бидний амьдралын салшгүй чухал хэсэг гэдгийг ойлгон ухамсарлаж, алтнаас үнэтэй чандмань эрдэнэ-усаа хайрлан, гамнах нь хүн төрөлхтний хамгийн сайн ойлгон сэхээрэх учиртай мэдлэг юм. Энэ талаар иргэдэд мэдлэг мэдээлэл түгээх үүднээс БОАЖЯ, ЦЕГ-н Экологийн цагдаагийн алба болон Усны газраас санаачлан “Цэнхэр алт усаа хайрлая” аяныг зарлан хэрэгжүүлж байгаа билээ. Тус аяны хүрээнд Экологийн цагдаагийн албанаас өгсөн ярилцлагад “Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийт усны нөөц 564.8км³ байна. Үүнээс нуур, тойром 500.0 км³, гол мөрөн 34.6км³, мөстөлт 19.4км³, газрын доорх ус 10.8км³ байна. 2019 онд 81 гол, мөрөн, 287 булаг, шанд, 78 нуур, тойром, 11 рашаан сэргэсэн бол эсрэгээрээ 6161 гол мөрөн, 12591 булаг шанд, 3895 нуур тойром, 512 рашаан ширгэсэн гэсэн судалгаа байна.

Дэлхийн хэмжээнд нэг хүний хоногийн усны хэрэглээ 100-105 л байдаг бол манай улсын орон сууцанд амьдардаг нэг хүний хоногийн усны дундаж хэрэглээ дэлхийн хөгжингүй орны нэг хүний хоногийн хэрэглээнээс 2 дахин их буюу 230-280 литр байна. Харин гэр хорооллын хэрэглэгчид дэлхийн дундаж түвшнээс 5-10 дахин бага буюу 6-8 литр ус хэрэглэж байна. Манай улс цэвэр усны нөөцөөр дэлхийн 145 орноос 22-т бүртгэгддэг боловч урсгал усыг хуримтуулах, нөөцлөн ашиглах гэх гэмт мэт гадаргын усны хэрэглээ багатайгаас гадна улсын хилээр урсан гардаг тул усны нөөц багатай орны тоонд багтдаг. 1995 онд ЖАЙКА-гийн судалснаар хүний хоногт хэрэглэх усны хэмжээг 258.7 мянган шоо метр хэмээн тогтоосон байдаг. Гэтэл өнөөгийн нийслэлийн хоногийн усны хэрэгцээ энэ нөөцөөс хэтэрч, 299 мянган шоо метр болчихоод буй. Нийслэлийн хүн ам энэ

Дэлхийн хэмжээнд нэг хүний хоногийн усны хэрэглээ 100-105 л байдаг бол манай улсын орон сууцанд амьдардаг нэг хүний хоногийн усны дундаж хэрэглээ дэлхийн хөгжингүй орны нэг хүний хоногийн хэрэглээнээс 2 дахин их буюу 230-280 литр байна.

эрчээрээ өсвөл 2030 он гэхэд хоногийн усны хэрэгцээ 500 орчим мянган шоо метр болж нэмэгдэх тооцоо гараад байгаа." гэсэн байгаа юм. Энд дурьдсан тоо баримтууд үнэхээр анхаарал татахгүй байхын аргагүй аж. Монгол Улсын хэмжээнд ашиглаж болох усны нөөц 610 мянга гаруй тонн, үүний 80 хувь нь гадаргын ус, 20 хувь нь газрын гүний ус эзэлж байна. Гэтэл бид дан ганц газрын гүний усыг ашиглаж байна. Энэ нь эргээд усны нөөц багасахад нөлөөлж байгаа юм. Ялангуяа орон сууцны иргэдийн усны хэрэглээ үнэхээр их байдаг. Шүршүүрт орохоос илүүтэй ванн дүүрэн ус тосон хэвтэнэ, усны цоргоо нээлттэй чигээр шүд, нүүр, үс гээг бүр аяга тавгаа ч угаана, 00-н усаа ойр ойрхон татна.... гэх мэт дурьдваас олон дүр зураг харагдана.

Манайх шиг цэвэр усаа 00-доо ашигладаг улс дэлхийд байхгүй гэдэг. Манай улсын уул уурхайд дандаа гүний цэнгэг усыг хэрэглэдэг баримт ч байна.

Манайх шиг цэвэр усаа 00-доо ашигладаг улс дэлхийд байхгүй гэдэг. Манай улсын уул уурхайд дандаа гүний цэнгэг усыг хэрэглэдэг баримт ч байна. Ийм байхад бид ядаж өөрсдөөсөө эхэлж, өрх айл, иргэн бүр саванд ус хийж аягаа угаадаг, аяганд ус аваад шүдээ угаадаг, шүршүүрийн доор олон дахин, удаан зогсохгүй болох сон. Иргэдэд энэ мэдээлэл илүү түлхүү хүрээсэй, иргэн бүр усаа хайрлан ирээдүй хойч, эх орныхоо төлөө өөрөөсөө эхлэн, бусдыг уриалаасай гэж хүснэм. Өнөөгийн бидний хандлага, үйлдэхүйгээс ирээдүй хойч маань ус, агаарыг амтлан амьд оршин байж чадах эсэх нь шууд хамааралтай байх билээ.

Ус болон хөрсний бохирдолтой холбогдох бас нэгэн байгалийг бохирдуулагч нь бидний өдөр тутамдаа хэрэглэдэг хувцасны үйлдвэрлэл аж. Хувцас үйлдвэрлэлийн салбар нь ядуу буурай орнуудын ард иргэдээр хямдажиллах хүчин хийж, хуучирсан барилга байшинд үйл ажиллагаа эрхэлснээр олон хүний эрүүл орчинд ажиллаж, амьдрах эрхийг зөрчихийн зэрэгцээ хувцас хийх, арьс ширийг угаах, хувцсыг будах зэрэгт хром мэтийн маш их химийн бодис ашиглаж, ашигласан хортой усаа шууд голд цутгадаг байна. Үүнээс болж Энэтхэг улсад хөрс болон ундны усны бохирдол маш их болж үүнээс үүдэн төрөхийн гажиг, хорт хавдар, элэгний шар өвчин зэрэг газар авч, олон хүн нас барж байна. Жил бүр ойролцоогоор 80 сая шинэ хувцас зарагддаг нь 20 жилийн өмнөтэй харьцуулахад 4 дахин их хэмжээ бөгөөд 1 сая тонн хувцас хог дээр хаягдаж газарт булагддаг. Гэхдээ эдгээр хувцас нь ихэнхдээ синтетик материалтай байдаг тул газарт шингэхгүй хэдэн зуун жил болно гэсэн үг. Тиймээс хувцас үйлдвэрлэлийн салбар нь хүрээлэн буй орчныг бохирдуулалтаараа газрын тосны үйлдвэрийн дараа дэлхийд 2-т ордог гэсэн мэдээллийг саяхан уншиж байлаа. Энэ бүхний сэдэл, үйлдвэржилт нэмэгдэх шалтгаан нь хүмүүс бид өөрсдөө юм шүү дээ. Тиймээс бид үүнийг өөрчилж чадна. Хүнд цагаа тулахаар

Ус болон хөрсний бохирдолтой холбогдох бас нэгэн байгалийг бохирдуулагч нь бидний өдөр тутамдаа хэрэглэдэг хувцасны үйлдвэрлэл аж.

тийм ч олон зүйл хэрэггүй байдаг. Гэвч хязгааргүй шуналт сэтгэхүй нь хүнийг хэдэн шүүгээ дүүрэн хувцастай байлгадаг. Гэсэн атлаа зарим нэг хувцсыг жилдээ ганц хоёрхон л өмсөх жишээний. Түүнчлэн олон хувцастай байхын хэрээр угаалга цэвэрлэгээнд хичнээн литр усыг зарцуулж байгааг хэмжихэд бас их тоо гарна. Угаалгын машинд зарцуулж буй цахилгаан, усны хэрэглээгээ багасгах нь өрхийн эдийн засагт ч гэсэн томоохон нэмэр болох юм. Тиймээс минималист сэтгэлгээг хөгжүүлж хэт их хэрэглээгээ хянаж, хэтэрсэн зардлаа хэмнэж, байгаль орчиндоо ээлтэйгээр хүний орчлонд үдлээд буцах боломж хүн бүрт бий билээ.

Байгаль орчинтой холбогдох бас нэгэн сэтгэл эмзэглүүштэй асуудал бол самар жимсний хэтэрсэн буруу хэрэглээ болон мод бэлтгэл түүнээс гарах сөрөг үр дагаврууд юм. Аялан явах зуурт анзаарч харсан зүйл бол энд тэндгүй үс нь унаж халзарсан толгой шиг өм цөм огтлуулсан мододтой, тачирхан ой байлаа. Модоор хийж, хэрэглэх зүйл асар их байдаг учраас модны наймаагаар баяжсан хүмүүс олон. Түүнчлэн мод бэлтгэхэд тусгай зөвшөөрөл олгож, төлбөр хураамж авдаг учраас түүнээс зайлхийсэн хүмүүс хулгайгаар мод бэлтгэн нийлүүлэх явдал газар авсан гэж хэлж болно. БОАЖЯ-наас Ойгоос мод бэлтгэх журам гэж гаргасан нь угтаа бол экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалсан, байгаль орчинд халгүй технологиор ойн нөөцийг зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн зөв төлөвлөлт, хуваарилалт, хяналт бүхий мод бэлтгэлийн тогтолцоог бий болгоход зориулагдсан боловч хулгайгаар мод бэлтгэн, хувиараа баяжсан нөхдөд энэ журам үйлчилдэггүй нь тодорхой. Монгол орны газар нутгийн 12 хувийг л ой эзэлдэг бөгөөд 40 орчим хувийг ашигласан байгаа тухай мэдээ байна. Хулгайгаар мод бэлтгэхэд хувь хүнээс гадна аж ахуйн нэгжүүд их оролцдог аж. Тэдний зарим нь ойн арчилгаа тордолгооны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө урвуулан ашиглаж, арчилгаа нэрийн дор хулгайгаар мод бэлтгэж байгаад баригдсан хэд хэдэн тохиолдол байна. Тэр ч байтугай шүдний чигчлүүр хийдэг Хятадын үйлдвэрт манай монголчууд хамаг хусан ойгоо хулгайгаар зөөгөөд дуусч байгаа өр өвдөж, өмнөөс нь ичмээр муухай мэдээг саяхан харлаа. Хүмүүс яагаад ийм өөдгүй, арчаагүй сэтгэхүйтэй байна вэ? Бид энэ орчлонд ирээд буцсан ч үр чинь үлдэж, үргэлжлэн амьдарна шүү дээ. Тэр цагт амьдран орших байгальгүй, уух усгүй, эрүүл агааргүй өрөвдөм ирээдүйг үлдээчихээд энэ хорвоогоос тайван явж чадна гэж үү, бодоосой. Мод ч гэсэн амьтай. Тэд ургаж, унаж уйлж, үр жимсээ

Ойгоос мод огтлон авахад хүртэл нарийн цээр, ёс гэж байдаг. Зөвхөн хэрэгцээний хэмжээгээр түлээ түлш, аливаа хэрэгцээний модоо авахдаа нэг дороос бөөнөөр бус, хэсэг хэсэг газраас цоолдон авах, авахдаа нялх зулзаган мод, нойтон мод, тэгш сайхан ургасан модыг огтлохыг ямагт цээрлэдэг байна. Заавал ойг цэвэрлэн унанги буюу хөгширч мөчир гишүү нь хатсан модыг түүж огтолж хэрэглэх ёстой. Ургаа нойтон мод огтолбол мод сүүн нулимсаар уйлж, огтолсон хүнийг сүү, цагаан идээний хомсдол гачаалд хүргэдэг гэж сургадаг байна. Түүнчлэн мод бол газрын хэвлийтэй үндсээрээ холбогдсон байдаг тул булаг шандны дэргэдэх модыг огтолдоггүй аж.

өгч хүний л нэгэн адил энэ дэлхийд амьдардаг. Гэтэл хүн бид өөрсдөөсөө бусдыг бодохгүй өршөөлгүй сэтгэлээр байгалиа сүйтгэсээр л байх уу?

Ойгоос мод огтлон авахад хүртэл нарийн цээр, ёс гэж байдаг. Зөвхөн хэрэгцээний хэмжээгээр түлээ түлш, аливаа хэрэгцээний модоо авахдаа нэг дороос бөөнөөр бус, хэсэг хэсэг газраас цоолдон авах, авахдаа нялх зулзаган мод, нойтон мод, тэгш сайхан ургасан модыг огтлохыг ямагт цээрлэдэг байна. Заавал ойг цэвэрлэн унанги буюу хөгширч мөчир гишүү нь хатсан модыг түүж огтолж хэрэглэх ёстой. Ургаа нойтон мод огтолбол мод сүүн нулимсаар уйлж, огтолсон хүнийг сүү, цагаан идээний хомсдол гачаалд хүргэдэг гэж сургадаг байна. Түүнчлэн мод бол газрын хэвлийтэй үндсээрээ холбогдсон байдаг тул булаг шандны дэргэдэх модыг огтолдоггүй аж.

Энэ мэтчилэн ёс заншил өндөртэй ард түмэн сэн, бид. Гэтэл энэ бүх сургаал, ёсыг зөрчин зөвхөн өөрийнхөө өнөөдрийн төлөө байгаль дэлхийгээ сүйтгэн яваа хүн та ойлгож ухааран, өнөөдрөөс эхлэн авсан бүхнээ байгальдаа эргүүлэн өгч буян үйлдээсэй гэж чин сэтгэлээсээ хүснэм. Нэг модыг тайрахад 4-5 минут зарцуулдаг бол нэг мод ургаж гүйцэхэд 40-50 жил зарцуулагддаг байна. Ой модыг хамгаалснаараа бид дэлхийн хуурай газрын бүх ургамал амьтдын 2/3 хувиас илүүг хамгаалж чадна. Нас бие гүйцсэн нэг мод арван хүний амьсгалах хүчилтөрөгчийг ялгаруулдаг бол нэг хүн 18 мод тарихад насаараа амьсгалсан агаараа эх дэлхийдээ буцаан өгч чаддаг аж. Тиймээс хүн бүр мод тарьж, эх дэлхийгээ ногоон байгаль болгоосой. Зөвхөн уул устай ойр гэлтгүй утаа тоос бужигнасан хотын гудамж, айл өрх бүр модоор дүүрэн байвал агаар нь цэвэршиж, амьсгал нь эрүүл байх юм. Учир нь мод агаар дахь тоос шороо, утаа тортгийг 75 хувиар бууруулдаг байна. Ийм байхад хүн нэг бүр мод тарьж, эх дэлхий, эргэн тойрноо эрүүл цэвэр байлгаж чадахаар билээ.

Ой бол нэгэн жижиг дэлхий юм. Тэнд модод ургаж үр жимсээрээ амьтдаа хооллон байгаль эхийн бас нэгэн үрсийн адил нэгнээ тэтгэн, дэмжиж амьдардаг. Мод бэлтгэлийн хэтэрсэн хэрэглээнээс гадна ойг сүйтгэж байгаа бас нэгэн хөнөөлт үйл бол самар жимс түүх нэрээр талхалж гүйцдэг явдал юм. Уг нь хуулийн хугацаагаар самрыг есдүгээр сарын 10-ны өдрөөс дараа оны гуравдугаар сарын 15-ныг хүртэл түүж бэлтгэх боломжтой байдаг. Гэвч зарим хүмүүс найман сар дөнгөж гарав уу үгүй юу л болц нь гүйцээгүй самар жимс түүж, зарж эхэлдэг. Байгалийн болон биологийн маш чухал нөлөө бүхий хушин ой манай орны нийт ойн 60 гаруй хувийг эзэлдэг. Энэхүү хушин ойгоос самрыг болсон болоогүй хамаагүй түүж, моддыг гэмтээж, мөчрийг нь хугалагсад нэн олон. Уг нь жимс, самар, эмийн ургамал зэргийг боловсорч гүйцээгүй үед нь үндэс мөчиртэй нь түүдэггүй заншилтай. Бас өөрсдийн дураараа, хэмжээ хязгааргүй түүдэг. Угтаа бол самрын 30 хувийг түүж 70 хувийг байгальд нь үлдээх нь зүйтэй. Учир нь тухайн байгальд амьдардаг ан амьтан болох хэрэм, зурам, гахай, баавгайн хоол нь самар тул тэдэнд бас үлдээх ёстой юм. Түүгээр тэд өвлийн хүнсээ нөөцлөн ичихдээ бэлтгэнэ. Хэрэв амьтдыг хайрлалгүй самрыг түүвэл амьтад ичээндээ

орж чадахгүй суурьшлын бүсээр явах аюул нүүрлэнэ гэх мэт дагавар үр нөлөө ихтэй гэдгийг хүмүүс ойлгодоггүй нь хэцүү. Жишээлбэл бид хэрмийг самар иддэг гэдгийг бүгд мэддэг. Эх хэрэм жилд 2 удаа 6 хүртэлх зулзага гаргаж, дангаар өсгөдөг. Гэвч харамсалтай нь хоол тэжээлийн олноц муутайгаас буюу бидний юу ч үгүй цөлмөж хоосолдог ховдог зангаас болж зулзагануудын 75-85 хувь нь эхний жилийн өвөлдөө үрэгддэг гэсэн мэдээ байна. Бид энэ байгаль дэлхийд ганцаараа амьдардаггүй гэдгээ санамаар. Түүнчлэн хуурайшилтын үетэй давхцан дураар мод бэлтгэж, самар жимс түүгсэд хэнэггүй хайнга зангаасаа болж гал алдан түймэр тавих нь олон. 2019 оны байдлаар ой хээрийн түймрийн тохиолдол 121 бүртгэгдсэн байгаагийн ихэнх шалтгаан үүнтэй холбоотой. Хоолгүй амь тэмцэн ядах амьтдыг дахин орон гэргүй болгон түйвээдэг хүмүүсийг яалтай билээ. Түүгээр ч зогсохгүй ан хийх нэртэй зугаа гаргагсад олширч, гэмгүй амьтдын амиар наадна. Биед сайн, эмчилгээнд хэрэглэнэ гэх нэрээр ховордсон ан амьтдыг дураараа агнан хил давуулагсад ч бий. Тарваганы махыг малын махаас илүүтэй хэрэглэгсэд зундаа олширно. Түүнийг нь дагаад тахал өвчин гарч, хорио цээр тогтоогоод байхад надад л хамаагүй, би л зүгээр гэх хөгийн аминчхан үзлээрээ энд тэндгүй хөөрхий амьтдыг хороон, цөөлнө. Энэ мэтчилэн хоёр хөлт хүн төрөлхтнөөс амьтан, ургамал, байгаль дэлхий цөм айн чичирч байна. Гэвч хүн бид байгалийг бүтээгээгүй, харин энэ амьтан, ургамлын нэгэн адил өөрсдөө байгалийн бүтээгдэхүүн эс ширхэг гэдгээ ухамсарлан ойлгоосой. Үслэг хүрэм буюу шуба л өмсөхгүй бол өвлийг давахгүй мэт гоёж гоодохыг тэргүүнээ болгосон хүмүүсээс болж булга, минж, үнэг, тарвага гэх мэт



үслэг амьтад үрэгдэж дуусна. Булган шуба хийхдээ сорыг нь алдуулахгүй гэж хөөрхий амьтныг амьдаар нь өвчдөг тухай мэдээ, бичлэг үзсэнээс хойш ийм төрлийн хувцасыг харахаас хэцүү санагдаад, өмсөх тухай бодохоо ч байсан. Цааны годон гутал гээч сүүлийн үед бас эрчээ аван ганцхан гутал хийхийн тулд хичнээн цаа бугыг үгүй хийж байгаа нь тодорхой. Энэ мэтчилэн амьтан, ургамлаа хайрлахаа мэддэггүй ухамсар дорой хүмүүн танаас эх болсон байгаль дэлхийнхээ өмнөөс өршөөл эрэн мөргөө. Биднийг хайрлаач, хамгаалаач...

ДҮГНЭЛТ БУЮУ УХААРАХУЙ, УРИАЛАХУЙ

Ерөөс байгаль эх гэдэг миний сэтгэлийн төсөөллөөр энгэртээ хүн төрөлхтнийг эрхлүүлэн, харамгүй хайраа түгээн эрхлүүлж байдаг зөөлөн сэтгэлт ижий санагддаг. Үрс нь болсон хүмүүн бид түүнээс бүхнийг авдаг. Гоо үзэсгэлэнгээр нь мэлмийгээ баясгаж, рашаан усаар нь биеэ эмнэн, ундаалж, самар жимснээс авхуулаад эмийн ургамал хүртлээ амт шимийн дээдийг авч, энгэр хормойг нь ухан байж эрдэнэс баялгийг нь цөлмөн сэндийлж....ер түүнээс үргэлж авахын шижимтэй амьдардаг. Тэгсэн атлаа эргээд түүнийг энэ их хайраар нь эргүүлэн хайрлаж чаддаг билүү. Энгэр өөд нь авиран байхдаа эгэлгүй гоо сайхныг нь гутаан баллаж хад чулууг нь элдвээр сийчиж, ургаа моддыг нь хадгаар уяж боомилон, овооны дээд гэж өөрсдөө залчихаад элдэв чихэр боов, архи дарс, мөнгө төгрөг овоолно.Уулыг нь сэндийлж, усыг нь бохирдуулан татрааж, ан амьтдыг нь устган цөөлж, энэ дэлхийд зөвхөн өөрсдөө амьдарч, ээжийн эрх хүү байх ёстой мэт аашилна. Хайрын хариуд хайр л байх ёстой. Энэ байгаль эхийнхээ ачийг хариулж, эргээд заавал хариуг нь барьж, ан амьтдаа хайрлан үржүүлж, ургамал модоо нэмж ургуулж, авсан бүхнээ заавал буцаан өгч байх ёстой юм. Гэтэл жилээс жилд ой модгүй нүцгэн уул, ай саваа дүүргэлгүй нарийсах гол мөрөн, идэх хоолгүй өлбөрөх ан амьтан, нэр төрөл нь сураг ч үгүй болж буй ховор амьтад.... Энэ муу бүхэн гагцхүү хамгийн ухаант гэгдэх хүн бидний хийсэн хэргүүд. Гэвч байгаль эх ганцхан хүүхэдгүй билээ. Ээж бүхэн хүүхдүүдээ нэгэн ижил сэтгэлээр хайрладаг болохоор бусад үрсийнхээ сүйдэхийг харж зүгээр тэвчихгүй, эрх дураараа хүүгийнхээ тарьсан балагт ташуур эргүүлэн ороолгох үе ирнэ. Тэр цагт нөмөрлөх уулгүй, уух усгүй, амьсгалах агааргүй, идэх жимс ургамалгүй болсон эзгүй цөл газарт эрхийн тэнэг хүмүүн тэнгэр, бурхан дуудан уйлаад ч нэмэргүй болсон байх вий. Тиймээс байгалиас авч буй бүхнээ эргүүлээд заавал буцаан төлж, хайрыг хайраар хариулж байх ёстой билээ. Байгаль орчны нөхөн сэргээлт гэдэг том асуудал үүнээс улбаатай. Энэ асуудал заавал уул уурхай, геологи хайгуулынханд зориулагдсан сэдэв бус. Хэрэгтэй хэрэггүй зүйлс сараачаад хог болгон хаяж буй цаасаа хичнээн мод тайран, уйлуулж хийснийг санах хэрэгтэй. Хий дэмий гоожуулаад сул урсгаж буй усныхаа хэмжээ хязгаар, нөөцийн тухай хааяа ч гэсэн бодож байгууштай. Бүхнээ сэндийлүүлэн, хоосорч, үзэсгэлэн гоо нь өдрөөс өдөрт гундан буй байгаль эх минь гээгдмэл үзэсгэлэнгээ хүн биднээс нэхэж, гэнэт өндийн ташуур далайх цөвүүн цагийг үзмээргүй байнам. Хүн байгальдаа хэдий чинээ хайр гамгүй

хандана, байгаль дэлхий төдий чинээ хатуу хариугаа биднээс авна гэдгийг мартаж болохгүй.

Хамгийн сүүлчийн мод цавчигдаж унахад
Хамгийн сүүлчийн загас ангаж үхэхэд
Хамгийн сүүлчийн гол ширгэж дуусахад
ХҮН та мөнгийг идэж болдоггүйг ойлгоно.....

Зүрх зүсэм, хөндүүр мэдрэмж төрүүлэх эдгээр мөртөөс хүмүүн та байгалийг юутай их сүйтгэж байгаагаа ойлгох болов уу. Өдөр тутам яригддаг хог хаягдал, хөрс, ус, агаарын бохирдол, хулгайн мод, самар..... гэх эдгээр сэдэв иргэн бүрт хамаатай. Үндсэн хуульд заагдсаны дагуу эрүүл, аюулгүй орчинд амьдрах ёстой гэж засаг төрөөс шаардан, ажлыг нь хийлгэх нь хүн бүрийн эрх ч гэлээ байгалиа хамгаалж хайрлах иргэний үүргээ ч мөн давхар ухамсарлавал эрх, үүргийн холбоосоор эх байгаль минь сэргэн, дэлгэрэх учиртай сан. Улс орны нийгэм, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд гэх мэт бүх салбарыг хамран, өнгөрсөн одоо ирээдүй гурван цагийг дамнах байгаль орчны асуудал бол нялх балчраас авахуулаад настай буурлууд хүртлээ өөрсдийн ухамсар сэтгэхүйдээ бат шингээж, алхам тутамдаа байгаль дэлхийгээ хайрлах ухаант хүний уужим нинжин сэтгэлийг зориулах учиртай юм. Хүн бүрийн амьсгалах, амьдрах наад захын хэрэгцээ болсон агаар, ус, байгаль дэлхий үгүй бол хүн төрөлхтөнд алтан овоо байгаад ч амьд үлдэх сонголт үгүй билээ.

Энэ бүхнийг бичиж дууссаныхаа дараа иргэн би:

Хураасан хогоо боломжоороо ялгаж
Хувцасны шүүгээгээ эмхлэн дундалж
Усны хэрэглээг дуслаар хэмнэж
Ургамал жимсний болцыг анхаарч
Цаасыг хаяхдаа моддыг бодож
Цаашдын хэрэглээгээ хэмнэхийг хичээж
Амьтны арьсаар биеэ гоёлгүй
Амьд байгалиа хайрлан энэрэхийг
Ахуй соёлдоо бүрэн шингээж
Алхам тутамдаа хичээн амьдръя
Эхийн ёсоор үрсдээ ч сургамжлан
Эгнэгт байгалиа эн тэргүүнд хайрла
БАЙГАЛЬ ЭХ МИНЬ АМГАЛАН БАЙГ.

УЛС ТӨРИЙН НАМ, СОНГУУЛЬ



УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛ

(Намын гишүүний татварын жишээн дээр)

Б.Эрдэнэдалай

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор

Улс төрийн нам сонгуульд амжилттай оролцож засгийн эрхийг авахын төлөө улс орныг хөгжүүлэх “бодлого, мөрийн хөтөлбөр”-ийг сонгогчдод санал болгодог улс төрийн институт юм.

Сонгуульд амжилттай оролцох, сонгуулийн бус үед улс төрийн үйл ажиллагаа явуулж улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, намын бүтцийг тогтвортой ажиллуулах, үүний тулд тухайн улс төрийн намын бүх түвшний гишүүд намын шийдвэрлэх ёстой аливаа асуудалд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, оролцдог, бүх төлөөлөх түвшний сонгуулиудад хүйс харгалзахгүйгээр нэр дэвшин өрсөлдөх, нэр дэвшигчид саналаа өгөх, намын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хянах зэргээр намын үйл ажиллагаанд оролцдог хариуцлагатай гишүүдтэй байх нь намын төлөвшил, дотоод ардчиллыг тодорхойлно.

Германы судлаач Насмахер “Орчин үеийн Өрнөд Европ, Умард Америкийн ардчиллын түүх бол үндсэндээ бол нам төвт ардчиллын туршлага бөгөөд улс төрийн намгүйгээр ардчиллыг бүтээн байгуулах оролдлогууд амжилтгүй болж байсан” гэж үзсэн. Тийм учраас аливаа улс орны улс төрийн тогтолцоо, тэр дундаа дарангуйлагч дэглэмээс ардчилалд шилжиж буй орнуудад улс төрийн намын төлөвшил чухал үүрэгтэй юм.

Улс төрийн нам, намын систем дөнгөж төлөвшиж, хөгжиж буй орнуудын хувьд намын төлөвшилд анхаарах нь чухал ач холбогдолтой гэж судлаачид үздэг. Ингэхдээ улс төрийн намын санхүүжилтийн эх сурвалжуудыг судлан, хандивлагчдаас хараат бус байдлыг бий болгож ардчилсан, шударга сонгуулийн өрсөлдөөнтэй байх нь анхаарах шаардлагатай асуудал болоод байна. Иймээс энэхүү өгүүлэлдээ намын санхүүжилтийн хамгийн чухал эх үүсвэр болох намын гишүүдийн татварын асуудлыг авч үзэн шинжиллээ.

¹ Nassmacher, Karl-Heinz. “Introduction: Political Parties, Funding and Democracy” Chapter 1 in *Funding of Political Parties and Election Campaigns: Handbook Series. International IDEA*, 2003. p.6-7

УДИРТГАЛ

Орчин үед улс төрийн намууд гишүүдийн татвараар санхүүжихэд улам бүр хүндрэлтэй болж байна. Үүний нэг шалтгаан нь бусад эх үүсвэр тухайлбал, төрийн санхүүжилт нэмэгдсэнээр намын гишүүнчлэлийн ач холбогдол буурсан юм. Гэвч төрөөс санхүүжилт үзүүлдэггүй улс орнуудад ч гэсэн гишүүний татвараас олох мөнгөний хэмжээ эрчимтэйгээр буурсан байна. Тухайлбал, Британийн Хөдөлмөрийн Намын гишүүний татварын хэмжээ 1992 онд 50% - иар, 1997 онд 25% - иар буурсан байна². Энэ нь зөвхөн Их Британид төдийгүй Европын улс орнуудад бүгдэд нь ажиглагдсан юм.

Шинээр ардчилал тогтсон төв болон зүүн Европын улс орнууд, түүнчлэн Грек, Испани, Португал зэрэг орнууд гишүүний татварт төдийлөн анхаарал хандуулдаггүй бөгөөд амьжиргааны түвшин бага, ардчилсан оролцооны соёл төлөвшиж чадаагүй Румын, Украин зэрэг пост-коммунист ардчилсан орнуудад гишүүний татвар нь орлогын гол эх үүсвэр хэзээ ч байгаагүй бөгөөд улс төрийн намууд нь ч гишүүдээ татвар төлөхийг хүчтэй уриалан дэмждэггүй. Гишүүдээс татвар авах явдлыг ихэнх тохиолдолд хуулиар хязгаарладаггүй. Намууд өөрсдөө хэдий хэмжээний татвар авах вэ гэдгийг тодорхойлдог. Ихэвчлэн татварын доод хэмжээг зааж өгдөг тухайлбал, Канадын шинэ Ардчилсан нам сард хамгийн багадаа 5\$ -ын татвар төлөхийг заасан байдаг. Английн Консерватив намын гишүүн хэрвээ 23-аас дээш настай бол жилд 25 паундын татвар төлдөг³. Орлогын түвшингийн хэмжээгээр төлөх татварын хэмжээ өсөх, буурах загварыг намууд ашигладаг байна.

ГИШҮҮНИЙ ТАТВАР ГЭЖ ЮУ ВЭ?

Улс төрийн намын санхүүжилтийн уламжлалт хэлбэрийн нэг нь гишүүдийн татвар (татвар гэдэг үгийг Я.Цэвэлийн 2013 онд хэвлэгдсэн Монгол хэлний товч тайлбар толь⁴, МУ-ын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргасан Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь⁵-д “татварлаж авах зүйл”, “оноож авах зүйл” гэж тайлбарлажээ) бөгөөд намын санхүүжилтийн хамгийн ардчилсан, хууль ёсны, асуудал үүсгэдэггүй хэлбэр юм. Олон тооны гишүүдтэй, тэдний тогтмол төлдөг татвар дээр суурилдаг улс төрийн намууд элитийн намуудыг бодвол иргэдийн итгэлийг олж авах, тэдэнд анхаарал халамж тавих нь илүү өндөр байдаг. Анхан шатны түвшний дэмжигчидтэйгээ ойр дотно байдаг улс төрийн намын удирдлага нь том хандивлагчдын хязгаарлагдмал ашиг сонирхлыг гэхээс илүү олон түмний илүү өргөн хүрээтэй ашиг сонирхлыг илэрхийлдэг. Гишүүний татвар нь намын албан ёсны бодлого дахь гишүүдийн нөлөөллийг тогтвортой хангаж өгч тодорхой хувь хүн, эсвэл бүлэг хэт нөлөө үзүүлэхээс сэргийлж өгдөг.

² Ingrid van Biezen. *Financing Political parties and election campaigns – guidelines*. 2003. p.18

³ *Membership of UK political parties*. House of commons library.

⁴ Я.Цэвэл. *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ.,2013. 726 дахь тал

⁵ ШВА. *Хэл зохиолын хүрээлэн. Монгол хэлний товч тайлбар толь*. УБ.,2008. 1943 дахь тал

Дэлхий даяар улс төрийн намын гишүүдийн тоо эрс буурч байгаагаас шалтгаалан намын гишүүдийн тооноос илүү сонгуулийн үеэр авдаг дэмжигчдийн саналаар намын бодит дэмжлэгийг тодорхойлдог болсон. Судлаач доктор Э.Гэрэлт-Одын диссертацийн ажилд дурдсанаар, Р.Катз болон П.Мэйр, Л.Билли нарын “Намын гишүүнчлэлийн бууралт” өгүүлэлд Дани Улсыг жишээ болгон авчээ. Дани Улсад 1960-аад оны үед улс төрийн намууд 600 гаруй мянган гишүүнтэй байсан бол 1990-ээд оны сүүлчээр 220 гаруй мянган намын идэвхтэн гишүүнтэй болж гишүүдийн тоо буурч, намын бодлого, үйл ажиллагаанд гишүүд оролцохоо больсон⁶ нь харагдаж байна.

Улс төрийн намын гишүүдийн бууралтыг Европын орнуудын жишээн дээр харьцуулан судалсан, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэд болох П.Мэйр, В.Бейзин нарын “Орчин үеийн Европ дахь улс төрийн намуудын гишүүнчлэлийн бууралт” бүтээлд 1980-аад оноос 2008 оныг хүртэлх хугацаанд намуудын гишүүнчлэл эрс буурсан байгааг дараах хүснэгтээс харна уу.

Хэдийгээр намын гишүүнчлэл дэлхийн улсуудад буурч байгаа ч гишүүний өгсөн татварыг тухайн намын явуулж буй бодлогод зарцуулах, татвараа намдаа өгсөн намын гишүүн эргээд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, ингэснээр намын гишүүний оролцоог бүх шатанд хангах зэрэг ач холбогдол хэвээр байна.

Хүснэгт 1. Европын улс төрийн намуудын гишүүнчлэл⁷

(сонгогчдын дунд эзлэх хувь)

Улсууд	1980	1990	1999	2008
Австри	28,48	23,71	17,66	17,27
Швед	8,41	8,00	5,54	3,87
Франц	5,05	2,98	1,57	1,85
Герман	4,52	3,89	2,93	2,30
Итали	9,66	9,10	4,05	5,57
Норвеги	15,35	13,13	7,31	5,04
Испани	1,20	2,07	3,42	4,36
Их Британи	4,12	2,63	1,92	1,21
Голланд	4,29	3,19	2,51	2,48
Ирланд	5,00	4,86	3,14	2,03

6 Гэрэлт-Од. Э. Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009. 47-48 дахь тал

7 Ingrid van Biezen, Peter Mair and Thomas Poguntke. ‘Going, going... gone? The Decline of Party Membership in Contemporary Europe’, *European Journal of Political Research*. 2012. 51(1). p.43-46

МОНГОЛ ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол дахь “Улс төрийн намын тухай” хуулийн 16-р зүйлийн 2 дахь хэсэгт намын санхүүжилтийн эх үүсвэрт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө орох бөгөөд намын хөрөнгөд гишүүний татвар, гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын бэлгэдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс, намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого, өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого, намын мөнгөн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү зэрэг байхаар хуульчилсан.

Манай намуудын хувьд гишүүдийн татвар, хандив, төрийн санхүүжилтээс санхүүжилтийн үндсэн эх үүсвэрээ бүрдүүлдэг. Харин хуульд заасан бусад эх үүсвэрүүдийн хувьд намын санхүүжилтийг бүрдүүлэхэд жинтэй нөлөө үзүүлж чаддаггүй гэж судлаачид, улс төрийн намуудын төлөөлөл үздэг ч огт орхигдуулж болохгүй сэдэв юм. Дээр дурдсанчлан, намдаа татвараа өгч буй намын гишүүн эргээд намын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих, дотоод ардчиллыг бий болгоход хувь нэмрээ оруулж байгаа төдийгүй улс төрийн намыг төлөвшүүлэхэд оролцож буй хэрэг юм.

Судлаач доктор С.Мөнхбатын диссертацийн ажилд дурдсанаар буюу 2009 оны байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 18 намын гишүүдийн тоог Монгол Улсын сонгуулийн насны 2 хүн тутмын нэг нь, нийт хүн амд харьцуулж үзвэл 4 хүн тутмын нэг нь ямар нэгэн намын гишүүн байх⁸ тооцоо гарч байжээ. Нээлттэй нийгэм форум, Сант марал сангийн хамтран 2014 онд гүйцэтгэсэн “Намуудын санхүүжилтийн талаарх олон нийтийн санал бодлын судалгаа⁹”-нд санамсаргүй түүврийн аргаар хамрагдсан 1200 респондентоос 18,4% нь ямар нэг намын гишүүн, үлдсэн 81,6% нь намын гишүүн бус иргэд байна. Эндээс 6 хүн тутмын нэг нь ямар нэг намын гишүүн байна гэсэн тооцоо гарчээ. Энэ нь улс төрийн намын гишүүнчлэл буурч байх магадлалтайг харуулж байна.

2020 оны 9-р сарын 15-ны байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 36 нам үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэхүү бүртгэлд намуудын гишүүдийн тоо¹⁰ 815-161300-ын хооронд байна. Намуудын гишүүдийн тоог эцэслэн гаргасан статистик байхгүй, намууд сонгуулийн үеэр гишүүдийн “хөөсөн” хий тоо гаргаж нийтэд зарладаг, гишүүдийн бодитой тоог гаргадаггүй гэсэн шүүмжлэлийг судлаачид болон улс төрийн намуудын төлөөлөл илэрхийлдэг.

Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг бий болгох, гишүүд сонгогчдын саналыг сонсон хүлээн авдаг, үйл ажиллагаа, санхүүжилт ил тод нээлттэй намыг бий болгох зорилготойгоор *Улс төрийн намын дотоод*

8 С.Мөнхбат. Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшилтийн зарим асуудал. Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009. 109-110 дахь тал

9 Нээлттэй нийгэм форум, Сант марал сан. Намуудын санхүүжилтийн талаарх олон нийтийн санал бодлын судалгаа. УБ., 2014. 18 дахь тал

10 Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудын гишүүдийн тоог харьцуулав.

ардчиллын индекс¹¹-ийг “Дефакто институт” болон “Нийгэм улс төрийн боловсрол” ТББ (судлаачийн тэргүүлдэг) хамтран Израйлийн “Ардчилал” институтийн аргачлалын дагуу намуудыг албан ёсны дүрмийн хүрээнд авч үзэхээс гадна бодит практик, туршлагыг нь тусгаж үнэлэх зорилготойгоор 2018 онд анх удаа судалгааны тоон аргыг ашиглан улс төрийн зургаан намыг хамруулан гүйцэтгэсэн. 2019 онд судалгааны арга зүй, аргачлалыг улам боловсронгуй болгон чанарын судалгааны аргыг ашиглан 2019 оны 5 дугаар сарын байдлаар Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 32 улс төрийн намыг хамруулан судлахаар зорьсон боловч МАН, АН, МАХН, ХҮН, ЭОН, ИЗНН, МНН, ҮЗН гэсэн 8 улс төрийн нам энэхүү судалгаанд оролцсон юм. Ингэхдээ оролцоо, төлөөлөл, өрсөлдөөн, санхүүжилт ба ил тод байдал гэсэн дэд үзүүлэлтүүдийг авч үзсэн.

Энэхүү судалгаанд намын гишүүдийн сэтгэлгээнд улс төрийн нам хэрхэн зохион байгуулагдсан байх ёстой зэрэг ойлголтууд өмнөх нийгмийн үеийнхээс өөрчлөгдөөгүй байна гэж үзэж болохоор үр дүн гарсан. Өөрөөр хэлбэл, улс төрийн намын гишүүдэд улс төрийн боловсрол хангалттай очиж чадахгүй байна.

Эксперт: “Улс төрийн нам дотор хамтын удирдлагын шийдвэр явагдахгүй байна гэдэг нь гишүүд оролцохгүй байна л гэсэн үг. Харин ч даргаа яах юм бэ гээд байж байна. Үүнийг ямар нэг хувь хүнээр төлөөлүүлж буруутгах хүнд юм. Иймээс улс төрийн боловсролыг олгох ажил хэрэгтэй байна. Энэ нь бас л өртөгтэй. Ийм зардлууд намуудад байхгүй. Жишээ нь, сумын намын байрны өдөр тутмын зардал л гэхэд хүнд шүү дээ¹².”

УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

“Улс төрийн намын дотоод ардчилал 2018” судалгааны дүнгээс улс төрийн намын гишүүдийн оролцоо намын бүх түвшинд харьцангуй бага байгаа нь ажиглагдсан юм. Намын удирдлагын түвшинд төлөөллийн зарчим хэрэгжиж байгаа ч чанарын судалгаанд оролцогчдын илэрхийлж байсан “намын бүтэц болон шийдвэр гаргах бүх үйл ажиллагаа дээрээс доош чиглэлд байна” гэсэн байр суурь батлагдсан. Гэхдээ энэхүү судалгааг намын гишүүдээс авч улс төрийн намын дотоод ардчиллын талаар тодорхой мэдээлэл өгснөөрөө цаашид гишүүдийн оролцоо намын үйл ажиллагаанд хангалтгүй байх зэрэг гарах сөрөг үр дагавар, нөлөөнөөс зайлсхийх боломжтой. Жишээ нь, намын үйл

Эксперт: “Улс төрийн нам дотор хамтын удирдлагын шийдвэр явагдахгүй байна гэдэг нь гишүүд оролцохгүй байна л гэсэн үг. Харин ч даргаа яах юм бэ гээд байж байна. Үүнийг ямар нэг хувь хүнээр төлөөлүүлж буруутгах хүнд юм. Иймээс улс төрийн боловсролыг олгох ажил хэрэгтэй байна. Энэ нь бас л өртөгтэй.”

11 Азийн сангийн дэмжлэгтэйгээр Дефакто институт, Нийгэм улс төрийн боловсрол ТББ хамтран “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2018, 2019”. Зөвлөх: доктор Э.Гэрэлт-Од

12 Азийн сангийн дэмжлэгтэйгээр Дефакто институт, Нийгэм улс төрийн боловсрол ТББ хамтран “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2018”



ажиллагааны, санхүүжилтийн зэрэг тайлангуудыг нэхдэг, хяналт тавьдаг болж намын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болох магадлалтай гэж үзсэн¹³ байна.

Уг судалгааг хийснээр судалгааны баг намын гишүүдэд улс төрийн боловсрол олгоход тодорхой хувь нэмэр оруулсан. Учир нь намын гишүүдээс судалгаа авах явцад улс төрийн намын дотоод ардчилал, санхүүжилтийн талаарх ойлголт, “Улс төрийн намын тухай” хуулийн заалтуудыг ямар нэгэн байдлаар тайлбарлах шаардлага тулгарч байсан нь цаашид намууд гишүүддээ хандсан сургалт, судалгаа, нөлөөллийн ажлуудыг хийх шаардлагатайг харуулж байсан юм.

Монгол Улсын хувьд улс төрийн намын гишүүн, нэр дэвшигчид гишүүний татварын хэмжээ, татвар төлөх хугацаа, татвар хураах зэрэг асуудлыг намуудын дотоод дүрмээр зохицуулж байна. 2005 оны “Улс төрийн намын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт гишүүн намын дүрмээр тогтоосон хэмжээгээр татвар төлөхөөр заасан байна. Тухайлбал, МАН (Монгол Ардын нам)-ын гишүүн сар бүр цалин, түүнтэй адилтгах орлогын 1 хувийг, ИЗН (Иргэний Зориг нам)-ын гишүүн сар бүр 300 төгрөгийн, ЭОН (Эх Орон нам)-ын гишүүн сар бүр 100

¹³ *Азийн сангийн дэмжлэгтэйгээр Дэфакто институт, Нийгэм улс төрийн боловсрол ТББ хамтран “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2018”*

төгрөгийн, АН (Ардчилсан нам)-ын гишүүн сар бүр 100 төгрөгийн татварыг намдаа төлж байна. Үүнээс гадна намын сонгуульт гишүүн бүр намдаа өндөр хэмжээний хураамжийг төлдөг. МАН-ын Бага хурлын гишүүн улиралд 200000 төгрөг¹⁴, АН-ын Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүн улиралд 250000 төгрөг, ИЗН-ын Улс төрийн зөвлөлийн гишүүн улиралд 668000 төгрөгийн татварыг тус тус төлдөг¹⁵ байна.

Хүснэгт 2. Улс төрийн намын гишүүдийн намдаа төлдөг татварын хэмжээ¹⁶

№	Улс төрийн намын нэр	Нийт гишүүдийн тоо	Гишүүний татвар өгөх гишүүдийн тоо, татварын хэмжээ	Сонгуульт гишүүний татвар өгөх гишүүдийн тоо, татварын хэмжээ	Нийт дүн
1	МАН	161.300	160.990	310	25.720.064.000 төг
		1 сард өгөх татвар	160.990*3.200 ¹⁷ төг= 515.168.000 төг		
		1 улиралд өгөх татвар		310*200.000 төг= 62.000.000 төг	
		1 жилд өгөх татвар	515.168.000 төг*12= 6.182.016.000 төг	62.000.000 төг*4= 248.000.000 төг	
		4 жилд өгөх татвар	6.182.016.000 төг*4= 24.728.064.000 төг	248.000.000 төг*4= 992.000.000 төг	
2	Ардчилсан нам	150.000	149.772	228	1.630.905.600 төг
		1 сард өгөх татвар	149.772*100 төг= 14.977.200 төг		
		1 улиралд өгөх татвар		228*250.000 төг= 57.000.000 төг	
		1 жилд өгөх татвар	14.977.200 төг*12= 179.726.400 төг	57.000.000 төг*4= 228.000.000 төг	
		4 жилд өгөх татвар	718.905.600 төг	228.000.000 төг*4= 912.000.000 төг	
3	ИЗНН	35.000	34.962	38	573.961.600 төг
		1 сард өгөх татвар	34.962*300 төг= 10.488.600 төг		
		1 улиралд өгөх татвар		38*668.000 төг= 25.384.000 төг	
		1 жилд өгөх татвар	10.488.600 төг*4= 41.954.400 төг	25.384.000 төг*4= 101.536.000 төг	
		4 жилд өгөх татвар	41.954.400 төг*4= 167.817.600 төг	101.536.000 төг*4= 406.144.000 төг	

14 Монгол Ардын Намын ажилтны лавлах. МАН-ын санхүүжилтийн журам. УБ.,2009. 105 дахь тал

15 Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв. Улс төрийн намын санхүүжилтийн мониторинг. УБ.,2007. 32 дахь тал

16 Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудын гишүүдийн тоог тухайн намын дүрмээр гишүүдээс авах татварын дүнтэй харьцуулав.

17 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 320.000 төгрөгийн 1 хувиар тооцож болох юм. 3200 төгрөгөөр тооцвол МАН-д гишүүний татварт их хэмжээний мөнгө төвлөрнө.

Судалгааны ажлын хүрээнд улс төрийн намуудаас санхүүжилтийн эх үүсвэрүүд, гишүүдийн татвар нийт орлогын хэдэн хувийг эзэлдэг, татвараас цугларсан орлогын зарцуулалт, хэдэн хувийг иргэдийн улс төрийн боловсролд зарцуулдаг, тайланг өөрийн намын гишүүдэд тайлагнадаг эсэх, мэдээллийг ил тод байлгадаг эсэх зэргийг тодруулахаар уулзсан боловч мэдээлэл авч чадаагүй, мэдээллийг өгөхөөс татгалзсан. Гишүүдийн татвараас хэдэн төгрөгийн санхүүжилт намд төвлөрдөг болохыг зарим намуудын дүрэмд заасан хамгийн бага үнээр Хүснэгт 2-т тооцоолон гаргалаа.

Намуудын санхүүжилтийн журмуудад зааснаар, тухайн намын жирийн гишүүд 100 төгрөг, 300 төгрөг хүртэл өгч болохоор байгаа нь нам, нэр дэвшигчид сонгуулийн болон сонгуулийн бус үед томоохон хандивлагчдын “хандив”-т тулгуурлан санхүүжилтээ босгох тогтолцоо руу явж байна гэж харагдаж байна.

Эцэст нь дүгнэхэд, Монгол дахь улс төрийн намуудын талаар хийгдэж байгаа судалгаануудад улс төрийн намын төлөвшил тааруу, намын гишүүдийн оролцоо хангалтгүй, дотоод ардчилал байхгүй, санхүүжилтийн тогтолцоо хууль бус, далд, цөөхөн хэдэн ашиг хонжоо хайсан хандивлагчдаас хараат, сонгуулийн бохир технологи, хууль бус аргыг өргөн хэрэглэдэг болсон энэ үед улс төрийн намын гишүүд намдаа татвараа төлж, түүний хариуд бодлогын өрсөлдөөн, цэвэр ил тод санхүүжилт бүхий тогтолцоог удирдлагаас нэхэх, хяналт тавьдаг зөв тогтолцоог хэвшүүлдэг “хариуцлагатай гишүүн” байх нэн шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Азийн сангийн дэмжлэгтэйгээр Дэфакто институт, Нийгэм улс төрийн боловсрол ТББ хамтран “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2018”
2. Азийн сангийн дэмжлэгтэйгээр Дэфакто институт, Нийгэм улс төрийн боловсрол ТББ хамтран “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2019”.
3. Ардчилсан намын дүрэм, журмын эмхэтгэл. УБ.,2009
4. Гэрэлт-Од.Э. Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал (1990 оноос хойш). Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009.
5. Монгол Ардын Намын ажилтны лавлах. МАН-ын санхүүжилтийн журам. УБ.,2009.
6. Мөнхбат.С. Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөвшилтийн зарим асуудал. Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2009.
7. Нээлттэй нийгэм форум, Сант марал сан. Намуудын санхүүжилтийн талаарх олон нийтийн санал бодлын судалгаа. УБ.,2014
8. Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсрол төв. Улс төрийн намын санхүүжилтийн мониторинг. УБ.,2007.

9. ШУА. Хэл зохиолын хүрээлэн. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,2008
10. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,2013.
11. Эрдэнэдалай. Б. Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршлага ба Монгол дахь тулгамдсан асуудал. Улс төрийн ухааны докторын диссертаци. УБ., 2015.
12. Ingrid van Biezen. Financing Political parties and election campaigns – guidelines. 2003.
13. Ingrid van Biezen, Peter Mair and Thomas Poguntke. 'Going, going... gone? The Decline of Party Membership in Contemporary Europe', European Journal of Political Research. 2012. 51(1).
14. Membership of UK political parties. House of commons library
15. Nassmacher, Karl-Heinz. "Introduction: Political Parties, Funding and Democracy" Chapter 1 in Funding of Political Parties and Election Campaigns: Handbook Series. International IDEA.,2003.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД АРДЧИЛЛЫГ ХЭМЖИХ НЬ

А.Бат-Оргил

Дефакто институтийн ахлах судлаач

АБСТРАКТ

Энэхүү судалгааны өгүүлэл бол Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын 2018, 2019 индекст хийсэн дүн шинжилгээ юм. Дотоод ардчиллын индексийг Израйлын Ардчилал институтээс гаргасан индекс дээр үндэслэж Дефакто Институтын судалгааны баг гүйцэтгэсэн. Анх 2018 онд индексийг гаргахдаа намын гишүүдээс асуулга авч буюу тоон судалгаан дээр үндэслэсэн бол 2019 онд фокус групп ярилцлага буюу чанарын судалгаан дээр үндэслэж гаргасан. Тоон болон чанарын судалгааны үр дүн эрс ялгаатай гарсан. Тиймээс харьцуулсан анализ хийх боломж бүрдсэн. Индексийн үр дүн нь арга зүйгээс гадна бусад хүчин зүйлүүд нөлөөлдөг болох нь харагдсан. Жишээлбэл 2019 он нь сонгуулийн өмнөх жил, мөн нөхөн сонгууль зэрэг үйл явдлууд болж байснаар ялгаатай байсан. Эцэст нь Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг хэмжихэд чанарын судалгааны арга зүй нь илүү тохирно гэж дүгнэсэн.

Түлхүүр үг: Дотоод ардчилал, Ардчиллын индекс, Монголын улс төрийн намууд

ОРШИЛ

Орчин үеийн ардчилсан тогтолцоонд улс төрийн намууд нь иргэд, төрийг холбосон гүүр гэдэг утгаар маш чухал үүрэгтэй (Rahat & Shapira, 2016). Ардчилсан тогтолцооны хамгийн чухал инстүүцийн нэг учраас намууд өөрсдөө ардчилсан байх ёстой гэдэг дээр маргаан бараг гардаггүй. Рахат, Шапира (2016) нар дотоод ардчиллыг удирдлага, төсөв, нэр дэвшигчдийг тодруулах зэрэгт гишүүдийн оролцоо хэр зэрэг байгаагаар тодорхойлсон байдаг.

Монголд 2005 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлд нам нь ардчилсан зарчмыг баримтлах ёстойг хуульчилж өгсөн. 2018 он миний бие бусад судлаачдийн хамтаар Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг хэмжих оролдлогуудыг хийж эхэлсэн. 2018 онд бид улс төрийн

намуудыг оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал ба санхүүжилт гэсэн дөрвөн чиглэлээр асуулга боловсруулж, намуудын гишүүдээс санамсаргүй түүврийн аргаар асуулга авч гаргасан. 2019 онд бид чанарын судалгааны аргачлалыг ашигласан. Энэхүү өгүүллийн гол зорилго нь намуудын дотоод ардчиллыг хэмжихэд цаашид ямар арга зүй ашиглах, юу юуг анхаарах ёстойг тодруулах юм.

ХЭМЖИХ АРГАЧЛАЛЫН ТУХАЙД

Улс төрийн нам судлаачдын зүгээс дотоод ардчиллыг хэмжих олон оролдлогууд хийсэн байдаг. Жишээлбэл Сузан Скарров, Томас Погунтке, Пол Вебб нар хоёр төрлийн индекс боловсруулсан. Нэгт. намын их хуралд үндэслэсэн (assembly based), хоёрт бүх гишүүдийн санал хураалтад үндэслэсэн (plebiscitary based) хоёр юм. Энэ хоёр төрлийн индекс нь хэн шийдвэр гаргах вэ гэдгээрээ ялгагддаг. Өөр нэг хэмжих оролдлого нь Гидеон Рахат, Асаф Шапира нар улс төрийн намуудыг зөвхөн дүрмийнх нь хүрээнд бус амьдрал дээр хэрхэн дүрмээ хэрэгжүүлж байна гэдэгт анхаарч, экспертийн үнэлгээ хийсэн.

Дефакто институтын хувьд 2018 онд тоон судалгааг буюу улс төрийн намын гишүүдээс асуулга авах аргыг сонгосон. Учир нь Израйлын Ардчилал институтын адилаар дотоод ардчиллыг бие даан судалдаг экспертүүд цөөн, мөн намуудын дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл олон нийтэд ил бус байсан.

Нийт дээд шүүхэд бүртгэлтэй намуудын гишүүнчлэлийн хэмжээ 535,234 байсан бөгөөд эндээс 384-г санамсаргүй байдлаар түүвэрлэж асуулгаа авсан. Энэхүү түүврийг гаргахдаа итгэлцлийн түвшин 95%, хүлээн зөвшөөрөгдөх алдааг 5% байхаар тооцсон. Ингэхдээ улс төрийн намуудын хот болон орон нутгийн гээд 3000 орчим нэрс, утасны дугаар цуглуулж, түүвэрлэлтээ хийсэн.

Ингээд асуулга дээр үндэслээд дараах байдлаар үнэлгээг өгсөн.

- Индекс нь 0-30 бол ардчилсан бус
- Индекс нь 31-60 бол хагас ардчилсан
- Индекс нь 60-аас дээш бол ардчилсан

Харин 2019 оны судалгаанд арга зүйгээ өөрчилсөн. Учир нь дээр дурдсан том, жижиг намуудын гишүүдийн тооноос хамаараад адилхан хэмжээний түүвэр сонгоход төвөгтэй байсан. Мөн 2018 оны судалгаанд оролцогчдын хариултын түвшин (response rate) хангалттай өндөр байгаагүй. Тийм учраас улс төрийн намын гишүүдийг оролцуулсан фокус групп ярилцлагуудыг зохион байгуулж, дараа нь уг хариултууд дээр нь үндэслэж экспертүүд үнэлгээг өгсөн. Ингэхдээ мөн намуудын вебсайт, нийгмийн сүлжээнүүдэд мониторинг хийж үнэлгээндээ тусгасан.

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Намын дотоод ардчилал гэх нэр томъёо анх олон нийтийн (масс) намууд бий болж эхэлсэнтэй цуг гарч ирсэн (Дуверже, 1961). Сүүлийн жилүүдэд дотоод ардчилал гэх энэ сэдэв судлаачдын анхаарлыг татах болсон нь улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, ардчиллын чанаржуулахад чухал үүрэгтэй гэж үзэж байгаатай холбоотой юм (Cross and Katz, 2013). Жишээлбэл Сингх (2014) дотоод ардчилал бол иргэд, төрийг холбох гол хэрэгсэл гэсэн байдаг. Мөн түүнчлэн дотоод ардчилал нь зөвхөн намын гишүүдэд хамаатай зүйл биш. Дотоод ардчилал нь гишүүнээр элсэхийг хүсч байгаа хүнд ч шийдвэр гаргахад нь чухал үүрэгтэй (Скаров, 2005).

Өнөөдөр маш олон оронд намын дотоод ардчиллыг хуульчилсан байдаг. Жишээлбэл Европын Холбооны улсуудад намууд нь

"Code of Good Practice in the Field of Political Parties (2009)" дүрмийг баримтлах учиртай. Уг баримт бичигт дараах дөрвөн зарчмыг гол болгож дурдсан байна.

- Намын дотоод процедур, дүрэм журамд гишүүдийн санаа бодлыг тусгасан байх ёстой.
- Намын лидерийг сонгох процедурт гишүүд оролцсон байх
- Намын нэгжүүд, намын удирдлагын харилцаа холбоо тодорхой байх ёстой.
- Намын санхүүжилт нээлттэй байх ёстой ба аудит, мониторинг хийх албан ёсны механизм байх ёстой.

Гэхдээ дотоод ардчиллыг хуулиар нарийн зохицуулахыг буруу гэж зарим судлаачид үздэг. Карасимеонов (2005) намын дотоод процедур, үйл ажиллагааг гаднаас нь зохицуулснаар гишүүдийн чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхэд халдаж байна гэж үзсэн. Жишээлбэл нийгмийн цөөнхийг төлөөлөх зорилготой улс төрийн намууд өөрсдийн үнэт зүйлийн дагуу зохион байгуулалтаа хийх эрхтэй байх ёстой гэж хэлсэн байдаг. Нөгөө талаасаа дотоод ардчиллын өндөр шаардлага тавьснаар шийдвэр гаргах, шийдвэрээ хэрэгжүүлэх зэрэгт үр ашиггүй байх, цаг хугацаа алдах зэрэг асуудал гардаг (Scarrow, 2005).

Дотоод ардчиллыг хэмжих тухайд бол Погунтке, Скаров, Вебб нар намуудын гишүүд шийдвэр гаргахад хэр зэрэг оролцож байгаагаар хэмжсэн (Poguntke, Scarrow, and Webb, 2016). Ингэхдээ намуудын дүрэм, танилцуулга, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарсан мэдээллүүд дээр оноо өгсөн. Өөрөөр хэлбэл цаасан дээр бичигдсэн баримтууд түшиглэсэн. Гэхдээ Погунтке нар нь (2016) дээр дурдсан хоёр төрлийн ялгаатай индексийг бий болгосон. Их хуралд суурилсан индекс нь хуралд оролцогчид нь аливаа асуудал дээр мэтгэлцэж, эцэст нь хурал өөрөө шийдвэр гаргадаг бол бүх гишүүдийн саналд үндэслэсэн индекс нь асуудлын талаарх мэтгэлцээн, шийдвэр гаргах процесс хоёрыг тусад нь салгаж өгсөн байдаг. Гэхдээ энэ хоёр индексийн алийг нь сонгох вэ гэдэг нь тухайн орны улс төрийн намын тухай хуулийн зохицуулалтаас хамаардаг (Poguntke, Scarrow, and Webb, 2016).

Дотоод ардчиллыг хэмжихэд таван гол чиглэл байх ёстой гэж үзсэн эрдэмтэд бол Рахат, Шапира (2017) хоёр юм. Тэд гишүүдийн оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, хариу үйлдэл үзүүлэх байдал, ил тод байдал гэсэн таван чиглэлийг тодорхойлсон. Харин Борз, Жанда (2018) нар дээрх таван чиглэлийг хэтэрхий ерөнхий байна гээд улс орны ардчилал, намын ардчилал хоёрыг хэмжих хэмжүүр ялгаатай байх ёстой гэж мэтгэсэн байдаг. Борз, Жанда нарынхаар бол дээрх 5 чиглэл нь улс орын хэмжээний ардчиллыг хэмжихэд л илүү тохирох аж. Ер нь одоог хүртэл дотоод ардчиллыг хэмжих тал дээр эрдэмтэд нэгдсэн байр суурин дээр очоогүй байна (Cross & Katz, 2013).


МОНГОЛЫН НАМУУДЫН ДОТООДЫН АРДЧИЛЛЫГ ХЭМЖСЭН НЬ

Монголын тухайд бол 2005 онд УИХ-аар Улс төрийн намын тухай хуулийг баталсан нь дотоод ардчиллыг намуудаас шаардах үндэслэлийг бий болгосон (Гэрэлт-Од, 2015). Гэхдээ энэ хуулиар гишүүд шийдвэр гаргахад хэрхэн оролцохыг нарийвчлан томъёолоогүй. Тийм учраас бид Израйлын туршлагыг харгалзан оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн хэмжүүрээр дотоод ардчиллыг хэмжсэн.


2018, 2019 оны индекс

2018 намуудын дундаж оноо 49.9 байсан бөгөөд өмнө дурдсанчлан намууд 60-аас дээш оноо авч чадаагүй учраас хагас ардчилсан гэх ангилалд хамаарч байна. Харин 2019 оны индекст намуудын үнэлгээ нь өсч, дундаж оноо нь 54,5 оноо болсон. Мөн 4 нам 60-аас дээш оноо авч ардчилсан гэх ангилал руу шилжсэн байна. Шалтгаан нь тухайн үед УИХ-ын 42-р тойрогт нөхөн сонгуульд оролцохоор намууд бэлдэж, дотоод үйл ажиллагаа нь ихэвхижсэн, мөн 2020 оны УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажил эхэлсэн зэрэгтэй холбоотой гэж судлаачид дүгнэсэн.

Зураг 1. 2018 оны Дотоод ардчиллын индекс



Зураг 2. 2019 оны Дотоод ардчиллын индекс



ОРОЛЦОО

Энэ чиглэлд бид намуудын удирдлага, бодлого, зорилтоо сонгоход гишүүдийн оролцоо хэр зэрэг байгаагаар хэмжсэн. Жишээлбэл АН даргаа сонгохдоо бүх гишүүдийн оролцоог хангаж чадсан. Харин бусад намууд их хурлаараа намын даргаа сонгож байна. Энэ хоёрын ялгаатай үнэлэх үү, адилхан үнэлэх үү гэдэг нь дээрх assembly based, plebiscitary based-ийг сонгосон уу гэдгээс хамаарахаар байна. Үүнийг цаашид үнэлгээ, хэмжилт хийх хүмүүс хамгийн түрүүнд анхаарах хэрэгтэй.

ӨРСӨЛДӨӨН

Үнэлгээ хийхэд тулгарч буй хамгийн гол асуудал нь хоёр том намд хэт олон горилогч нар байхад нөгөө талд нь жижиг намуудад нэр дэвших боловсон хүчин олдохгүй байх асуудлууд гарч байсан. Хоёр том намын зүгээс нэр дэвшигчдээ сонгохдоо ил, далд санхүүгийн шаардлага тавьж байгаа нь дотоод ардчиллын хувьд хамгийн том асуултын тэмдэг болж байна. АН нам дэнчин хэлбэрээр ил тод зарласан бол МАН хувьд хандив хэлбэрээр зохион байгуулж байна. Том, жижиг намуудыг өрсөлдөөний энэ харилцан адилгүй нөхцөл байдал нь үнэлгээний нэг том асуудал юм.

ТӨЛӨӨЛӨЛ

Жендерийн тэгш эрхийг хангах тал дээр намууд хуулийн шаардлага болох эмэгтэйчүүдийн 20 хувийн квотыг мөрдөж байна. Энэ 20 хувийн квот нь хангалттай эсэх дээр мөн л дахин бодолцох шаардлагатай. Мөн улс төрийн намуудын дотоод бүтцийн байгууллагууд, тэдний гишүүдийг намын удирдлагын зүгээс томилж байгаа эсэх дараа дараагийн үнэлгээнд анхаарч тусгах шаардлагатай нь харагдсан. Өөрөөр хэлбэл намын үйл ажиллагаа дээрээс доош чиглэсэн байна уу, (top-down), доороос дээш (bottom-up) чиглэсэн байна уу гэдэг л асуудал юм.

ИЛ ТОД БАЙДАЛ (БА САНХҮҮЖИЛТ)

2018 оны байдлаар 3 нам өөрийн вебсайттай байсан бол 2019 онд 5 нам болж нэмэгджээ. Мөн намуудын нийгмийн сүлжээний хаягууд тодорхойгүй байгаа нь гишүүдийг төөрөгдүүлж байна. Ер нь орчин

үеийн намууд бүгд өөрсдийн веб сайт, нийгмийн сүлжээний алба ёсны хуудастай байх ёстой юу гэсэн асуулт гарч ирж байна. Мөн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн тухайд нарийн стандарт нь ямар байх ёстой вэ гэдгийг тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл АН санхүүгийн тайлангаа веб дээрээ байршуулаад удалгүй буцаагаад авчихсан.

ДҮГНЭЛТ

2018 оны индексээс харвал намуудын авсан оноо нь хоорондоо маш ойрхон байна. Гэхдээ чиглэл бүр дээр нь нэг бүрчлэн харвал ялгаатай зүйлүүд харагдана.

2018 онд намууд хагас ардчилсан гэсэн оноо авч байсан бол 2019 онд 4 нам ардчилсан гэх ангилалд шилжсэн. Энэ ялгаа нь дээрх аргачлалын зөрөөтэй холбоотой.

Тиймээс шууд харьцуулах боломжгүй юм. Дээрх судалгааны үр дүнд улс төрийн намуудын дотоод ардчиллыг хэмжихэд чанарын судалгааны арга нь илүү тохиромжтой гэж дүгнэж байна. 2018 оны тоон судалгааг хийхэд олон гишүүнтэй

намуудаас түүвэрлэлт, цөөн гишүүнтэй жижиг намууд цөөн хүнтэй түүвэрлэлтийг хооронд харьцуулахад хүндрэлтэй байсан. Мөн асуулгад оролцогчдын хариу үйлдэл үзүүлэх хувь (response rate) нь бага байсан. Ер нь намын дотоод ардчиллыг асуулгын аргаар нь хэмжихэд учир дутагдалтай гэж Сандри (2011) судалгаандаа дурдсан байдаг. Сандригийн (2011) хувьд кэйс судалгааны арга л хамгийн сайн тохирох аж.

2018 онд намууд хагас ардчилсан гэсэн оноо авч байсан бол 2019 онд 4 нам ардчилсан гэх ангилалд шилжсэн. Энэ ялгаа нь дээрх аргачлалын зөрөөтэй холбоотой.

Нөгөө талаасаа Покунтке нарынх шиг зөвхөн намын дүрэм, журам дээр суурилж үнэлэх нь бодит байдалтай тохирохгүй, ялангуяа Монголын нөхцөлд тохиромжгүй арга юм. Харин Рахат (2016) нарын экспертийн үнэлгээг хийх боломжтой боловч Монголын улс төрийн намуудыг судалдаг экспертийн тоо харьцангуй цөөн байна. Ялангуяа жижиг намуудын үйл ажиллааны талаар үнэлгээ хийхэд тухайн экспертүүд мэдээллийн зөрөө маш нөлөөтэй.

Мөн Монголын улс төрийн намууд нь таваас бусад нь өөрсдийн вебсайтгүй байна. Мөн тэд тогтмол мэдээллээ шинэчилдэггүй. Бас нийгмийн сүлжээнд албан ёсны баталгаажсан хаягаар бус олон тооны хаягаар янз бүрийн мэдээлэл цацдаг нь дотоод ардчиллын үнэлгээнд нөлөөлж байна. Тиймээс улс төрийн намуудын гишүүдтэй ганцаарчилсан бүтэцлэгдсэн, хагас бүтэцлэгдсэн ярилцлага хийх, фокус групп ярилцлага хийх, мөн намуудын гишүүдийн хэвлэл

мэдээллээр өгсөн ярилцлагуудад контент анализ хийх зэрэг чанарын судалгааны арга зүй нь хамгийн тохиромжтой нь харагдсан.

Мөн цаашид бид их хуралд суурилсан (assembly based) үнэлгээгээр явах уу, бүх гишүүдийн санал асуулгаар (plebiscitary based) дүгнэх үү гэдэгт нэгдсэн шийдвэр гаргах шаардлагатай нь харагдаж байна. Жишээлбэл АН бүх гишүүдээсээ намын даргаа сонгож байхад, МАН их хурлаас намын даргаа сонгож байна. Энэ хоёр хоёулаа ардчилсан гэх үнэлгээ авах боловч дээрх хоёр нь зарчмын ялгаатай зүйлүүд юм.

Эцэст нь дүгнэхэд улс төрийн намуудын үйл ажиллагаа нь дээрээс доош чиглэлтэй байна уу, доороос дээш чиглэлтэй байна уу гэдэгт дараа, дараагийн үнэлгээ төвлөрөх нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Cross, W. & Katz, R. S. (2013) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press.

Gerelt-Od, E. (2009) *Institutionalization of Political Parties in Mongolia (since 1990)*

Cross, W. (2013) 'Party Leadership Selection & Intra-Party Democracy'. In Cross, W. & Katz, R. S. (eds.) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press, pp. 100

Duverger, M. *I Partiti Politici*, Milano, edizioni di Comunità, 1961.

Karasimeonov, G. (2005). *Organizational structures and internal party democracy in South Eastern Europe*. GorexPress.

Scarrow, S. (2005) *Political Parties & Democracy in Theoretical*

Practical Perspectives: Implementing Intra-Party Democracy

Sandri, G. (2010). *Intra-party democracy and its effects on membership mobilization: A case study*.

Singh, R (2014) "Intra-party Democracy and Indian Political Parties", Hindu Centre for Politics and Public Policy

Rahat, G. & Shapira, A. (2016) *An Intra-Party Democracy Index: Theory, Design & A Demonstration*

Rahat, G. (2013) 'What is Democratic Candidate Selection?'. In Cross, W. and Katz, R. S. (eds.) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press, pp. 136 – 149.

Von dem Berge, B., Poguntke, T., Obert, P. & Tipei, D. (2013) *Measuring Intra-Party Democracy*

Poguntke, T., Scarrow, S. E., Webb, P. D., Allern, E. H., Aylott, N., Van Biezen, I., ... & Enyedi, Z. (2016). *Party rules, party resources and the politics of parliamentary democracies: How parties organize in the 21st century*. *Party Politics*, 22(6), 661- 678

Borz, G., & Janda, K. (2018). *Contemporary trends in party organization: revisiting intra-party democracy*. *Party Politics*, 1354068818754605.

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ЗАРИМ ШААРДЛАГЫГ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗСЭН НЬ

С.Номынбаясгалан

Судлаач (LL.M)

I. ОРШИЛ

Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах **“амин”** хэрэгцээнээс үүдэлтэй.¹ Ийнхүү сонгуулийг улс төрийн байгууллаас салдаггүй, ёстой л орхиж болдоггүй дагуул мэт. Түүний гол учир шалтгаан юу вэ гэвэл ард түмэн засгаа гартаа авч, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагаас нь **“шууд”** урган гардагт оршиж байна.² Тиймээс Монгол Улсын иргэн бүр биечлэн буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй бөгөөд ийнхүү оролцох хамгийн тодорхой хэлбэр нь **“сонгууль”** билээ. Улсын Их Хурлын эсхүл орон нутгийн Хурлын сонгууль³ уу гэдгээс үл хамааран сонгууль нь ард түмний хүсэл эрмэлзлээ илэрхийлэх нийтлэг агаад бодитой арга төдийгүй олон улсын жишигт нийцүүлэн явуулсан цагт хүний улс төрийн **“үндсэн”** эрхийг хангадаг эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн чухал үйл явдал⁴ эргэлзээгүй болно. Тэгээд ч сонгууль **“зайлшгүй”** байх олон улсын эрх зүйн зарчимтай. Сонгуулийн ардчилсан шинж чанар, нийгэм–улс төрийн үр өгөөж, гүйцэтгэх үүрэг нь түүнийг зохицуулан тодорхойлох эрх зүйн зохицуулалтаас багагүй шалтгаална. Эрх зүйн зохицуулалтын улс төрийн агуулга, утга учир нь нийгмийн ямар бүлгийн төлөөлөгчийг хэнээр, хэрхэн сонгуулах вэ, түүнийг яаж хуульчлан баталгаажуулах вэ гэдэгт оршино. Засаглалын эрх мэдэл ард түмний мэдэлд байж, ард түмнээс эх үүсэлтэй байдгийн хувьд сонгууль нь мөн ард

1 Чимид Б., *Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!*, *Үндсэн хууль ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 27 дахь тал*

2 Чимид Б., *Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!*, *Үндсэн хууль ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 28 дахь тал*

3 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 01 дүгээр сарын 30–ны өдөр батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль гэснийг цаашид “орон нутгийн Хурлын сонгууль” гэж нэрлэн бичсэн. Түүнчлэн хууль зүйн утгаараа орон нутгийн Хурлын сонгууль нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, иүүд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөлөөр бүрдүүлэх үндсэн аргад тооцогддог. <https://www.legalinfo.mn/law/details/15125?lawid=15125>

4 Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), Уб., 2009, 82 дахь тал

олны хүсэл зориг, эрх ашгийн илэрхийлэл, хэрэгжилт байх ёстой.⁵ Энэ нь Улсын Их Хурлын гэлтгүй орон нутгийн Хурлын сонгуулийн эрх зүйн зохицуулалтын тулгуур үндэс нь юм. Чухамдаа сонгуулийн ямар асуудлыг үндсэн хуулийн түвшинд,⁶ ямар асуудлыг эрхийн бусад актад буюу сонгуулийн хуульд тусгах вэ гэдэг асуудлыг ихээхэн нарийвчлан авч үзэх нийгмийн хэрэгцээ шаардлага улам бүр бий болсоор байна.

Энэ утгаараа сонгуулийн үндсэн зорилго нь төв, орон нутгийн төлөөлөгчдийн байгууллагыг иргэдийн өргөн оролцоотойгоор **“санал”** хураалтаар шалгаруулан томилоход оршиж байна.⁷ Тиймээс сонгуулийн эрх зүйн амин сүнс нь “иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрх” гэж тодорхойлж ирсэн байна.⁸ Энэ нь ардчилсан төр тогтох язгуур үндэс болсон иргэний нийгмийн тулгуур үзэл санаа, зарчмуудыг, нийгэм өөрийг удирдах, хөгжих дотоод механизм бүрдүүлэх төдийгүй иргэний нийгэм хөгжих, төлөвших гол үндэс болох⁹ учраас орон нутгийн Хурлын сонгуульд тэгш сонгох, сонгогдох эрхийн тухай асуудал ихээхэн чухал юм.

Иймээс иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвших сонирхолтой иргэний **“сонгогдох эрх”** хязгаарлагдах боломжтой эсэх, хэрэв хязгаарлагдах боломжтой гэж үзвэл хязгаарлагдах хүрээ хязгаарыг тодруулах, сонгогдох нь томилогдохоос ялгаатай болох, цаашлаад авлига, албан тушаалын гэмт хэрэгт шийтгэгдэж байсан иргэний сонгогдох эрхийг бүх насаар нь хязгаарлах нь хэр зохистой вэ, түүнчлэн энэхүү эрхийн агуулгын багтаамжийг тодорхойлсны үндсэн дээр нэр дэвшигчид тавигдах хууль зүйн зарим шаардлага, түүнийг зайлшгүй эргэн харах нөхцөл байдал Улсын Их Хурлын гэлтгүй **“орон нутгийн Хурлын”** сонгуулийн хүрээнд үүсээд байна. Түүнчлэн орон нутгийн Хурлын сонгуулийг олонхын (**мажоритар**) тогтолцоогоор¹⁰ явуулах тохиолдолд буюу сонгогч шууд сонгох эрхийнхээ¹¹ үндсэн дээр нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа өгөхөд тэрхүү шаардлага нь хэр тохирч нийцсэн, иргэний нэр дэвшин сонгогдох эрх хэрэгжих боломжтой байгаа эсэхийг эргэцүүлэн авч үзэх шаардлагатай байна. Энэ нь нийтлэлийг бичих үндэслэл болов. Энэ талаар орон нутгийн Хурлын

5 Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо: Улс төр судлалын шинжлэгээ, (Редактор Жамбал А.), Уб., 2000, 27–28 дахь тал (Цаашид “Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Дурдсан бүтээл” гэж товчилно. С.Н.)

6 Энэ нь үндсэн хуульд сонгуулийн үйл ажиллагааны зарчмын чанартай үндсэн асуудлыг тодорхойлох хандлага зонхилдог. Энэ нь сонгуулийн хэм хэмжээг эрх баригч намаас зөрчих, эсхүл гуйвуулахаас сэргийлэхэд чухал ач холбогдолтой учраас үндсэн хуулийн нэр хүнд, тодорхой байдал зэрэг нь сонгуульд оролцогчдын итгэлийг бэхжүүлнэ гэж үздэгтэй холбоотой болов уу.

7 Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо, (Улс төр судлалын шинжлэгээ), Уб., 2000, 33 дахь тал

8 Чимид Б., Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008, 45 дахь тал

9 Лүндэндорж Н., Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага, Уб., 2002, 292–297 дахь тал

10 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль олонхын /мажоритар/ тогтолцоотой байна” гэж заасан.

11 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөвлөлгүгээр оролцож, саналаа нууцаар гаргана” гэж заасан.

сонгуулийн хуулийн “тухайлсан зохицуулалтын”¹² жишээн дээр авч үзэхийг зорилоо. Иймд энэ нийтлэлд иргэний улс төрийн суурь эрх болох сонгох, сонгогдох эрхийн, тэр дундаа “идэвхгүй эрх” буюу сонгогдох эрхийн баталгааг хангахад үндсэн хуулийн тодорхой маргааныг хянан шийдвэрлээд гаргасан тайлбар болох “**зарчмын зөрүүтэй**” хууль зүйн үндэслэлүүдийн үүднээс авч үзэхийг оролдлоо.

II. ҮНДСЭН АСУУДАЛ

A. Нэр томъёоны тухай товч авч үзсэн нь

Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга (1993) хэмээх бүтээлд “Сонгох, сонгогдох эрх” нь иргэд төрийг удирдахад оролцох хууль зүйн үндсэн хэлбэр” гэж тэмдэглэсэн¹³ бол Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (2009) хэмээх бүтээлд Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад өгөх онолын тайлбарыг “. . . сонгогдох эрх нь Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлал, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүнээр сонгогдож төрийн алба хаших мандаттай болохыг хэлнэ” гэж тайлбарласан байна.¹⁴ Харин сонгуулийн талаархи онолын бүтээлүүдэд “. . . сонгогдох эрхийг “**идэвхгүй эрх**” гэх бөгөөд сонгуулийн албан тушаалд “**нэрээ дэвшүүлэх**” боломжийг илэрхийлнэ. Ийнхүү сонгогдох эрхийн чадамжтай болоход хуулиар зохих шалгуур тогтоодог. Түүнийг “нэр дэвшигчдэд тавигдах шаардлага” гэж тодорхойлдог” хэмээн нийтлэг байдлаар бичсэн байна.¹⁵

- 12 Энэ нийтлэлийн хүрээнд дараахь эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн болно. Үүнд: Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20–ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэсэн нь, энэ хуулийн 32 дугаар зүйлд “Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь болон бие даан нэрээ дэвшүүлэгч нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх . . . дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ” гээд 32.2.9 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэсэн нь, мөн энэ зүйлийн 32.3 дахь хэсгийн 32.3.11 дэх заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэснийг тус тус харна уу: <https://www.legalinfo.mn/law/details/14869?lawid=14869>
Мөн түүнчлэн 2020 оны 01 дүгээр сарын 30–ны өдөр баталсан Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэсэн нь, энэ хуулийн 31 дүгээр зүйлд “Нэр дэвшүүлсэн нам, эвсэл хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ” гээд 31.2.10 дахь заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэсэн нь, мөн энэ зүйлийн 31.3 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшигч нь хуульд заасан бие даан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ” гээд 31.3.12 дахь заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэснийг тус тус харна уу.
- 13 Энэ нь сонгуулийн насанд хүрсэн иргэн төрийн байгууллагыг сонгож бүрдүүлэхэд биечлэн оролцож сонгох, эдгээр байгууллагын бүрэлдэхүүнд өөрөө орж сонгогдох гэсэн хоёр хэсгээс бүрддэг цогцолбор эрх. Сонгох, сонгогдох эрх нь төрийн удирдлагын мөн чанар, онцлогүүдтай уялдан нийт ирээдэд үүсч бий болдоггүй, төрөөс хууль тогтоомжид тодорхойлсон тусгай болзол хангаж байж уг эрхийг эдэлдэг гэж үздэг. Монгол Улсын хууль зүйн яам, Хамтын бүтээл, Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, (Хянан тохиолдуулсан: Совд Г., Жамбалдорж О.), Уб., 1993, 37–38 дахь тал
- 14 Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Хамтын бүтээл), Уб., 2009, 83 дахь тал
- 15 Чимид Б., Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008, 46 дахь тал

Б. Нэр дэвшүүлэх үндэслэл, түүнд тавигдах зарим шаардлагын тухай

Нийгэмд сонгуулийн хэрэгцээ шаардлага зайлшгүй байдаг боловч түүнийг улс төрийн сонголт хийх хэрэгсэл, арга болгож жинхэнэ зориулалтаар нь хэрэглэхийн тулд зайлшгүй чухал болзолт нөхцөл байх ёстойг улс төрийн практик нотлон харуулж байна. Тиймээс сонгууль ба түүнд шаардлагатай нөхцөл бололцооны холбоо хамаарлыг бодит амьдрал дээр тэдгээр нь нэгдмэл үйл явц байж бие биедээ харилцан нөлөөлж нэгэн зэрэг бүрэлдэн төлөвшдөг байна.¹⁶ Энэ утгаараа хууль зүйн болон эдийн засаг, нийгмийн баталгаатай эрх, эрх чөлөө нь хүн ард сонгуульд оролцох, эрх чөлөөтэй сонголт хийх бодит эх үндэс, тулгуур нь болж өгч байна. Иймд “нэр дэвшүүлэх” гэдэг бол уг язгуураараа аль нэг нам, эвсэл, бүлэг, хэсгийн төдий бус харин иргэн бүрийн улс төрийн эрхийн асуудал. Иймд тэдний энэ эрх бусад оролцоог зохиомлоор хязгаарлаж болохгүй.¹⁷ Үүнд хууль журам нийцэж байх ёстой. Тиймээс нэр дэвшүүлэх нь сонгуулийн ямар тогтолцоотой, тухайн улс орон ардчиллын үнэт зүйлсийг хэр зэрэг ойлгон хэрэглэж байгаа зэргээс хамааран янз янзын хэлбэр, арга, журамтай.¹⁸

Энэ ч утгаар нь, Үндсэн хуульд нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх, орон нутагт бүрэн засаглах эрх зүйн баталгааг бүрдүүлсэн.¹⁹ Үүнийг хэрэгжүүлэх нутгийн өөрөө удирдах байгууллага бол “иргэдийн Хурал” бөгөөд юуны өмнө Үндсэн хуулиар статус нь тодорхойлогдсон. Иргэд нийтээрээ цугларч, эсхүл иргэдээс сонгогдох замаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах бөгөөд байгуулах арга нь орон нутгийн Хурлын сонгууль юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “мандат өвөртлөгч” сонгогдсон төлөөлөгч нараас бүрддэг байгууллага.²⁰ Иргэдийн Төлөөлөгчийн Хурал иргэдээ төлөөлөх байгууллага зэргийг нь бодолцвол манай орны нөхцөлд улс төрийн намаас хол, мажоритар тогтолцоогоор явуулах нь зохистой мэт. Хувийн ашиг сонирхлоос ангид тэгш, шударга, хариуцлагатай, олон нийтийн итгэл даах байдлыг ханган ажиллах эсэх нь иргэдээ төлөөлөх гэж сонгогдож буй төлөөлөгчийн хүсэл зоригоос шууд хамааралтай.²¹

Түүнчлэн өмнөх орон нутгийн Хурлын сонгуулиудын заримд нь сонгуулийн холимог тогтолцоог ашиглаж байсан боловч зарим нэг сөрөг эрсдэлүүд үүсч байсан учраас эргээд мажоритар тогтолцоонд шилжсэн байна.²² Харин энэ удаагийн орон нутгийн Хурлын сонгууль олонхиор сонгох тогтолцоонд²³ буюу аргад нийцүүлсэн нам эвслээс нэр дэвшүүлэх буюу эсхүл сонгогдох эрх бүхий

16 Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, *Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо, (Улс төр судлалын шинжлэгээ), Уб., 2000, 22–23 дахь тал*

17 Чимид Б., *Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008, 129 дэх тал*

18 Чимид Б., *Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008, 129 дэх тал*

19 Тунгалаг О., *Орон нутгийн хурал, Уб., 2000, 6 дахь тал*

20 *Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга, хэрэгжилт), Уб., 2017, 273 дахь тал*

21 *Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга, хэрэгжилт), Уб., 2017, 274 дэх тал*

22 *Хамтын бүтээл, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжлэгээ, Уб., 2016, 170 дахь тал*

23 *Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг харна уу.*

иргэн бие даан нэрээ дэвшүүлэх гэсэн нэр дэвших хоёр хувилбар хуульчлагдсан байна.²⁴ Ийнхүү тухайн орон нутгийн иргэн орон нутгийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшихэд Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан дараахь шаардлагуудыг хангасан байх нөхцөл тавьсан байна. Үүнд:

Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөргүй байх;

Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх гэх зэрэг хуульд заасан нийтлэг шаардлагын зэрэгцээ “авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй байх” гэсэн тусгай шаардлага тавьсан байна.

В. Хязгаарлалтаас хориглолт руу

Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн талаар “Тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр орон нутгийн Хурлын сонгуульд оролцож, тухайн шатны Хурлын Төлөөлөгчийг сонгох эрхтэй. 18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй” гэж тодорхойлноос гадна “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй” гэсэн хязгаарлалтыг тусгасан байна.

Ийнхүү хязгаарласан зохицуулалтыг хуульчилсан хэрнээ “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшихийг хориглосон” зохицуулалтыг давхар оруулж өгсөн байна.²⁵ Цаашлаад ял эдэлж байгаа эсэх талаархи цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаанаас гадна авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаархи холбогдох байгууллагын лавлагааг нэр дэвшигч тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлсний үндсэн дээр бүртгэх талаар зохицуулсан байна. Хэрэв нэр дэвшигч урьд нь авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож, шүүхээр ял шийтгүүлж байсан тохиолдолд түүнийг бүртгэхээс татгалзан орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвших буюу иргэний улс

²⁴ Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг харна уу.

²⁵ Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийг харна уу.

төрийн эрх болох сонгогдох эрхийг “тодорхой” хугацаагаар бус харин насан туршид нь хязгаарласан шинжтэй болсон эрх зүйн зохицуулалт орон нутгийн Хурлын сонгуульд үйлчилж байна. Энэ нь сонгуульд өрсөлдөх сонирхол бүхий иргэний орон нутгийн Хурлын төлөөлөгчид нэр дэвших улс төрийн эрхийг үгүйсгэсэн төдийгүй Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаатай эдлэх сонгох, сонгогдох үндсэн эрхийг маш ноцтой хязгаарласан хууль зүйн сөрөг үр нөлөө үзүүлж байна. Иймд үндсэн эрхийг төрийн зүгээс хязгаарлах үндэслэлүүд өдгөө нэг мөр шийдэгдээгүй боловч дараахь хэдэн үндэслэл дээр судлаачид маргадаггүй. Үүнд: (i) зөвхөн хуулийн үндсэн дээр хязгаарлах, (ii) Үндсэн хуулийн заалтад захируулах замаар, (iii) Харьцангуй байх, (iv) Эрх зүйт ёсны үндсэн зарчмыг зөрчихгүй байх.²⁶ Эдгээр үндэслэлийн үүднээс авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан этгээдийн улс төрийн эрхийг бүх насаар нь хязгаарлахыг зөвтгөн үзэх боломжгүй юм. Учир нь бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч хөрөнгө, орлогынхоо мэдүүлгийг гаргах үүрэгтэй.²⁷

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ хэмээх (2016) судалгаанд “орон нутгийн Хурлын хэр хэмжээнд нь тохирсон сонгуулийн өөр тогтолцоог хэрэглэж болно. Орон нутгийн иргэдээс нэр дэвшүүлэх замаар орон нутгийн сонгууль дахь улс төрийн намуудын оролцоог хумиж болно. Орон нутгийн засаглалын салбарт бүхэлд нь үндсэн хуулийн зохицуулалтыг бага байлгаж, тухайн асуудлуудад уян хатан шийдэл эрэлхийлэх нь илүү зохистой” гэсэн дүгнэлтийг хийсэн байна.²⁸

Цаашлаад олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, Монгол Улсын олон улсын гэрээ нь сонгуулийн тухай заалтаараа “эх сурвалж”²⁹ болж, сонгуультай холбоотой олон улсын гэрээ хэрэлцээр, баримт бичгийг Үндсэн хуульд харшлахгүй бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримтлах учиртай юм. Иймд орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд тодорхойлсон Хурлын төлөөлөгчийг бүх нийтээр, шууд, чөлөөтэй, саналаа нууцаар гаргаж сонгох зарчим нь бүхэлдээ олон улсын гэрээний болон гэрээний бус зэрэг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчимд бүрнээ нийцэж байгаа гэж үзэж³⁰ болох юм. Эндээс аваад үзвэл, Монгол Улсын Үндсэн хууль болоод орон нутгийн Хурлын сонгуулийн хуульд сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмыг олон улсын эрх зүйн түвшинд тодорхойлон заасан болох нь харагдаж байна. Түүнийг үгүйсгэнэ гэдэг Монгол Улсын олон улсын гэрээг зөрчиж, иргэдийнхээ улс төрийн эрхийг хориглон “устгана”³¹ гэсэн үг. Харин

26 Өнөрбаяр Ч, Үндсэн хуульд ёсны хөгжил, түүний чиг хандлага, Уб., 2014, 49 дэх тал

27 Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг тус тус харна уу.

28 Хамтын бүтээл, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Уб., 2016, 174 дэх тал

29 Чимид Б., Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), Уб., 2008, 44 дэх тал

30 Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульд ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 48 дахь тал

31 Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульд ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011, 150 дахь тал

ч эсрэгээрээ Монгол Улс олон улсын (Иргэн болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт гэх мэт) гэрээ, хэлэлцээрт нэгдсэн учраас түүнийг шударгаар биелүүлэх үүрэгтэй. Иймд авлига, албан тушаалын гэмт хэрэгт шийтгэгдэж ял эдэлж байсан хүмүүсийн орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвших буюу сонгогдох эрхийг нь бүх насаар нь буюу насанд туршид нь хязгаарлах бус, харин хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой болзол нөхцөл, шалгуурыг хангасан байдлыг харгалзан сонгох, сонгогдох эрхийн агуулгад нийцсэн шаардлагын хүрээнд тэдгээрийн сонгогдох эрхийг хангах хууль зүйн боломж олгох нь зүйтэй байх болов уу.

Энэ утгаараа, орон нутгийн Хурлын сонгуулийг чухам ямар хүчин зүйл ардчилсан, шударга сонгууль болгодог вэ гэсэн асуулт зүй ёсоор гарч ирэх юм. Энэ асуултад сонгуулийн зарчмуудыг үзэх үндсэн дээр хариулт өгч болох юм. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд “сонгуулийн зарчмыг иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэх бөгөөд сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана” гэж зохицуулсан байна.³² Эндээс авч үзвэл, тухайн орон нутгийн сонгогч орон нутгийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигчид итгэл хүлээлгэх эсэх, хэрэв итгэл даахгүй авлига, албан тушаалын гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдож, шүүхээр ял шийтгүүлж байсан гэж үзвэл санал өгөхгүй байх зэрэг асуудлаа өөрөө бие даан шийдвэрлэн “чөлөөтэй” сонголтоо хийх өргөн боломжтой байна. Энэ нь сонгогдох нь томилогдохоос ялгаатай болохыг харуулж байна.

Г. Хориглосон хууль зүйн үндэслэлийг шүүмжлэхийн учир

Эрх зүйн зохицуулалт талаасаа нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хуульчлахдаа “ялгүй байх” гэсэн ойлголтыг анх тодорхойлсон бөгөөд ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дууссан байхад ч нэр дэвшигчид урьд гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан этгээд гэдэг утгаар улс төрийн эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж буй хэрэг³³ гэж үзэж байсан. Энэ асуудал холбогдох “маргаан бүхий агуулга” төсөөтэй үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлээд гаргасан “зарчмын зөрүүтэй” хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлтүүд хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

Эхний дүгнэлтийн тухайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар дүгнэлтийг “Хууль тогтоогч . . . сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад “ялгүй байх” гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа үндсэн хуулийн

³² *Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг харна уу*

³³ *Амарсанаа Ж., Үндсэн хуулийн маргаан, Уб., 2012, 641 дэх тал*

зөрчлийн шинжийг агуулсан байна” гэсэн үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн байна.³⁴

Харин удаах дүгнэлтийн тухайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг “2008 оны 06 дугаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт . . . нэр дэвшигчид огт ял шийтгүүлж байгаагүй гэх шалгуур тавьж, аливаа гэмт хэргийг буюу санаатай, эсхүл болгоомжгүй, түүнчлэн санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэсэн гэмт буруугүйн холимог хэлбэрийг өргөн хүрээнд хамааруулж хуульчилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн дүгнэлт гаргах үндэслэл болсон гэж үзэхээр байна. Харин авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно гэсэн заалт нь тодорхой төрлийн гэмт хэргийг нэрлэн зааж хязгаарлалт тогтоон хуульчилсан зохицуулалт байх бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцсэн 2005 оны сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтаас агуулга, зарчмын хувьд өөр байна. . . . өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн бодлогын хүрээнд хуульчлагдсан хязгаарлалт гэж үзэхээр байх тул иргэний сонгогдох эрхийг бүх насаар нь хязгаарласан хэмээн шууд дүгнэх үндэслэлгүй” гэсэн үндэслэлээр Үндсэн хууль зөрчөөгүй гэж шийдвэрлэсэн байна.³⁵ Энэ дүгнэлтийн үндэслэлд сонгогдох эрх нь туйлын эрх биш тул сонгуульд нэр дэвшигчид буюу сонгогдох эрхээ хэрэгжүүлэгч иргэнд шалгуур, нөхцөл тогтоох нь сонгох эрхийг баталгаажуулахад чиглэгдэх учиртай. Ийнхүү тогтоохдоо Үндсэн хуульд, ардчилсан ёсыг хамгаалах хууль ёсны зорилгод нийцсэн, үндсэн хуулийн эрх зүйн “хэмжээ хэтрэхгүй” байх зарчмын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн хүрээнд хуулиар тодорхойлох боломжтой гэсэн хэрнээ авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан этгээдийг ямар хугацааны дараа, ямар нөхцөл шалгуурыг хангасны үндсэн дээр дахин сонгуульд нэр дэвших улс төрийн эрх нь нээгдэх эсэх асуудалд хариулт өгөөгүй байна. Өөрөөр хэлбэл, нэр дэвших эрхийг ямар хугацаанд хязгаарлагдах төдийгүй өнөөгийн тодорхойгүй хугацаагаар сонгуульд нэр дэвших буюу сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байдал нь Үндсэн хуулийн эрх зүйн хэмжээ хэтрэхгүй байх зарчмын агуулгад нийцэж буй эсэх талаар дүгнэлт хийгээгүй байгаа нь энэхүү дүгнэлтийг шүүмжлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын үндэслэлд “. . . цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж үзвэл дээрхи хуулиар тогтоосон хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон эсэх . . .”-ийг шалгаж үзээд Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэж байсан практик бий.³⁶ Гэтэл дээрхи тохиолдолд чухам ямар

34 <https://www.legalinfo.mn/law/details/1040?lawid=1040>

35 <https://www.legalinfo.mn/law/details/15323?lawid=15323>

36 <https://www.legalinfo.mn/law/details/1090?lawid=1090>

хугацааны дараа, мөн ямар хуульд заасан үндэслэл, журмаар тогтоосон нөхцөл, шалгуурыг хангасны үндсэн дээр иргэний сонгуульд нэр дэвших буюу сонгогдох эрх нь нээгдэх боломжтой эсэх нь тодорхойгүй байдалд хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийгээгүй орхисон нь орон нутгийн Хурлын сонгуульд авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан этгээдийн нэр дэвшин, цаашлаад сонгогдох эрхийг тодорхойгүй хугацаагаар хассан гэж үзэж болохоор байна. Ийнхүү маргаан бүхий төсөөтэй асуудлаар зарчмын зөрүүтэй үндэслэл бүхий дүгнэлтүүд хүчин төгөлдөр үйлчилж, иргэний сонгох, сонгогдох эрхэд эергээр нөлөөлөхийн зэрэгцээ сөргөөр нөлөөлөх хууль зүйн үндэслэлийг бий болгоод байна.

III. ДҮГНЭЛТ

Эцэст нь тэмдэглэхэд, Үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрх нь улс төрийн эрхийн үндсэн бүрэлдэхүүнд хамаарах бөгөөд сонгох эрхийг Монгол Улсын эрх зүйн чадамжтай, сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ эдлэхээр, харин сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд тухайн албан тушаалын онцлогийг харгалзан тусгайлсан болзол, шалгуурыг хуулиар тогтоож болдог. Энэ нь Үндсэн хуулийн болон сонгуулийн эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарлалт төдийгүй Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд ч үүнийг хүлээн зөвшөөрсөн гэдэгтэй санал нийлж байна. Түүнчлэн бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч хөрөнгө, орлогынхоо мэдүүлгийг гаргах үүргийг хүлээсэн болохоос биш, авлига, албан тушаалын гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдон шүүхээр ял шийтгүүлсний дараа тодорхойгүй (Тодорхойгүй хугацаа гэсний учир нь ямар ч хугацаа байж болохоор эрх зүйн зохицуулалтын хийдэлтэй байна. Энэ нь бүх насаар хязгаарлах агуулгыг илэрхийлж байна) хугацаагаар орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвших эрхийг хориглох үндэслэл болох учиргүй.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 30–ны өдөр баталсан Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэснийг, энэ хуулийн 31 дүгээр зүйлд “Нэр дэвшүүлсэн нам, эвсэл хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ” гээд 31.2.10 дахь заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэснийг, мөн энэ зүйлийн 31.3 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшигч нь хуульд заасан бие даан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ” гээд 31.3.12 дахь заалтад “авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа” гэснийг тус тус эргэн харах зайлшгүй шаардлагатай байна. Үүнд л энэ нийтлэлийн гол утга учир оршино. Энэхүү

нийтлэлийн хүрээнд орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид тавигдах дээрхи шаардлагын асуудлыг чухамхүү энэ утгаар нь илүүтэй эргэцүүлэн хөндөн бичлээ.

IV. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ШУА-ын Философи, социологи, эрхийн хүрээлэн, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо, (Улс төр судлалын шинжилгээ), УБ., 2000

Хамтын бүтээл, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал: Онол, арга зүй, хэрэгжилт, УБ., 2017

Чимид Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IV, УБ., 2011

Чимид Б., Сонгуульд суралцахуй, (Тогтолцоо, үйл явц, эрх зүй), УБ., 2008

Төрийн албаны үнэт зүйлс: Тулгамдаж буй асуудлууд. Судалгааны тайлан. Удирдлагын академи. УБ., 2018. 14 дэх тал

ЗАЛУУ СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ТЭДНИЙ СОНСОЖ БУЙ ДУУ НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Уянга

Улс төр судлалын магистр

Түлхүүр үг: Залуучууд, улс төрийн оролцоо, мэдлэг ойлголт, орчин үеийн дуу хөгжим, төлөвшил

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хуулиар "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" (УИХ, 1992) гэж заасан байдаг. Иймээс сонгууль нь Монголын ард түмэн төрийн болон орон нутгийн өөрөө удирдах эрхээ хэрэгжүүлэх үндсэн арга юм. Гэвч 18-25 насны залуучуудын хувьд сонгуулийн идэвх хамгийн муу байгаа нь он оны сонгуульд оролцогчдын нэгдсэн дүнгээс харагдаж байна. 2016 онд энэ насны бүлгийн 2 хүн тутмын нэг буюу ойролцоогоор 50 хувь нь сонгуульд оролцоогүй бол 2020 оны сонгуульд 62 хувь нь оролцсон хэдий ч тус сонгуульд саналаа өгсөн нийт сонгогчдын хамгийн бага хувийг эзэлсэн байна.

Энэ нь залуу сонгогчдын хувьд улс төрийн мэдлэг боловсрол дутмаг, улс төрийн оролцооны ач холбогдлыг бүрэн ойлгоогүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж буйг судлаачдын дүгнэлтээс харж болно. Олон нийтийн хувьд улс төрийн бодлого, хөтөлбөрийн цаад учир шалтгаан, элдэв нэр томъёог тэр болгон ойлгож өөрийн болгож чаддаггүй, харин үүнийг орлуулсан зураг, бэлгэдэл зэргийг амархан хүлээн авч эзэмшдэг.

(Elder Charles D, 1983) Энэ тухай 1928 онд Оросын соёл судлаач В.Н.Волошинов "Аливаа соёл, үзэл суртлыг тодорхой биет дүрс, аялгуу, өнгө, биеийн хөдөлгөөн гэх мэт материаллаг зүйлсээр илэрхийлэн хүмүүст хүргэх хэрэгтэй. Ингэж байж тэрхүү хийсвэр тунхаглал нь хүмүүс хоорондын харилцаанд бодитойгоор бууж ирдэг" (Andreas, 1996) гэж тэмдэглэжээ.

Иймд залуу сонгогчид, тэр дундаа 18-20 насны залуусын сонсож буй орчин үеийн дуу хөгжим

Залуу сонгогчдын хувьд улс төрийн мэдлэг боловсрол дутмаг, улс төрийн оролцооны ач холбогдлыг бүрэн ойлгоогүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж буйг судлаачдын дүгнэлтээс харж болно.

нь юуны тухай өгүүлж байгаа болон тэдний итгэл үнэмшил, үзэл бодолд хэрхэн нөлөөлж байгааг судлах замаар залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд орчин үеийн дуу хөгжмийг ашиглах нь чухал асуудлын нэг болоод байна.

ЗОРИЛГО:

18-20 насны залуусын сонсож буй дуу хөгжим нь тэдний үзэл бодол, бие хүний төлөвшилд хэрхэн нөлөөлж буйг судлах замаар орчин үеийн дуу хөгжмөөр залуучуудын улс төрийн мэдлэг боловсрол, оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлахад энэхүү илтгэлийн зорилго оршино.

ЗОРИЛТ:

- 18-20 насны залуусын хөгжлийн онцлог байдлын талаарх эх сурвалж, материалыг судлах
- Анкетын аргаар залуусын нийтлэг сонсож буй дуу, түүний давтамжийг тодорхойлон түүнд боловсруулалт хийх
- Залуучуудын нийтлэг сонсдог дууны утгыг тодорхойлох
- Анкет болон контент судалгааны үр дүнд үндэслэн орчин үеийн дуу хөгжмөөр дамжуулан залуу сонгогчдын улс төрийн оролцоог нэмэгдүүлэх тухай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ:

18-20 насны залуучуудын нийтлэг сонсдог дуу, түүний давтамжийг анкетын аргаар илрүүлсэн.

Контент анализ хийх судалгааны аргаар залуучуудын нийтлэг сонсдог дууны утгыг задлан шинжилсэн.

ҮНДСЭН ХЭСЭГ

Монгол судлаачид болох Ж.Даваа, Ж.Санжжав нар 18-20 насны үеийг хүний амьдралын орь залуу үе гэж үзсэн байдаг. (Даваа Ж., 2008) Энэ нас нь хүний хувийн чанар, ертөнцийг үзэх үзэл итгэл бүрэлдэн тогтож бие даасан амьдрал, үйл ажиллагаанд шилжих буюу бие хүн болж төлөвших хариуцлагатай үе юм.

Энэ насанд өөрийгөө таньж, илэрхийлэхтэй холбоотой олон асуудлуудын талаарх өөрийн ойлголт, байр суурийг тэд нийгмээс хуримтлуулсан туршлага, мэдээллийн хэрэгслүүд, хамт олны яриа, сонсож буй дуу хөгжим зэргээр дамжуулан өөртөө бий болгож байдаг. (Даваа Ж., 2008) Энэ тухай АНУ-ын Канзасын их сургуулийн профессор Соусер өөрийн судалгаагаараа дуу хөгжим нь хүний сэтгэл, оюун санааг удирдах хүчтэй зэвсэг болохыг тодорхойлсон бөгөөд түүний судалгаа нь 12-18 насны гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдэд

чиглэж байжээ. Энэхүү судалгааны үр дүнд тухайн хэргийг үйлдэх болсон шалтгааны 72% нь дуу хөгжим сэтгэл зүйд нь нөлөөлснөөс үүдэлтэй болохыг илрүүлсэн байна. Ийм ч учраас өнөөгийн шинэ залуу үеийнхний амьдралын салшгүй нэг хэсэг болсон дуу хөгжмөөр дамжуулан олж авсан ойлголт мэдлэг тэднийг бие хүн болж төлөвшихөд ихээхэн нөлөөтэй юм.


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

18-20 насны залуусын сонсож буй нийтлэг дууг илрүүлэн, тэдний үзэл бодолд хэрхэн нөлөөлж буйг тандах зорилготой 5 асуулт бүхий судалгаанд 18, 19, 20 насны залуу сонгогчдын төлөөлөл хамрагдсан болно. Судалгаанд энэ насны нийт 200 залуус хамрагдсан.

ТООН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:


18-20 насны залуусын дийлэнх нь гадаад дуу сонсдог. Анкетын судалгаагаар 18-20 насны залуус өдөрт хэдэн удаагийн давтамжтайгаар дуртай дуугаа сонсдог болохыг асуухад дараах байдлаар хариулжээ.

График №1 Дуртай дуугаа өдөрт хэдэн удаа сонсож буй байдал (дунджаар) Энэхүү графикаас үзэхэд



Судалгаанд хамрагдсан нийт 200 залуу сонгогчийн 34,5 хувь нь буюу 69 нь өөрийн дуртай дуугаа өдөрт дунджаар 7 болон түүнээс дээш удаа сонсдог хэмээн хариулсан бол 27 хувь буюу 54 нь өөрийн дуртай дуугаа өдөрт 5-6 удаа сонсдог гэж хариулсан байна. Иймд 18-20 насны залуусын хувьд дуу хөгжим гэдэг амьдралынх нь салшгүй нэг хэсэг болсон байна.


Ийнхүү сонсохдоо энэ насны залуус ямар улс орны дууг илүү сонсож байгааг тодруулсан “Та өөрийн ихэвчлэн сонсдог дуугаа жагсаан бичнэ үү?” гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

График №2 18-20 насны залуу сонгогчдын сонсож буй дуу

Судалгаанд хамрагдсан 18-20 насны нийт 200 залуу сонгогч нийт 854 дуу нэрлэн бичсэн ба үүнээс 369 нь буюу 43,2 хувь нь монгол дуу байсан бол энэ насны залуусын сонсож буй дууны 485 нь буюу 56,8 хувийг гадаад дуу эзэлж байна. Үүнээс үзэхэд 18-20 насны залуус гадаад дуу хөгжим, тэр дундаа англи дуу сонсож, холливудын кино үзэж, Coca cola уух зэргээр өрнөдийн хэв маяг, соёлын үнэт зүйлсэд татагдаж буй нь харагдаж байна. Нөгөөтээгүүр гадаад дуу сонсож хэлний мэдлэг, чадвараа дээшлүүлдэг залуус байдаг хэдий боловч хүмүүс аливаа зүйлийн сөрөг талыг илүү анзааран, этгээд гаж, өвөрмөц үг хэллэг, зан авирыг даган дууриадаг болохыг "Олон нийтийн зан үйлийн цуврал судалгаа"-ны дүнгүүд харуулж буй юм. (Мөнхцэцэг. Ц., 2010)

Дээрх 854 дууг 18-20 насны залуус ямар учраас сонсдог талаар тодруулах зорилго бүхий 2-р асуулт болох "Та ямар учраас энэ дууг сонсдог вэ?" хэмээх асуултад дараах байдлаар хариулжээ.

График №3 18-20 насны залуу сонгогчдын дуу сонсож буй шалтгаан



Дээрх графикаас үзэхэд нийт 854 дууны 197 дууг буюу 23 хувийг нь залуус тухайн дууны утга агуулга таалагддаг учраас сонсдог байна. Харин тухайн дууны утгыг төдийлөн ойлгодоггүй буюу зүгээр л, мэдэхгүй болон ая хэмнэл нь таалагддаг болохоор, хэн нэгний нөлөөгөөр гэх мэт хариултууд давамгайлж байгаа нь харагдаж байна.

Гэтэл хүн ухамсарлан ойлгосон зүйлээ л өөрийн амьдрал үйл ажиллагаанд дагаж мөрддөг гэсэн үзлийг XX зууны үеийн сэтгэл судлалын шинжлэх ухааны хөгжилд гүнзгий нөлөө үзүүлсэн Зигмунд Фрейд "Сэтгэц задлан шинжлэлийн

онол"-оороо үгүйсгэсэн байдаг. (Мягмар О., 2012) Тэрээр хүний сэтгэцийг мөсөн уултай зүйрлэн далайн түвшинээс дээш өчүүхэн төдий цухуйх оргил нь ухамсар, үлдсэн хэсэг нь ухамсарт бус хэсэг хэмээгээд ухамсарт бус хэсэг нь хүний зан үйлийг зохицуулахад нэн чухал үүрэгтэй гэж үзсэн. (Даваа Ж., 2008) Өөрөөр хэлбэл тухайн дууны утга санааг залуу сонгогчид ойлгосон, эс ойлгосноос үл хамааран тухайн дууны агуулга хүний ухамсарт бичигдэн үлдэж үйл ажиллагааг чиглүүлж байдаг.

Дээрх 854 дуунаас 7 болон түүнээс дээш давтамжтай дууны жагсаалтыг гаргалаа. Хүснэгт №1

Хүснэгт №1

№	Монгол дууны жагсаалт	Давтамж
1	Gangbay – Ганган цагаан	15
2	Vandebo – Чиний нүдээр	11
3	Ginjin, Mrs M – Бороо	9
4	168– Бүжье бүжье	8
5	Gangbay – Seen	8
6	AM-C – Гүнд	8
7	Vandebo – Унана	7
8	Gangbay – Могжоохон хүү	6
9	Vandebo – Too deep	6

Үүнээс хамгийн их давтамжтай 4 дууны утгад тоон анализ хийв. Ингэхдээ 8, 7 болон 6 давтамжтай дуунаас санамсаргүй түүврийн аргаар сонголт хийхэд AM-C – Гүнд хэмээх дуу таарсан болно.

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН:**Орчин үеийн дуу “Чи” төвтэй байна**

Тоон судалгаагаар илрүүлсэн үр дүнг дараах байдлаар задлан шинжлэв.

Дууны нэр: Ганган цагаан	Дууны төрөл: Поп
Дуучны нэр: Gangbay	
Контет анализын үр дүн	Залуу сонгогчдын ойлголт
<p>18-20 насны нийт залуусын 7.5 хувь нь сонсож буй дуунаас хайлтын утга болгон дараах үгсийг сонгоход:</p> <ul style="list-style-type: none"> • “Чи” - 25 удаа • “Би” - 21 удаа • “Гадаад үг хэллэг” – 58 удаа • “Цагаан - 5 удаа гарсан. • “Шиг” - 4 удаа • “Хайр” - 3 удаа 	<ul style="list-style-type: none"> • Насан туршдаа хайрлахгайхалтай эмэгтэйтээ учирвалтүүнд бүхнээ зориулна. • Чи бол үнэ цэнэтэй эмэгтэй. • Сайхан бүсгүй хүн байх тухай. • Хоёр залуу нэг бүсгүйн араас гүйж байгаа тухай.

Дээрх хүснэгтээс үзэхэд “Ганган цагаан” хэмээх энэхүү дуунд гадаад үг хэллэг хамгийн их давтамжтай байсан бөгөөд эдгээр үгийг орчуулж үзэхэд дуунд өмнө нь дурдсан утга санааг дахин давтсан буюу тохиромжтой үг хэллэг байсаар байтал гадаад үгийг хэрэглэсэн байна. Энэ нь 18-20 насны залуусын дунд “шинэ үг хэллэг үүсгэх гэсэн оролдлого буюу чамирхал” (Сүхбаатар Ц., 2009) болох талтай.

Түүнчлэн хайр дурлалын тухай өгүүлж буй энэ дуунд хосуудын адил тэгш харилцааг илтгэн харуулах “бид, хамт, цуг” гэсэн үгс хэрэглэгдээгүй бөгөөд “чи” хэмээх үгийн давтамж нь “би” гэсэн үгийн давтамжаас илүү өндөр байсан нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хосуудын харилцаанд чи л чухал байр суурь эзэлж байна, чамаас бүх зүйл шалтгаална гэсэн утгыг агуулж байна.

Дууны нэр: Чиний нүдээр	Дууны төрөл: Поп
Дуучны нэр: Vandebo	
Контет анализын үр дүн	Залуу сонгогчдын ойлголт
<p>18-20 насны нийт залуусын 5.5 хувь нь сонсож буй дуунаас хайлтын утга болгон дараах үгсийг сонгоход:</p> <ul style="list-style-type: none"> • “Чи” - 32 удаа • “Би” - 19 удаа • “Болгосон” - 6 удаа • “Гадаад үг хэллэг” - 1 удаа • “Хараалын үг” - 1 удаа гарсан 	<ul style="list-style-type: none"> • Чиний нүдээр өөрийгөө харж, чамд ямар санагддагаа мэдэх тухай. • Чи намайг өөрчилж байна. • Чи намайг хуурсан учраас би өөр хэнд ч дахин итгэхгүй. • Би ганцхан чамайг л гэж амьдрах болно.

Дээрх хүснэгтээс үзэхэд хосуудын хайр сэтгэлийн тухай өгүүлж буй “Чиний нүдээр” хэмээх энэ дуунд хосуудын адил тэгш харилцааг илтгэн харуулах үгс огт хэрэглэгдээгүй бөгөөд “чи” гэдэг үг хамгийн их буюу 32 удаа давтагдсан байна. Энэ нь уг дууг сонсогч залуусд чи л намайг өөрчилсөн, чи намайг ийм хүн болгосон гэх мэт ойлголтыг өгчээ.

Дууны нэр: Бороо	Дууны төрөл: Реп буюу үглэх
Дуучны нэр: Ginjin, Mrs M	
Контет анализын үр дүн	Залуу сонгогчдын ойлголт
<p>18-20 насны нийт залуусын 4.5 хувь сонсож буй дуунаас хайлтын утга болгон дараах үгсийг сонгоход:</p> <ul style="list-style-type: none"> • “Чи” - 11 удаа • “Би” - 9 удаа • “Бороо” - 22 удаа • “Бид” - 7 удаа • “Гадаад үг хэллэг” – 1 удаа • “Ороосой, ирээсэй” – 28 удаагийн давтамжтай байна. 	<ul style="list-style-type: none"> • Бороо оруулахыг хүссэн дуу. • Бороо зогсоход бидний хайр ч бас дуусна гэсэн утгатай. • Салалтын тухай дуу. • Бороо ороход гуниглаж, сэтгэл өвддөг гэсэн утгатай.

Үүнээс үзэхэд ороосой, ирээсэй гэсэн үг хамгийн өндөр давтамжтай байна. Мөн л хайр дурлалын тухай өгүүлж буй энэ дуунд хосуудын адил тэгш харилцааг илтгэн харуулах “бид” гэсэн үг 7 удаагийн давтамжтай байна. Харин харилцаанд оролцогч эсрэг талаа илэрхийлж буй чи хэмээх үг 11 удаагийн давтамжтай байгаа нь харилцагч талийхаа үүрэг, нөлөөг илүү чухалчилсан хандлагыг илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл бороо ороосой тэгвэл чамтай илүү удаан байх болно гэсэн санааг агуулж байна.

Дууны нэр: Гүнд	Дууны төрөл: Реп буюу үглэх
Дуучны нэр: АМ-С	
Контег анализын үр дүн	Залуу сонгогчдын ойлголт
<p>18-20 насны нийт залуусын 4 хувь нь сонсож буй энэ дуунаас хайлтын утга болгон дараах үгсийг сонгоход:</p> <ul style="list-style-type: none"> • “Чи” - 31 удаа • “Би” - 8 удаа • “Хайр” - 8 удаа • “Гүнд” - 6 удаа • “Хүмүүс”- 1 удаа • “Гадаад үг хэллэг” – 8 удаа давтагдсан байна. 	<ul style="list-style-type: none"> • Чамтай цуг dance хийе. • Чиний зүрх сэтгэлийг хайраар дүүргэе. • Зүрх сэтгэлээ чамд нээе гэсэн утгатай. • Би зүрх сэтгэлийнхээ гүнээс чамайг хайрладаг.

Дууны утгад анализ хийж үзвэл уг дуу нь хайр дурлалын тухай дуу бөгөөд хамгийн өндөр давтамжтай үг нь харилцаанд оролцогч эсрэг талаа илэрхийлж буй чи хэмээх үг 31 удаагийн давтамжтай байна.

Түүнчлэн уг дууны шүлгээс үзэхэд:

Чамд ямар ч хязгааргүй

Гунигтай зүрхийг бооцоонд авъя... гэсэн нь “уншигч сонсогч нарт цэгцтэй ойлголт өгөх, өгүүлэх гэж буй зүйлээ оновчтой илэрхийлэх гэх мэт найруулгын эрхэм чанаруудыг” (Сүхбаатар Ц., 2009) өөртөө бий болгож чадаагүй нь дууны шүлгээс харагдаж байгаа юм.

АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН СҮЛД ДУУ

“Хонхны дуу”

Монголын түүхэнд дуу хөгжим, ард түмнийг зоригжуулж, урам өгч, ардчилсан хувьсгалын төлөө хүн бүрийг нэгтгэж чадсан удаа бий. “Хонхны дуу” бол 1990 оны Ардчилсан хувьсгалд Монгол залуучуудыг үзэл бодол, итгэл үнэмшлээр нь нэгтгэж чадсан бэлгэ тэмдэг байсныг судлаачид хүлээн зөвшөөрдөг.

Тэгвэл уг дууны утгыг дараах байдлаар задлан шинжлэв.

Дууны нэр: Хонхны дуу	Дууны төрөл: Поп
Дуучны нэр: С.Цогтсайхан	
Контет анализын үр дүн	Залуу сонгогчдын ойлголт
<ul style="list-style-type: none"> • “Би” - 4 удаа • “Бид” - 9 удаа • “Сэрээ” – 15 удаа • “Хонхны дуу”- 14 удаа • “Хүсэл зориг” – 5 удаа давтагдсан байна. 	<ul style="list-style-type: none"> • Хонхны дуу монголчуудыг сэрээж буруу замаас гаргасан. • Хүний эрх, эрх чөлөөгөө монголчууд авч чадсан тухай. • Эрх чөлөөгүй байсан үеэс эрх чөлөөтэй ардчилсан нийгэмд шилжсэн тухай.

Дууны утгад анализ хийж үзвэл “Хонхны дуу” ард түмнийг эрх чөлөөгүй, үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй амьдрал буюу нойрноос сэрээж өгсөн хэмээх санааг агуулж байгаа бөгөөд энэхүү байдлаас гарч өөрсдийн амьдралыг өөрчлөхөд хүн бүрийн үүрэг оролцоо, хүсэл зориг чухал хэмээн өгүүлжээ. Өөрөөр хэлбэл “Бид” хэмээх үгийн давтамж “би, чи” гэсэн үгсийн давтамжаас их байгаа нь ардчилсан хувьсгалд Монголын ард түмэн нийтээрээ оролцох ёстой гэсэн үзэл санааг түгээсэн байна.

ДҮГНЭЛТ

18-20 насны залуу сонгогчдын нийтлэг сонсдог орчин үеийн дөрвөн Монгол дууны утгыг задлан шинжилж үзэхэд уг дөрвөн дууны утгад бусдад төвлөрсөн хандлага зонхилж байгаа нь илэрсэн юм. Өөрөөр хэлбэл энэ насны залуус тухайн дуунаас олж авсан утга санаа, мэдээллийн үндсэн дээр хүрээлэн байгаа орчин болон бусад хүнтэй харилцахдаа бүхний төвд “чи”-г буюу харилцаанд оролцогч эсрэг талаа тавьж, бусдын үзэл бодол, хүсэл сонирхлыг эн тэргүүнд тавьж хүндэтгэн үзэх эерэг талтай. Нөгөөтгээгүүр харилцагч талаа чухалчлан авч үзсэнээр аливаа зүйлийн хариуцлага, үр дагаврыг ч өөрт бус бусдад өгч, бурууг бусдаас хайсан хүн болж төлөвших эрсдэлтэй байна.

Өөрөөр хэлбэл 18-20 насны залуусын хувьд улс төрийн сонголт хийхдээ “миний саналаар дутахгүй”, “Би оролцож, саналаа илэрхийлсэн ч энэ бүхнийг өөрчилж чадахгүй” гэх мэт өөрийн үнэ цэнэ, боломжийг дутуу үнэлсэн хандлагатай байгаа нь залуу сонгогчдын улс төрийн оролцоо муу байгаад нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл 18-20 насны залуусын хувьд улс төрийн сонголт хийхдээ “миний саналаар дутахгүй”, “Би оролцож, саналаа илэрхийлсэн ч энэ бүхнийг өөрчилж чадахгүй” гэх мэт өөрийн үнэ цэнэ, боломжийг дутуу үнэлсэн хандлагатай байгаа нь залуу сонгогчдын улс төрийн оролцоо муу байгаад нөлөөлж байна.

Харин ардчилсан хувьсгалын бэлгэ тэмдэг болсон “хонхны дуу”-г задлан шинжилж үзэхэд бүх нийтийн оролцоо, хүн бүрийн хүсэл зориг зэргийг тусгасан, “Бид” хэмээх үг олон давтамжтай байгаагаараа залуу сонгогчдын нийтлэг сонсож буй орчин үеийн дуу хөгжмөөс ялгаатай байна.

Иймд орчин үеийн дуу хөгжим залуусын хэрэгцээ болох тусам түүнийг бүтээгч уран бүтээлчдийн үүрэг хариуцлага улам өндөр байх ёстой. Түүнчлэн дуугаар дамжуулан гоо зүйн хүмүүжилтэй, ёс суртахуунтай, үүрэг хариуцлагаа ухамсарладаг бие хүн төлөвшүүлбэ гэвэл тэдний дуу хөгжмөөр дамжуулан хүлээн авч буй мэдээлэл нь аливааг ухамсарлуулсан, үнэнг өгүүлсэн, мэдээллийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, хувийн болоод улс, үндэстнийхээ соёл уламжлалаар бахархах сэтгэлийг төрүүлсэн байх нь зүйтэй юм.

САНАЛ БОЛОН ШИЙДЭЛ

Залуучуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд:

- Залуу сонгогчдын дунд алдартай, нөлөө бүхий уран бүтээлчдээр дамжуулан улс төрийн мэдлэг олгох агуулга бүхий контент бүтээх
- Сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх тухай асуудлыг зөвхөн сонгуультай холбоотойгоор анхаарч үзэх бус үе шаттайгаар улс төрийн мэдлэг олгох контент болон дуу хөгжмийг төрөөс санхүүжүүлэх.

- Өмнөх үеийн уран бүтээлчдийн сор болсон дуу хөгжмөөс суралцаж дууг тодорхой ёс зүй, гоо зүйн шалгуур үзүүлэлт, шаардлага хангасан нөхцөлд олон нийтэд хүргэх буюу хариуцлагатай байх.
- ЕБС-ийн завсарлагааны цагаар хонхны оронд эх орон, байгаль дэлхий, нутаг устай холбоотой дуу хөгжим тавих.
- 18-20 насны оюутан залуусын дунд дуу хөгжимтэй холбоотой дугуйлан секц байгуулах нь өөрсдийн сонирхол дээр тулгуурлах учир илүү нээлттэй, идэвхтэй оролцоог бий болгож сурах чадварыг дээшлүүлнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Andreas, D. (1996). Politischer Mythos und symbolische Politik. Der Hermannmythos: Zur Entstehung des Nationalbewusstseins der Deutschen. Hamburg.

Elder Charles D, C. R. (1983). The Political Use of Symbols. London.

Мөнхцэцэг Ц. (2010). Политайнмент буюу цэнгээнт улс төр. Уб: Соёмбо принтинг.

Санжжав, Д. (2013). Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал. Уб.

Сүхбаатар, Ц. (2009). Монгол хэлний найруулгазүй. Уб.: Удам соёл ХХК.

Сүхбаатар, Ц. (2000). Найруулгын тухай. Уб.: Соёмбо принтинг.

Сүхбаттар, Ц. (2006). Найруулгазүйн судалбар. Уб.

Даваа, Ж. (2008). Хүн болох үе шат. Уб: МУИС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв .

Мягмар, О. (2012). Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. Уб.

УИХ. (1992). Монгол Улсын Үндсэн Хууль. Уб.

<https://www.youtube.com/watch?v=axdOKdaepYE> - Gangbay - Gangan tsagaan дуу

<https://www.youtube.com/watch?v=z8M1gmQJtko> - Vandebo - Чиний нүдээр дуу

<https://www.youtube.com/watch?v=CwmX5Hzkd9Q> - Gingin, Mrs M. - Бороо дуу

<https://www.youtube.com/watch?v=tyb-AwhJj5Y> - AM-C - Gund дуу <https://www.youtube.com/watch?v=oVc48f-xhko> - Хонх - Хонхны дуу

ХАВСРАЛТ: КОНТЕНТ АНАЛИЗ

Дуу №1 Gangbay – Ганган цагаан			
Код	Хайлтын утга	Давтамж	Давтамжын утга
1	Чи	25	Чи - Би-гийн эсрэг ойлголт буюу би-тэй харилцагч тал.
2	Би	21	Би - Хувь хүн өөрийгөө нэгдүгээрт тавьсан эгоцэнтрист хандлагыг илтгэн харуулдаг.
3	Хайр	3	Хайр - Хос болсон 2 хүний хоорондын итгэл, хүндлэлийн бат холбоог илтгэн харуулдаг.
4	Шиг	4	Шиг - Аливаа зүйлийн шинжтэй өөр нэгэн зүйлийг адилтган хэлэх.
5	Цагаан	5	Цагаан – Харын эсрэг өнгө, хүний цайлган зан аашыг илэрхийлнэ.
6	Гадаад үг хэллэг	58	Орчуулбал: Неу, Девучка Yeah – Хөөе, Охин еэх Ты моя сердечка – Чи миний зүрх Ты как бабочка – Та эрвээхэй шиг юм. На мня сиди я как цветочка – Би яг л цэцэг шиг над дээр сууна

Дуу №2 Vandebo – Чиний нүдээр			
Код	Хайлтын утга	Давтамж	Давтамжын утга
1	Чи	32	Чи – Би-гийн эсрэг ойлголт буюу би-тэй харилцагч тал.
2	Би	19	Би – Хувь хүн өөрийгөө нэгдүгээрт тавьсан эгоцэнтрист хандлагыг илтгэн харуулдаг.
3	Болгосон	6	Болгосон – Аливаа зүйлийг анхны байдлаас нь өөрчлөх утгатай бусдаар үйлдүүлэх хэв.
4	Хараалын үг	1	Новш - Доромж өнгө аясыг агуулдаг бүдүүлэг утгатай.
5	Гадаад үг хэллэг	1	Орчуулбал: Cool – Дажгүй

Дуу №3 Ginjin, Mrs M - Бороо			
Код	Хайлтын утга	Давтамж	Давтамжын утга
1	Чи	11	Чи - Би-гийн эсрэг ойлголт буюу би-тэй харилцагч тал.
2	Би	9	Би - Хувь хүн өөрийгөө нэгдүгээрт тавьсан эгоист хандлагыг илтгэн харуулдаг.
3	Бид	7	Бид - Би болон чи гэсэн 2 талын байр суурь эн тэнцүү байгааг илтгэн харуулна.
4	Бороо	22	Бороо - Агаарын тунадас ууршин унасан усан дуслууд.
5	Ороосой, ирээсэй	28	Ороосой, ирээсэй – Мөрөөдөн хүсэх шинжтэй дотогш нэвтрэх утга бүхий үг.
6	Гадаад үг хэллэг	1	Toxic – Хортой

Дуу №4 AM-C - Гүнд			
Код	Хайлтын утга	Давтамж	Давтамжын утга
1	Чи	31	Чи – Тухайн харилцаанд оролцогч тал.
2	Би	8	Би - Хувь хүн өөрийгөө нэгдүгээрт тавьсан эгоист хандлагыг илтгэн харуулдаг.
3	Хүмүүс	1	Хүмүүс – Амьд бие субъектийг заасан олон тооны нэр
4	Хайр	8	Хайр - Хос болсон 2 хүний хоорондын итгэл, хүндлэлийн бат холбоог илтгэн харуулдаг.
5	Гадаад үг хэллэг	8	Dance - Бүжиг

Дуу №5 Хонх хамтлаг – Хонжны дуу			
Код	Хайлтын утга	Давтамж	Давтамжын утга
1	Бид	9	Бид - Би болон чи гэсэн 2 талын байр суурь эн тэнцүү байгааг илтгэн харуулна.
2	Би	4	Би - Хувь хүн өөрийгөө нэгдүгээрт тавьсан эгоист хандлагыг илтгэн харуулдаг.
3	Сэрээ	15	Сэрээ – Унтах явцыг дуусгах, сэрг мэдрүүлэх.
4	Хонхны дуу	14	Хонхны дуу – Хонхноос гарах чимээ.
5	Хүсэл, зориг	5	Хүсэл, зориг – Хүслээ биелүүлэхийн төлөө шийдсэн санаа.



KONRAD ADENAUER STIFTUNG

Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Сөүлийн гудамж Браухаус 22
Улаанбаатар хот 14253
Монгол улс

Утас: +976-11-319135/36
www.kas.de/mongolei
www.facebook.com/kas.mongolei
info.mongolia@kas.de